

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ПРОТОКОЛ

199 I оны II
сарын 13 өдөр

Дугаар 3

Улаанбаатар
хот

Ардын Их Хурлын II хуралдааны 3 дахь өдрийн ажиллагаа өглөөний 9⁰⁰ цагт Ардын Их Хурлын хуралдааны танхимд эхлэв. Хуралдаан Ардын Их Хурлын дарга Ж. Уртнасан даргалав. Хуралдаанд 427 депутатууд хүрэлцэн ирэхээс 405 депутат ирсэн, ирц 95 хувь байв. /Хоцорч ирсэн депутатуудын нэрсийг хавсаргав/

Депутат Г. Чингэл, Т. Батмөнх, Ц. Охинтогтох, Н. Сампилноров нар өвчтэй, депутат Г. Сүрэнжаргал гадаадад ажлаар явсан байв.

Ардын Их Хурлын хуралдааны нэр дээр байгууллага, хамт олон иргэдээс ирсэн санал, хүсэлт, утас, цахилгаан, захидлыг Ардын Их Хурлын орлогч дарга Ц. Лоохууз 9⁰⁴ цагт уншиж сонсгов.

Ардын Их Хурлын II хуралдааны Дэгийг эцэслэн боловсруулах ажлын хэсгийн ажлагч I-р тойргийн депутат С. Баярын мэдээллийг 9⁰⁸ цагаас эхлэн сонсов. Сонсголын явц дунд "депутатууд бусдад саналаа тулгах, зөвшөөрүүлэх гэж хүч хэрэглэх, бусдад уриалах эрхгүй" гэсэн саналыг байлгах шаардлагагүй гэж 422-р тойргийн депутат Н. Төмөртогос, 426-р тойргийн депутат Ж. Барамсай нар үг хэлэв. Ардын Их Хурлын дарга Ж. Уртнасан дээрхи санааг Дэгд байлгах, эсэхийг санал хурааж шийдье гэв. Санал хураахад зөвшөөрсөн 241/77%, татгалзсан 64/20%, түдгэлзсэн 8/3%, бүгд 313/73% байв.

Ардын Их Хурлын депутатуудын 77 хувь нь зөвшөөрснөөс уг заалтыг дэгд үлдээв. Энэ саналыг тайлбарлах 326-р тойргийн депутат Ж. Гомбожав, 427-р тойргийн депутат Ц. Элбэгдорж, 7-р тойргийн депутат Ц. Балдорж, 39-р тойргийн депутат П. Ламжав нар үг хэлэв.

Депутат С. Баярын мэдээлэл үргэлжлэн 9⁴⁵ цагт дуусав.

Ардын Их Хурлын дарга Ж. Уртнасан Дэгийг зүйл тус бүрээр хэлэлцэлгүй бүхэлд нь санал хураах замаар батлах санал гаргах, энэ тухай гарах тогтоолын төслийг уншиж сонсгов. зөвшөөрсөн 393/94%, татгалзсан 19/5%, түдгэлзсэн 4/1%, бүгд 416/97%.

Дэгийг баталсан тул олшруулж депутатуудад тараахаар тогтов.

10-р тойргийн депутат О.Дашбалбар үг хэлэх зөвшөөрөл авч, II сарын 10-нд болсон цуглаанд оролцогчдоос гаргасан Ардын Их Хурлын Хуралдаанд өргөх бичгийг уншиж сонсгов.

Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан шинээр батлагдсан Дэгийн дагуу хуралдаанаа үргэлжлүүлэн хэлэлцэх асуудал, дотоод журмаа батлах санал гаргав. 39-р тойргийн депутат Д.Ламжав үг хэлэх зөвшөөрөл хүссэн боловч депутатууд зөвшөөрсөнгүй.

406-р тойргийн депутат Ч.Тэрбиш Ардын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудалд нэмэх, өөрчлөх зүйлийн талаар сонгогчдынхоо өмнөөс санал хэлэв. Мөн 420-р тойргийн депутат Д.Гомбожав, 27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж, 261-р тойргийн депутат Д.Пүрэв нар үг хэлж цааш үг хэлэх депутат олон байгаа тул эхлээд санал хурааж дарааллаа тогтоохоор шийдвэрлэв.

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журмыг батлая гэдэг дээр санал хураав. зөвшөөрсөн 374/91%, татгалзсан 32/8%, түдгэлзсэн 6/1%, бүгд 412/96% байв.

Хуралдааны дарааллыг урьдчилан тараасан төслийн дагуу батлах дээр санал хураав. зөвшөөрсөн 346/84%, татгалзсан 60/15%, түдгэлзсэн 7/2%, бүгд 413/97%, 180-р тойргийн депутат Д.Жумдаанбаатар үг хэлж, бусад улс оронд хандсан уриалга, ард түмэндээ хандсан тайлбар гаргах санал гаргав. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллын талаар 149-р тойргийн депутат Т.Анигар, 10-р тойргийн депутат О.Дашбалбар, 425-р тойргийн депутат П.Ганзориг, 407-р тойргийн депутат Б.Нүүрэй, 167-р тойргийн депутат Ш.Гүрбазар, 191-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, 287-р тойргийн депутат Ч.Хурц, 426-р тойргийн депутат Ж.Барамсай, 294-р тойргийн депутат И.Бадарч, 171-р тойргийн депутат Ж.Лхагважав, 25-р тойргийн депутат Л.Энэбиш, 41-р тойргийн депутат Н.Пүрэвдорж, 168-р тойргийн депутат Г.Вандандагва, 107-р тойргийн депутат Л.Баяндалай, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 429-р тойргийн депутат Р.Рэнцэннацаг, 418-р тойргийн депутат Ж.Оросоо, 351-р тойргийн депутат Б.Мөнгөн, 154-р тойргийн депутат Е.Моголцог, 98-р тойргийн депутат Д.Марав, 47-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 258-р тойргийн депутат Ш.Гунгаадорж, 315-р тойргийн депутат Ч.Бат-эрдэнэ, 423-р тойргийн депутат М.Гэрэлсүрэн, 295-р тойргийн депутат Р.Баярсайхан, 80-р тойргийн депутат Д.Зарьккан, 146-р

тойргийн депутат М.Мөнхбат нар санал гаргав.

Хуралдаан II⁰⁰-II²⁰ цагт завсарлав. Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан II сарын II-ний өдрийн хуралдаанд үг хэлсэн хүмүүсийн тоог танилцуулаад, хуралдааныг үргэлжлүүлэв.

I66-р тойргийн депутат Ц.Дамцагдорж, I88-р тойргийн депутат Б.Буяндэлгэр, I80-р тойргийн депутат Д.Жумдаанбаатар, 4I6-р тойргийн депутат Д.Пэлжээ, I83-р тойргийн депутат Ч.Намсрай, 340-р тойргийн депутат Б.Сумьяа, I23-р тойргийн депутат Д.Пүрэвдорж, 38I-р тойргийн депутат Н.Цэрэнхүү, 63-р тойргийн депутат Х.Пүрэвдагва, IO-р тойргийн депутат О.Дашбалбар, II5-р тойргийн депутат Б.Даваасүрэн, I4I-р тойргийн депутат Ж.Авхиа, 92-р тойргийн депутат Г.Бүдий, 425-р тойргийн депутат П.Ганзориг, 282-р тойргийн депутат Д.Лхагвасүрэн, 350-р тойргийн депутат Ц.Давааням, I40-р тойргийн депутат Т.Гантөмөр, IO3-р тойргийн депутат Л.Дүйсэнсанги, 88-р тойргийн депутат А.Рэгзэн, I86-р тойргийн депутат Р.Чойжинням, 3I7-р тойргийн депутат Д.Мандах, IO9-р тойргийн депутат С.Лхагвасүрэн, 74-р тойргийн депутат К.Мизамхан, 29-р тойргийн депутат Г.Нямдаваа, 245-р тойргийн депутат Ч.Чинбат, 46-р тойргийн депутат Ю.Жаргал нар хэлэлцэх асуудлын дарааллаар үг хэлж санал таслав.

Улсын Бага Хурал, Засгийн газрын тайланг эхэлж сонсохыг зөвшөөрсөн 76/I9%, татгалзсан 306/77%, түдгэлзсэн I5/4%, бүгд 397/93%, болов.

Хэлэлцэх асуудлын дараалалыг төсөлд байгаа хэвээр үлдээв. 287-р тойргийн депутат Ч.Хурц, I86-р тойргийн депутат Р.Чойжинням, 3I7-р тойргийн депутат Д.Мандах, 426-р тойргийн депутат Ж.Барамсай, I9I-р тойргийн депутат Б.Лханаасүрэн, 250-р тойргийн депутат Г.Дамдиндорж, I83-р тойргийн депутат Ч.Намсрай, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, I88-р тойргийн депутат Б.Буяндэлгэр, I84-р тойргийн депутат С.Билэгсайхан, 406-р тойргийн депутат Ч.Тэрбиш, 245-р тойргийн депутат Ч.Чинбат, 60-р тойргийн депутат Д.Дамбийжанцан, 275-р тойргийн депутат С.Батсүх нар санал хураалттай холбогдуулан үг хэлэв. Ардын Их Хурлын дарга Ж.Уртнасан олон депутатууд дахин/3 дахь/ санал хураалгая гэсэн санал гаргасан тул хоёрдахь хувилбараар буюу "Засгийн газар, Улсын Бага Хурлын тайлан хэлэлцсэний дараа Их цаазын шинэ төслийг хэлэлцье" гэсэн хувилбараар санал хураав.

зөвшөөрсөн 75/18%/, татгалзсан 318/77%/, түдгэлзсэн 49/5%/, бүгд 412/96%/,

Олонхийн саналаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хэвээр үлдээв. Хуралдааны дотоод журмаа бөөнөөр нь хэлэлцэж баталъя. зөвшөөрсөн 397/95%/, татгалзсан 14/3%/, түдгэлзсэн 5/1%/, бүгд 416/97%/, Ж.Уртнасан:

Хуралдааны их завсарлага болоход 15 минут дутуу байна. Илтгэлээ эхлэн сонсож байгаад завсарлах уу? эсвэл шууд завсарлаад 15⁰⁰ цагаас хуралдаанаа үргэлжлүүлэх үү? гэсэн асуудал байна. Үүнийг санал хурааж шийдвэрлэе. Эхлээд шууд завсарлага хийгээд дараа нь илтгэлээ сонсоё гэсэн дээр санал хураав. зөвшөөрсөн 391/97%/, татгалзсан 8/2%/, түдгэлзсэн 4/1%/, бүгд 403/94%/

Хуралдаан 12⁴⁵ цагт завсарлаж 15⁰⁰ цагаас үргэлжлэв. Хуралдаанд 380 депутат байв.

15⁰² цагт "Монгол улсын Их цааз /Үндсэн хууль/-ын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай" илтгэлийг БНМАУ-ын Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлын зохион байгуулах комиссийн дарга П.Очирбат тавив. /Илтгэлийг хавсаргав/

АИХ-ын II хуралдааны Дөгийн 10-р зүйлийн дагуу Их цаазын төсөл дээр ажиллах 15 хүний бүрэлдэхүүнтэй депутатуудын ажлын хэсгийг сонгох саналыг 16³⁰ цагт АИХ-ын дарга Ж.Уртнасан гаргав.

132-р тойргийн депутат С.Чулуунбаатар ажлын хэсгийн үүрэг зорилгыг тодруулж өгөхийг хүсэв. Депутат С.Баяр асуудалтай холбогдуулан тайлбар хэлэв. 287-р тойргийн депутат Ч.Цэрэндагва 5 бүлэг дээр төрөлжин ажиллах хороодыг байгуулах санал гаргав. 280-р тойргийн депутат Ш. Цэндбаяр, 15-р тойргийн депутат Д.Лүндээжанцан, 139-р тойргийн депутат И.Гүлхүү, 287-р тойргийн депутат Ч.Хурц, 13-р тойргийн депутат Л.Цог, 261-р тойргийн депутат Д.Пүрэв, 298-р тойргийн депутат Д.Тангад, 52-р тойргийн депутат Э.Бат-Үүл, 1-р тойргийн депутат С.Баяр, 163-р тойргийн депутат Б.Мижид, 105-р тойргийн депутат Б.Чойжилсүрэн, 198-р тойргийн депутат С.Батмөнх, 55-р тойргийн депутат Ц.Адъяасүрэн, 314-р тойргийн депутат М.Гантөмөр, 107-р тойргийн депутат

Л.Баяндалай, 23-р тойргийн депутат Ц.Энхбат, Ерөнхийлөгч П.Очирбат нар үг хэлэв.

Хуралдаан 17⁰⁰ цагт завсарлаад 17²⁴ цагт ажлаа үргэлжлүүлэв.

Депутатуудын ирц 398/93%/ байв. Үндсэн хуулийн төслийг эцэслэн боловсруулах хорооны талаар 12-р тойргийн депутат Г.Очирбат, 32-р тойргийн депутат Д.Манцах нар үг хэлж дараа нь санал хураав.

I.Дэгийн X зүйлийн дагуу нэг хороо байгуулах: зөвшөөрсөн 334/82%/, татгалзсан 57/14%/, түдгэлзсэн 13/3%/, бүгд 404/92%/.

II.Хүний тоог 2I байна гэж: зөвшөөрсөн 372/82%/, татгалзсан 22/5%/, түдгэлзсэн 11/2%/, бүгд 405/92%/

Хорооны бүрэлдэхүүнд орсон 2I хүний нэрийг уншиж танилцуулав. 237-р тойргийн депутат Ч.Хурц, 163-р тойргийн депутат Б.Мижид, 281-р тойргийн депутат Б.Нямдорж, 211-р тойргийн депутат Д.Дагвадорж нар дээрхи асуудалтай холбогдуулан үг хэлэв. Улсын Бага Хурлын зөвлөх С.Төмөр бүрэлдэхүүний талаар тайлбар хэлэв.

7-р тойргийн депутат Ц.Балдорж, 231-р тойргийн депутат Г.Амарбаян, 390-р тойргийн депутат Ү.Аварзэд, 167-р тойргийн депутат Ч.Гомбосүрэн, 27-р тойргийн депутат Л.Пүрэвдорж/хорооны бүрэлдэхүүнээс нэрээ татав/, 280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр, 258-р тойргийн депутат Ш.Гунгаадорж, 24-р тойргийн депутат Р.Хатанбаатар /Б.Чимид, К.Зардыхан, Мнэнхсайхан, Р.Хатанбаатар нар нэрээ авав/, 413-р тойргийн депутат Н.Насан-Очир, 235-р тойргийн депутат Ц.Өөлд, 405-р тойргийн депутат Б.Лигдэн/нэрээ авав/ нар бүрэлдэхүүний талаар санал бодлоо хэлэв. Депутатуудын орон нутгийн бүлэг, намууданс санал авч маргааш өглөө шийдвэрлэх хүртэл уг асуудлыг нээлттэй орхихыг зөвшөөрсөн 332/81%/, татгалзсан 60/15%/, түдгэлзсэн 17/4%/,

Нээлттэй орхив.

18⁰⁶ цагаас илтгэгч П.Очирбатаас бичгээр, амаар депутатууд асуулт асуув/Соронзон бичлэгийг хавсаргав/

114-р тойргийн депутат С.Ёндонжамц, Улсын нэр, сүлд, далбааны тухай, 405-р тойргийн депутат В.Лигдэн /микрофоноор/ бичгээр асуулт асууж байгаа депутатуудын нэр, тойргийг хэлж байх тухай, 82-р тойргийн депутат А.Сарай нэгтгээд хичнээн аймаг болох, 243-р тойргийн депутат Г.Амарбаян сүлд, далбааг солих зайлшгүй шаардлагын тухай, /Улсын Бага Хурлаас хариулах/, 133-р тойргийн депутат Ц.Нанзаддорж /микрофоноор/ Улсын Бага Хурлын төслийн талаар гишүүд индрээс хариулах, 137-р тойргийн депутат Г.Бааран ерөнхийлөгчийн эрх хэмжээний тухай, 222-р тойргийн депутат Д.Банзрагч /микрофоноор/ ерөнхийлөгчийн эрх хэмжээний талаар, 168-р тойргийн депутат Г.Вандандагва төр, эдийн засгийн аюулгүй байдлын баталгааг хэрхэн хангах, 218-р тойргийн депутат Ц.Гомбо /микрофоноор/ газрын тухай болон тусгаар тогтнолыг хангах ямар болзол байдаг талаар асууж Ерөнхийлөгч товч хариулав.

18⁴⁰ цагт зарим асуултад Дэд ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын дарга Р.Гончигдорж хариулж эхлэв. Үүнд улсын нэр, их цааз гэсэн тухай К.Зардыхан, Б.Чимид нар хариулах болов.

18⁴³ цагт 4-р тойргийн депутат К.Зардыхан, 396-р тойргийн депутат Б.Чимид нар хариулав.

Улсын Бага Хурлын гишүүн Ц.Товуусүрэн улсын нэр, тамга, тэмдэг, албан хуудас, мөнгөн тэмдэгт өөрчлөгдөхтэй холбогдож гарах зардлын тухай, Улсын Бага Хурлын гишүүн Д.Маам төрийн шинэ сүлдний талаар тайлбар хийв. Үүгээр өнөөдрийн хуралдаан 19⁰⁰ цагт дуусав. /Соронзон бичлэгийг хавсаргав/

АРДЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ОРЛОГЧ ДАРГА

J. Urtynasan Ж.УРТНАСАН
N. Batbayar Н.БАТБАЯР
T. Jagai Т.ЖАГАЙ
C. Looxuuз Ц.ЛООХУУЗ
D. Moonidoi Д.МООНДОЙ

ТЭМДЭГЛЭСЭН *A. Jundandorj* А.ЮНДЭНДОРЖ
G. Khuralbaatar Г.ХҮРЭЛБААТАР

7

АРДЫН ИХ ХУРЛЫН 1991 ОНЫ II ДҮГЭЭР
САРЫН 13-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНЫ ИРЦИЙН
БАЙДАЛ

Ирвэл зохих: 426

Хуралдаанд ирээгүй /шалтгааныг дурдана/:

Депутат Г.Чингэл /339/, Т.Батмөнх /376/, Ц.Охинтогтох /254/,
Н.Сампилноров /199/, Г.Жадамбаа /97/, Хүзкей /83/, Т.Тогоо /203/
нар өвчтэй.

Депутат Г.Сүрэнжаргал /299/ гадаадад ажлаар явсан.

Хуралдаанд хоцорч ирсэн:

С.Баярцогт /288/ 20 минут

Л.Шагдар /378/ 2 цаг

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

1991.11.13
Кассет № 70
9.00-9.15

Ж.Уртнасан: Хуралд оролцож байгаа улсуудын өглөөний амгаланг айлтгая. Өнөөдрийнхөө хуралдааны ажиллагааг эхэлж байна. Энэ хугацаанд хөдөөний хөдөлмөрчдөөс ирсэн мэдээлэл, захидлын тоймыг манай орлогч дарга Лоохууз гуай танилцуулна.

Ц.Лоохууз: II дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны явцад Ардын Их Хурлын хуралдааны нэр дээр байгууллага, иргэдээс бичгээр 30, цахилгаанаар 7, утсаар 16, бие хүн хурлын байранд 4 хүн ирж санал хүсэлт тавьсан байна.

Баян-Өлгий аймгийн "Алтайн хөгжил" нэгдлийн гишүүд цахилгаан утсаар мэдээлсэн байна. Октябрийн районы 6 дугаар хорооны иргэн Жамьяндондог, мөн районы 25 дугаар хорооны иргэн Гунгаажав, Нийслэлийн 46 дугаар сургуулийн хичээлийн эрхлэгч Баасандорж нар утсаар мэдээлсэн байна.

Өвөрхангай аймгийн зохицуулах зөвлөлийн хүмүүсүүд цахилгаанаар тус хуралд мэдэгдэл өгсөн байна.

Хуулийн төслийг аливаа туйлшруулалгүй, холч мэргэн ухаанаараа тунгаан бодож, урт настай хууль батлан гаргана гэдэгт түмэн олон хүлээн итгэж байна гэж бичсэн байна.

Улаанбаатар хотын Багшийн коллежийн аж ахуйн дарга Мижиддорж, Нийслэлийн 46 дугаар сургуулийн хичээлийн эрхлэгч Баасандорж нар Ардын Их Хурлын хуралдааны ажиллагааг хэвлэл, мэдээллээр өргөн сурталчилж, ялангуяа улсын Бага Хурал, Засгийн газрын үйл ажиллагааны тайланг ард түмэн их сонирхож байгааг зориуд анхааруулсан байна.

Сүхбаатарын районы 10 дугаар хорооны IY байшингийн 22 тоотод суудаг Бямбажав хүлээн авах байраар ирж, Их Хурал 2 өдрийн хуралдаанаараа зөвхөн хурлын дэгийг хэлэлцэж, дэндүү жижиг

зүйлээр маргаж, цаг алдаж байгааг анхаарч, ухаалаг, уужуу хандаж, хуралдаандаа оролцохыг хүсч байна гэж бичсэн байна.

Ингээд бусад асуудлууд бол голдуу Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайлантай холбогдсон хүсэлтүүд, Үндсэн хуулийн тухай хэлэлцэхэд хамаарагдах ийм зүйлүүд байна. Үүнийг тухай үед нь уншиж танилцуулъя гэж хурлын тэргүүлэгчид шийдсэн байна.

Ж.Уртнасан: Одоо уламжлал ёсоор өглөөний ирцийг бүртгэж үзье. Ирц бүртгэмэд бэлтгэнэ үү?

Депутатуудын хуралдаанд ирсэн ирцийг бүртгэж байна. Техник сааталгүй гэж бодож байна. Гэхдээ пүүсийн инженерийг дуудахгүй бол бид нарт хариу хэлэхгүй байна. Энэ хугацаанд цаг алдаад яах вэ? Дэгийг эцэслэн боловсруулах ажлын гур группийн дарга Баярын сонсголыг сонсч байна.

Г дүгээр тойргийн депутат, дэг эцэслэн боловсруулах комиссын дарга С.Баяр:

Эрхэм депутатуудын өглөөний амгаланг айлтгая. Ардын Их Хурлын II хуралдааны дэг боловсруулах редакцийн ажлын хэсэг байгуулагдсан цагаасаа хойш 3 удаа хуралдаж, бүлэг тус бүрээр сүүлд нь зарчмын хувьд санал тохироод та нөхдөд толилуулан барих ийм төсөл байна.

Тэгэхдээ бид редакцийн хэсэг дээр ярьж байгаад ингэж тогтсон байгаа юм. Нэгэнт редакци танилцуулж байгаа учраас та бүгдийн гар дээр байгаа дэг дээр оруулсан засвар, найруулгын шинэ томъёоллыг хэлж, эцэслэн батлуулсны дараа хэвлүүлж, гар дээр чинь тавих нь зүйтэй юмаа гэж, илүү зардал, чирэгдэл гаргахгүй байх үүднээс, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, редакцийн ажлын хэсэг бол Ардын Их Хурлын хуралдааны үед зарчмын хувьд санал хураалтаар олонхийн /бичлэг тасарсан байна/

редакци, ажлын хэсгийн хаягаар ирсэн нийт 12 саналыг харгалзаж үзсэн болно. Ингээд бид бүгдийг унших шаардлагагүй болов уу гэж бодож байна. Зөвхөн редакци засвар оруулсан хэсгээ та нөхдөд анхааруулаад хэлээд явчих нь зүйтэй болов уу гэж бодож байна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдааны дэг

Энэ жижигхэн оршил хэсэг байгаа. Энэ дээр бол санал гараагүй тийм учраас энэ хэвээрээ байгаа.

Нэгдүгээр бүлэг. Хуралдааны үндсэн журам

Нэгдүгээр зүйл дээр хэд хэдэн засвар орсон. Ардын Их Хурлын хуралдааны үйл ажиллагаа нь депутатууд, ард түмний нийтлэг эрх ашиг, үндэсний эв нэгдэл, төрийнхөө хуулийг дээдлэн, дотоод журам, дэгийг чанд сахин, асуудлыг чөлөөтэй, ажил хэрэгчээр хэлэлцэж, ардын Их Хурлын /Үндсэн хууль/ болон энэ дэгд гэж нэмж оруулсан. "болон энэ дэгд" гэсэн 3 үг нэмж оруулсан. Өөрөөр заагаагүй бол /хашилт хааж байгаа/ хуралдаанд оролцсон нийт депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үүний дараа бүхэл бүтэн абзац нэмсэн байгаа. Үүнийг хичээнгүйлэн бичиж авахыг хүсье.

Хэрэв цөөнх хүсвэл асуудлаа тайлбарлаж, дахин санал хураалгаж болно. Цөөнхийн саналыг үндэслэн тухайн асуудлаар 3 хүртэл удаа дахин санал хураалгаж болох бөгөөд

Хурлын дарга зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дахин санал хураах эсэхийг шийдвэрлэх эрхтэй.

Одоо бүхэлд нь нэг уншъя. Хэрэв цөөнх хүсвэл асуудлаа тайлбарлаж, дахин санал хураалгаж болно. Цөөнхийн саналыг үндэслэн тухайн асуудлаар 3 хүртэл удаа дахин санал хураалгаж болох бөгөөд Хурлын дарга зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дахин санал хураах эсэхийг шийдвэрлэх эрхтэй.

I дүгээр зүйлийн 2,3 дугаар хэсэгт өөрчлөлт ороогүй байна.

2,3, 4 дүгээр зүйлийг багцаар нь баталсан.4 дүгээр зүйлийн 2 дугаар хэсэгт Ардын Их Хурал 4 орлогч даргатай байна гэдэг редакцийн засвар оруулсан.

Депутатуудын санал гаргасны дагуу Дэгийн 5 дугаар зүйлийг 2 хуваасан.Ингээд 5 дугаар зүйлд хэлэлцэх асуудал гэж нэг зүйл гарч ирсэн.

5 дугаар зүйлийн I бол хасагдсан байгаа.Тэгээд 2 нь нэг болж байгаа.5-ын 2 нь нэг болоод, иймэрхүү редакцитай болсон.

Ардын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудал түүний, дарааллыг хуралдаанд оролцсон депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.Ардын Их Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудал, түүний дарааллыг хуралдаанд оролцсон депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ./Хоёр дахин уншсан болно/

5 дугаар зүйлийн - 2 дугаар хэсэг.Ардын Их Хурлын депутатууд хуралдаанаар хэлэлцэх асуудал, дотоод журмын талаарх саналаа бичгээр буюу амаар гаргаж болно./Мөн хоёр дахин уншлаа/

5 дугаар зүйлийн 3 дугаар хэсэг.Хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгагдаагүй шинэ асуудал хэлэлцүүлэх санал гаргавал, түүнийг хэлэлцүүлэн санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон нийт депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. /Мөн хоёр дахин уншлаа/


5 дугаар зүйл ийм болсон, 3 хэсэгтэй.

6 дугаар зүйл.Депутатуудын бүлэг гэсэн гарчигтай.
6 дугаар зүйлийн I дүгээр хэсэг.Депутатууд Ардын Их Хурлын

хуралдаанаар хэлэлцэх асуудлаар саналаа солилцож, нэгтгэх, хуралдаанд нэгдсэн саналаа илэрхийлэх зорилгоор депутатуудын бүлэг байгуулж ажиллаж болно.

2 дугаар хэсэг. Депутатын бүлэг нь гишүүний тоо, бүлгийн ахлагч, мөн тухайн бүлгийн талаарх бусад мэдээг хурлын даргад бүртгүүлснээр үйл ажиллагаагаа явуулах эрхтэй болно. /Мөн хоёр дахин уншлаа./

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

Ардын Их Хурлын I дүгээр тойргийн депутат С.Баяр:

-За ингээд нэгэнт 5 дугаар зүйлээ хоёр хуваасан учраас цаашаа зүйлүүдийн дугаар нэг нэг ахиад явчихаж байгаа юм. Ингээд би шинэ дугаараа хэлээд явъя даа. Ингээд 7 дугаар зүйл. Депутатын бүрэн эрхийг зөвшөөрөх. Энэ дээр гуравхан үг нэмсэн байгаа. Энэ 7 дугаар зүйлийн нэгдүгээр хэсгийн эхний мөрөнд байгаа юм. Ардын Их Хурлын хуралдааны эхэнд нөхөн гэдгийн дараа ба дахин сонгуулиар гэсэн ийм гурван үг оруулсан байгаа. Дахин сонгуулиар гэсэн. Эхэнд нөхөн ба дахин сонгуулиар сонгогдсон депутатын бүрэн эрхийг шалгаж хүлээн зөвшөөрөх тухай Ардын Их Хурлын депутатууд бүрэн эрхийн асуудал эрхэлсэн байнгын комиссын илтгэлийг хэлэлцэнэ. За 7 дугаар зүйлд ийм засвар орсон байгаа юм.

За 8 дугаар зүйлд энэ гарчигт нь Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нарын эрх, үүрэг, эрх гэдэг үг нэмсэн. Зүйл дотроо бол засвар алга.

9 дүгээр зүйл ерөнхийдөө хэвээрээ, тэгэхдээ сүүлчийн, төгсгөлийн өгүүлбэрийг нь редакцийн шинэ томъёолол оруулж ирж байгаа юм аа. Энэ бол зарчмын юу байхгүй л дээ. Аппаратыг Ардын Их Хурлын даргын захирамжаар томилогдсон ерөнхий нарийн бичгийн дарга удирдана. Аппаратын аппаратыг гээд их сонин юм байсан тэнд. Аппаратыг Ардын Их Хурлын даргын захирамжаар томилогдсон ерөнхий нарийн бичгийн дарга удирдана. Ингээд, 9 дүгээр зүйл дээр өөр юмгүй.

10 дугаар зүйл хэвээр.

II дүгээр зүйл. Энд нэлээд засварууд бий. Ардын Их Хурлын хуралдааны нийтлэг журам. Энэ эхний өгүүлбэр өөрчлөлт ороогүй юм байна. 9 цагаас 13 цаг хүртэл, 15 оройн хуралдааныг 15 цагаас 19 цаг хүртэл, 2 цаг тутам 20 минутын завсарлагатай явуулна гээд хэвээрээ, тэгээд цаашаа бол тодорхой асуудал хэлэлцэх явцад шаардлагатай бол хуралдааны хугацааг сунгах, депутатуудын бүлгийн санал болгосноор хуралдааныг түр завсарлах асуудлыг ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааныг сунгах болон түр завсарлагаа үргэлжлэх хугацааг тухай бүрт нь хэлэлцэж тохирно.

гэсэн байгаа. Энд ням гаригт амарна гэсэн ийм томъёоллоор депутатуудын олонхийн санал гарсан. Зүгээр редакц бид ярьж байгаад энэ томъёолол тийм ч их оновчтой биш юм болов уу гэсэн ийм санал гаргасан. Учир нь юу вэ гэвэл, ерөөсөө ажлын шаардлага гараад ням гаригт ажиллах шаардлагатай болбол ням гаригт ажиллах бололцоогоо бүрмөсөн хаачихаж байгаа юм энүүгээрээ. Тэгэхлээр энэнийг жаахан уян хатан хийвэл яасан юм бэ? Нэгдүгээр хувилбар нь ерөөсөө ням гаригт амарна гэдгийг хасчих юм бол дээр нь хуралдааны хугацааг сунгах боломжийг нээж өгсөн учраас ингээд явчихаж болох юм гэж. Тэгэхлээр ням гаригт амрах эсэх нь ерөөсөө тодорхойлогдоогүй учраас энэ ойлгомжгүй гэсэн бас нэг ийм юм байвал хоёрдугаар хувилбар нь бол ням гаригт амарна гэсэн өгүүлбэрийг шаардлагатай бол ням гаригт хуралдаж болно гэсэн.

Нэгдүгээрт ням гаригт ерөнхийдөө амрах юм байна гэсэн боломжийг нь зааж өгч байгаа юм. Шаардлага гарах юм бол ажиллаж ч болно гэсэн уян хатан хувилбар байвал яасан юм бэ гэж бодож байна. Энэ дээр Хурлын эрхэм дарга санал хураалгаж өгөөд ийм томъёоллоор оруулах юмуу, хасах юм уу, хэвээр нь үлдээх юм уу гэдэг дээр депутатууд өөрсдөө шийдэх асуудал. Энэ дээр шууд хураачихвал яасан юм бэ?

Ш. Уртнасан:—Энэнийг зөвшөөрч санал хурааж болох юм гэхдээ жаахан явъя даа.

С. Баяр:— За. Тэгэхлээр энэ дээр санал хураалгаж өгөөчээ гэсэн эхний ийм хүсэлт байгаа тийм ээ. Эргэж буцалгүй одоо л батлаад явчихвал зүгээр байна.

Ш. Уртнасан:—Цахим техник хэвийн ажиллагаанд орсон шиг байна. Тэгэхлээр эхлээд ирцээ үзчихье. Дараа нь энэ дээр санал хураая. Ирц бүртгэж байна.

Хуралдаанд ирэх депутат ирвэл зохих 427 хүнээс 406 хүн ирсэн байна. 95 хувийн ирцтэй байна. Ингээд хуралдааныхаа ажиллагааг үргэлжлүүлье. За одоо ажлын групп, ажлын хэсгийн ахлагч

Баярын оруулж байгаа энэ редакцийн хэсгийг дэгд энэ редакц хийсэн хувилбараар үлдээе гэсэн санал хураалт явуулж байна.

С.Баяр:—II дүгээр зүйлийн ням гаригт амарна гэдгийг шаардлагатай бол ням гаригт хуралдаж болно гэдэг хувилбараар оруулж болох уу гэдэг дээр санал хураалгажөгнө үү.

Ж.Уртнасан:—Тийм. За санал хураалтад бэлтгэнэ үү.

Санал хураалт явуулж байна. За баярлалаа. Санал өгсөн депутатуудын 73 хувь нь букуу 295 депутат энэ засварлан найруулсан хэсгийг зөвшөөрч дэгд үлдээж байна. 103 хүн татгалзаж, 4 хүн түдгэлзсэн байна. Олонхийн саналаар үлдээв.

С.Баяр:—За баярлалаа. II дүгээр зүйлийн хоёрдугаар хэсэг энэ эхний малгайн өгүүлбэр хэвээр байгаа юм. Депутатууд хуралдаанд оролцохдоо гээд а/ 2-ын "а"-д депутатуудын санал гаргасны дагуу депутат нь хуралдаан даргалагчаас үг хэлэх зөвшөөрөл авч, тойргийн дугаар, нэрээ хэлсний дараа үг хэлнэ гэдэг томъёоллоор орсон. Депутат нь хуралдаан даргалагчаас үг хэлэх зөвшөөрөл авч тойргийн дугаар, нэрээ хэлсний дараа үг хэлнэ.

б/ заалт бол хасагдсан юм байгаа юм. Ингээд в нь б болоод хэвээр. В заалт хэвээр, хуучнаар бол г юм. Бид олон тоогоор бичсэнийг үсгээр бичсэн. Эхний удаа долоо, хоёр дахь удаа д гэдгийн хоёр гэдгийг тоогоор биш, гурав дахь удаа гурван минут хүртэл, бүгд гурван удаа үг хэлж санал гаргаж болно гэсэн энэ редакцийн чанартай юм хийсэн.

Энэ хуучнаар бол д, шинээр бол г. Энэ дээр бол бид нэлээн ярьж ерөнхийдөө сүүлдээ ийм тохиролцоонд хүрсэн юм байгаа юм. Яагаад гэвэл энэнийг редакцад үлдээсэн л дээ. Депутат нь үг хэлэхдээ бусдыг доромжлох, гүтгэх гээд цаашаагаа байгаа юмыг редакц нэг бодоорой гэсэн. Тодорхой шийдэнд хүрээгүй байгаа. Уг нь доромжлох, гүтгэх нь Эрүүгийн хуультай л даа. Ерөөсөө хориглож л байгаа л даа. Манай бүгд найрамдах дээр байдаг шүү дээ. Тийм байгаа юм. Энд онцлон нэгэнт хэлж байгаа учраас

4.

энэ дээр хасъя гэсэн санал гараагүй. Гагцхүү өөрийн саналыг тул-
 гахаар хүч хэрэглэхийг бусдад уриалахыг гэдэг дээр бол янз
 янзын санал гарсан. Би хувьдаа энэнийг сайнтөсөөлж чадахгүй байгаа
 юм. Энэ үйлдлийг, өөрийн саналыг тулгахаар хүч хэрэглэхийг бусдад
 уриална гэж чухам ямар үйлдлийг хэлэх вэ гэдгийг ойлгохгүй байгаа
 юм. Тэгэхлээр бид нэлээн ярилцаж байгаад ийм томъёоллоор байвал
 яасан юм бол доо гэсэн. Депутат нь уг хэлэхдээ бусдыг доромжлох,
 гүтгэх, сүрдүүлэхийг хориглоно гэж. Энэ олон үгээр хэлж байгаа
 зүйлийг сүрдүүлэх гэдэг агуулга байгаа юм болов уу гэсэн ийм
 таамаглалаар редакцийн комисс депутат та бүхэнд толилуулж үзье.
 Ингээд биднийгээ дэмжих юм бол энэ хувилбараар үлдээвэл яасан
 юм бэ. Энэ бол арай илүү тодорхой юм гэсэн ийм бодолтой байна.

Энэ томъёолол дээр санал хураалгаж өгөхийг эрхэм даргаас
 хүсч байна. Депутат нь уг хэлэхдээ бусдыг доромжлох, гүтгэх,
 сүрдүүлэхийг хориглоно. Миний энэ хэлсэн томъёолол дээр санал
 хураалгаж өгнө үү.

Ж. Уртнасан:— За энэ дээр санал хураая.

Ардын Их Хурлын 422 дугаар тойргийн депутат Н. Төмөртоогоо:
 Энд ингэж хэлвэл яасан юм бэ? Депутат нь уг хэлэхдээ бусдыг
 доромжлох, гүтгэх, өөрийн саналыг бусдад тулгах, сүрдүүлэхийг
 хориглоно гэвэл.

Ардын Их Хурлын 426 дугаар тойргийн депутат Ж. Барамсай:
 —Тэгэхээр энэ дээр гол утга нь уриалах гэдэг үг байгаа юм.
 Бусдыг уриалах гэдэг тэр гол утга бол тэр сүрдүүлэхээс өөр.
 Тийм учраас энэ уриалах гэдэг үг бол хамгийн гол утга нь байх
 шиг байна гэж би бодоод байна. Сүрдүүлэх уриалах хоёр өөр шүү
 цээ. Өөрөөр хэлбэл миний саналыг дэмжиж өгөөд та нар тэг
 гэж уриална гэдэг бол сүрдүүлэхээс өөр.

С. Баяр:—Тэгэхлээр редакц бол нэлээн ярьсан л даа.
 Ер нь бол саналаа тулгана гэж чухам юуг хэлэх вэ? Бид бол
 түрүүн нээчихсэн байгаа шүү дээ. Цөөнх бол гурван удаа хэлж
 болно гэж. Үнэхээр тэр санал нь зөв санагдаад гурвын гурван удаа

босоод ингээд байхыг тулгана гэж үзэх үү. Яаж байна гэж үзэх вэ? Нөгөө талаар уриална гэдэг бол цаанаа шийтгэлтэй байж таармааргүй юм шиг санагдаж байна. Депутатууд өөрийнхөө боломжтой хэрэгсэл, юүгээрээ л яаж байгаа шүү дээ. Тэгэхдээ гүтгэх, доромжлох, сүрдүүлэхийг үнэхээр хориглоно гэж.

Ж. Уртнасан:—За энэ дээр хоёр хувилбар гарч ирлээ. Сүрдүүлэх гэдэг редакц хийсэн нэг хувилбар байна. Депутат Барамсайн хэлж байгаа тэр уриалах гэсэн ийм хоёр хувилбар, уриалах гэдэг үгийг заавал үлдээе гэсэн ийм санал гарч ирж байна. Энэ редакцийн шинэчилсэн хувилбар дээр санал хураалт явуулж байна.

За баярлалаа. Депутатуудын 77 хувь нь буюу 241 нь энэ найруулгыг үлдээе гэсэн санал ирүүлээ. 50 хүн татгалзаж, 3 хүн түдгэлзлээ.

С. Баяр:—За баярлалаа. II дүгээр зүйлийн хоёрдугаар хэсгийн ...

Ж. Уртнасан:—Уучлаарай! депутат нар аа! Энэ техник будилж байна уу, бид будилж байна уу гэдгийг шалгамаар байна. Дахин санал хураалт явуулъя. Энэ шинэ редакцаар санал хураалт явуулахад бэлтгэнэ үү.

Ардын Их Хурлын 326 дугаар тойргийн депутат Ж. Гомбожав: Тэгэхлээр энэнийг бид энэ цэгийн төслийг боловсруулахдаа ч их олон ярьсан байгаа юм. Тэгээд саналыг тулгахаар хүч хэрэглэхийг, бусдад уриалахыг гэдгийг энэ танхимд бодож хийсэн юм биш, өнгөрсөн жил ч бас хуралцааны үеэр зарим үед цухалзаж байсан. Одоо ч бас тийм байдал гарч магадгүй юм. Ер нь гудамж, талбайд, хэрвээ бидний энэ саналыг хүлээж авахгүй бол өлсгөлөн зарлана, цуглаан хийнэ, жагсаал хийнэ гэж бусдад уриалж болох юм. Ийм юм гарахгүй гэх баталгаа байхгүй учраас энэ үгийг оруулъя гэж ингэж л бид хийсэн юм байгаа юм.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

У. Баяр

БАЯРМАА

БИЧЭЭЧ Л. ХОРЛОО

-Ц.Элбэгдорж: -Энэ заалтыг бүхэлд нь хасах хэрэгтэй гэсэн санал гарч байсан. Яагаад гэхээр депутат хүн АИХ-ны үеэр хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээх ёсгүй гэсэн ийм зарчмаа барьж энийг бүхэлд нь хасах ёстой. Хэн гүтгэж байна, хэн доромжилж байна гэж, би доромжилж байна гэж үзэхэд нөгөө тал доромжлоогүй гэж үзнэ. Тийм учраас энийг бүхэлд нь хасах ёстой. Их Хурлын депутат Их Хурлын хуралдааны үеэр хэлсэн үгийнхээ төлөө хариуцлага хүлээх ёсгүй гэсэн үндсэн зарчмаа барих ёстой.

7 дугаар тойргийн депутат Ц.Балдорж: -Бид нар өчигдөр ярьчихсан юмаа дахин дахин яриад баймааргүй байна. Редакцийн ажлын хэсэг яаж байна гэхээр өчигдөр маргаж маргаж санал хураагаад тохирсон юмыг дахин шинэ томъёоллоор оруулж ирээд энийг ингээд задлаад байх юм бол дахиад өдөржингөө юм болно шүү дээ.

/кассетанд яриа давхардсан/

үгүй тэр сүрдүүлэх энэ тэр гээд шал огт яриагүй үг оруулж ирээд ингээд байхаар чинь ингээд дахиад өдөржингөө юм болно шүү дээ. Энийг л ингэмээргүй байна л даа.

Уртнасан:

-Хурлын хуралдаанаас өгсөн үүргийн дагуу редакци боловсруулаад оруулж ирж байгаа санаатай юм л даа. Буруу өгүүлбэр оруулсан байх л даа бодвол. Энэ дээрээ уучлалаа гуйж байна, редакци болбол дэгд редакци хийхээс биш батлах эрх бидэнд байхгүй. Батлах эрх нь бол Ардын Их Хурлын хуралдаанаараа л батлахаас өөр арга байхгүй.

Д.Ламжав: -Уучлаарай эрхэм депутатуудаа бид нар редакцийн гишүүний хувьд хэлж байна. Тэгэхээр энд бол бид нар өөрснөө бас хууль зөрчих эрхгүй учраас хуулинд баригдаад л одоо иймэрхүү юм болоод байгаа шүү. Ийм юм их цөөхөн байгаа гэдгийг хэлье. Цааш нь их засвар хийчихсэн байх гэж битгий бодоорой. Ийм л юм хэлэх гэсэн юм.

Уртнасан:

-II-р зүйлийн 2-ын хуучнаар бол Е км.Одоо бол Д заалт. Ийм томъёоллоор батлагдсан байгаа.Хэлэлцэх асуудлын онцлог байдлыг харгалзаж АИХ-ын удирдлага шаардлагатай гэж үзвэл саналыг депутатуудын нэрийн жагсаалтаар авч болно.За цаашаа яваад засвар байхгүй км байна.Е дээр хуучнаар бол Ж км байна. Депутатуудын ердийн олонхи гэдэг хасагдсан шүү дээ олонхийн саналаар.Тэгээд АИХ-ын удирдлага шаардлагатай гэж үзвэл гэдэг томъёоллоор сүүлд нь батлагдсан.За Ж энэ бол хуучнаар З заалт км.Энэ бол ийм томъёоллоор орсон шүү.Депутатууд хуралдаанд хэлэлцэх асуудлын хүрээнд тодорхой асуудлаар тусгайлан санал хураалгах буюу хэлэлцүүлэг хийлгэх санал гаргавал түүнийг депутатуудын ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

И заалт хэвээрээ,К заалт хэвээрээ,Л заалтан дээр ийм томъёоллоор оруулсан.Хуучин дугаараар нь хэлээд яв л даа,энэ дээрээ бол дугаар хөөгөөд өөр өөр юутай болчихсон байгаа.Хуралдааны үед иргэд , байгууллага хамт олноос АИХ-д ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, бусад асуудлыг АИХ-ын удирдлага, депутатуудад зарлан сонгоно.Тэгэхлээр өргөдөл гэдэг дээр санал хураах санал хураагаагүй, редакци бол өргөдөл гэдгийг өргөх бичиг гэж томъёолвол яасан км бэ, өргөдлөөс арай илүү түгээмэл утгатай км болов уу.гэсэн ийм юутай л оруулж байгаа км. Тухай бүрт гэдгийг бол хасах , редакци дээр хассан байгаа км. Яагаад гэвэл тухай бүрт гэдэг бол ажлын боломж бололцоо байхгүй л дээ.Ирсэн болбол даруйд нь танилцуулаад байх боломж бидэнд байхгүй.Тэгэхлээр АИХ-ын удирдлага депутатуудад зарлан сонгоно гэхэд бол АИХ-ын удирдлагатай энэ асуудлыг ерөнхийдөө мэдэлд үлдээж байгаа км.Цаашаа М заалт бол хэвээрээ, Н заалт бол хасагдсан.II-р зүйлийн 3 дугаар хэсэг хэвээр үлдсэн.1 дүгээр бүлгийн хувьд бол ийм байна.2-р бүлэг нэгэнт 5 дугаар зүйл 2 хуваагдсан учраас 2 дугаар бүлэг маань 12 дугаар зүйл гэж эхэлж байгаа.Монгол улсын Их цаазын төслийг хянан хэлэлцэх, батлах журам,1-р хэсэгт засвар алга, хуучин 2 дугаар хэсэг хасагдсан.3-р хэсгээ бид бол редакцийн засвар хийгээд А,Б хэсгийг нь болиод Монгол улсын Их цаазын төслийн хэлэлцүүлэг нь анхны, эцсийн гэсэн 2 үе шаттай байна гэсэн томъёоллоор оруулж ирж байгаа км.4 дүгээр хэсэг бол хэвээрээ,4 дүгээр хэсгийн дээд хэсгийг хэлж байгаа км л даа. А бол хэвээрээ, тэр дээд өгүүлбэрийг хэлж байгаа км л даа.

Б-д энд нэг хэдэн үг оруулсан.Энэ Хэдэн үгийг хассан байна, энийг редакцид бас үлдээсэн юм.65 %-иар шийдээд, редакцияад нэг ороод ирээч ээ гэсэн бид бол сүрхий редакторласан юмгүй зүгээр тэр илтгэл, Их цаазын төслийг боловсруулах болсон шалтгаан , боловсруулсан явц гэсэн ийм үгнүүдийг хасаад ерөнхий гол санааг нь үлдээсэн.Тэрнийг уншиж танилцуулахад илтгэл, Их цаазын төслийн зарчмын гол гол үндэслэл боловсруулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээ, ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, хуулийн зохицуулалтаас үүсч гарах нийгэм эдийн засаг, хууль зүйн үр дагаврыг хураангуйлан тодорхойлж танилцуулна гэсэн ийм томъёоллоор оруулж ирж байгаа юм.В заалт бол хэвээрээ юм.Г заалтан дээр депутатуудын саналаар зарим засвар хийсэн.Асуулт, хариултыг тогтсоны дараа Их цаазын төслийн талаар АИХ-ын депутатууд ерөнхий санал солилцож гэж 3 үг нэмсэн.Тэгээд цааш нь бол бүлэг, зүйл, хэсэг тус бүр дээр үг хэлж санал гаргана.Депутатууд үг хэлж санал гаргахдаа энэхүү дэгийн II дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан журам хугацааг баримтлана гэж ингэж оруулсан байгаа.Хугацаанаас гадна бас журам байгаа л даа.Тэрнийг бодолцох гэж тэгж хийсэн юм.Тайлбар дээр бол засвар байхгүй.Д заалт бол хэвээрээ.Е заалтан дээр бол ийм редакциятай болсон.Депутатууд үг хэлж санал гаргаж дууссаны хаалтан дотор санал шүүмжлэлийг тасалсны дараа бүлэг, зүйл тус бүрээр хэлэлцэж гэж орсон шүү.Саналын зөрүүтэй зарчмын асуудал бүрээр санал хураана.Тэгэхдээ саналын зөрүүтэй зарчмын асуудлыг депутатуудын гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ гэсэн ийм шинэ редакцияар оруулж байгаа.Энэ бол та нөхдөд тараасан дэг дээр техникийн алдаа гараад Е-гийн дараа И гээд орчихсон, энэ маань Ж юм байгаа шүү дээ.Энэ бол хэвээрээ,за 3,АИХ, Их цаазын төслийг зарчмын асуудлаар гэж нэмж оруулсан, бүхэлд нь зөвшөөрсөн нөхцөлд зохих саналын дагуу уг төслийг найруулан засч түүнийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий депутатуудын хороог ажлын хэсэгтэй байгуулж ажиллуулна гэж оруулсан,тэр 2 дугаар өмүлбөр нь хасагдсан.За 12 дугаар зүйлийн 5, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэж оруулах хянан хэлэлцэхэд дор дурдсан журмыг баримтлана гээд явж байгаа.За энэ А дээр бол тэр ажлын хэсэг гэдгийн оронд депутатуудын хороо гэж санал хураагаад олонхи авсан учраас ингэж орж байгаа юм.Б,В 2 бол хасагдсан.

Тэгэхлээр Г маань Б болж байгаа юм. За энийг шинэ редакциар оруулж байгаа. Депутатын хороо, түүний хэсгийн ажлын хэсгийг боловсруулж эцсийн хэлэлцүүлэгт оруулж байгаа Их цаазын төслийг бүлэг, зүйл, хэсэг тус бүрээр хэлэлцэж шаардлагатай гэж үзвэл нэрээр санал хурааж батална. Ийнхүү хэлэлцэхдээ энэхүү дэгийн II -р зүйлийн 2 дахь хэсэгт заасан журам, хугацааг баримтлана гэдэг ийм томъёоллоор орчихлоо. Энэ ажлын хэсэг анхаараарай энэ А, Б гээд хуучин Д дугаар нь явж байна шүү. А, Б, В шүү. Хуучнаар бол Д юм. Энэ дээр ийм засвар орсон. Депутатын хороо түүний ажлын хэсгээс Их цаазын төслийг эцэслэн боловсруулж хэлэлцүүлэхээр оруулах хугацааг төслийн боловсруулалтын түүний саналын зөрүүтэй асуудлын шинж байдал, ажлын хэмжээ

шаардлагыг харгалзан хэлэлцэж тогтооно. Хуралдаан даргалагч гэдгийн оронд хуралдаан даргалагчийг хассан байгаа шүү дээ. хэлэлцэж тогтооно гэж орж байгаа. За II-р зүйлийн 6 дугаар хэсэг энэ дээр редакцийн засвар нөгөө Үндсэн хуулийн нэмэлт гэдгийн оронд их цаазын хавсралт гэж орж байгаа. Хуучин 7 хасагдсан шүү. 7 дугаар хэсэг. 12 дугаар зүйл дээр хэвээрээ галцхүү тэр нэгэнт дугаар нааш цааш хөдөлсөн учраас энэхүү дэгийн 10 биш II дүгээр зүйлд заасан нийтлэг журмыг баримтлана гэсэн редакцийн засвартай. За 13 дугаар зүйл, энэ дээр ерөнхийдөө хэвээрээ байгаа юм. Зүгээр I дүгээр хэсэгт нь нэмж сонгож болно гэсэн, сонгон байгуулж болно гэж ийм засвар орж байгаа юм. 13 дугаар зүйл дээр өөр засвар алга. 14 дүгээр зүйл, энэ редакцийн хэсгээс анхаарах хэрэгтэй юм байна. 12 дугаар зүйл 2 удаа явж байна шүү, бидний хувьд. 3 дугаар бүлэг, 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлд шинээр бол 16 дугаар зүйл бол хэвээр үлдсэн. Хууль бусад шийдвэрийг нийтлэх энэ дээр редакцийн хэсгээс зарчмын гэх үү тийм санал Их Хурлын депутатуудад оруулж байна. Юу гэхлээр бол АИХ-ын хууль бусад шийдвэрийг нийтлэх журмаа бол энд бид үлдээе. Галцхүү Их цаазыг нийтлэхдээ хэний гарын үсэгтэй нийтлэх вэ, ер нь хэн батламжлах вэ яах вэ гэдэг асуудлыг Үндсэн хуулинд хэлэлцэх явцдаа Үндсэн хуулиндаа юмуу, Их цаазын хавсралт хуулинд тусгах нь илүү зохимжтой юм уу гэж үзсэн. Энэ талаар депутатуудын санал гарсан, тухайлбал депутат Цогийн саналыг бол бид нэлээн үндэстэй юм гэж үзэж байгаа. Яагаад гэвэл шинэ Үндсэн хууль хүчин төгөлдөр болохлээр хуучин маань одоо хүчингүй

болно. Тэгээд байгаа үндсэн хуулинд а ч гэсэн нэмэлтэн дотор Их цааз ер нь Үндсэн хуулийг батламжлах тухай асуудал огтхон ч заагаагүй. Тийм учраас энэ хууль зүйн шинэ зохицуулалтыг шаардаж байгаа асуудал юм. Энэ асуудлыг дэгийн хэмжээнд зохицуулах нь арай томдох болов уу, ийм учраас Үндсэн хуулиа хэлэлцэхдээ хэлэлцээ. Тэр Их цаазыг нийтлэх үед хэн гарын үсэг зурах вэ гэдэг асуудлыг тухайн үед нь яриад бусад зүйлийг нь энд нь үлдээе гэж ингэж бид ярилцаад энэ саналаа та нөхдөд одоо сонордуулж байгаа юм. Тэгэхээр 16 дугаар зүйлийн I дүгээр хэсэг бол ийм найрлагатай болсон. АИХ-ын баталсан хууль тогтоол, бусад шийдвэрийг АИХ-ын даргын гарын үсэгтэйгээр нийтлэнэ. I дүгээр хэсэг нь ер нь ийм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ш.Бурмаа

Ш.БУРМАА

1991.XI.13.
Кассет 73
9.45-10.00

I дүгээр тойргийн депутат С.Баяр: ...2 дугаар хэсэг нь хэвээр, 3 дугаар хэсэг нь бид нэлээн ярилцсан юм.Ардын Их Хурлын хуралдааны дэгд бол аппаратын ерөнхий нарийн бичгийн дарга гарын үсэг зурна гэж байгаа.Тэгэхээр энэ бол үнэхээр Ардын Их Хурлаас гаргаж байгаа албан ёсны бичиг баримт, тэгэх тусмаа нийтлэхэд Ардын Их Хурлын депутат бус хүн.Тэгээд ч бид энэ хүнийг албан ёсоор Ардын Их Хурлаасаа ерөнхий нарийн бичгийн дарга болгож хараахан сонгоогүй байгаа, томилоогүй байгаа.

Ер нь Ардын Их Хурлын хуралдааны тогтоол, протоколд Ардын Их Хурлын дарга, орлогч дарга нар гарын үсэг зурж гаргаж байх нь илүү зохимжтой юм болов уу гэж санасан. Нэг хүнийхээр гарч таарахгүй.Нэгэнт бид дарга, орлогч дарга нарыгаа сонгосон, нийтлэхдээ бол энэ 5 хүний гарын үсэгтэй гарч байх нь илүү зохимжтой юм болов уу гэж бодоод ийм томъёол-лоор оруулж байна.

Ж.Уртнасан: -Та бидний даалгаврыг амжилттай бие-
лүүлж депутат нөхдийн гаргасан саналыг дэгийг эцэслэн боловс-
руулахад тусгаж хүч хөдөлмөрөө дайчлан ажилласан ажлын хэс-
гийн нөхдүүдэд та бүгдийн нэрийн өмнөөс талархал дэвшүүлж,
ажлаа гүйцэтгэлээ гэж бодож байна. Ингээд дэгийг батлах
санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэнэ үү.

Дэгийг зүйл тус бүрээр дахиж хэлэлцэхгүйгээр бөөнөөр нь
батлах санал оруулж байна. Зөвшөөрөх үү?

132 дугаар тойргийн депутат С.Чулунбаатар: -Одоо
саналаа хураамаар байх юм, дарга аа.

Ж.Уртнасан: -Олонх энэ саналыг дэмжиж байна.
БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоол. 1991 оны II дүгээр сарын
13-ны өдөр. Хуралдааны дэгийг батлах тухай. БНМАУ-ын Ардын
Их Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Ардын Их Хурлын II хуралдааны дэгийг хавсралт
ёсоор баталсугай гэсэн тогтоолыг батлуулахаар оруулж байна.

Санал хураалт явуулъя, санал хураалтад бэлтгэнэ үү.

Санал өгсөн депутатуудын 94 хувь нь буюу 593 хүн дэгийг баталж байна. 19 хүн буюу 5 хувь нь татгалзаж, 4 хувь нь тудгэлзэж байна. Та бид хуралдааныхаа дэгийг баталлаа. Одоо ингээд эцсийн засвар хийсний дагуу олшруулан хувилж та бүгдэд тараана.

Депутат Дашбалбарт уг хэлэх зөвшөөрөл олгоё.

10 дугаар тойргийн депутат О. Дашбалбар: -10-ны өдрийн хөдөлмөрчдийн цуглаанаас Ардын Их Хуралд өргөн мэдүүлэх энэ бичгийг намайг гардуулж өгөөрэй гэж өгсөн, та нар мэдэж байгаа, би энийг уншъя.

БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит II хуралдаанд өргөн мэдүүлэх нь:

Бүх ард түмнээс хууль ёсоор сонгогдсон БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат нөхөд өө!

Та бүхэнд эх орон, ард түмнийхээ хувь заяаг шийдвэрлэх эгзэгтэй, түүхэн хариуцлагатай цаг мөч тулж ирлээ. Иймд Ардын Их Хурлын хуралдааны үйл ажиллагаанд амжилт хүсэхийн ялдамд улс орныхоо Үндсэн хуулийг батлах онцгой хариуцлага хүлээж буй та бүхэнд хандан доорх саналыг толилуулья. Үүнд:

1. Хуралдаанаар Үндсэн хуулийг төслийг хэлэлцэхээс өмнө Улсын Бага Хурал, Засгийн газрын тайланг нухацтай хэлэлцэх.

2. Хууль тогтоох нэн хариуцлагатай үүргээ хангалтгүй биелүүлж байгаа Улсын Бага Хурлын бүрэлдэхүүнийг шинэчлэх.

3. Бодлого, үйл ажиллагаа нь ард түмний олонхийн итгэлийг алдагдуулж, үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон Засгийн газрын үйл ажиллагааг зогсоож, ард түмний язгуур эрх ашигт зохицсон нийгэм, эдийн засгийн бодлого явуулж чадахуйц шинэ Засгийн газрыг эмхлэн байгуулах. Эл учир нь монголын дотоод хэрэгт хилийн чанадаас хэт оролцох замыг нээж эх орон, ард түмний язгуур эрх ашигт зохицохгүй санаа бодлоо тулгаж байгаа Засгийн газрын алдаатай бодлого, шийдвэрүүдийн нө. өгөөр сүүлийн жил

гаруйхан хугацаанд ард түмний аж амьдрал эрс доройтож, эдийн засгийн тусгаар тогтнол алдагдах аюул тулгарч үе уламжилсан монгол төрийн бодлого алдагдаж, монгол улс ард түмнийхээ хүчинд тулгуурлан хөгжих гол зам хаагдаж хууль ёсыг зөрчиж нийгмийн эмх замбараагүй байдал ердийн үзэгдэл болсонд сэтгэл гүнээ эмзэглэж байна.

Улс орны валютын сан хөмрөг хөөсөрч, шударга хөдөлмөрийн үнэ цэнэ алдагдаж, амар хялбар аргаар баяжих гэсэн явуургүй бодлого бүхий этгүүдүүд улс орны мөхлийн ирмэг рүү түлхэж байна. Энэ бүхний эсрэг тодорхой арга хэмжээг төр, засгийн зүгээс авч хэрэгжүүлэхийн оронд тэдэнд ая тал засан өөгшүүлж дэмжиж буй нь Улсын Бага Хурал, Засгийн газарт итгэхгүйн бодит шалтгаан болж байна.

4. Үндсэн хуулийн төсөл хэлэлцэхдээ сонгогчдын дийлэнх олонхийн санал бодлыг үндэслэн доорх нийтлэг саналыг харгалзан үзэхийг хичээнгүйлэн хүсье. Үүнд:

-Үндсэн хууль хэмээх уламжлалт нэрийг хэвээр үлдээх. БНМАУ-ын төрийн сүлдийг хэвээр хадгалах, сүлд, дууллын үг, аянг өөрчлөхгүй байх. БНМАУ нэрийг хэвээр үлдээх. Улс орон, ард түмний хувь заяаг шийдвэрлэх шилжилтийн үед төрийн эртний сонгодог уламжлалаа болгоож Ерөнхийлөгчийн засаглал тогтоох. Ерөнхийлөгчийг бүх ард түмнээр шууд сонгуулах. Үндсэн хуульд БНМАУ-д гаднаас цагаач, дүрвэгсдийг цөөн тоогоор боловч авахгүй байхыг тусгах.

Мөн газар улсын өмч байсан Үндсэн хуулийн хуучин заалтыг хэвээр үлдээх. Монголын ард түмэн хагас мянган жил шүтэж биширч, тэдний ахуй амьдрал, зан суртахуун, соёл иргэншил, оюун санаанд арилшгүй ул мөрөө үлдээсэн бурхны шашныг төрийн шашин хэмээн батлах. Эдгээр саналыг нийт ард түмний эрх ашигт олонхийн хүсэл эрмэлзэл гэдгийг болгоон тунгааж ёсоор болгоно гэдэгт та бүхэнд гүнээ итгэж байна.

Гадаадын улс орнуудтай харилцан ашигтай хамтран ажиллаж, тэдний дэмжлэг тусламжийг оновчтой ашиглан өөрчлөн байгуулалт,

4.

ардчилал, шударга ёсыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхийн төлөө байна.

Зах зээлд шилжих үед зайлшгүй гарах бодит бэрхшээлийг ухамсарлаж, түүнийг туулж гарах тэсвэр тэвчээр, амьдралын ухаан ард түмэнд бий. Харин зохиомол бэрхшээл, үндэсний эрх ашгийг гажуудуулсан бодлогыг бид эсэргүүцэж байна. Ардын Их Хурлын хуралдаанд тус холбоодын төлөөлөгчдийг ажиглагчаар оролцуулах, шаардлагатай үед хэлцэл хийхийг хүсч байна. Монголын автотээвэрчдийн холбоо, Ажилчдын нэгдсэн холбоо, Барилгачдын холбоо, Багш нарын холбоо, Нийтийн ахуй үйлчилгээний ажилтан, ажилчдын холбоо, Худалдаа, нийтийн хоолны ажилтан, ажилчдын холбоо, Холбоочдын эвлэл, Монголын тусгаар тогтнолыг хамгаалах ард түмний 281-ийн холбоо, Монгол ухаан төв, 1991 оны II дүгээр сарын 10. Улаанбаатар хот. Ийм өргөн барих бичиг байгаа юм. Хүссэн ёсоор би та бүхэнд уншиж танилцууллаа. Ингээд Их Хурлын даргад гардуулъя.

Ж.Уртнасан: -Бид хурлын дэгтэй боллоо.Ийм учраас бид дэгийнхээ дагуу ажиллах шаардлагатай болсон гэдгийг депутат нөхөд маань ойлгож байгаа байх.Одоо бид хэлэлцэх асуудлынхаа дагуу, дэгийнхээ дагуу энэ Их Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудал, төлөвлөгөө, дотоод журмыг хэлэлцэж эхэлье. Энэ төлөвлөгөө, дотоод журмыг та бүхэнд тараасан учраас дахин уншиж сонгох хэрэггүй гэж бодож байна.Энэ төлөвлөгөө, дотоод журмын талаар депутатуудын саналыг сонсьё.

39 дүгээр тойргийн депутат Д.Ламжав: -Саян өргөх бичиг барьсантай холбогдуулж би зарим нэг тодруулах асуулт тавимаар байх юм.Би асуулт тавиад хариулт авна, өөр хэлэлцэх юм надад байхгүй.

Ж.Уртнасан: -Уучлаарай, эрхэм депутатууд аа. Хэрвээ бид асуулт, хариулт явуулаад эхэлбэл үүнийг хэлэлцэж эхэлсэнд тооцогдох юм.Ийм учраас бид асуулт, хариултыг депутат дашбалбартай ярьж болох юм.Энэ бол сонордуулах бичиг.

Хэлэлцэх асуудал, дотоод журмаа шууд хэлэлцэж эхэлбэ. Та бүгдийн гар дээр байж байгаа, энийгээ анхааралтай судалж үзсэн байх. Одоо энэнийхээ талаар ярилцаж саналаа солилцье.

406 дугаар тойргийн депутат Ч.Тэрбиш: -Хэнтий аймгийн хэсэг депутатууд хурлын ажлын комиссоор дамжуулж хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал толилуулсан юм. Хэрвээ тэр санал тань дээр байгаа бол тэрийг уншаад танилцуулж өгнө үү. Байхгүй бол би эндээс хэлэх үү?

Бидний санал ийм байгаа юм. Энэ хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний 4 дүгээрт байгаа Монгол улсын Их цаазын төслийг хэлэлцэх асуудлыг хойш нь оруулж 8 дугаарт оруулъя. Хэлэлцэх асуудлын хамгийн эхэнд БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагаа, дотоод, гадаад бодлого, үндсэн асуудлыг хэлэлцье. Энэ дээр диллэрүүдийн үйл ажиллагааг шалгасан Засгийн газрын комиссын дэлгэрэнгүй мэдээллийг хамт авч хэлэлцье. Тэгээд бусдыг дарааллаар нь явъя гэж байгаа. Яагаад вэ гэхээр, өнгөрсөн жил бид засаг, төрийн тогтолцоог шинээр байгуулсан. Энэ засаг, төрийн тогтолцоо маань ямаршуу ажиллаж байгаа юм, цаашид ямар хэлбэрээр ажиллуулах хэрэгтэй юм. Энэндээ үнэлэлт, дүгнэлт өгөөд тэрнийхээ дараа Их цаазын төсөлд саналаа оруулахад бас хэрэгтэй болов уу гэж бодож байгаа юм.

Тэгэхээр Засгийн газрын үйл ажиллагааг хэлэлцэх явц дунд Бага Хурлын шийдвэртэй холбогдсон асуудлууд гарч ирэх байх. Тийм учраас Засгийн газрын үйл ажиллагаа бол хамгийн түрүүнд хэлэлцэгдэх нь зүйтэй юм болов уу гэсэн ийм санал оруулсан юм.

27 дугаар тойргийн депутат Л.Цүрэвдорж:

Ж.Уртнасан: -Цүрэвдорж гуай, 6 дугаар микрофонд зөвшөөрөл өгсөн.


420 дугаар тойргийн депутат Д.Томбожав: -Хэлэлцэх асуудлын дарааллаар энэ төслийг хэвээр батлах саналтай байна. Засгийн газрын болон Бага Хурлын тайланг эхлээд хэлэлцэх юм бол асуудал ихээхэн ээдрээтэй болно. Бидний өнөө-

гийн зорилго бол Үндсэн хуулиа хэлэлцэж батлах нэгэн гол зорилго байгаа. Ийм учраас энэ асуудлыг Үндсэн хуулиа урьдаар хэлэлцэж баталъя. Энүүнд нотолгоо бий. Энийг эрхэм депутатууд ойлгож байгаа байх.

Гэхдээ Засгийн газрын болон Бага Хурлын тайлан хэлэлцэх асуудалд би өөрөөр хандах гэсэн асуудал биш ээ. Үндсэн хуулиа эрхэмлэж байгаа юм.

27 дугаар тойргийн депутат Д. Цүрэвдорж: -Нэг үндэслэл хэлье гэж бодож байна. Их цаазынхаа төслийг эхэлж хэлэлцэх нэг үндэслэлийг би хэлье. Магаад гэвэл, Их цааз бол Улсын Бага Хурлын нэг жилийн дотор хийсэн ажлын зонхилох нэг чухал асуудал нь юм. Тийм учраас Үндсэн хуулийнхаа төслийг хэлэлцээд Улсын Бага Хурал энэ Үндсэн хуулийг хэр зэрэг боловсруулсан, Улсын Бага Хурлын байгуулсан комисс хэр зэрэг ажиллаж, Улсын Бага Хурал хоёр удаа хэлэлцэж, яаж боловсруулж, ямархуу янзын ийм Их цаазын төслийг оруулж ирж вэ гэдгийг хэлэлцэж борлуулаад энийгээ Улсын Бага Хурлын тайланг хэлэлцэхдээ энэ Их цаазыг хэр зэрэг боловсруулсан бэ гэдгийг нийлүүлж Улсын Бага Хурлынхаа ажилд дүгнэлт өгөх ёстой гэж бодож байна. Ийм учраас Их цаазынхаа төслийг I дүгээрт хэлэлцье. Их цаазын улс төрийн учир холбогдлыг түрүүн хүн хэлчихлээ, би тийм учраас давтахгүй.

Соронзон хальстай тулгаж нийлсэн



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.ОЮУНЧИМЭГ

261 дүгээр тойргийн депутат Пүрэв -Хэлэлцэх асуудлын талаар ийм санал байна.Нэгдүгээрт,Их цаазын буюу Үндсэн хуулийн төслийг эхэлж хэлэлцэх нь зүйтэй юмаа.Яагаад гэвэл бид ард түмнээ хүндэтгэх хэрэгтэй юм.Төрт ёсоо дээдэлж,бэлэг дэм-бэрэлтийг бодож энэ асуудлыг нэгдүгээрт хэлэлцэх их ач холбог-долтой байх аа.Хоёрдугаарт Улсын бага хурлын тайланг эхлэн хэлэлцвэл Их хурлын уур амьсгал дотор нэг зүйл цухалзаж бай-гаа нь юу вэ гэхлээр Бага хуралд еөрчлөлт хийх асуудал юмаа.Тэгэхлээр хэрэв ийм байдалд бид эхлэн Бага хурлын тайланг хэлэлцэхэд хүрчих юм бол Их цаазын төслийг өргөн барьж байгаа энэ субъект бүрэлдэхүүний хувьд алга болж их еөрчлөлт гарвал бид энэ хуулийг хэлэлцэж батлах боломж нэлээд хаагдах хүрээнд бэрхшээл учирна гэж бодож байна.Гуравдугаарт Засгийн газрын тайланг эхлэн хэлэлцэх боломж өнөөдөртөө бүрдээгүй байна гэж үзэж байна.Яагаад гэвэл Засгийн газрын тайланг хэлэлцэхэд алт,валютын асуудал хөндөгдөх нь гарцаагүй.Үүнийг хөндөж яри-хад хүрвэл сая Улсын бага хурлаар авч хэлэлцээд Бага хурлаас парламентын комисс байгуулсан.Энэ комисс бол энэ алт,валютын асуудлаар еөрийн дүгнэлтийг хийж үүнийг Их Хуралд мэдээжээр сонсох ёстой.Энэ бол бэлэн болоогүй байна гэж бодож байна.

Ер нь уУлсын бага хурал,Засгийн газрыг сонсож түүний үйл аялгаанд үнэлэлт дүгнэлт өгөх,еөрчлөх,шинэчлөх энэ эрх мэдэл бол Их хуралд нээлттэй байгааг харгалзаж үзнэ үү гэж бодож байна.

Уртнасан - Депутат нөхөд өө, Олонхи нь энэ танхимын олонхи депутат санал хураая гэсэн саналтай байх шиг байна.Тийм учраас санал хурааж үзье.Энэ хэлэлцүүлгийг,депутатуудын саналыг авъя,эсвэл санал хураая гэсэн ийм хоёр санал байгаа юм.Тэгэхлээр шууд санал хураалт явуулъя гэсэн

-Энэ дараалал буруу байна.Өөр санал байна.Үүнийг зөвшөөрч байна уу үгүй юу гэдэг дээр санал хураая.

Уртнасан -Бид санал хураалт явуулахын өмнө дарааллаа ярьж эхэлнэ.Одоо шууд санал хураах уу,үгүй юу гэдэг дээр санал хураая.Санал хураалтанд бэлтгэнэ үү.

-Их хурлын даргаа та асуудлаа ярилцах хэрэгтэй шүү дээ.Та асуудлаа тулган хүлээлтэй болохгүй л дээ.

-Энэ дээр чинь зарчмын асуудал байна л даа. Зөвшөөрлөө хэлье.

Уртнасан -Уучлаарай.Одоо дэгийнхээ дагуу ажиллана.Олонхийн саналыг хүндэтгэхийг хүсч байна.

-Энэ бол хэлэхгүй бол болохгүй асуудал юм л даа. Ингээд байх юм бол бид хуралд оролцох шаардлага байх юмуу үгүй юу.Асуудлаа ярих хэрэгтэй шүү дээ.Бид чинь асуудлаа чөлөөтэй ярилцана гээд хүн 3 удаа уг хэлэх эрх олгочихсон байгаа.Үүнийгээ эдлэхгүй юм бол,би эрхийнхээ дагуу уг хэлэхийг зөвшөөрч байна.Тэгэхгүй бол энэ чинь тэндээс гарсан саналыг санал хураагаад байх юм бол бид чинь яаж ажлаа явуулах юм бэ. Тийм учраас би уг хэлэхийг Их хурлын дарга зөвшөөрч байна уу.

Уртнасан -Нэгийн нэгдүгээр зүйлийг бид баримталж байна. Олонхийн саналаар санал хураалт явуулж байна.

-Энэ зарчмын асуудал юм л даа.Энэ чинь.Баталчихаад ярина гэж байхгүй шүү дээ.Эхлээд санал хураахын өмнө л ярина уу гэхээс биш.Тийм биз дээ.

Уртнасан -Олонхи депутатууд санал хураалгахыг шаардаж байгаа учраас депутатууд санал хураалтанд бэлтгэнэ үү. Бид шууд энэ дэгийнхээ дарааллаар санал хураалт явуулна. Одоо бид саналаа хураая.Одоо энэ нэг дотоод журмынхаа дарааллыг хэлэлцээ гэдэг дээр санал хураалт явуулах гэж байна.Үүнийг зөвшөөрвөл бид дарааллаа ярьж эхэлнэ.Хэлэлцэх асуудлын дарааллыг,нэрээ ч тогтох асуудал ярина.

—Хэлэлцэх асуудлаа ярьж байж дарааллаар хэлэлцмээр юм.

Уртнасан —Энэ төлөвлөгөөнд туссан 3 асуудлыг та бид хэлэлцсэн. БНМАУ-ын АИХ-ын зарим депутатуудын эрхийн тухай Жаргал гуай илтгэлээ тавьчихсан. Бид БНМАУ-ын АИХ-ын дарга, орлогч дарга нарыг сонгочихсон. АИХ-ын II хуралдааны дэгийг хэлэлцээд баталчихлаа. Одоо бид хэрвээ үүнийг мөрдөхөөр бол БНМАУ-ын Их цаазын төслийг хэлэлцэж эхлэх учиртай. Энэ дээрээ бид юуны өмнө энд заагдсан, энэ дээр бичсэн нэр томъёог бид зөвшөөрч байгаа бол энэ дарааллаа ярьж эхлэх учиртай юм. Ийм учраас юуны өмнө та бүгдээс төлөвлөгөө, дотоод журман дээр бичигдсэн ерөнхий зүйлийг зарчмын хувьд зөвшөөрөх үү гэдэг дээр санал хураалт явуулж байна. Санал хураалтанд бэлтгөө. Ер нь энэ дээр хэлэлцсэн зүйлийн талаар санал хураалт явуулж байна. Өөрөөр хэлбэл бид хэлэлцэх асуудлаа баталчихъя. Хэлэлцэх асуудал, дотоод журмаа баталчихъя. Дараа нь бид дарааллаа ярья.

Одоо хэлэлцэх асуудлаа батлая гэсэн санал хураалт явуулж байна. Бид хэлэлцэх асуудлыг баталлаа. Санал өгсөн депутатуудын 374 депутат буюу 91 хувь нь дотоод журмыг баталж байна. Татгалзсан хүн 32, хувь 8, түдгэлзсэн 6 хүн байна, 1 хувь юм. Одоо бид хоёрдахь санал хураалт явуулахыг та бүхнээс хүсч байна. Энэ манай хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журман дээр бичигдсэн дарааллын дагуу Их хурал хуралдаж асуудлаа хэлэлцээ гэдэг дээр санал хураалт явуулах саналтай байна. Яагаад гэвэл сая хэд хэдэн депутатууд хэллээ. Энэ дээр бичигдсэн дарааллын дагуу явуулъя гэж. Хоёрдахь хувилбар бол Засгийн газрын ба Бага хурлын тайлан хэлэлцээ гэсэн хувилбар орж ирж байгаа юм. Энд бидэнд нэгэнт тараасан эх материал энэ байгаа учраас үүний дагуу санал хураалт явуулъя гэж бодож байна. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журмын дагуу энэ дээр бичигдсэн дэс дарааллын дагуу асуудлаа хэлэлцээ гэдэг дээр санал хураалт явуулах гэж байна. За санал хураалтанд бэлтгэнэ үү.

За баярлалаа, санал өгсөн депутатуудын 84 хувь буюу 346 хүн манай хурлын хэлэлцэх асуудал, төлөвлөгөө, дотоод журмыг энд бичиж та бидэнд тараасан энэ эхээр явуулъя гэж байна. Татгалзсан хүн 15 хувь буюу 60 хүн татгалзаж байна.

2 хувь буюу 7 хүн түдгэлзэж байна.

180 дугаар тойргийн депутат Жумшанбаатар -Энэ дэс дарааллыг зөвшөөрч байна.Би ечигдөр санал өгсөн байгаа.Бид бол дээврийнхээ биш дэлхийнхээ хэмжээгээр сэтгэмээр байна. Энд юу бодмоор байна вэ гэхлээр зэрэг дэлхий улс түмэнд энэ чухал шинэчлэлтийн үед одоо ёстой жинхэнэ хөх Монголынхоо дуу хоолойг сонсгосон уриалга гаргаж өгвөл ямар байна вэ. Үнэхээр тэр улс түмнүүд яаж хүлээж авах гэдэг нь энэнээс их хамаарна.Нэгдүгээр дотор ийм нэг асуудал байгаа юм.Ер нь бусдын зовлон гэж байхгүй.Ийм учраас дэлхийд дахин санаа зовнисон,бид бол цаг хугацаа орон зайны хязгаарлагдмал байдалд, байгалийн харь гариг энэ төрийн юу ч мэдэхгүй нөхцөлд бид амь зууж байна аа.Ийм учраас нэг сайхан ухаалаг уриалга гаргамаар байгаа юм.Хоёрдугаарт нь бид ард түмэндээ тайлбар өгмөөр байна.Бид ийм том Үндсэн хууль баталчихаад энэ дагуугаа ард түмэндээ тайлбар өгөх юм бол бид бас засаг төр маань ажлаа явуулахад Их хурал ингэж шийдвэр гаргалаа,ийм чиглэл өглөө гэдэг ийм ойлголт өгвөл засаг,төр маань ажлаа явуулахад их хэрэгтэй болов уу гэж бодож байна.Ийм учраас энэ ажил хөнгөн хялбар бишээ.Иймд комисс гаргаж энэ хоёр асуудалд хандуулбал ямар вэ гэсэн санал байгаа юмаа.Дэс дарааллын хувьд бол зөв л дөө.

149 дүгээр тойргийн депутат Анигар -Би нэг юм хэлмээр байна.Төлөвлөгөө,дотоод журмыг баталчихлаа.Бусад асуудал гэдэг дээр жаахан чиглэл юмуу гаргаж өгөхгүй бол бөөрөнхийлөөд баахан юм орчихож байгаа шүү дээ.Хүмүүс нилээн олон асуудал, санал гаргаад байгаа.Гол нь ямар асуудал оруулах юм бэ гэдгийг сонсмоор байна.

Уртнасан -Бусад асуудал гэдгийг бид ярилцаж тохирсон шүү дээ.Нээлттэй үлдээе.Магадгүй манай намын бүлэг,зарим бүлгүүдээс сонсгол мэдээлэл оруулж ирэх байх.Үүнийг бид тухайн үедээ хэлэлцэж шийдвэрлээ гэж тогтсон шүү дээ.

10 дугаар тойргийн депутат Дашбалбар -Цөөнхийн саналыг сонсоё.Цөөнхийн саналыг харгалзах хэрэгтэй байх гэж бодож байна.

Хэлэлцэх асуудлын дарааллын алийг хаана нь оруулах вэ гэдгийг хэлэлцүүлэх хэрэгтэй байсан. Хэлэлцүүлээгүй, шууд тулгах маягаар санал хураачихлаа. Энэ бол дэгээ зөрчиж байна. Түүгээр ч барахгүй Их хурлын дарга өөрөө дэгээ зөрчиж байна. Яагаад гэвэл шууд тулгасан. Ийм учраас би хэлэлцүүлээд дахин санал хурааж дэгийн дэс дарааллыг олох ийм санал тавьж байна.

Уртнасан - Санал сонсоё. Бид цөөнхийн саналыг сонгож байна гэж ойлгож байгаа.

425 дугаар тойргийн депутат Ганзориг - Дарааллын асуудалд цөөн болсныхоо хувьд саналаа хэлье гэж бодож байна. Депутатууд Үндсэн хуулийг хэлэлцэх нь бидний гол зорилт гэдгийг бүгдээрээ хүлээн зөвшөөрч байгаа. Гэхдээ бид гол зорилгоо ард түмнийхээ өмнө хариуцлагатайгаар биелүүлэхийн тулд зарим үндэслэлээ тодруулах хэрэгтэй байна. Ардын Их хурал чинь нэг танхимтай байх юмуу эсвэл хоёр танхимтай байх юмуу. Танхим дотроос Засгийн газрын гол гол сайдууд гарах юмуу үгүй юу. Бид мэтийн зарчмын гол асуудлаа. Энэ маань Их цааз дотор тусна шүү дээ. Тийм учраас үүнийг зөв юмуу үгүй юу гэдгийг Засгийн газар, Бага хурлын тайланг хэлэлцэх үед тодорхой болно шүү дээ.

407 дугаар тойргийн депутат Нүүрээ - Тэгэхлээр шинэ Үндсэн хуулиас зохицуулалтаас үүсч гарах нийгэм, эдийн засаг, хууль зүйн шинэ үр дагавар гарна. Тийм учраас шинэ Үндсэн хуулийг батлахын өмнө нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг шугамыг бид тогтоох ёстой. Энэ дээр бид Засгийн газрын тайлан илтгэлийг сонсох ёстой нэгдүгээрт. Хоёрдугаарт нийт ард түмний язгуур эрх ашиг өнөөдөр төдийлөн баталгаажиж чадаагүй байна. Ийм учраас хууль тогтоох дээд байгууллага, Бага хурлын тайланг эхэлж сонсож юун дээр алдаж байсан, юун дээр онож байсан гэдгийг бид эхэлж мэдэж байгаад дараа нь бид шинэ Үндсэн хуульдаа энэ юугаа тусгах хэрэгтэй байгаа юм. Одоогоор мөрдөгдөж байгаа хууль эрхийн актын хүрээнд Засгийн газрын танхимын гишүүд, Улсын бага хурлын танхимын гишүүдийг хариуцлагын асуудал хүлээлгэх ёстой. Үүнийг бол одоогийн мөрдөж байгаа хуулиар бол энэ асуудлыг хэлэлцэж тогтоох ёстой. Энэ учраас хэлэлцэх асуудлын дараал-

лыг өөрчилж Засгийн газрын тайланг нэгдүгээрт сонсож, тэрэн дээр ялангуяа банкны гадаад харилцааны үйл ажиллагаанд хийсэн дэлгэрэнгүй мэдээг сонсоод дараагаар нь Бага хурлын тайланг сонсоод хамгийн эцэст нь Үндсэн хуулийг хэлэлцээ гэсэн саналтай байна.

167 дугаар тойргийн депутат Гүрбазар –Тэгэхээр энэд энд 2 зүйлийг анхаарахгүй байна гэж бодоод байна л даа. Энэ бол бид эгзэгтэй асуудлуудыг хэлэлцэнэ. Тэгэхлээр магадгүй тухайн тухайн үед нь битгий ойлго л доо. Хурлынхаа мэдрэмжээр бодохгүй бол болохгүй. Одоо бол хурлын дарааллыг өөрчлөх гэж байгаа улсууд бол 281-ийн холбоо юмуу ямар нэгэн төр, засгийн эсрэг бодолтой хүмүүсийн нэгдэл цөөнх болж байна гэж ойлгодог. Тэгэж ойлгог хамаагүй. Гэтэл дараа нэг юмыг шуургалан шийдтэл хамгийн үнэнийг шийдэх гэж үнэнийг бодож байгаа цөөнх болчихвол яах юм бэ. Тэгэхлээр ерөөсөө монгол улсын нэрийг БН Монгол болгочихвол яах юм бэ. Цаана нь Монгол улс гээд хэлэх гээд байгаа улс чинь тайлбар өгөх хэрэгтэй болдог. Тэрэнтэй адилхан яриг л даа, яриг. Яриад тэртэй тэргүй юм чинь ойлгогдоно. Хүн ярихгүй байх тусмаа алддаг. Энэний чинь цаана нэг хүний санал ч санал л даа. Тэгэхээр яриад үзэг, депутатууд сонсог, дэг дээрээ хоёр хоног маргалдаж байсан гэхээсээ илүү дараалал дээрээ нэг гурван цаг маргалдаж гэнэ, тэгээд маргаж маргасны эцэст депутатуудын санал, энэ энэ үүднээс Их цаазаа хэлэлцэх нь зүйтэй гэж үзжээ гэж! тайвшрах. Энэ чинь бидэнд бас гадна дотно байгаа хүмүүсийнхээ сэтгэл санааг баясгах, монгол хүн чинь жаахан юманд баярлаж, жаахан юманд тайтгардаг, тэрнээс биш өнөөдөр жагсчихсан, төрөө унагачихсан, одоо муудъя, сайдая гэсэн зарим хүмүүсийн ярьж байгаа тийм хүч байхгүй. Ард түмэн гэдэг чинь жаахан юманд баярлаж байдаг улсууд. Тэгэхээр энийг чинь жаахан бодолтой, ер нь дараа дараагийнхаа асуудал дээр бодож байгааг бид. Ингэхгүй шуургалах юм бол сүүлд нь жинхэнэ бидний Үндсэн хууль дээрээ байж байгаа үнэнийг саяынх шиг алдвал яах юм бэ? Энэ дараалал өөрчлөгдөхгүйг ойлгож байна л даа. Тэгэхдээ ярих ёстой байсан юм. Энэ бол дараа дараагийн юманд хэрэгтэй. Өнөөдөр энд цөөнх нь буруу байж гэж бодоход, цөөнхийн талд үнэн байгаа юм Үндсэн хуульд бий шүү. Тэрэн шиг

бас ингээд баталчихвал яах юм бэ? Тэрийг чинь бас бодохгүй юм бол, өнөөдрийн хувьд дараалал дээр бид хожиж болно. Дараа нь бид Үндсэн хуулиндаа алдах вий. Энийг л хэлмээр байна. Ер нь бодох ёстой шүү.

Ж. Уртнасан -Баярлалаа. Бид цөөнхөө хүндэтгэдэг. Тэр дэгийнхээ сан зарчмаар бид цөөнхийн саналаа сонсож байна гэж ойлгож байгаа.

191 дүгээр тойргийн депутат Б. Лханаасүрэн -Тэгэхээр өнөөдөр та нөхдүүд сая санал хураалаа. Энэ хэлэлцэх асуудлын журмаар явбал бид их алдаа хийнэ, өнөөдөр Ардын Их Хурал. Яагаад вэ гэхээр улс орон, ард түмэн маань биднээс их зүйл хүлээж байгаа. Бид хамгийн нэгдүгээрт Улсын Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайланг хэлэлцээд, дараа нь ард түмний хүсэн хүлээж байгаа тэр Их цааз гэж нэрлээд байгаа та нарын тэр хуулийг хэлэлцвэл зүгээр юм уу гэж бодож байна. Яагаад вэ гэвэл, би нэг хоёр гурван үндэслэлийг хэлмээр байна. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Ардын Их Хурлын дарга шууд зарлаад санал хурааж байна. Энэ бол зарчмын хувьд маш буруу үйлдэл хийж байна. Даргын хувьд. Би дахин анхааруулъя. Өчигдөр бас анхааруулсан. Та асуудлыг хэлэлцүүлээгүй байж, шууд санал хурааж байна. Энэ бол зарчмын хувьд буруу. Бид бол таны тавьсан саналыг хэлэлцэх ёстой. Тэр саналаар хэлэлцэх үү, яах вэ? Дэс дарааллын хувьд, өнөөдрийн хувьд, хэлэлцэх асуудлын хувьд бид ярилцах ёстой. Гэтэл та энэ дэгэнд байгаа дарааллыг өөрөө санал хураая гээд шууд асуудал оруулж байгаа асуудал бол зарчмын хувьд буруу. Энийг таны удирдлагын хувьд алдаа гэж бодож байна. Би хоёр дахь удаагаа анхааруулъя.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

Баян

Д. БАЯНДҮҮРЭН

Бичээч Энэбиш

Яагаад Улсын Бага Хурлын тайлангяагаад өнөөдөр эхэнд хэлэлцэх ёстой байна вэ гэвэл нэгдүгээрт Монголын нийт ард түмэн өнөөдөр бухимдаад энэ саарал ордны гадаа юмаа бариад жагсахад бэлэн болчихсон байна. Бид яагаад энэ ард түмний санал хүсэлтийг эхэлж хүлээж авдаггүй юм бэ? Яагаад Улсын Бага Хурлаар өчнөөн, төчнөөн хууль батлаад түүнийхээ төлөө хариуцлага хүлээдэггүй юм бэ гэдэг асуудлыг бид өнөөдөр ярилцах ёстой.

Гэтэл ард түмний саналыг тайтгаруулж Их цааз гэдэг нэрийдлийн энэ хуулийг хэлэлцээд, эхэлж хэлэлцэж байгаа асуудал бол зарчмын хувьд ерөөсөө буруу асуудал гэж бодож байна.

Хоёрдугаарт Засгийн газрын тайланг хэлэлцэх асуудал бас үндэслэлтэй. Өнөөдөр ард түмний амьжиргаа ямар асуудал байна. Ямар байдалд байна уу, ямар асуудлууд дэвшигдэж тавьж байна уу. Алт, диллер, 20 дугаар тогтоол, өчнөөн төчнөөн асуудал байхад бид үүнийг яагаад Ардын Их Хурал ардаа хаячихаад Их цааз гэдэг нэрийдлээр бид энэ хурлынхаа асуудлыг тайтгаруулах гээд байгаа юм бэ. Энэ надад ойлгомжгүй байна. Тийм учраас энэ хоёр асуудлыг хэлчихээд дараа нь ард түмэндээ хэлээд тэгээд Их цаазаа хэлэлцээ гэсэн ийм санал байна. Энэ бол зарчмын асуудал юм шүү эрхэм депутат болгооно биз.

287 дугаар тойргийн депутат Ч.Хурц: Тэгэхээр үнэхээр бид саналаа зөв ярьж энэ хурлынхаа дэгийн дагуу явуулах нь зүйтэй байх гэж бодож байна. Одоо бол цөөнхийн нэрийн өмнөөс саналаа хэлье гэж бодож байна.

Бид, миний өөрийн депутатын хувьд санал бол ийм байна. Эхлээд Засгийн газрын илтгэл, түүнд тавих асуудлуудаа асуучихаад хэлэлцүүлэг хиймгүй байна. Дараагаар нь мөн Бага Хурлын илтгэлийг сонсчихоод дараагаар нь асуулт хариултаа явуулчихаад хэлэлцүүлэг хиймгүй байна. Тэгээд дараа нь шууд Их цааздаа ормоор байна. Энэ ямар учир вэ гэхээр та бүгд, эрхэм депутатууд бодооч. Ер нь Засгийн газар чинь жил тойронгийн хугацаанд энэ шинэ бидний батлах гэж Үндсэн хуулиар ажилчихсан юм шүү. Зах

зээлийн эдийн засагт биднийг оруулах гээд байгаа ямар зах зээлийн эдийн засагт оруулах гээд байгаа юм бэ гэдгийг чинь бид мэдэхгүй, тэгээд тэр зах зээлийн эдийн засгийн үеийн Монголын хуулийг батлах гээд байна. Гэтэл зах зээлийн харьцаанд шилжих үеэр ажиллачихсан Засгийн газрынхаа илтгэлийг эхлээд сонсчихоод асуулт, хариултаа явуулчихаад нэг өдөр ч юмуу, хоёр өдөр, мөн Бага Хурлынхаа үйл ажиллагааг сонсчихоод тэрэн дээрээ ямар ч хэлэлцүүлэг хийлгүйгээр, ямар ч хэлэлцүүлэг хийлгүйгээр, тэр сонссон сонсгол дээрээс дүгнэлт хийгээд Их цаазын зүйл ангид ийм юм орох ёстой юмаа. Энэ чинь буруу байна. Энэ бичсэн чинь ингээд ингээд түрүүчийн Засгийн газрын үйл ажиллагаанд зөрчил гарч байна гэж ингэж бид дугарах ёстой юмаа. Жишээлбэл Их цаазын асуудлыг ярихад засаглалыг буруу хувааж байгаагаас, би ганцхан жишээ хэлье. Засаглалыг буруу хувааж байгаагаас Ерөнхийлөгч зарлиг гаргаад, Засгийн газар тогтоол гаргаад, Бага хурал зөвлөмж гаргаад ганцхан асуудлаар гаргасан. Энэ бол намрын тариа хураалтын асуудлаар гаргасан. Ингэж засаглалыг буруу хуваарилж байгаагаас болж улс эх оронд хэн нь эзэн юм бэ гэдэг чинь олдохоо байчихаад байна. Тийм учраас бид засаглалаа зөв хуваая, зөв эзнийг нь олж гэж ярьж байгаа болбол эхлээд илтгэлээ сонсчихёе, юу юу хийчихсэн юм бэ эд чинь. Тэгээд хэдүүлээ асуух зүйлээ асуучихъя, цагаа хэмнээ, бид цаашаа хэлэлцүүлэг хийхээ байя, хэлэлцүүлэг хийхээ байя депутатууд. Зөвхөн илтгэлээ сонсчихёе. Ард түмэн тэгээд тэр хэлэлцүүлгийн үндсэн дээр ард түмэн чинь бас илтгэлийг чинь сонсоод юугээ ч юм илтгэж байгааг өнөөдөр бидний гар дээр алга байна. Ард түмэн тэр илтгэлийг чинь сонсоод депутатууддаа үгээ хэлэг л дээ. Явц дунд. Бид тэгээд Их цаазан дээрээ тэрнийг тусгая л даа. Ийм учраас заавал энэ Засгийн газрын илтгэлийг хэлэлцээд, тэгээд хэлэлцүүлэг болоод арван хэд хоног тэр дилерийн хэрэгт ороод явчих юм биш биз дээ. Ийм юмнуудыг битгий бодоочээ. Хамгийн гол нөхөд минь бид ард түмэндээ үг хэлэхийн тулд, их цаазаа батлахын тулд зах зээлийн харилцаанд ажиллачихсан. засгийнхаа газрын үйл ажиллагааг, Бага Хурлынхаа үйл ажиллагааг бид яримаар байна. Бага Хурлын үйл ажиллагааг ярихад би ойлгож байна

энэ их хурлын депутатуудаас ихээхэн шүүмжлэл гарна. Гэтэл Их цааз дээр чинь ганцхан шатны парламент хийчихээд байж байгаа шүү дээ. Гэтэл магадгүй ганцхан шатных болохгүйнээ гэдгийг чинь Бага Хурлын чинь нэг жилийн үйл ажиллагаа харуулаад Их Хурал байх ёстой юм байна хоёр шатных байх ёстой юм байна гэдгийг бид хэлэх гэж байгаа юм биш үү. Ийм нөхцөл байдалд зөвхөн энийг сэтгэлийн хөдөлгөөнөөр юмуу, хэсэг хүмүүсийн уур амьсгалаар ингэж битгий асуудалд хандаачээ депутатууд минь. Миний санал болбол хэлэлцүүлэг хийхгүйгээр зөвхөн асуудлаа сонсчихоод, илтгэлээ сонсчихоод ард түмэндээ Засгийн газар ийм байна шүү гэдэг Засгийн газрын илтгэлээ тавьчихъя, асуудлаа бид тавьчихъя, хэлэлцүүлэг хийхээ байя. Мөн Бага Хурлынхаа илтгэлийг сонсчихъя, тэгээд би энийгээ ард түмэндээ тавьчихъя. Ингэж хэлэлцвэл зөв зүйтэй байна гэсэн саналыг хэлэх гэсэн юм. Та бүхэнд.

426 дугаар тойргийн депутат Ж. Барамсай: Би нэг юм ярья. Нэгдүгээрт яг тэр дэгийн дагуу хэлэлцэх асуудлыг түрүүн тэр депутат хэлсэн. Нийтээр энэ дэс дараагийн нь хэлэлцүүлэлгүйгээр гурван өдөр дэгийн тухай ярьсан мөртлөө 30-хан минутын дотор энийг маш яаралтайгаар ингэж батлуулж байна. Энэ цаанаа ямар учиртай юм бэ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт би сая депутат Хурц гуайн саналыг бүрэн дүүрэн дэмжиж байна. Энэ одоо эхлээд Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайланг хэлэлцэхээс юунаас айгаад байгаа юм бэ, хэнээс айгаад байгаа юм бэ, яачихна гэж бодоод байгаа юм бэ, энд бол бид хэлэлцүүлэг хийхээ болъё л доо. Юу хийсний нь ард түмэн мэдэг. Ялангуяа Засгийн газар маань өнөөдөр юу хийж байна аа. Яасан юм бэ, аргагүй болоод ингэсэн юм үү. Эсвэл биднийг нэг нэг сараар хуурч явсаар байгаад өдий байдалд орсон юмуу, үнэхээр бид чинь эсвэл ерөөсөө бүсээ чангалж ингэж амьдрах юмуу, үгүй бол энэ ямар байна гэдгийг ард түмэн мэдэх хэрэгтэй байна. Өнөөдөр чинь ард түмний бүхмидал, ард түмний хамгийн хэцүү байдалтай, ширтэж байгаа юм бол манай Засгийн газар ямар үйл ажиллагаа явуулж байна вэ гэдгийг харж байгаа шүү дээ. Энийг ингэж харж, эцсийн эцэст бид нарыг ингээд бодоод

үзэхэд нэг жилийн туршилтын жил боллоо шүү дээ. Энэ туршилтын жилдээ бид нар ямар юм хийсэн юм бэ? Энэ бүхнээс ургуулаад Их цааз маань ямар байх юм бэ? гэж энэ үндэс суурийн ирээдүйн аугаа их бол урьдчилсан юмнуудаа ярьж байж батлахгүйгээр болохгүй байхаа гэж би хувьдаа болож байгаа юм. Тэрнээс бид бол шүүхийн хурал хийхгээгүй. Тэр дилерын асуудлыг тэнд нь тийм юм болохоо байсан, тэрийг хөө, тэрийг шоронд хий гэж ингэж хийх гэж байгаа сэтгэлтэй хүн нэг ч алга. Тэгээд эцсийн эцэст энэ хурлын ажиллагаанаас нэг найруулсан жүжиг сценари харагдаж байгаа шүү. Юм болгон дээр. Хэрэгцээ гарвал сүүлд хурлын дараа хэлнэ.

293 дугаар тойргийн депутат И. Бадарч: Эрхэм хүндэт депутат нараа. Энэ дээр нэг зарчмын нэг асуудлыг бодолцооор байна.

Өнөөдөр цөөнх нь болж уг хэлж байгаа улсууд зүйтэй юм ярьж байна. Үнэн чанартаа хөдөлмөрчид их бухимдаж Бага Хурал, Засгийн газрын талаар их сэтгэл дундуур байгаа. Гэхдээ бид энэ дээр төвчээр гаргаж зарчмын асуудлыг бодмоор байна. Өнөөдөр дэлхий нийт бол манай засаг, төрийн шинэ тогтолцоог болбол харж байгаа. Энийг хуульчлан бататгахыг сонсохыг яаханаа гэдэг зүг Монголын бүх өнцөг бүрээс ч гэсэн, дэлхий нийт ажиглан харж байна. Ийм учраас бид энэ нэгэнт буй болсон тогтсон засаг төрийнхөө үндэс нь тунхаглах ёстой. Ийм учраас энэ Үндсэн хуулийг ч, Их цаазаа болбол эхэлж хэлэлцэх нь бидний ариун үүргээ. Төвчээр гаргаад нэг хоёр, гурав хоногоор хойшлуулаад дараа дараагийн асуудалдаа бид энэ бага хурал, Засгийн газрынхаа тайланг хэлэлцэх нь зүйтэй. Ийм учраас бид саналыг нэг бүрчлэн хурааа. Түрүүчийн санал хураасны зарчмын асуудлаараа явж ямар ч байсан эхлээд бид Үндсэн хуулиа батлаад тунхаглачихаж болно. Ингэсний дараагаар бид өнөөдөр Бага Хурлаа ч өөрчилж болж байна. Засгийн газраа ч өөрчлөлт оруулж болж байна. Энэ асуудал дараа нь бидэнд оногдоно шүү дээ. Энд яарах юм алгаа гэж хэлмээр байна.

Их хурлын даргаа яагаад уг хэлүүлэхгүй байна аа та. Хоёр дугаар микрофон дээр нэлээд удаан зогсч байна.

Хоёр болоогүй байгаа шүү.

Уучлаарай таниас түрүүн зогссон дөрөвдүгээр микрофон.

171 дүгээр тойргийн депутат Ж.Лхагважав: Улс орны эдийн засгийн хямралд орсон байгаа асуудлыг Засгийн газар мэдэж байгаа. Улсын Бага Хурлаас баталсан олон төрлийн хуулиуд бий. Тухайлбал 30-аад хууль байгаа. Энэ хуулиуд ямар нэгэн зөрүү гарсан асуудлыг өнөөдөр ард түмэн нийтээрээ мэдэж байгаа. Өнөөдөр биднийг сонгоод явуулсан, төлөөлөөд явуулсан ард түмэн маань юу хүсч байгаа вэ гэхдээр Үндсэн хуулийн тухай асуудлыг л хамгийн түрүүн бодож байгаа. Ер нь бидэнд уулзалт хийгээд явахдаа ч гэсэн сонгогчид, хөдөлмөрчид маань Үндсэн хуулиа л хууль шиг болгоод ирээсэй гэсэн ийм асуудал байгаа. Тийм учраас өнөөдөр Засгийн газрын үйл ажиллагаа, Улсын Бага Хурлын үйл ажиллагааг ард түмэн хэвлэл, мэдээлэл, радио телевизээр нийтдээ мэдэж байгаа учраас заавал түрүүлэх гээд байх шаардлагагүй юм. Тийм учраас бид өнөөдөр Үндсэн хуулийнхаа төслийг урьдаар хэлэлцэж байж энэнээс юу гэх дээр сүүлдээ дүгнэлт гаргаж болох байх гэж бодож байна. Тийм учраас олонхийн саналыг үндэслэж энэ Үндсэн хуулийнхаа төслийг урьдаар хэлэлцэж авах нь зүйтэй гэж ингэж бодож байна.

25 дугаар тойргийн депутат Д.Энэбиш: Энд бид их анхааралтай хандах хэрэгтэй юм. Их цаазын маань хэлэлцэх явцад бид энэ депутатууд сайн ойлгогдохгүй олон асуудал гарна. Үүнд бол нэг танхимтай байх уу, хоёр танхимтай байх уу, Засгийн газар гэдэг бүхэл бүтэн бүлэг Их цаазад байгаа. Энд бол Бага Хурал, Засгийн газрыг яах гээд байна гэдэг юм яриад байх юм. Бид уг нь миний хувийн бодол, би сая татгалзсан санал өгсөн. Яагаад гэвэл миний хувийн бодол энэ депутатууд одооныхоо Бага Хурал, Засгийн газар хоёроо сонсоод жаргал, зовлонгийг нь ойлгож байж, цааш нь яах юм бэ гэдгийг нь мэдэж байж энэ хууль дотроо ийм юм оруулах нь зүйтэй байж гэж ингэж л хэлж баталмаар юм. Дараа нь Бага Хурлынхан, Засгийн газрынхан хэлнэ шүү дээ. Шилжилтийн үеийн Засгийн газар гэдэг чинь ийм байх хэрэгтэй юм байна гэж Ерөнхий

сайд чинь зовлонгоо энд хэлнэ биз дээ. Тэгээд бид урьдчилаад ойлгохгүй байж байж, өнөөдрийн Засгийн газрынхаа зовлон, жаргалыг ойлгохгүй байж, өнөөдөр тэр Засгийн газар толгойлж буй хүнийхээ саналыг сонсоогүй байж дараа нь бид хэлэлцэх байж байж ийм Засгийн газар байна гэж Их цааздаа оруулдаг нь зөв юмуу. Би Хурц гуйн хэлж байгааг маш их дэмжиж байна. Бид энийгээ баталчихаад дараа нь одоо хэлэлцэхээрээ Засгийн газрыг ингэдэг ч байж, Их Хурлаа ингэдэг ч байж, ийм танхимтай ч байдаг байж, урьд нь Бага Хурлаа сонссон бол ингэх байж гэж би болбол бодож байна. Бага Хурал бол ажилдагаараа ажиллана, энэ Бага Хурал бол байх ёстой, энүүгээрээ үргэлжилнэ, субъект алга болно гэж байна. Ийм юм бол байхгүй. Байхгүй гэж би ойлгож байна. Тийм учраас ийм санал тавьж байна. Ер нь бол бид энэ Их цааз дотор байгаа юмаа учрыг нь олохгүй эхэлж батална гэдэг юм яриад байдаг чинь буруу шүү дээ.

41 дүгээр тойргийн депутат Н. Пүрэвдорж: Өнөөдөр энд бол. Манай сонгогчидтой би 4-5 удаа уулзсан. Өөрийнхөө. Тэгэхээр сонгогчид маань юу гэж хэлсэн бэ гэхээр та нар түрүүчийн туршлага чинь байна шүү. Шинэ асуудлыг, хуулийг батлахын өмнө өнгөрсөн жилийнхээ хугацааны алдаа, доголдолтой, сайн, муутай талыг дүгнэлт өгч чадаагүй байж байж дахиад шинэ хууль батлах юм бол энэ чинь том алдаа болно шүү. Өнгөрсөн нийгмийнхээ хууль зүйн практикийг дүгнэж байж, юу нь болж байна, юу нь болохгүй байна, цаашдаа ямар хэлбэрээ зөв сонгох вэ гэдгийг зөв алхам хийхийн тулд өнгөрсөн практикаа л дүгнэнэ. Нэг жил ч бай, хоёр жил ч бай. Дараа нь шийдвэр гаргахад Их цаазыг ул үндэстэй батлах уу. Ерөөсөө ийм зарчмын асуудлыг сонгогчид маань тавьсан учраас би энийг нийт депутатын өмнө хэлж байна. Энэ танхимын уур амьсгал битгий алдаачээ. Та бүхэн өнөөдөр сонгогчидоо төлөөлж ирсэн улсууд шүү. Бид Их цаазыг заримдаг, дэгэн, догон түрүүчийн гаргасан хуулиуд шиг ийм ерөөсгөл юм хийж болохгүй. Асар хариуцлагатай хууль. Тийм учраас өнгөрсөн туршлагаа нэгтгэж дүгнэж, тэрийгээ ойлгож авч байгаад дараа нь үнэн зөв, жинхэнэ хууль гаргах ёстой. Ийм хариуцлагатай болсон. Тийм учраас дараалал дээр бол эхлээд туршлагаа нэгтгэж дүгнэе. Нэг жил ч бай хамаа байхгүй. Асар их туршлага бий. Дараа нь зөв үндэслэлтэй, аль аль талын

Соронзон хальстай тулгаж

нийлсэн

Бичээч

М. Дорж Б. Энхтуяа

В. Оюун

42

Н.Пүрэвдорж /41 дүгээр тойргийн депутат/ -Дарааллын хувьд тайлангаа хэлэлцье. Дараань Их цаазаа баталъя. Мэдээжийн хэрэг Бага Хурлын сайн муу талаа бид эхлээд ойлгож байж, юмаа ярина.

Г.Вандандагва /168 дугаар тойргийн депутат/ -Цөөнх болсны шалтгаан бол арай өөр байгаа миний хувьд. Ер нь энэ улс төр, эдийн засаг, нийгмийн байдал хүнд болсон энэ явцад бас Ардын Их Хурал өөрөө буруутай. Өөрөөр хэлбэл өнөөдрийг хүртэл дээд байгууллага маань яаж ажиллах ёстой вэ гэсэн хууль зүйн актгүй ирсэн. Энэ нь Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд бол Ардын Их Хурлын үйл ажиллагааг хуулиар зохицуулна гэсэн байгаа. Бид ерөөсөө л нэгдүгээр хуралдааны дэгээр ажилласан шүү жилийн хугацаанд. Тэгэхээр энд байгаа, тараачихаад байгаа дотоод дүрэм гээч юмаа яах юм байгаа юм, энийг бас нэг шийдмээр юм. Өөрөөр хэлбэл шинэ Үндсэн хууль батлагдсаны дараа шилжилтийн явцад Ардын Их Хурлын роль бол өнгөрсөн жилийнхээс хэдэн зуун хувь өндөр байхгүй бол энэ нөлөөлөл ихтэй байх ёстой.

Хоёр дахь саналын хувьд бол Үндсэн хуулийнхаа төслийг хэлэлцье. Дараа нь тайлангуудыг хэлэлцье. Үнэхээр Засгийн газар, Бага Хурал хоёр хариуцлагагүй ажилласан нь үнэн. Маш олон дутагдал, нөхцөл байгаа. Гэтэл энэ бүгдийг ярьсны дараа танхимын маань уур амьсгал энэнд хүчтэй автагдаж ирээдүйд бидний батлах ёстой Үндсэн хуулиас ардчилсан гол гол зарчмуудыг хасчихвий дээ гэж санаа зовж байна. Гагцхүү бид Үндсэн хуулийнхаа зүйлийг хэлэлцчихээд, дараа нь тайлангаа сонсчихоод, хамгийн сүүлд шилжилтийн тухай хуулийг бид нар хавсралт хуулийг батлах ёстой. Тэнд ёстой бид нар шаардлагатай бол өнөөдөр огцрох уу, өнөөдөр шинэ хууль руугаа орох уу, гурван сарын дараа орох уу гэх мэтчилэн чухал юм тэнд байх ёстой гэдгийг депутат нөхдүүд анхааралдаа аваач гэж хүсмээр байна.

Л.Баяндалай / 107 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр

43

би хамгийн цөөнх болсон түүдгэлзсэн 7 хүний нэг юм. Тэгэхээр энэн дээр нэг ийм завсрын шинжтэй хувилбар байвал яасан юм бэ? Зарчмын хувьд бид эхлээд Их цаазаа сонсъя. Тэгээд санал асуулгаа явуулъя. Асуулт хариултаа явуулъя. Магадгүй энэний дараа ерөнхий санал шүүмжлэлээ тавьсан ч яахав. Зүгээр хаана нь зогсоохыг гишүүд бид өөрсдөө шийдье, тухайн үедээ шийддэг юм уу, одоо шийддэг юм уу. Тэгээд зогсоогоод завсарлаад Засгийн газар, Бага Хурал хоёрынхоо тайланг мөн түрүүний Хурц гуайн хэлдгээр зөвхөн сонсъя. Зөвхөн сонсоод асуулт хариултаа авчихъя. Тэгээд Их цаазаа цааш нь ургэлжлүүлье. Ер нь ч ингэх завсар бидэнд гарч ирнэ. Анхны хэлэлцүүлгийн дараагаар юм уу, ажлын хэсэг ажиллах, тэр нөгөө бид нарын ажлын хэсэг ажиллуулах, дахин хянан редакци хийлгэх, экспертиз хийх энэ тэр гээд Их цаазыг хэлэлцэх явцад завсар гарна. Гардаггүй юм бол бид ийм завсар гаргая. Зарчмын хувьд энэ гурван асуудлыг гурвуулангийн нь зэрэг сонсож байж бид Их цаазаа шийдэхгүй юм бол үнэхээр хоорондоо уялдаатай асуудал байгаа юм.

Бид эхлээд Засгийн газраа сонсчихоод ингээд авч хаячихаад дараа нь Их цааз хэлэлцдэг, гэтэл Их цаазаар Засгийн газрыг чинь хуучин журмаараа сонгохоор ч байдаг юм уу, бид нарын авч ха хэлэлцсэнээс ч өөр ч байдаг юм уу ийм болоод байна. Бага Хурлаар хэлэлцээд гишүүдээ нөхөн сонгочихоод дараа нь хэлэлцэнэ гэсэн чинь Их цаазаараа бид Бага Хурал гээч юм байхгүй болгочихсон ч байж мэднэ. Ийм учраас энийг завсрын шинжтэй байвал яасан юм бэ? Биднийг явуулахдаа Их цаазаа, Үндсэн хуулиа баталж ирээрэй гэж гол эхлээд захисан юм. Дараа нь Засгийн газар, Бага Хурлаа нухацтай шиг аваарай гэж захисан юм. Тэгэхээр бид нарыг өнөөдөр энд цугласныг хүн эхлээд эд нар яах гэж цугласан юм бэ гэхээр Их цааз буюу Үндсэн хуулийг хэлэлцэх гэж л энд ирсэн гэж ойлгож байгаа. Тэгэхээр эхлээд тэр асуудлыг нь аваад хэлэлцье. Гэхдээ төгс биш, завсрын шинжтэйгээр авбал яасан юм бэ гэсэн нэг ийм завсрын шинжтэй санал оруулж байна. Энийг Их Хурлын депутатууд маань болгооно уу?

Ш.Цэндбаяр /280 дугаар тойргийн депутат/ -За хэлэлцэх асуудлын дараалал бол тийм хатуу тогтсон байж бол болохгүй байх гэж бодож байна.Энэ бол ихээхэн уян хатан байх ёстой гэж бодож байна.

Хоёрдугаарт бид улс төрийн шинэ тогтолцоогоор улс орон маань нэг жил ажиллаж, амьдарч, зовж зүдэрч, жаргал, зовлонгийн нь үзэж, ингэж ирсэн нэг жилийн хугацаа.Ийм учраас бид үнэхээр улс төрийн шинэ тогтолцоонд шилжих тийм Үндсэн хуулийг батлах гэж байгаа энэ нөхцөлд бид энэ нэг жил ч гэсэн, хугацаа хэдийгээр богино ч гэсэн энэ нэг жилийн хугацааны туршлага, ололт, амжилт, алдаа оноо их чухал юм.Ийм учраас энэнд тулгуурлаж, энэний дараагаар бид Үндсэн хуулиа хэлэлцсэн бол бид болох байсан гэдэг ийм саналыг би дэмжиж байна.Үүнтэй холбогдуулаад бид алдаа хийж байгаа, энийгээ бас хүлээн зөвшөөрөх ёстой.

Хууль тогтоох дээд байгууллага буюу манай парламент маань одоогоор хоёр танхимтай байгаа.Тэгвэл бид энэ хэлэлцэх асуудлаар зөвхөн хууль тогтоох байгууллага, Улсын Бага Хурлын тайлан, түүнд үнэлэлт, дүгнэлт өгөх гэж байгаа.Тэгвэл бид Их Хурлын асуудлыг зөвхөн нэг мэдээлэл төдий сонсоод өнгөрсөн.Тэгвэл бид яагаад Их Хурлын энэ нэг жилийн хугацаан дахь үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хэлэлцэж болохгүй байсан бэ? Энэн дээр бид алдсан.

Ер нь бид кино дараад асуудал шийдэх амархан.Гэтэл энэ шийдвэрлэж байгаа асуудлын цаана улс орны маань амьдралын амин чухал асуудлууд байж байгаа.Ийм учраас бид цөөнхийг тэвчээртэй, ажил хэрэгчээр сонсож байх ёстой.Олонхийн саналаар ихэнх асуудлыг шийднэ гэж хэлсэн боловч бид тэр цөөнхийн үнэтэй зүйлийг сонсох ёстой байсан.Ийм учраас бид энд ихээхэн тэвчээртэй хандах ёстой.Нэгийнхээ үгийг сонсдог ийм ёс суртахууны хүмүүжилтэйгээр депутатууд ажиллах ёстой гэдгийг дахин хэлмээр байна.

Д.Рэнцэннацаг -/429 дүгээр тойргийн депутат/ -За ард түмэн маань өнөөдөр их бухимдаж байна.Ард түмэн маань бухимдахдаа

өнөөдөр 20 дугаар тогтоол ч биш, 240 дүгээр тогтоол ч биш, Засгийн газар ч биш, Бага Хурал ч биш, ер нь эд нар дээр бухимдах нь бухимдаж байгаа. Өнөөдөр ер нь ард түмэн маань юунд бухимдаж байна вэ гэхээр зэрэг ерөөсөө энэ монгол улс чинь ямар улс болох гээд байгаа юм бэ? Би монгол хүн чинь ямар нэртэй хүн болох гээд байгаа юм бэ? гэдэг дээр их бухимдаж байна. Энэ улс чинь юу гэсэн улс болох юм бэ? Энэ улсын маань төр, сүлд ямар юм болох юм бэ гэдэг дээр илүү бухимдаж байна гэдгийг би ингэж ойлгож байгаа, ингэж мэдэрч байгаа. Энэ төр, засаг маань, энэ засаг захиргаа маань ямар засаг захиргаа болох вэ гэдэг дээр ч олон хүн нойр хоолгүй ядарч зүдэрч, сандарч байх шиг байна. Ийм учраас би юу хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг ерөөсөө энэ төслийнхөө, дэгийнхээ, дагуу дотоод журмынхаа дагуу БНМАУ-ынхаа Үндсэн хуулиа нухацтай ярилцаж авч, ийм улс байна, чи ийм хүн байна, чи ийм гүрэн байна гэдгээ хамгийн түрүүнд ард түмэндээ хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Ийм учраас би ерөөсөө эхлээд энэ Их цаазынхаа төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг би хэлье гэж бодож байна.

Ж.Орсоо /418 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр ийм санал байна. Үндсэн хуулийнхаа асуудлыг эхэлж хэлэлцье. Тэгэхдээ анхны хэлэлцүүлэг дууссаны дараагаар ажлын хороод гарч тэр засвар хийж байх хооронд Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайланг хэлэлцье. Энэ хугацаанд сонсьё гэсэн завсрын санал байна.

Б.Мөнгөн /351 дүгээр тойргийн депутат/ -Зарим хүмүүс, ер нь энэ депутатууд ихээхэн басамжилсан байдалтай байгааг хэлэх хэрэгтэй юм. Энэ байдлыг болимоор байна. Ерөөсөө энд суугаа бүх депутатууд сонгогч олон түмнийхээ санаа бодолтой ирсэн байгаа гэж миний хувьд бодож байна. Ийм учраас цаацдаа бол бас олон түмнээ, олон депутатуудаа хүндэтгэж байх нь зүйтэй гэж ингэж бодогдож байна.

Бас зарим хүмүүс шинэ Үндсэн хуульд засаг, төрийн зовлон оруулах ийм санал гаргаж байна. Миний бодоход засаг төрийн

зовлон Үндсэн хуульд оруулах биш ард түмэн бага зовох ийм Үндсэн хуультай байх нь зүйтэй болов уу гэсэн ийм бодолтой байна. Ийм ч учраас бидний үндсэн гол асуудал бол бидний ирээдүйн амьдралыг шийдэх Үндсэн хууль байх учраас энэн дээр эхэлж хэлэлцэх нь гарцаагүй. Бид ямар ч гэлээ гэсэн Засгийн газар, Бага Хурлын үйл ажиллагааг хэлэлцэнэ. Бид энэ бүхнийг хэлэлцэж байж л энэ танхимаас бүгдээрээ тарах ёстой болж байгаа. Тийм учраас бид гол асуудлаа Үндсэн хуулиа эхэлж хэлэлцэх нь гарцаагүй юм гэсэн бодолтой байна.

Е.Моголцог /154 дүгээр тойргийн депутат/ -Надад ийм санал байна. Юуны урд энэ хэлэлцэж байгаа асуудлын дагуу саяын депутатын саналыг би дэмжиж байна. Эхлээд Их цаазынхаа төслийг хэлэлцье. Их цаазын төслийг хэлэлцээд тэр хооронд ажлын комисс ажиллаж байх хугацаанд Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайланг сонсьё. Ингэж гурван илтгэл мэдэрч авсныхаа дараа бид санал бодлоо солилцож хэлэлцүүлэгт оръё. Эхлээд Их цаазынхаа төслийг хэлэлцье. Дараа нь Бага Хурал, Засгийн газрын ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч хэлэлцье гэсэн ийм санал байна.

Зүгээр бухимдаад байгаа тухай асуудлыг олон хүн ярьж байна. Бид ч өөрөө мэдэрч байгаа. Хамгийн гол бухимдаж байгаа юм юунд байна вэ гэхээр Засгийн газар, Бага Хуралд гол нь биш юмаа. Бид ямар Үндсэн хуультай, ямар улс болох вэ гэдэг дээр бухимдлын ихэнх нь байгаа. Засгийн газар, Бага Хурлын үйл ажиллагааг манай сонгогчид мэдсэн. Би өөрийнхөө сонгогчдын санал бодлыг энд илэрхийлэхэд ингэж ярьж байгаа юм шүү.

Малчин ард гэрийнхээ бүрээсийг сольж амжаагүй байхад манай төр, засаг олон дахин өөрчлөгдөх нь ээ. Ийм учраас Бямба-сүрэнгийн Засгийн газрыг шүүмжлээд, зааж хэлж өгөөд, таван жил ажиллуулж, үр дүнгий нь сонсьё. Олон улстай байгуулсан энэ гэрээ хэлэлцээрүүд, энэ олон асуудлыг одоо бусниулаад хаячих юм бол дахин одоо тэрнээс илүү бухимдалд орох юмаа гэдгийг сонгогч олон хэлж байгаа юм шүү. Үүнийг бид нар бас бодолцох хэрэгтэй юм. Зүгээр огцруулах, авч хаях асуудлаар

дүүрэн он жилүүд өнгөрлөө шүү дээ.Одоо бол байлгах, засах, залруулах, хэлж өгөх, шүүмжлэх энэ асуудал дээр анхаарлаа хандуулмаар санагдаж байна.

Д.Марав /98 дугаар тойргийн депутат/ -Ямар ч байсан сая дотоод дүрмээ баталсан учраас энэ дүрмийнхээ дагуу явмаар байна.Олонхийн санал авчихаад цөөнхийн саналыг сонсох нь үнэн. Тэгэхдээ эргэж буцаж байгаа юм манай даргад байна гэж би даргын зүгт анхааруулмаар байна.Та өөрөө Бага Хуралд байхдаа энэ зовлонг мэддэг, ер нь асуудлыг зохион байгуулах нэлээн чадвартай гэж сонсоод, тэгээд үзээд үнэлэлт дүгнэлт өгөөд байхад, та зарим тал дээр их байр суурь муутай, овсгоо муутай ажиллаж байна гэж анхааруулмаар байна.

Тэгээд энэн дээр зарим депутатуудын ярьж байгаа зүйл дээр би бас эмзэглэж байна.Жишээлбэл Лхаасүрэн гэхэд Улсын Бага Хурал хууль батлаад байна, хариуцлага хүлээлгээ гэж ингэж ярих юм.Мөн та нарын Их цааз гэж ингэж ярьж байна. Тэгэхээр энэ хүн өөрөө энэ Үндсэн хуулийг боловсруулахад саналаа хэлээгүй хүн юм уу, яагаад та нарын гэж яриад байгаа юм гэдгийг сүүлд нь өөрөөс нь хариулт авмаар байна.Энэ биш дарга бол ингээд байна л даа.Засгийн газрын зовлонг сонсьё гээд, их зовлон тоочвол үлдээх гээд байгаа юм уу, ер нь жаахан зовлон бага яривал бүгдийг нь бутраах гээд байгаа юм уу, иймэрхүү маягаар ингэж илүү үг ярьж, биднийг үл хүндэтгэж байгаагийг нь дэгийнхээ дагуу нэлээн сайн хатуу барьж өгөөч гэж дарга таниас хүсмээр байна.

Соронзон хальстай тулгаж
НИЙЛСЭН

Д.Алтанцэцэг

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч УРАНЧИМЭГ

47 дугаар тойргийн депутат С.Лхагвасүрэн:

Би ийм зүйл хэлэх гэсэн юмаа. Сая Барамсай депутат ярилаа. Дэгийг бид 2 өдөр хагас шахуу ярьсан. Үүнийг манай хүмүүс ойлгохдоо, гадуур юу гэж ойлгож байна вэ гэхээр Дэг гэдгийг тэр болгон /бичлэг тасарсан байна/ ...

арай микрофоноор хүсэлт тавьсан. Хэлэлцүүлж өгөөч ээ гэж. Тэгэхэд энд, тэндээс ч дургүйцэх шиг боллоо, тэндээс ч шууд, үндсэндээ 16 минутын дотор шийдэгдсэн. Тэгэхээр би үүнийг бодож байгаа юм.

Засгийн газрынхаа тайланг нэгдүгээрт нь авч ярья, Үндсэн хуулиа хоёрт нь авч ярья гэдэг нь гол биш байх гэж би бодож байна. Ард түмэн бол бүгдийг нь хүсч байгаа. Тэнд дотроо Их Хурлын депутат нарт нэлээн шахалт орж ирж байгаа гэж бодож байгаа. Орох ч ёстой. Учир нь бид нар уулзалт хийгээд тэр хүмүүстэйгээ хамт байж байгаа юм чинь, хааяа нэг очих үед, байнгын хамт зохион байгуулж ажиллаж байгаа улсууд бид, хүнээ сайн мэднэ шүү дээ. Уулзалт хийлээ ч гэсэн ганц удаа хийхгүй, хэд хэдэн удаа хийж байна шүү дээ, хороо, хороогоороо салбарлаж. Тэгэхээр хүмүүс ингэж ярьж байгаа юм. Ялангуяа сүүлийн бид нарыг наашаа явах уулзалтын үед ярьж байгаа шүү дээ. Одоо энд бичсэн, уг үсгээрээ байж байна, маш олон хүн ярьсан.

Анхдугаар чуулганаар та нар ихээхэн хайнга юм хийсэн шүү.

Түүнийхээ үр дүнг, нэгдүгээр асуудал болгож ярих юм байгаа биздээ гэж. Нэлээн олон улсууд ярьж байна. Энэ бол яригдах нь ойлгомжтой. Би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр, сая бол энэ дарааллыг депутатуудын хүрээнд, маш унацтай, ултай ярилцаад, тэгээд хамаагүй Үндсэн хуулиа эхэлж ярих нь зайлшгүй, энэ агуулгын хувьд ч тийм байж болно шүү дээ. Ингэж Гомбожав дарга анх хурал нээхдээ хэлсэн шүү дээ. Манай II хуралдааны үйл ажиллагаа бол асуудлаа ард түмэнтэй хамт шийдэх тийм үйл ажиллагаагаар явагдах болно гэж хэлсэн байгаа. Яг тэр байдлыг танхимаас ард түмэнтэйгээ

холбож өгөх байсан. Тэгэхдээ нэгэнт батлагдсан учраас цуцлах эрх байхгүй юм, цуцлах шаардлага байгаа ч юм уу, үгүй ч юм уу? Ийм л юм хэлэх гэсэн юм.

Хурц сайдын санал бол их зөв санал гэж бодож байна. Түүнийг давхардуулж яриад яах вэ?

258 дугаар тойргийн депутат Ш.Гунгаадорж: Тэгэхээр би түрүүн энэ оруулсан төслийн дагуу хэлэлцье гэдэг санал өгсөн хүн. Гэхдээ нэгэнт олонхи, цөөнх хоёр холидлоод ярьж байгаа учраас би саналаа тайлбарлахаас аргагүй байнаа.

Энд яригдаж байгаа хүмүүсийн саналын аль алиныг нь үгүйсгэх үндэсгүй байна. Аль алинд нь авах юм байх шиг байна. Гэхдээ хоёр асуудлыг зэрэг хэлэлцэж болдоггүй учраас, нэгийг урьдчилж ярих нь гарцаагүй байхаа. Тэгэхээр энэ зунжингаа Монголын ард түмний анхаарал, төвлөрч, ярьж, хэлэлцсэн зүйл маань юу билээ? Өнөөдөр монгол улсынхаа Их цаазыг хэлэлцэж батлах энэ л асуудал байгаа байх. Өнөөдөр монголын ард түмэн наашаагаа юу харж байгаа вэ гэхээр энэ 420 хэдэн депутат, энэ Үндсэн хуулийг ямар янзаар батлаад, ямаршүү Үндсэн хуультай гарч ирэх юм болоо гэдгийг хамгийн түрүүнд харж байгаа байх. Би ард түмний бүхмидэж байгааг мэдэж байна.

Засгийн газар, Бага хурлыг шүүмжилж байгааг ойлгож байна. Гэхдээ ер нь хамгийн гол анхаарал энд төвлөрч байгаа байхаа. Өнөөдөр Үндсэн хуулийг ярих, шинэ Үндсэн хуулийн тухай ач холбогдол үүнийг би дурдах, ярих хэрэггүй гэж бодож байна. Манай депутат, улс төрийн зүтгэлтэнгүүд, цөм үүнийг ойлгож байгаа учраас. Ийм учраас би бол энэ санал дээрээ хэвээрээ байна. Энд нэг зүйлийг нөхдийн ярьснаас тайлбарлаж ярихад бол 3 дахь санал гараад байх шиг байна. Ер нь Үндсэн хуулийнхаа төслийг хэлэлцэх явцдаа нөгөө Бага Хурал, засгийн газрын тайланг ярьж гэж байна.

Бага Хурлын, Засгийн газрын илтгэлийг сонсчихоод Үндсэн хуульдаа орё гэж байна. Үүнийг би хувьдаа зөвшөөрч боломгүй байна. Ер нь нэг асуудал дээр анхаарлаа төвлөрүүлж, алинаас нь ч эхэлдэг байд хэлэлцэж дуусгаад, дараачийн асуудлаа хэлэлцдэг зарчмаар явахгүй бол, нэгийг эхэлчихээд, дараа нэг рүү нь ороод, дахиад нөгөө дэхээ хэлэлцэнэ гэдэг маань бол асуудлыг ултай, суурьтай, буурьтай, зөв шийдэхэд энэ бол нэг их ач холбогдол өгөхгүй болов уу гэж бодож байна. Тийм учраас Үндсэн хуулиа эхэлж ярьдаг энэ зарчмаараа явах нь зөв байхаа. Сүүлд нь Бага Хурлын тайлан, Засгийн газрыг ярьснаар тэр хүч нь сулраад больчих юм бол энд байхгүй гэж бодож байна. Тэр үед шүүмжилдгээ шүүмжилнэ, тэгээд өөрчилдөг бол өөрчилнэ, энэ хүч бас л энэ эрх хэвээрээ байгаа. Харин Засгийн газар, Бага Хурлын тайланг сонсоход бага хугацаа үлдэнэ гэж үзвэл магадгүй би нэг санал хэлэх гэж байна, Засгийн газар, Бага Хурлын энэ илтгэлийг урьдчилаад 10 хэд хоногийн өмнө юм уу, өнөө маргааш ч гэсэн энэ депутатуудад одоо тараачихвал харин урьдаас уншиж танхилцаж, судалж байхад хэрэгтэй байх байх. Ийм учраас энэ илтгэлүүдийг урьдчилаад тараачихвал яасан юм бэ гэсэн ийм л санал байна.

315 дугаар тойргийн депутат Ч. Бат-Эрдэнэ:

Тэгэхээр бид нар түүхийн нэн эгзэгтэй үед орлоо гэж ярьж байгаа. Би энэ эгзэгтэй гэдгийг нэг хууль зүйн тогтолцооноос нөгөө тогтолцоонд шилжих, яг энэ Их Хурлын хуралдаж байгаа энэ үе мөчийг гэж ойлгож байгаа л даа. Тэгэхээр үүнтэй холбоотой нэг үндсэн асуудал бол энэ Монгол улсын Их цаазын Хавсралт хууль байна гэж үзэж байна.

Энэ Хавсралт хуулийг Их Хурлаар хэлэлцэх, эсвэл Бага Хурлын хэлэлцэх хуулийн кунд нь оруулах нь өнөөдөр бүрхэг байна. Дэгд зааснаар бол үүнийг Их Хурлаар хэлэлцмээр ч юм шиг ойлгогдож байгаа. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд бол энэ байхгүй юм шиг байгаа.

Тэгэхээр үүнээс үндэслээд би ер нь хэлэлцэх асуудлын дэс дарааллыг тогтоход бодох юм их байна гэж бодож байна. Үүнийг Их цаазын Хавсралт хуулийг боловсруулсан Үндсэн зарчим нь бол одоо энэ хууль, Их цаазаа батлаад, ингээд энэ бол 9.00 минутаас эхлээд үйлчлээд явах юм шиг байгаа юм.

Дараа нь энэ хууль үйлчилснээс хойш бол Бага Хурлын Их Хуралд зааснаас бусад эрх нь бол Бага Хуралд шилжээд, шинэчилсэн Засгийн газар байгуулагдахаас өмнөх бүх эрх нь бол одоогийн Засгийн газарт шилжээд ингээд явах юм шиг байгаа юм.

Тэгэхээр бид нар ингээд Их цаазаа баталчилаа. Тэгээд үүнийгээ Бага Хурлын мэдэлд үлдээх юм уу? эсвэл Их цаазаа дагаж мөрдөх энэ Хавсралт хуулиа бид батлаад, тарах юм уу гэдэг дээр их анхаарал төвлөрүүлмээр байна. Хэрвээ үүнийг Бага Хурлын мэдэлд шилжүүлэх асуудал гарах юм бол бид нар Их цааз батлагдсанаас хойших асуудлыг хэлэлцэхэд ямар хууль зүйн, эрх зүйн үүднээс хандах вэ гэдэг асуудал өнөөдөр бүрхэг байна.

Энэ дээр зохих тайлбар авч байж бид асуудлаа ярих нь зүйтэй юм уу гэсэн ийм санал байна.

423 дугаар тойргийн депутат М. Гэрэлсүрэн:

Би татгалзсан цөөнхийн нэг байгаа юм. Тэгэхээр бид ямар асуудлыг эхэлж хэлэлцэх вэ гэдэг дээр одоо депутатууд нэлээн маргалдаж байна. Тэгэхээр үүнийг бид өөр өөрийнхөө санаа бодлыг илэрхийлэх байх. Манай тойргийн сонгогчид бол надад захиж явуулахдаа, та ерөөсөө очиж өөрийнхөө, бидний үгийг дамжуулахдаа Засгийн газар, Улсын Бага Хурлын тайланг бол сонсох нь бол зөв.

Тэгээд Үндсэн хуулийг дараагийн асуудалд оруулахад саналаа хэлээрэй. Яагаад вэ гэхээр, үндсэн хуулийг батлахад, бид өнөөдөр хэдийгээр хэлэлцэгдсэн ч гэсэн бид сүүлчийн маань хоёрдахь төсөл ард түмнээр үнэндээ хэлэлцэгдэж бараг чадаагүй шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ хоёр тайланг сонсож байж, шинэ гаргах тэр удаан жил мөрдөх Үндсэн хуулиндаа тусгагдах янз бүрийн санаа

гарах вий гэдэг үүднээс ингэж авч үзэх нь зүйтэй юмаа гэсэн. Ийм санааг захисан байгаа юм, нэгд.

Ер нь Үндсэн хуулийг эхлээд хэлэлцлээ гэхэд үүнийг тодорхой хугацаанд мөрдөж эхлэх он сарыг заасан юм батлах нь зайлшгүй, тэгэхээр зэрэг Засгийн газар, Улсын Бага Хурлын тайланг сонсоход өнөөдөр бас тэгж эмзэглээд байх юм бол үүнд байхгүй байхаа гэж бодож байна. Энэ дээр нөхөр депутат Хурцын саналыг би дэмжиж байна. Тайлангий нь сонсоод, санал шүүмжлэл явуулахгүй, асуултаа явуулаад хэлэлцүүлэг явуулахгүй орхиё гэсэн энэ саналыг дэмжиж байна.

Ингээд энэ дээр нэг санааг хэлэхэд Хурлын дарга нэлээн хариуцлагаа дээшлүүлэхгүй бол болохгүй байна. Энэ дээр микрофонуудыг ухраадаг дарааллаар нь явуулаад, харин овоо замбараатай болж эхэлж байна.

Ингээд эцэст нь хэлэхэд ийм юм хэлмээр байна. Цөөнхийн саналыг, цөөнх болсон депутатуудын саналыг нэрээр авахгүй юу?

294 дүгээр тойргийн депутат Баярсайхан:

Тэгэхээр би энэ хэлэлцэх асуудлын дарааллыг ингэж өөрчлөх нь зүйтэй гэж бодож байна. Монгол Улсын Их цаазыг хэлэлцэхдээ бид хоёр хэлэлцүүлэг хийнэ. Нэгдүгээр хэлэлцүүлгээ одоо эхэнд нь оруулаад, ер нь Их цаазыг ямар Их цааз гаргах вэ гэдгийг ард түмэн хүсэн хүлээж байгаа. Тэгэхээр Ардын Их Хурлын хуралдааны I дүгээр хэлэлцүүлгээр, анхны уншилтаар ийм ийм юм нь жинхэнэ тогтжээ гэдгийг ард түмэндээ эхлээд зарлах хэрэгтэй байгаа юм.

Тэгээд бид дараагаар нь Бага Хурал, Засгийн газрынхаа тайланг хэлэлцье. Тэр хооронд ард түмнээсээ саналаа авъя. Бидний гаргаж байгаа шийдвэр, 430 хүний шийдвэр маань ард түмэн хүлээж авах юм уу? үгүй юу гэдгийг нь. Тэгээд түүнийгээ дараад нь Засгийн газар, Бага Хурлынхаа тайланг хэлэлцчихээд дараад нь хоёрдугаар хэлэлцүүлгэндээ ард түмнийхээ саналыг тусгаад шийдвэр гаргавал үнэхээр ард түмний маань санаанд нийцсэн Их цааз гарах

болов уу гэсэн ийм үндэслэлээр тэр 3 дугаар чиглэлийг дэмжиж байгаа юм. Энэ чиглэлээр бас бодож үзэх л ёстой зүйл.

Дараагийн нэг хэлэх юм, энэ үг хэлж байгаа улсууд дээр дэгээ жаахан барих юм бол Хурлыг удирдаж байгаа улсуудаас цагий нь бас харж байгаа юм болов уу? Түүнийгээ бас анхаараасай гэсэн ийм санал байна.

80 дугаар тойргийн депутат Л.Зарыккан:

Тэгэхээр хэлэлцэх асуудлын дарааллын тухай энэ асуудал бол Ардын Их Хурлын хуралдаан хийх бэлтгэл хангаагүйтэй холбоотой гарч байна гэж миний хувьд цөөнх болж байгаа юм. Яагаад вэ гэхээр хэрэв бидний гар дээр Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайлан байсан бол энэ асуудал огт яригдахгүй өнгөрөх байсан. Яагаад үүнийг шаардаж байна вэ гэхээр бидний дотор Үндсэн хууль байтугай, хууль баталж сурсан депутат цөөхөн байна.

Депутатуудын 80 гаруй хувь нь анх удаа сонгогдсон депутатууд. Тэр 60-аад оны үед Үндсэн хууль баталж байсан улсуудаас нэг нь ч алга байна. Тэгэхээр бидэнд материал их дутагдаж байна. Бидэнд өгсөн Ардын Их Хурлын тараасан материалд Их цааз гэсэн ганцхан цагаан дэвтэр байгаад, өөр ямар нэгэн тайлбар, аль заалт нь аль юунаас гаргаж авсан юм бэ? яасан юм бэ? энэ тухай юм байхгүй байгаа юм. Үүнтэй холбоотойгоор бид засаглалыг зөв хуваахын тулд одоогийн Бага Хурал хэр зэрэг ажиллаж юу нь болж, юу нь болохгүй байна вэ гэдэг дээр дүгнэлт хийх шаардлагатай байна.

Засгийн газрыг мөн тийм байдлаар бид дүгнэлт хийж, Их цаазад юу тусгав гэдгийг маш тодорхойгоор ярих шаардлагатай байна. Ийм учраас бид сая цөөнхийн санал болж, татгалзсан, дарааллаар. Ийм учраас эндээс гарах арга зам юу байна вэ гэвэл өнөөдөр бидэнд Бага Хурал, Засгийн газрын тайланг урьдчилан тараачихаад Их цаазынхаа төслийг хэлэлцээд явахад болохгүй юм байхгүй гэсэн ийм саналтай байна.

146 дугаар тойргийн депутат Д.Мөнхбат: Их Хурлын даргаас хүсэх асуудал байх юм.Энэ Их Хурлаар хэлэлцэх асуудлын, хэлэлцэж эхлэх үед үгээ хэлье гэж энэ микрофоны хоёр дээр зогсоод хэлж чадаагүй.Ерөөсөө маш шуурхайлаад, депутатуудынхаа үгийг сонсоогүй, дэгийнхээ журмыг баримтлалгүй, хоморголж батлуулсан энэ асуудал бол үнэхээр дутагдалтай байгаа юм.


Ийм учраас би энэ хэлэлцэх асуудлын дэс дарааллыг, дараалал бүрээр хэлэлцэж, үүнийг тогтоох нь зүйтэй байхаа гэсэн саналаа хэлье гэж бодож байна.Ингээд миний санал бол бид төрийн шинэ тогтолцоонд шилжиж ороод, Засгийн газар маань бид ерөөсөө зах зээлийн эдийн засагт шилжиж ороод жил гаруй хугацаа өнгөрлөө.Яг энэ хугацаанд, энэ Үндсэн хуулийн төслийг хэлэлцсэн.

Ийм учраас нэгэнт ийм үйл ажиллагаа явагдсан учраас заавал Бага Хурлын тайланг сонсч байж, Засгийн газрын тайланг сонсч байж, тэр дотроос Их цаазад асуудал тусна гэсэн асуудал үнэхээр бас учир дутагдалтай болов уу.Ийм учраас Их цаазыг ерөөсөө 4 дүгээр асуудалдаа оруулж хэлэлцье гэсэн ийм саналтай байгаа юм.

Харин Бага Хурлын илтгэлийг 5 дугаарт оруулж хэлэлцье. Бага Хурлын илтгэлийн дараа Засгийн газрын илтгэлийг оруулж хэлэлцье гэсэн ийм саналыг би оруулж байгаа юм. Ингээд эцэст нь хэлэхэд Их Хурлын дарга, орлогч нар дэгээ нэлээн бариач ээ.Дэгээ баталчихаад дэгээр үйл ажиллагаагаа явуулна гэж та өчигдөр өөрөө амлаж байсан.Ийм учраас ажил төрлийн үүргийн хуваарь баймаар байна.Хэн гэдэг хүн хичнээн удаа босч, хичнээн мину таар үг хэлж байна гэдэг хүртэл Их Хурлын дарга, орлогч нар гэсэн хуваарьтайгаар хяналт тавьж ажиллавал, хурлын үйл ажиллагаанд нэлээн тус хандив болох боловуу гэж бодож байна.

Ж.Уртнасан: Уучлаарай депутатууд аа.Дэгээ баримтлая. Одоо завсарлага 20 минут.

Соронзон хальстай тулгаж нийлсэн

 Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

Ж.Уртнасан -Хуралдаанаа үргэлжлүүлье. Манай зарим депутатууд Бага Хурлын дарга нарын ажлын хуваарийн тухай сонирхож байна. Бид танилцуулъя. Их Хурал дээр үг хэлж байгаа депутатуудын цагийн бүртгэлийг Батбаяр дарга бүртгэж тодорхойлж байгаа.Хэдэн удаа хэн үг хэлэв гэдэг нийт жагсаалтыг бидэнд Цахимтехник бидэнд гаргаж өгч байгаа юм. Та бүхэнд сонирхуулахад II-ний өдрийн хуралдааныхыг бид сонирхуулж болж байна. Хамгийн олон удаа 8-9 удаа үг хэлсэн хүн бол 427-р тойргийн депутат Ц.Элбэгдорж, 6-7 удаа үг хэлсэн хүн 132-р тойргийн депутат С.Чулуунбаатар, 5-6 удаа үг хэлсэн хүмүүс Д.Лүндээжанцан, Пүрэвдорж, С.Баярцогт нар юм. 3-4 удаа үг хэлсэн хүмүүс 15 байна, Баяр, Дашбалбар, Бямбаа, Зориг, Хатанбаатар, Пүрэвдорж, Энхсайхан, Лхагвасүрэн, Бат-Үүл, Адъяасүрэн, Энхбаатар, Лханаасүрэн, Шагдарсүрэн, Батбаяр, Гомбожав нар юм. 1-2 удаа үг хэлсэн хүн 86 хүн байна. Ингээд нэрээр гарч байгааг та бүхний анхааралд сонордуулъя.

Өнөөдрийн 17 цагийн завсарлага болон 14-15 цагт МСДН-ын бүлгийхэнтэй уулзаж санал бодлоо солилцох ёстой депутатууд 437-р өрөөнд ирнэ үү гэсэн зарлал байна. Одоо хуралдаанаа үргэлжлүүлье. Микрофоны дугаараар цаг, минутаа барьж явахыг та бүхнээс хүсч байна.

Б.Буяндэлгэр/188-р тойргийн депутат/ -Би түрүүнд таслуулсан шүү дээ, даргаа!

Ж.Уртнасан -Одоо 1-р микрофоноос явчихъя. Та хоёр дээр байгаа юм байна.

Ц.Дамцагдорж -/166-р тойргийн депутат/ -Надад тодорхой санал байна. Бүх илтгэлийг нэг зэрэг сонсоод, дараагаар шууд хэлэлцүүлэгтээ орёе гэсэн санал байна. Өөрөөр хэлбэл Их цаазын төслийг ард түмэн мэдэхгүй байгаа. Мөн Засгийн газар, Бага Хурлын үйл ажиллагааг ард түмэнд хүргээд, хэлэлцүүлэгтээ

ард түмэн, депутатуудынхаа саналыг сонсоё гэсэн саналтай байна.

Б.Буяндэлгэр/188-р тойргийн депутат/ -Бид тарааж өгсөн зүйлийн хүрээнд автаад өөр зүйл нэмж болохгүй юм шиг сэтгээд байна уу гэж бодогдоод байна. Өчигдөр дэг хэлэлцэж байхад бодогдож байсан. Мөн саяны хэдэлцэх асуудлын төлөвлөгөө дээр ч гэсэн. Үүн дээр нэг зүйлийг нэммээр юм.

Ерөнхийлөгчийн тайлангийн асуудал байна. Энэ нь Үндсэн хууль байгаа зүйл, Ерөнхийлөгч бидэнд тайлагнах ёстой юм. Энэ нь Ерөнхийлөгчийн тайланг хэлэлцэх сүүдчийн боломж ч байж магадгүй. Тайланг хэлэлцэх гэдгийг санаж байна. Үүнийг тараасан байгаа. Бид үүнийг хэлэлцэх ёстой, үүнийг хэлэлцэх асуудалд оруулах ёстой болов уу гэж бодож байна. Мэдээж Ерөнхийлөгчид хандах зүйл байгаа байх.

Бас нэг асуудал гэвэл Засгийн газрын үйл ажиллагааны тайланг Бага Хурлын тайлангийн дараа оруулах нь зүйтэй байх. Ноднин бид Бага Хурал, Засгийн газрыг эмхлэн байгуулсан. Бид эмхлэн байгуулсан Бага Хурлынхаа тайланг, мөн ажлын нэг жилийн үр дүнг бид эхлэж сонсох нь зүйтэй болвв уу гэж бодож байна.

Их цаазыг эхлэж хэлэлцэх нь зүйтэй. Бидэнд Их цаазыг хэлэлцэхэд , ер нь Бага Хурал, Засгийн газрын тайланг хэлэлцэхэд асуудал нэлээд хурцдана. Бидэнд Их цаазын төслийг хэлэлцэхэд нэгдүгээрт уужуу, тайван сэтгэл хэрэгтэй. хоёрдугаарт оюун ухаанаа дээд зэргээр шавхах хэрэгтэй. Улс, орон, хойч ирээдүйг ч бодсон үүнийг зайлшгүй хэлэлцэх зүйтэй болов уу гэж бодож байна. Хурц, Энэбиш депутатуудын хэлж байгаа нь сайхан санаа, гэхдээ энэ нь үндэслэл биш ээ.

Өнөөгийн тогтолцооны алдаатай, дутагдалтай тал нь юу байна, цаашдаа ямар тал дээр анхаарах юм, энэ нь аяндаа санал шүүмжлэлийн явцад энд сууж байгаа Бага Хурлын гишүүд, Засгийн

газраас сууж байгаа сайд, депутатууд аяндаа хэлэх учраас энэ нь хэлэлцүүлгийн явцад гарах болов уу гэж бодож байна.

Д.Жумдаанбаатар/180-р тойргийн депутат/ -Одоо асуудлаа тасалмаар санагдаж байна. Үүн дээр юу яримаар байна вэ гэхээр цөөнхийн хэлж байгаагаар ийм асуудал байна л даа. Төрийн тогтолцоо, хуучин явж ирсэн хууль нь Засгийн газрын үйл ажиллагаанд яаж нөлөөлсөнийг сонсоё гэж яриад байна. Үүнийг бодуштай юм. Буяндэлгэр депутат Ерөнхийлөгчийн хувьд ярьж байна. Бид Ерөнхийлөгчийн тайланг сонсож, үзсэн. Гэтэл тэр дотор явж ирсэн энэ төрийн тогтолцоо нь яаж нөлөөлснийг дүгнэлт өгсөн, зөрчилтэй талыг нь хэлсэн зүйл байхгүй байсан. Тийм учраас энэ талаар сонсвол ямар вэ гэсэн асуудлыг оруулаад, хэлэлцэх асуудлыг нь асуудал дотор нь оруулж нэгмөсөн тогтвол ямар вэ?

Засгийн газрын тайланг Бага Хурлын тайлан дотор Хийсэн ажлаа тайлагнасан болохоос төрийн тогтолцоогоор чухам ямар байдлаар ажил төрөлд нөлөөлсөн талаар юм ороогүй байж магадгүй учраас үүнийг оруулах талаас нь гол нь анхаарвал ямар байна вэ гэсэн санал байна. Ингээд асуудлаа тасалбал ямар вэ.

Д.Пэлжээ /416-р тойргийн депутат/ -Эрхэм депутатуудад мандаж уг хэлбэ. Цөөнхийн саналыг сонсож байгаа үед зөвхөн цөөнхийг төлөөлсөн хүмүүс уг хэлж баймаар байна. Хэрэв ингэхгүй бол хэлэлцүүлгийн шинжтэй болоод, хүн бүр яриад байна. Би бол олонхийн саналыг төлөөлж ярьж байгаа хүн. Үндсэн хуулийн төслийг дахин хэлэлцье гэсэн байр суурь дээр байна. Тэхдээ бид өнөөдрийг хүртэл ирсэн үр дагаварын тухай яримаар байна. Бид анхдугаар чуулганаасаа ямар алдаа хийсэн тухайгаа яримаар байна. Хүмүүсийн бухимдаад байгаа шалтгаан нь өнөөдөр Үндсэн хуулиа гаргалгүй байгаад бусад хуулиудаа гаргасан, эдийн засгийн бусад хуулиудыг гаргасан. Тийм учраас юуны өмнө

Үндсэн хуулиа хэлэлцэх ёстой. Үүн дээр маргах зүйл байхгүй гэж ойлгож байна.

Ч. Намсрай/183-р тойргийн депутат —Би цөөнхийн үүднээс хэлье гэж бодож байна. Түрүүнд депутат Хурц санал гаргасан, Адилбиш гуай дэмжлээ. Би мөн энэ саналыг дэмжиж байна. Үүн дээр би хоёр үндэслэл хэлмээр байна.

Бид улс орноо шинэ замаар явуулаад нэг жил явж байна. Өнгөрсөн анхдугаар хурлаас хойш улс төрийн шинэ тогтолцоог байгуулж өгсөн. Засгийн газар маань эрх зээлийн эдийн засагт шилжээд явж байна. Энэ хугацаанд болж байгаа ч юм бий, болохгүй ч юм байгаа байх. Муу бүхэн Засгийн газар, Бага Хуралтай ч холбоотой биш байх гэж бодож байна. Шинэ замаар явахад мэдээж алдаж, онож таарна.

Тиймээс өнөөдөр депутатууд бид нэг зүйлийг бодож анхаарвал сайн байна. Цөөнх болоод байгаа депутатууд Засгийн газрыг огцруулах, Бага Хурлыг огцруулах гэсэн бодлын өмнөөс бид өнөөдөр цөөнх болоогүй.

Бид өнөөдөр улс орныхоо нэг жилийн хөгжлөөр явсан шинэ замыг батлах, цаацрын замыг баталгаатай болгохын тулд Үндсэн хуулиа шинэчлэж, батлах гэж байгааг бид ойлгож байна. Үүнийг бид ойлгохгүй байгаадаа бид цөөнх болж асуудал тавиад байгаа юм биш ээ. Гол асуудал юу байна вэ гэхээр бид барилгыг суурьгүйгээр барьдагуйн адил бид Үндсэн хуулиа Засгийн газар, төрийн эрх барьж байгаа байгууллагынхаа ажлын тайланг сонсохгүйгээр хэлэлцэмгүй байна. Тухайлбал Улсын Бага Хурал Их цаазын төслийг боловсруулж оруулж байгаа. Хоёр удаа хэлэлцсэн. Өнгөрсөн анхдугаар Их Хурлаасаа парламентыг хоёр танхимтай байгуулсан, одоо нэг танхимтай болгохоор төсөлд тусгаад байна.

Бага Хурал яагаад ингэж тусгачихаад байгаа юм бэ гэсэн асуудал Бага Хурлын тайланд орж ирэх байх гэж бодож байна.

Тэхээр энэ гурван илтгэл нь эцсийн эцэст Их цаазыг хэлэлцэхэд саланги асуудал биш нэг асуудал гэж бодож байна. Зайлшгүй, суурийг нь авч үзэж байж, ер нь болж байна, болохгүй байна гэдгийг бүгдийг нь сонсож байж цааш нь юмаа яривал сайн байна. Тийм учраас депутат Хурцын тавьсан саналын дагуу эхлээд Бага Хурлын илтгэлийг дараа нь Засгийн газрын илтгэлийг сонсоод дараа нь Үндсэн хууль/Их цааз/-аа хэлэлцэх нь зүйтэй юм. Харин санал, шүүмжлэл явуулах явцад гурван илтгэлтэй холбогдсон санал, шүүмжлэлийг тусад нь явуулах нь зүйтэй юм.

Б.Сүмьяа/340-р тойргийн депутат/ -Надад хэн нэгэн хүн нөлөөлөх гэж оролдоогүйн адил би өөрийн бодол, саналаараа бусад депутатуудад нөлөөлье гэж бодохгүй байна. Бидний өнөөдрийн хуран цугларсан Их Хурлын хуралдаанд оролцож байгаа бидэнд ховорхон хувь заяа, ховорхон хариуцлагыг хүлээлгэсэн. Энэ үүднээс хуралдааны гол асуудал нь Их цааз буюу Үндсэн хууль гэдгийг би бүрэн ухамсарлаж байна. Үүнтэй холбоотойгоор нэг асуудал миний сэтгэлийг маш их зовоож байгаа юм. Бусад депутатуудын сэтгэлийг тийм хэмжээгээр зовоохгүй байж магадгүй. Тэр нь юу бэ гэхээр бид хэдэн арван жилд юм уу, зуун жилд тохиолдох үйл явдалд оролцоход хир зэрэг бэлэн байна вэ гэсэн асуудал миний сэтгэлийг маш их зовоож байгаа юм. Тэр нь юу бэ гэхэд бид Их цааз буюу Үндсэн хуулийг батлахыг тулд ямаршуу хэмжээний гар тээштэй гээр энэ тэнхимд орсон вэ гэсэн асуудал нь юуны урд ардчилал хөгжсөн, олон арван жилийн ардчиллын туршлагатай тэдгээр улсуудын хууль цаазат төрийн үндсэн хууль ямар байдрыг нэгбүрчлэн бид үзэж танилцсан уу? Миний хувьд бол чадаагүй ээ.

Бидний нэрийг нь авч хэрэглэхгээд байгаа Их цааз гэдгийг хэдэн хүн уншсан юм бэ, жинхэнэ эхээр нь, үүнийг би уншсан гэж хэлж болно. Цаашилбал манайд улс төрийн шинэ тогтолцоо бий болсноос хойш энэ төр, засгийн байгууллагуудын үйл ажиллагаа яаж явж ирсэн бэ гэсэн талаар надад мэдлэг бага байна, зөвхөн

хөндлөнгийн ажиглагчийн байрнаас үзсэн мэдсэнгүйл бага зэрэг ийм байгаа юм. Тэхээр энэ асуудал, Үндсэн хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах комисс, депутат бидэнд үнэнийг хэлэхэд зохион байгуулж өгөөгүй шүү дээ. Үүнтэй холбож би саналаа өгсөн. Саналаа өгчихөөд харж байхад би цөөнхөд орчихсон юм байна. Миний санал нь эхлээд Засгийн газар, Бага Хурлын тайланг сонсох ёстой гэсэн саналтай байгаа юм. Гэхдээ би энэ гурван асуудлыг бүхэл нэг асуудал гэж үзэж байна. Тэр битгий хэл түрүүчийн Их Хурлын хуралдааны өмнө Ардын Их Хурлын тухай өгсөн товч мэдээллийг ч гэсэн, өнөөдрийн хөндлөцөж байгаа гол асуудал Их цаазын тухай асуудлын нэг хэсэг гэж бодож байна. Тэхээр эд нарыг бүгдийг нь нийлүүлээд нэг асуудал, үүн дээр тулгуурлаж бид улс орныхоо дотоодод улс төрийн шинэ туршилт хийсэн нэг жилийн дүн дээр тулгуурлаж Их цаазын төслийг батлах ёстой гэж бодож байна. Энэ үүднээс би тэр саналыг өгсөн. Үүн дээр түрүүчийн нөхдүүд хэлсэн учраас тэр саналыг нь дэмжиж байна. Энэ нь Их цаазыг ул үндэстэй батлахын үндэс суурь болох юм. Энэ нь жирийн тайлан биш ээ. Хэрэв жилийн тайлан, хийсэн ажлаа тооцсон тийм зүйл байвал Их Хурлын депутатууд бид хүлээж авахгүй гэж бодож байна. Түүнээс хийсэн улс төрийн дүгнэлт, яагаад хоёр танхимтай гэдэг нь хэрэг дээрээ болохгүй байгаа юм. Засгийн газрын үйл ажиллагааны юу нь болж, болохгүй байсан. Энэ бүхэнд нарийн анализ хийсэн, дүн шинжилгээ хийсэн тийм илтгэлийг оруулж ирвэл депутатууд бид хүлээж авна. Түүнээс хуучин маягийн тайланг Их Хурлын хэлэлцэх асуудлыг бид хүлээж авах үндэсгүй гэж бодож байна.

Үүн дээр миний сэтгэлийг эмзэглүүлж байгаа зүйл юу бэ гэхээр харддаг, сөрддэг уур амьсгал ердөө тасрахгүй байна. Жишээ нь Их цаазын төслийн урд нь үүнийг нь хэлэлцчихье, түүн дээрээ үндэслээд Их цаазынхаа асуудлыг хэлэлцье гэхээр Улсын Бага Хурлыг тараах гэж байгаа юм шиг, эсвэл Засгийн газрыг унагах гэж байгаа юм шиг хардлага, сөрдлөг яваад байх шиг байна. Цаанаа тийм зүйл явж байгаа юу, үгүй юу, мэд. Миний хувьд тэгсэн юм байхгүй. Би Бага Хурлын үйл ажиллагааг хэдийгээр алдаа, дутагдал байсан ч гэсэн их зүйл богино хугацааны дотор хийсэн гэж бодож байна. Мөн бололцооныхоо хирээр ажилласан

Би Бага Хурлыг дэмжих санал өгнө. Гэхдээ хардах, сөрдээд байх үндэс байх үндэс байхгүй гэдгийг хэлж байгаа юм.

Эцэст нь хэлэхэд бид зөрүүтэй саналыг, хэн, хэнийхээ саналыг хүндэтгэж үзэж, харилцан бололцоотой зүйл дээр буулт хийж, зөвшилцд хурч байх нь зүйтэй юм гэж бодож байна. Энэ талаар хамгийн ухаалаг саналыг н.Хурцыг гаргалаа гэж бодож байгаа учраас би Хурцын саналыг дэмжиж байна. Тиймээс дахин санал хураах нь зүйтэй болов уу энэ асуудлаар.

Д.Пүрэвдорж/128-р тойргийн депутат/ -Миний хувьд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журмыг зөвшөөрч байгаа олонхийн нэг юм. Гэхдээ дэс, дараалал дээр ганц санал байна. Эхлээд бид Үндсэн хуулиа хэлэлцэх нь гарцаагүй ээ. Монголын ард түмэн шинэ Үндсэн хуулиа тэсэн ядан хүлээж байгаа. Гэхдээ Үндсэн хуулиа хэлэлцүүлэхдээ Ерөнхийлөгчийн илтгэлийг сонсоод, асуултаа гаргаад, эхний удаагийн саналаа ярилцсаны үндсэн дээр, эхний удаа хэлэлцүүлэг дууссаны дараагаар ажлын комисст ажиллаж байх энэ хугацаанд Бага Хурал буюу Засгийн газрын тайланг сонсоё гэсэн түрүүчийн хүмүүсийн саналтай нэг байна. Зөвхөн сонсоно, үүн дээр ярилцахгүйгээр дараагийн хоёр дахь удаагийн хэлэлцүүлэгт/Үндсэн хууль/ шилжиж орох нь зүйтэй байх гэсэн санал байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт Ерөнхийлөгчийн тайланг хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй болов уу гэсэн түрүүчийн саналтай нэгэн адил байна. Тухайлбал хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний 6-рт оруулах. Мөн түүнчлэн бусад асуудал гэж энэ төлөвлөгөөнд орсон байна. Энэ бусад асуудал гэдэгт зарим тодорхой асуудлыг нэрээр нь энэ төлөвлөгөөнд оруулж өгвөл яасан юм бэ? Энд юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр Банкны гадаад үйл ажиллагаа буюу алт, диллерийн тухай асуудлыг гарцаагүй авч ярих нь, энэ асуудлыг Засгийн газрын тайлантай хамтатган хэлэлцэх шаардлагагүй, тусад нь асуудал болгож хэлэлцэх нь зүйтэй болов уу гэсэн саналтай байна. Тийм учраас энэ асуудлыг төлөвлөгөөнд оруулж, Засгийн

газрын тайлан тавьсны дараагаар, түүний дараагийн дугаарт оруулж, төлөвлөгөөнд оруулж, тодорхой асуудал болгон төлөвлөгөөнд оруулж батлуулснаар энэ асуудлыг авч хэлэлцэх нь зүйтэй болов уу гэсэн саналтай байна.

Соронзон хальстай тулгаж нийлсэн

Ц.БАЯРМАА

Бичээч

С.ТУУЛ

381-р тойргийн депутат Н.Цэрэнхүү: -Хэлэлцэх асуудлын талаар депутат Хурц, Гүрбазар нарын саналыг хүндэтгэж байна. Гэхдээ нэг санал хувилбар байна. I-рт бид нар Үндсэн хуулиа хэлэлцэх нь зүйтэй. Гэхдээ Үндсэн хуулийн доторхи асуудлуудыг боловсронгуй зөв оновчтой шийдвэрлэхийн тулд зарим нэг танин мэдэхүйн ач холбогдолтой ойлголтын үүднээс Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайланг Хурцын саналаар сонсох нь зүйтэй байна. Ингэхдээ эхлээд бэлгэ дэмбэрэлээ бодож Ерөнхийлөгчийнхээ Үндсэн хуулийн илтгэлийг сонсоод хэлэлцүүлгэ явуулахгүйгээр Засгийн газрын тайланг сонсоод асуулт хариулт явагдаад дараад нь Бага Хурлынхыг сонсоод тэгээд эргээд Үндсэн хууль дээрээ хэлэлцүүлгээ өргөн хэмжээгээр явуулж эхний ээлжинд батлая гэсэн ийм саналтай байгаа юм. Ингэхийн тулд Ерөнхийлөгч, Засгийн газар, Бага Хурлын тайлан тавьж байгаа тайлангуудыг эх орон даяар телевиз, радиогоор нэвтрүүлэх шаардлагатай байгаа юм. Энд буцаад бид нар сонгогч нартайгаа ямар нэгэн байдлаар урвуу холбоо мөн гаднах атмосферийг мэдэхэд ч гэсэн тус нэмэр болох болов уу гэж бодож байна. Ийм санал байна.

63 дугаар тойргийн депутат Ж.Пүрэвдагва: -Энэ дээр хэлэлцэх асуудлын дараалал дээр депутатын хувьд бодож үзэхэд энд бол учир зүйн холбоо байна гэж ингэж үзэж байна. Юуны өмнө бид нар Их цаазынхаа төслийг хэлэлцэж өр нь ямар хэмжээний урт удаан хугацаанд үйлчлэх нэлээн тогтвортой байх Үндсэн хуулийг улс орныхоо шинэ Үндсэн хуулийг батлах гэж байна вэ гэж би ингэж ойлгож байна. Энэ Үндсэн хууль бол шилжилтийн үеийн юм уу, завсарын үеийн юм уу, тийм нэг богино настай үндсэн хууль байх ёсгүй байх гэж бодож байна. Үүний учраас хэрвээ бид нар эхлээд Бага хурал, БНМАУ-ын Засгийн газрын тайланг хэлэлцэх юм бол магадгүй миний ойлгож байгаагаар тайланд энэ Үндсэн хуультай холбоотой асуудал нь дийлэнх биш улс орны өмнө тулгарч байгаа хүндрэлтэй, бэрхшээлтэй асуудлууд өнөөдрийн асуудлууд нэлээн яригдах байх гэж бодож байна. Хэрвээ ийм байдлаар Бага Хурал, Засгийн газрын тайланг хэлэлцээд дараа нь Үндсэн хуулийнхаа төслийг хэлэлцэх

км бол магадгүй өнөө маргаашийн энэ хүндрэлтэй байдлыг Их цаазынхаа төсөлд тусгах эрмэлзэл сонирхолд автагдаж энэ утгаараа Их цаазын Их цааз, Үндсэн хууль маань богино настай км болж гарч магадгүй гэсэн ийм эмзэглэл төрж байгаа км. Нөгөө талаар бас нэг үндэслэл байна. Одоогийн төрийн тогтолцоонд өөрийнхөө байр суурийг эзэлж ажиллаж байгаа Ерөнхийлөгч БНМАУ-ын Бага Хурал, Засгийн газар, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа хууль хяналтын байгууллагуудын санал дүгнэлт, энэ шинэ хуулийн төслийг боловсруулахад ямар нэгэн хэмжээгээр бүгд оролцсон байх гэж би бодож байна. Ийм учраас хэрвээ Их цаазын төсөлтэй холбоотой энэ төрийн тогтолцооны байгууллагуудын санал дүгнэлтийг сонсоно гэж байгаа бол нэг өөр хэрэг байх. Тэр төсөлдөө туссан байх. Ийм л саналтай байна. Ийм учраас хэлэлцэх асуудлын дарааллыг хэвээр нь үлдээх ийм саналтай байгаа.

10-р тойргийн депутат О. Дашбалбар:

-Би Их хурлын депутатуудын анхааралд нэг км толилуулъя гэж бодож байна. Олонхийн санал дандаа зөв байдаг гэсэн хаанахын ямар хууль байдаг км бэ. Олонхийн санал үнэхээр зөв байдаг бол большвекууд 70 жил олонхи гэж яваад тэгээд зөв нь хаанаа байгаа км бэ. Энийгээ эргэж бодооц. 2-т бол би бүх депутатуудыг эргээд өнгөрсөн их хурлаа нэг санаасай гэж санаж байна. Тэр үед би сануулж байсан. Бид ерөөсөө яараад, сандраад аль эсвэл хэн нэгийгээ үг хэлэхийг хориод ингэснээрээ амжилтад хүрэхгүй байна. Жишээлбэл намайг 3 хоногийн өмнө депутатуудын семинар хийж байх үед хэлсэн, . . . жужиг найруулж байна аа гэж. Тэгэхэд Гомбожав гуай зохиолч Дашбалбар иймэрхүү үг дандаа хэлдэг ээ гэж ингэж хэлж байсан. Тэгэхээр энийг би баримтаар хэлье гэж бодож байна. Яагаад жужиг найруулж байна гэж хэлж байгаа км бэ гэхээр өнгөрсөн их хурлын үед бид Бага Хурлыг сонгохдоо бүтэн 2 хоног нойр хоолгүй 10 цаг хүртэл хуралдаад ингээд бидний арьс мах болсон биеийг орой нь өдөржин хуралдуулчихаад үдэш нь яг тарах гэж байхад хүн амьтан ядраад хоолоо идье явья гэж байхад та нар саналаа өгөө гэж хэлээд тэгээд санал хураалтасан. Тэр саналыг өгөхөд бүх

улсууд явах гэсэн тийм сэтгэхүй дээр ээ тоглоод нийт АИХ-ын депутатуудын 200 гаруй хүн буюу өөрөөр хэлбэл 50-иас нэлээн дээгүүр хувь нь Бага Хурлын талаар ямар ч ажил явуулаагүй тэр саналын хуудсыг хоосон нугалаад хийчихсэн байсан би комисст байсан учраас энийг сайн санаж байна. Иймэрхүү маягаар бид тоглуулаад байвал энэ Үндсэн хууль чинь Үндсэн хууль болтол байтугай юу ч болж чадахгүй нээ гэдгийг би хэлэх гэсэн юм. 2-т гэвэл аль 3 сард бид Засгийн газар, Бага Хурлын тайланг сонсьё гэдэг асуудлыг Улаанбаатар хотын бүх депутатууд тавьсан. 60 хэдэн депутатуудын саналыг бид өөрсдөө энэ саналыг тавиад орон нутгийн депутатуудад уриалга явуулаад санал нэгтгэй гар өргөөд батлалчихсаны маргааш нь өнөөдөр Ардын эрх сонин тавина гэж авчихаад депутат нөхөр Балдорж байж байсан. Тэгсэнхэрнээ маргааш нь болохоор тэр 60- хэдээс 2-хон хүн оруулсан. Нэг нь Радио телевизийн дарга Алтай, нөгөөдөх нь аварга Баянмөнх, маргааш нь 2 хүн бидний буруу байжээ, бид 2 татгалзаж байна гэж хэлсэн. Бусад нь санал дээрээ хэвээр үлдсэн. Ингээд эцсийн эцэст бид яасан бэ гэхээр улс орон байдалхүндэрлээ. Ийм нөхцөлд ямар ч байсан Их Хурал Бага Хурал Засгийн газрынхаа тайланг хэлэлцээд энэ хамтын оюун ухаанаар энэ асуудлаас яаж гарах вэ гэдгийг шийдье ер нь одоо ард түмэнд тулган хүлээлгэж байгаа юм их байна аа гэдгийг бид ярилцсан. Энийг тэр улсуудын санал юу ч биш болсон, маргааш нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Бага Хурлын дарга бүрэн бүрэлдэхүүнтэйгээ орж ирээд хүүхдүүдийн хэлдгээр биднийг будаа болгочихсон. Браг л одоо Засаг, төрийн эсрэг бослого гаргаж болышведууд ардчиллыг үгүй хийж гэж байна аа л гэж хэлсэн байх. Гэтэл тэнд ардчилсан хүчнийхэн өөрсдөө зөндөө олон хүн гар өргөсөн байсан шүү. Энийгээ эргэж санаач ээ гэж бодож байна. Одоо яагаад жүжиг найруулж байна гэж хэлэх гээд байгаа юм бэ энийг би өрөөсөө хатуу анхаараасай гэж санаж байна. Жишээ нь эхний ээлжийн суудлууд бол АИХ-ын депутатууд тойргийнхоо дугаараар суудал дээрээ сууж байгаа. Энд тойргийн дугаараар сууж байсан бүх хүмүүсийг босгоод өөр суудал дээр суулгаад одоо Бага Хурлын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, байнгын хороодын дарга бүгд энэ урд сууж байна. Энийг би жүжиг найруулж байна гэж үзэж байгаа. Найруулсан жүжигт нь та бид оролцон тоглож байна гэж үзэж байгаа. 2-рт би юу хэлэх гэж байна гэхээр энд утас тавь-

чихаад утсаар Их Хурлын удирдагчдыг Бага Хурал удирдаж байна гэж үзэж байна.

Яагаад гэвэл зарим асуудал дээр ингэж толгой сэгсэрч байна, зарим юман дээр ингэж болохгүй гэж ингэж хэлж байна, энэ бүгд чинь яаж байна гэхээр өнөөдөр бид энд ямар нэг сэтгэхүйн ийм нэг жүжгэнд оосорлуулчихаад өөрсдөө шийдвэр гаргах ийм боломжоо алдаж байна. Өглөө ерөөсөө шууд бидэнд Их Хурлын дарга тулган хүлээлгээд гар өргүүлээд зөвшөөрүүлчихсэн. Яагаад гэхээр энийг хэлэлцүүлэх байсан, янз бүрийн юм болох байсан. Энийг би ноцтой анхаараазай гэж бодож байна. Яагаад би Бага Хурлын Үндсэн хуулийг сүүлд нь хэлэлцэж болно. Энийг бол угүйсгэхгүй. Яагаад би Их Хурал Бага Хурал, Засгийн газрыг түүнд нь хэлэлцье гээд байгаа юм бэ гэхээр энд надад нэг зовлон байна. Энэ бол бид 20-иод хоног хуралдчихаад ядраад, ёстой дөнгөж хурал эхлэхэд бид удаан хуралдахгүй, эртхэн ар тийшээ явна шүү гэж хэлж байсан деунатууд маань юун та нар битгий юм дэмий дөнгөсөөд бай, Засгийн газар, Бага хурал ямар хамаатай юм, одоо бид явлаа, ядарч байна, өөрөөр хэлбэл энийг сайтар найруулсан жүжиг байна гэдгийг би энүүгээр батлах гэсэн юм. Яагаад гэвэл бид ядарна, бид 20-иод хоног хуралдана. Сүүлд нь Засгийн газар, Бага Хурал 2-ын асуудал хэлэлцэх үед бид идэвхтэй энийг хэлэлцэж чадахгүй болно. Ингээд өнөөдрийн тогтолцооны бүх алдаа дутагдал хэвээр үргэлжлэх ийм боломжийг нээгээд өгч байгаа юмаа. Түүнээс биш бид Бага Хурлыг байхгүй болгоно гэсэн юм байхгүй. 2-т гэвэл бид замд гарчихсан хүний хойноос пээ тийм юм нь өгөөд явуулчихдаг байж гэж хэлэхгүйн тулд энэ өнөөдрийн засаг төрийн тогтолцоо чинь яг хэвээрээ энэ Үндсэн хуулинд тусгагдаж байгаа. Энийг энэ хэвээр нь тусгахад юуг анхаарах вэ, юуг анхаарахгүй вэ гэдгийг бид одоо Засгийн газар, Бага Хурлын тайланг хэлэлцэж байж шийдэх ёстой. Өөр ямар ч арга байхгүй. Нөгөө талаар гэвэл энд би бас нэг юманд санаа зовоод байна. Элгээр нь мөлхүүлнэ гэж хэлээд байгаа. Тэгээд элгээр нь мөлхүүлэхгүйн тулд би Засгийн газрын тайланг эхэлж сонсьё, ард түмнийхээ эрх ашийн үүднээс гэж ингэж бодож байгаа юм. За өөр бас нэг юманд санаа зовж байна. Хэрвээ олон түмэн бол Засгийн газар, Бага Хурлыг эхэлж авч хэлэлцээсэй гэдэг ийм сонирхол бол маш их байгаа. Тийм сонирхолгүй хүчин ч байгаа байх. Гэхдээ хэргийн учир нь эндээ

байгаа биш, ямар ч л байлаа гэсэн бухимдсан олон түмэн үндсэндээ орон даяар ажил хаялт хийгээд эхлэх юм бол та бид өөрсдөө тэртэй тэргүй туйлдаж байгаа эдийн засгаа улам туйлдуулахад хувь нэмрээ оруулна гэдгийг санаачээ гэж хэлэх гэсэн юм. Үндсэн хуулинд байгаа асуудлууд Их Хурал нэртэй бага хурал л батлагдах гээд байна шүү дээ. Одоогийн тогтолцоо яг хэвээрээ, тэрнийгээ тулган хүлээлгэхийн тулд өнөөдөр бүх кмыг хийж байна гэдэг ийм кмыг хэлэх гэсэн юм. Түүнээс гадна зарим депутатууд тэнд үйлчлээд байгааг ерөөсөөч ойлгохгүй байна. Гарч ирээд Бага Хурал сайн ажиллаж байна гэж хэлж байна. Бага Хурал сайн ажиллаж байна, Засгийн газар сайн ажиллаж байна гэж хэлэхэд одоо хэн итгэх юм энийг ойлгоход хэцүү байна. За ингээд би бол үндсэндээ санал өндөрлөх тийшээ хандаж байна. Ер нь эцсийн эцэст бид нар хуурагдана шүү, би энийг харин хатуу хэлчихье. Бямбасүрэн орж ирээд сайхан зөөлөн дуугаар яриад эхэлнэ. Тэгээд 20 минут, 30 минут бид нарыгаа паналдчихаад л гараад явчина. Өөр зам байхгүй. Ерөөсөө ч одоо ингэж бид хуурагдаж байгаа, Бямбасүрэн бол биднийг удаа дараа хуурсан. Ард түмнээ удаа дараа хуурч байгаа. Өнөөдөр дахиад л хуурагдана, сэтгэхүйгээр тоглож байна шүү. За ингээд хамгийн сүүлд би нэг үг хэлье. Бага Хурал байхгүй ингээд хэрвээ бүрэн эрхийг дуусгачихвал субъектгүй болно гэж байна, Үндсэн хууль хэлэлцэх. Үндсэн хууль хэлэлцэх субъект байгаа. Яагаад гэвэл Ерөнхийлөгч Үндсэн хуулийн комиссын дарга нь бөгөөд түүнийгээ хэлэлцүүлэх бүрэн чадвартай үлдэнэ гэж ингэж санаж байна. Идэх, уух кмгүй өлссөн зовсон нь зөвхөн биднийг харж байгаа байх, Тэр ард түмнийхээ сэтгэлийг нэгдүгээрт бодох хэрэгтэй, 2-т Монгол улсын 70 жилийн түүхэнд гараагүй гэмт хэрэг үйлдчихээд байгаа Засгийн газрыг бид өмгөөлөөд байгаа шүү. Энийгээ санаарай.

II5-р тойргийн депутат Б. Даваасүрэн: -Үндсэн хуулиа эхэлж хэлэлцэх санал байна. Миний өөрийн санал бол Үндсэн хуулийн I дүгээр хэлэлцүүлгийг хэлэлцсэний дараагаар Бага Хурлын тайлан болон Засгийн газрын тайланг хэлэлцэж болохгүй юу гэсэн хувийн саналыг оруулах байна. Ингээд олонхи санал давхардаж байгаа учраас санал хураах асуудалдаа ормоор байна. Нөгөө талаар Их хурлын даргад хандаж хэлэхэд Булган аймгийн II9 дүгээр тойргийн депутат Цэен-Ойдовын асуудлыг шийдэж өгөх-

гүй бол ажиглагчийн байраар санал хураах апаратгүй сууж байгаа байдлыг ойрын хугацаанд харгалзаж үзэхийг хүсч байна.

141-р тойргийн депутат Ж.Авхиа: -Эрхэм хүндэт депутатууд аа АИХ-ын энэ удаагийн сонгуулийн 400 гаруй депутат та бидэнд онцгой хариуцлагатай түүхэн үүрэг ноогдож байгаа гэж үзэж байна. Энэ болбол Монгол улсын их цааз, Үндсэн хуулийн төслийг батлах явдал юмаа. Энэ бол бидний хувьд нэр төрийн хэрэг, энэ хурлын хувьд бол онцгой үйл явдал аа. Ер нь аливаа асуудлыг бид шийдэхдээ уг асуудлын ач холбогдлыг бас авч үздэг учиртай байгаа. Өнөөдрийн энэ хуралдаанаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудын дотор чухал талаас нь аваад үзвэл Их цаазынхаа төслийг хэлэлцэхээс өөр аргагүй юмаа. Ер нь Ард түмнээ сэтгэл эмзэглүүлсэн олон асуудал энэ Их цаазын төсөлд байгаа энийг ямар замаар хэлэлцэж, яаж шийдэхийг олон түмэн маань хүлээж байгаа. Ийм учраас миний санал болбол олон депутатуудын нэгэн адил Их цаазаасаа эхэлбэ гэж ингэж бодож байна. Ингэхдээ болбол зарим нөхдүүд ярьж байна. Ер нь анхныхаа хэлэлцүүлгийг хийчихээд дараагаар нь Бага Хурлын тайлан, Засгийн газрынхаа тайланг хэлэлцбэ гэж, ер нь Их цаазынхаа төслийг хэлэлцэх асуудлын төгсгөлийг задгай орхиод ингэж хэлэлцэх нь болбол илүү зохимжтой байж болох юмаа. Засгийн газрын тайланг биш эхлээд Бага Хурлын тайланг сонсох нь зүйтэй гэж бодож байна. Яагаад гэвэл Бага Хурал бол манай төрийн тогтолцооны нэг чухал хэсэг. Шууд холбоотой байгаа манай хуралдаантай. Ийм учраас Бага Хурлаас эхлэх нь зүйтэй юмаа. Хэлэх зүйл юу байна вэ гэвэл энэ Үндсэн хуулийн хавсралт хууль бол төрийн удирдлагын харилцааны чухал асуудлыг нэгэн цаг үед зохицуулах маш чухал хуулийн төсөл байна. Ийм учраас энэ хуулийн төслийг хэлэлцэх явдал энэ хэлэлцэх хэргийнхээ төлөвлөгөөнд албан ёсоор оруулж өгөх нь зүйтэй гэж ингэж үзэж байна.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ж.Авхиа

Ш. БУРМАА

92 дугаар тойргийн депутат Г.Бүдээ:

-Би бусдыг

дууриаж кнопон дээр гар дараагүй. Олонхийн талд байгаа юм байна. Гэхдээ цөөнхийн саналыг хүндэтгэж байна. Дуулмаар, бодмоор юм их байна. Олон янзын санаа нэлээн ярих нь зүйтэй болов уу даа гэсэн ийм юмнуудыг гарч ирлээ. Ингээд бодохлоор улс орон маань харж байна, бид нарыг, дэлхий нийтээрээ харж байна. Энэ танхим ихээхэн хариуцлагатай, эгзэгтэй цаг мөчид тулж ирсэн. Энийгээ дугаарлаад үзэхээр Үндсэн хууль бууу Их цааз яриа байхгүй I дүгээрт ороод байх юм. Олон түмэн бухимдаж байгаа нь үнэн. Бага Хурлынхаа үйл ажиллагааг, Засгийн газрынхаа үйл ажиллагааг олон түмэн ч мэдэж байгаа. Бид ч мэдэж байгаа. Юутай ч байсан I дүгээр асуудал дээрээ анхаарлаа төвлөрүүлээд энүүнийгээ батлаад авбал дараачийн асуудлууд нэг их хохироод байхгүй болов уу.

Засгийн газрынхаа үйл ажиллагаа, Бага Хурлынхаа үйл ажиллагааг урьдаар сонссоноор бухимдлыг дарчих тооцоо ямар янзын тооцоо байгаа юм бол оо. Харин ч аль аль ч үгүй самруулаад нөгөө Их цаазынхаа төслийг оруулж ирэх субъектээ сэтгэл санааны хувьд, хүний хувьд унагаана. Ингээд үймүүлээд хаячих вий дээ гэсэн юм дотор бодогдоод ерөөсөө болохгүй байна аа. Энүүнийг сонордуулах гэсэн юм.

425 дугаар тойргийн депутат П.Ганзориг:

-Цөөнх

дотор үндсэндээ хоёр хуваагдаад байна гэж ойлгож байна. Нэг хэсэг нь болохоор Засгийн газраа буулгах, нэг хэсэг нь Засгийн газрыг буулгахдаа гол биш, хамгийн гол нь Үндсэн хуулиндаа энэ Засгийн газар, Бага Хурлын явж ирсэн энэ туршлагыг ашиглаж, Үндсэн хуулиндаа оруулах саналаа тодруулах ийм хэсэг болчихоод байх шиг байна. Бид нэгэнт санал хураасны дараа явж байгаа болохоор цөөнх болсныхоо үгийг сонсох хэрэгтэй байна шүү дээ. Гэтэл цөөнх ярьж байхад дундуур нь олонх нь орж ирээд үймүүлээд зарчимгүй яваад байх шиг байна.

Бага Хурлаар хэлэлцэгдсэн төслийг ард олон үнэндээ хараагүй байгаа шүү дээ. Олон түмэнд хэвлэл мэдээллээр, олон түмний өгсөн саналыг энэ төсөлд тусгаагүй гэж байн байн мэдээ-

лээд байхад бид энд шууд төслийг хэлэлцээд эхэлж болохгүй байна. Тийм учраас Их цааз, Үндсэн хуулийнхаа төслийг эхлээд сонсьё. Тэгээд Засгийн газар, Бага Хурлынхаа тайланг хэлэлцвэл яасан юм бэ? Энэ хугацаанд энэ төслөө сонинд тавих хэрэгтэй байна. Тэгээд ард олонг сонсоод, тэр сониноос үзээд өөрсдийнхөө саналыг ирүүлэх боломжтой болох юм биш үү.

Улсын Бага Хурал, Засгийн газрын ажиллаж ирсэн зарчим бол үндсэндээ зах зээлийн зарчим, цаашид бидний замнах зарчмаар ажиллаж ирсэн, үндсэндээ. Тийм учраас эндээс маш их санаа оноо гарна гэдгийг анхааруулмаар байна.

282 дугаар тойргийн депутат Д.Лхагвасүрэн: -Тэгэхээр бид цөөнхөд санал өгсөн хүн. Тэгээд энэ чиглэлээр зориуд ярья гэж бодсон юм. Юуны өмнө бид өргөн олон түмнээ төлөөлж энд хуран цуглараад ярилцаж байгаа болохоор бидний шийд энэ цаана байгаа өргөн олон түмний итгэл найдварыг хүлээн, тэдний санаа сэтгэлд нийцсэн ийм шийд бид гаргаж байх хэрэгтэй байх гэж бодож байна.

Тэгэхээр бид энэ Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайланг эхэлж хэлэлцүүлэх гээд байгаагийн учрыг ерөнхийд нь хүмүүсүүд тайлбарлачихлаа. Гол учир утга нь ерөөсөө төр, засгийн одоогийн тогтолцоо ямар байгаа юм бэ? Энэ чинь цаашдаа ер нь хэн нь хэнийгээ яаж бариад яагаад байгаа юм бэ? Энэ зөв юмуу, буруу юмуу гэдгийг бид тайлангаас дүгнэлт хийх хэрэгтэй гэж бодож байгаа юм.

Олон түмэн ч, сонгогчид маань ч гэсэн хэн нь яаж удирдаж байгаа, энэ эх орныг, хэн хариуцах юм гэдэг асуудлыг бидний өмнө тулгаж тавьж байгаа. Тэгэхээр Бага Хурлаас баталж гаргасан Их цаазын төсөл бол үндсэндээ ард түмний саналыг аваагүй төсөл. Тийм учраас ард түмэн энд бухимдаж байгаа юм. Ард түмний дийлэнх олонхийн саналыг энд няц цохисон. Тэгэхлээр Бага Хурлын тайланг эхэлж хэлэлцэх хэрэгтэй гэсэн саналыг зориулж энд оруулж байна.

Дараа нь би бусад асуудалтай холбоотой нэг, хоёр санал хэлье. Энэ бол хавсралт хууль, прокурор, шүүхийн тайлангийн асуудлыг энд хэлэлцүүлэхээр оруулах саналыг тавьж байна.

Гуравдугаарт, би эцэст нь хэлэхэд бид, депутатууд маань өөр өөрийн байр сууриа хадгалж байх хэрэгцээтэй байна. Зарим үед санал авахад хэт их хэлбэлзсэн, нэг асуудлаар хоёр, гурав авахад хэт хэлбэлзэлтэй тоо тэр самбар дээр гарч ирж байна. Тэгэхээр энэ дээр бол бид их анхааралтай хандвал яасан юм бэ гэсэн саналтай байна.

Нөгөө талаар би Их Хурлын даргад хандаж энэ эгзэгтэй санал авах гэж байгаа үед тэр анхааруулж, хонх дуугаргахаас өмнө тодорхойхон шиг хоёр, гурав хэлж байж санал авахуулж байхгүй бол хуучин авч байсан саналдаа ташаарч кино дарах асуудал байна уу даа гэж ажиглагдаж байна.

350 дугаар тойргийн депутат Ц. Давааням: -Би татгалзаж санал өгсөн 60 хүний нэг ээ. Эхлээд Их цаазын төслийн хэлэлцэх асуудлаар би яарамгүй байна гэж бодож байна. Эхлээд Бага Хурлын тайлан сонсох нь зүйтэй. Дараа нь Засгийн газрын тайлан сонсох нь зүйтэй. Ингэснээрээ бид нийт ард түмэнд Засгийн газрын юу хийснийг, Улсын Бага Хурлын юу хийснийг тайлагнасны дараагаар бид эргээд энэ танхимдаа, ард түмэнтэйгээ, сонгогчид-тойгоо дахин уулзах бололцоотой учраас би татгалзаж санал өгсөн юм.

Ийм учраас эхлээд Бага Хурлын тайлан хэлэлцье гэсэн санал дээрээ байна.

140 дүгээр тойргийн депутат Т. Гантөмөр: -Тэгэхээр бид нар өөрсдийгөө бүгдээрээ бухимдсан болгоод бүх асуудлаа зарчмын гэж зарлаад ингээд байвал энэ сайн нөлөө юу л байх бол.

Нөгөө талаар энэ монгол сэтгэлгээ гэдэгт эргэж буцаад байх асуудал нэг их сонин биш. Өөрөөр хэлбэл, бид нар Үндсэн хууль батлах сайн үйл бүтээхээр энд ирсэн, ер нь гол зорилго энэ. Тийм учраас энэ луугээ эргэж буцаад байлгүй шиг яваад орчихвол яасан юм бэ? Бэлтгэл муу байж болно. Гэхдээ

бидэнд бэлтгэл бий. Бид нарын, хүмүүсийн дунд бий болоод байгаа, энэ талаар бүрэлдээд байгаа энгийн ч гэж ярьдаг юмуу, нийтлэг ч гэдэг юмуу ийм ухамсар бий болж байна. Энийг бид энэ Үндсэн хуульд тусгах асуудал их чухал байна.

Нөгөө талаар бид үндэслэл гаргах, асуудлыг тавих, санал гаргах энэ чадвараа нэлээн ашиглалаа. Тэгэхээр нөгөө чадвар нэгийгээ сонсох чадвар, нэгийгээ хүндэтгэх чадвар, энийгээ бас ашиглаад саналаа хураагаад ер нь дахин энийгээ ярилгүй шийдвэл яасан юм бэ? Сайн үйл бүтээхэд саад бас байдаг гэдэг. Бас юмыг яаж мэдээ билээ, энэндээ түргэн яваад орчихвол яасан юм бэ гэсэн санал байна.

103 дугаар тойргийн депутат Дүйсінсанги: - Би хөтөл-

бөр, төлөвлөгөөн дээр депутатуудын зарим саналтай эсрэг байна. Тухайлбал, Хурц депутатын саналыг нэлээн олон депутат дэмжлээ. Анхлаад Үндсэн хуулиа хэлэлцээд эхний хэлэлцүүлэг явуулчихаад дараагаар нь илтгэлүүд хэлэлцээд тэгээд холион бантан хийхийг би зөвшөөрөхгүй байна. Над шиг ухаан муутай хүн бол түрүүчийн 5, 6 хонох юмуу, 8 хонох юмуу, эргээд нөгөө Үндсэн хуулин дээр үсэг бүрчлэн ямар асуудал дээр хэлэх, ямар юмыг өөрчлөх байлаа гэсэн бодлыг саармагтуулж, энэ бол үндэсгүй юмуу гэсэн.

Аль нэг асуудлыг эхэлсэн бай, тэр асуудлаа дуусгаж, дараачийнхаа асуудлыг хэлэлцэх нь зүйтэй болов уу гэсэн нэгдүгээр санал байна.

Хоёрдугаарт, зарим депутатуудыг бас арай хэтэрхий байгаа тал байна уу гэсэн бодол байх юмуу? Эд нар чинь удаашруулах гэж байгаа юмуу, сунжруулах гэж байгаа юмуу, та нар очоод урьд талынхаа асуудал, хөтөлбөр дарааллыг тэрнээсээ эхлээд дараа тэрийг хэлэлцээрэй гэж хэлсэн гэж бараг хэлээд байх юм. Тэр худлаа байх гэж би бодож байна, үгүй ч байж мэдэх юм.

Гуравдугаарт, та нар эхлээд Үндсэн хуулиа хэлэлцэх юм бол дараа нь яараад гэр луугаа явчихна, хөдөөнийхөн гэсэн, тухайлах юм бол намайг тийм бодолтой ирсэн гээд үзмэрчин хүн мэтээр тэгэж хэлж байна. Би энэ дээр

арай хэтрүүлэг хэлээд битгий тэгээд байгаач. Шууд шууд өөрсдийнхөө саналыг тодорхой хэлээд яваач ээ гэсэн ийм саналыг хэлэх гэсэн юм. Эцэст нь хэлэхэд би бол олонхийн санал өгсөн хүн. Тэгээд тэр саналаараа Үндсэн хуулиасаа эхлээд хөтөлбөрийнхөө дагуу хурлаа шуурхайлъя гэсэн саналтай байна.

88 дугаар тойргийн депутат А.Рэгзэн: -Тэгэхээр депутат бид нар хэлэлцэх төлөвлөгөө ёсоор бүх асуудлыг дараалал ёсоор авч хэлэлцэнэ гэж миний хувьд бодож байгаа. Урьдаж хэлэлцэх төлөвлөгөө ёсоороо Үндсэн хуулийнхаа төслийг хэлэлцье гэсэн олонхийн саналд миний санал багтаж байгаа. Тэгэхээр хөдөлмөрчдийн бухимдлыг өнөөдөр Засгийн газар болон Бага Хурлын тайланг сонссоноор өнөөдөр хөдөлмөрчдийн бухимдал арилна гэвэл арай эндүүрэл байх. Бид энэ төлөвлөгөө ёсоор хугацаандаа багтаж бүх асуудлыг шийднэ гэж би бодож байгаа.

Үндсэн хуулийг бид Улсын Бага Хурал ард түмнээс санал аваад, хэлэлцээд төслийг хоёр хувилбар, хэлэлцээд бидний гар дээр тавьсан. Бид заавал Засгийн газар болон Бага Хурлын илтгэлийг сонсч байж энд засвар, үг, үсэг найруулга хийх нь миний бодлоор арай тийм байж таарахгүй байх гэж бодож байх юм. Ийм учраас хурлынхаа дараалал ёсоор Үндсэн хуулиа одоо хэлэлцэх нь зүйтэй юм. Ер нь цөөнхийн саналыг хүндэтгэж ихэнх саналаа сонссон учраас бид хурлын дэгийнхээ дагуу одоо саналаа хураагаад энэ үйл ажиллагаандаа орвол яасан юм бэ гэсэн бодолтой байх юм.

186 дугаар тойргийн депутат Р.Чойжинням:

Цөөнхийн саналыг олонх нь босч ирээд дандаа няцааж ухуулж байх ёстой юмуу, дэгээ барих ёстой юмуу? Энэнд хариулж өгөөч. Хоёрдугаарт, энд дунд сууж байгаа бид нарт микрофон олдохгүй анх удаа, хүнийг гуйж байж энд ирүүлээд нэг микрофонтой болж байна. Тэгээд одоо бид нар цөөнх гээд цөөнх саналаа, харин олонхдоо бид нар нөлөөлж ярих ёстой. Би цөөнхийн хүн. Гэтэл цөөнх нь босч ирээд олонхийг няцаагаад байдаг. Бид нар харин цөөнх нь олонхдоо нөлөөлж чадах нуу, ойлгуулах нуу гэдгийг бид нар дэгийнхээ дагуу ярих ёстой

гэж бодож байна. Бид ингээд уралдаад байх юм бол энэ хурал маань юу болох юм бэ? Энийг асуух гэсэн юм.

Ж. Уртнасан: -Бид хурлынхаа дэгэнд цөөнхийг хүндэтгэж саналыг сонсох ёстой. Олонхийн саналаар асуудлаа шийднэ гэсэн ийм дэгтэй. Тэгэхээр бид цөөнхийн саналыг хүндэтгэж сонсч байгаа юм. Одоо микрофоны ард гуравхан хүн байна. Энэ гурван депутатын саналыг сонсоод санал хураалт явуулъя.

ЗГ7 дугаар тойрогийн депутат Д. Мандах: -Саналууд үндсэндээ нэлэн давхцаж байна. Гэхдээ арай өөр маягтай санал хэлэх гэсэн юм. Үү гэхээр шуудхан саналаа хэлэхэд эхлээд Үндсэн хуулиа хэлэлцэж эхлээд I дүгээр хэлэлцүүлэг дуусгаад ажлын хэсэгт Үндсэн хуулиа өгчихөөд дараа нь Засгийн газрын тайлан, Бага Хурлын тайланг дуустал нь хэлэлцье гэсэн ийм саналтай байгаа.

Энэ дээр би зарим нэг үндэслэл хэлье гэж бодож байна. Нэгдүгээрт, Засгийн газрын үйл ажиллагаа болон Бага Хурлын тайлангаас бол Үндсэн хуульд тусгах юм бол тийм ч их олдхоггүй болов уу гэж бодож байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын тайлан дээр бол хүнсний хангамж гэдэг юмуу, эсвэл алтны зарцуулалтын асуудал гэдэг юмуу ийм жижиг асуудлууд нэлээн яригдах байх.

Бага Хурал дээр хуулийн боловсруулалтын талаар нэлээн яригдах байх. Тийм учраас шууд Үндсэн хуульд тусгах асуудал бол энэ хоёрыг эхэлж хэлэлцсэнээс нэг их олон гарахгүй, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, дээр хэлсэн санал бол бас их зүйтэй. Өөрөөр хэлбэл, бид нар шинэ сэргэг байгаа дээрээ Их цаазынхаа төслийн үндсэн зарчмыг тогтож авах нь зүйтэй гэдэг үүднээс энэ саналыг хэлж байгаа юм.

Гуравдугаарт, бид нар Засгийн газрын тайлан болон Бага Хурлын тайланг цаасан дээр буулгаж авах бололцоогүй, цаасны бололцоогүй гэдгийг хэлсэн байгаа. Тийм учраас энэ

тайланг хэлэлцэхдээ эргэж буцалгүй нэгдүгээр хэлэлцүүлгийн дараа бол бүгдийг хэлэлцээд яриад дуусгах ёстой болов уу.

Харин энэ дээр хамгийн гол анхаарах ёстой асуудал бол миний бодлоор бол энэ шилжилтийн асуудал байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол, шинээр батлагдсан Үндсэн хууль маань юу гэж нэрлэгдсэн байлаа гэсэн энэ лүү яаж шилжих вэ? Одоогийн тогтолцооноос тэр лүү шилжих асуудал. Энэ дээр депутатууд нэлээн анхаарал хандуулах ёстой болов уу гэж би бодож байна. Энэ шилжилтийг бид нар яаж зохицуулах вэ, шийдэхийнхээ өмнө харин одоогийн Засгийн газар, Бага Хурлын асуудлыг ноцтой ярих ёстой. Тэгэж байж шилжилтийг яаж хийх вэ гэдэг асуудлыг бол шийдэх ёстой юм.

Хамгийн эцэст үүнтэй холбогдуулаад Их цаазын хавсралт хуулийн тухай асуудлыг энэ хэлэлцэх асуудалд нэрээр зааж оруулж явах ёстой гэж бодож байна. Яагаад гэвэл, энэ шилжилтийн асуудлыг бид нар яаж зохицуулснаас улс орны ойрын үеийн, улс төрийн ч байдаг юмуу, эдийн засгийн бусад тогтвортой үйл ажиллагаа энээс шууд шалтгаалах учраас энэ хуулийн асуудлыг ач холбогдол өгч тусад нь дотоод хэлэлцэх асуудлын дараалалд оруулах ёстой гэж бодож байна.

Хамгийн эцэст, хурлын удирдлагад хандаж бас нэг хүсэх зүйл байна. Юу гэхээр бол, хоорондоо их ялгаагүй мөртлөө бас маш их ач холбогдол бүхий олон саналууд гарч байна. Энэ саналуудыг бүгдийг нэгбүрчлэн, жижиг жижигхэн ялгаатай ч гэсэн бүгдийг нэг мөсөн жагсааж байж санал авах нь зүйтэй.

Соронзон хальстай тулгаж нийлсэн:

Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.ОЮУНЧИМЭГ

Кассет 01
1991-ХI-12
12.05-12.20

Ардын Их Хурлын 109 дүгээр тойргийн депутат С.Лхагвасүрэн:
-Тэгэхлээр цөөнхийн саналыг хүндэтгэх үндсэн дээр өөр нэг санал хэлмээр байна. Улсын Бага Хурал, Засгийн газрын тайланг хэлэлцэх арга бол хоёр янз байхаар сая депутатууд ярьж байх шиг байна. Тайланг хэлэлцэх явцдаа төр засгийн тогтолцоонд засгийн эрхийг хуваарилах явцад Улсын Бага Хурал, Засгийн газрын үйл ажиллагаанаас дүгнэлт хийх гэсэн нэг хэсэг байна. Ерөнхийд нь бүхий л үйл ажиллагаанд дүгнэлт хийх гэсэн хоёр дахь хэсэг байх шиг байна. Хэрэв ингэх юм бол цаг алдах юм. Тийм учраас миний санал бол энэ төр засгийн тогтолцооны асуудлыг энэ практикийг шинэ Үндсэн хуульдаа ямар нэгэн хэмжээгээр тусгаж авъя гэх юм бол энд хуралдаж байгаа депутатууд, улс төрчид, хуульчдын бүрэлдэхүүнтэй экспертизийн групп гаргаж одоогийн энэ ажиллаж байгаа Улсын Бага Хурал, Засгийн газрын энэ одоогийн тогтолцоонд дүн шинжилгээ хийх хэрэгтэй байна гэж үзэж байна.

Энэ шинжилгээг харин Үндсэн хуулийнхаа төслийг хэлэлцэхдээ харгалзан үзэж байвал цаг хожих юм биш байгаа гэсэн ийм санал байна аа.

Ардын Их Хурлын 74 дүгээр тойргийн депутат К.Мизамхан:
-Энэ хурлын хэлэлцэх асуудлын дэс дарааллын дагуу эхлээд Үндсэн хуулиа хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ дээр нэг хоёр үндэслэл байна л даа. Нэгдүгээрт энэ улс эх орныхоо тулгуур хууль шинэ Үндсэн хуулийг батлах бол гадаад, дотоодын асуудал дээр ч гэсэн зохих нөлөөлөл өгөх ёстой юм. Гадаад орнууд ч гэсэн Үндсэн хуулиа батлах асуудал дээр зохих ажил хийж байгааг бид анхаарах ёстой юм аа. Нөгөө талаар Ардын Их Хурлын II хуралдаанаар Үндсэн хуулийг хэлэлцэн батална гэдгийг манай сонгогчид хүлээж байгаа. Энэнийг ч бид анхаарах ёстой юм. Бага Хурал, Засгийн газрын үйл ажиллагааны хувьд бид тэртээ тэргүй хэвлэл мэдээллээр тодорхой мэдэж байгаа болохоор энэнийг дараачийн дэс дарааллын дагуу хэлэлцэхэд буруутах

юм алга гэж бодож байгаа.Цөөнхийн санал, зарим нэг сэтгэлийн хөдөлгөөнийг дагаж бид үндсэн асуудлаас гажиж болмооргүй байна.

Ардын Их Хурлын 30 дугаар тойргийн депутат Г.Нямдаваа:

--Надад нэг хоёр санал байна аа.Цөөнхийн санал гэж тавиад байгаа энэ хүмүүсийн ярьж байгаа үгнээс нь сонсоход би бол ийм дүгнэлт гаргаж хэлмээр санагдаад байна.Юу гэхлээр зэрэг Бага Хурал, Засгийн газрын тайланг сонсоод энэнээсээ дүгнэлт гаргаад Үндсэн хуульдаа бас тусгах гэсэн ийм санаа гаргаж байгаа юм. Тэгэхлээр зэрэг Бага Хурал, Засгийн газрын тайланг хэлэлцэхэд Бага Хурлын хууль тогтоох танхим, Засгийн газрын энэ гүйцэтгэх танхимын үйл ажиллагаа, зарчим нь цаашдаа байна шүү дээ. Их Хурлын танхим гэсэн нэртэй байх юм уу, Улсын Их Хурал гэсэн, Засгийн газрын танхим Засгийн газрын танхим гэдгээр л байх байх. Тэгэхээр зэрэг энэ зарчим бол нөлөөлөхгүй баймаар санагдаад байгаа юм.Тол нь энэ дээр чинь хувь хүний асуудалтай холбогдсон Засгийн газрын танхимын гишүүд гэдэг юм уу, Бага Хурлын гишүүдийн асуудалтай холбогдсон яриа, асуудлыг хэлэлцчихээд тэр Үндсэн хуулийнхаа асуудал уруу одоо орчих км шиг бодогдоод гээд байна аа.

Бусад асуудал гэсэн асуудал дээр би депутатын хувьд бас нэг асуудлыг оруулж өгөөсэй гэж хүсч байна.Энэ бол Депутатуудын тухай хууль байгаа.Энэ хуулиар бүх шатны депутатууд нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй явна гэсэн зүйл бий.Энэ асуудлыг өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг би санал тавьж байна.Энэ шалтгаан, үндэслэлийг би энэ асуудлыг оруулсны дараа тодорхой ярьж, хэлэлцүүлэх ийм бодолтой байна.

Ардын Их Хурлын 245 дугаар тойргийн депутат Ч.Чинбат:

--Их Хурлын даргад хүсэлт тавимаар байна. Энэ голоор байж байгаа депутатуудад нэг нүүдлийн микрофон ажиллуулж өгөөчээ гэж өчигдөр одоо хоёр өдөр хүсэлт тавилаа.Энэнийг яагаад анхааралдаа авахгүй байна вэ? Энэ чинь ерөөсөө гараа гозогонуулахаас өөр ямар ч эрх мэдэлгүй суугаад байна шүү дээ.Сонгогчдынхоо

3.

бодол саналыг илэрхийлэх нөхцөл бололцоогоор хангагдмаар байна. Энэ Их цаазын төслийг хэлэлцэж эхлэхээс өмнөн нэг нүүдлийн микрофон заавал ажиллуулж өгөөчээ гэж байна. Зарим нь болохоор утас-тай, микрофонтой байгаад байдаг. Зарим нь юу ч үгүй суугаад байж одоо хэцүү байна шүү дээ. Энэнийг салаалдаг юм уу, паралель хол-бодог юм уу ингээд энэнийг нэг заавал арга хэмжээ авч өгмөөр байна. Энэ голоор чинь зүтгээд, хүн амьтны хөл гар гишгэгчих гээд очерт ч орохгүй байна. Нэгээс хоёр микрофон байвал болмоор юм шиг байна. Ийм нэг арга хэмжээг зориуд авч өгөөчээ гэж хүсч байна. Нэгэнт боссоных бас энэ дэс дараалал дээр саналаа хэлж болох уу? Микрофонтой болгочихвол бас л их баярламаар байна.

—Энэ зарим улсууд давхардуулаад нэлээн олон санал хэллээ. Тэгэхлээр бид чинь нэг ийм юм анхаармаар байна. Энэ чинь цөөнх гээд санал хураасны дараагаар босч ирээд би цөөнхөд орсон гээд яриад байх юм бол цөөнх нь ингэж давамгай эрх эдлээд, олонхи болсон улсууд нь дуугүй суугаад байх юм уу энэ чинь. Тэгэхлээр энэ чинь цөөнх гэж хэнийгээ хэлэх юм бэ? Цөөнх гэдэг чинь тодорхой саналтай, бодолтой ийм улсуудын нь гаргаж ирж ярих юм уу? Зүгээр л санал хураасны дараа би цөөнхөд орчихлоо гээд яриад байх юм бол бид чинь үргэлжилсэн, сунжирсан хурлаас гарахгүй нь байна шүү дээ. Ийм учраас энэ дэгдээ энэ цөөнх гэдгээ ямар томъёоллоор цөөнх гэж нэрлэх юм бэ? Бүгдээрээ цөөнх болчих гээд байна шүү дээ энэ чинь. Үг хэлэхээрээ бүгдээрээ цөөнх, асуудал шийдэхлээр зэрэг олонхи гэдэг ийм заагийг нэг жаахан ялгаж өгөхгүй бол энэ чинь ерөөсөө болохгүй нь ээ.

Ж. Уртнасан:—Баярлалаа. Энэ голын суудал дээр сууж байгаа депутатууд хоёр өдөр хүсэлт тавьж байгаа юм. Энэ явуулын микрофон ажиллуулж өгөөчээ гэж. Зөврийн гэж. Тэгэхээр ажлын техникийн хэсэгт мэдэгдсэн юм аа. Хүссэн. Тэгэхлээр богино долгионы микрофон манайд барьдаг богино долгионы микрофон байдаггүй юм байна. Тэр бол өөрийн хянах самбартай, өөрийн хүлээн авах станцтай байж байж ажилладаг юм байна. Манай техникийн боломж өнөөдөр бид нар энд хоёр микрофон энд тавиад ард нь нэг микрофон

ажиллаж байгаа. Энэнээсээ өөрөөр техникийн хөгжил бол, бид техникийн дээд зэргийн хүчин чадал дээр байна нэгдүгээрт. Хоёрдугаарт Их цаазыг хэлэлцэх үед замбараатай, нэрээ компьютерт бичүүлж, принтер дээр нэрийн дарааллаар гаргасны дараа бид уг хэлж байх учраас, ийм системд орох учраас энэ микрофоны байрлалыг өөрчилж болмооргүй байна. Үүнийг тайлбарлаж хэлье. Ингээд бид хурлын дэгийн дагуу цөөнхөө хүндэтгэж саналыг нь сонслоо. Үндэслэлүүд гарлаа гэж бодож байна. Тэгээд цөөнхийн саналын дагуу дахин нэг санал хураалт явуулах ийм шаардлагатай боллоо. Санал хураалтанд бэлтгэнэ үү. Одоогийн санал хураах томъёолол гэж хажуугийн саналтай хүмүүсийн саналыг бид ингэж томъёолж байна. Засгийн газрын болон Бага Хурлын илтгэлийг хэлэлцсэний дараа Монгол улсын Их цаазын шинэ төслийг хэлэлцье гэдэг дээр санал хураалт явуулъя. Санал хураалтанд бэлтгэнэ үү.

За энэ санал дээр зөвшөөрсөн 19 хувь буюу 76 хүн байна. Татгалзсан 306 депутат буюу 77 хувь нь татгалзаж байна. Түдгэлзсэн 15 хүн буюу 4 хувь нь байна. Ийм учраас депутатуудын, бидний дэгийн дагуу олонхийн, цөөнхийн саналыг сонсож, олонхийн саналаар шийдвэрлэдэг, цөөнхийн хүслийг сонсож. Ийм учраас хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журам энэ хэвээрээ үлдлээ. Харин депутат нөхдийн саналаар бусад асуудал гэдэг дээр Хавсралт хуулийн тухай, Прокурор, Шүүхийн тайлан, бусад мэдээлэл гэж нэмэлт оруулж болох юм. Үүнийг бид жич ярьж болох болов уу гэж бодож байна. Дараа ярилцаж болъё. Одоо та бүгдийн сонорт сонордуулах нэг ийм асуудал байна. Манай Их цаазын төслийг хэлэлцэхэд гаднын дипломат корпусын гадаадаас манай оронд сууж байгаа дипломат корпусын ажилтнууд оролцохоор хүрэлцэн ирээд байгаа юм. байна. Илтгэл 90 минутын хугацаатай. Ийм учраас бид хэлэлцэж эхэлбэл өдрийн хоолны цагаас нилээд хождох байдалтай байна. Тэгэхээр нэг санал хураалт явуулъя. Одоо илтгэлийг сонсоно. Үдийн хоолны дараагаар сонсох хоёр хувилбараар. Одоо илтгэлийг сонсоно, үдийн хоолны дараагаар сонсоно гэдгээр санал хураалт явуулъя. Одоо ерөнхийлөгчийн илтгэлийг хэлэлцэж эхэлъе.

-Хурлын дарга аа би нэг үг хэлье. Та ерөөсөө шал
 өөр асуудал хэлэлцүүлээд санал хураалгачих юм. Бид чинь өөр
 асуудал ярьсан шүү дээ. Бид эхэлж яриагүй шүү дээ. Саяын таны хэлс-
 ний дагуу эхлээд Бага Хурлын илтгэлийг, дараа нь Засгийн газар
 рын илтгэлийг хэлэлцээд хэлэлцүүлэг дуусаад дараа нь Их цааз-
 даа орё гэж яриагүй шүү дээ. Бидний ярьсан зүйл чинь Их цааздаа
 орно оо гээд энэнийгээ ярилцна. Тэгэхээсээ урд эхлээд илтгэ-
 лүүд хэлэлцье гэж ийм санал тавьж хэлэлцүүлсэн шүү дээ.

Ж. Уртнасан: - Би ч тэгж ойлгож санал хураалгасан гэж
 бодож байгаа. Хэрвээ андуурсан бол энэнийг залруулж болох юм.
 Депутат нөхөд үүнийг шийдэх байх гэж бодож байна.

Үүнийг шийдэж болох асуудал гэж бодож байна. Цөөнх саналаа
 ярьж байгаа үед олонхи нь ярихаа больчихье. Ингээд л шийдчихье.

Д. Мандах

-Хурлын дарга аа уучлаарай, би түрүүн зориуд анхааруулж
 хэлсэн шүү дээ. Энэ чинь хоорондоо ялгаагүй юм шиг мөртлөө
 зарчмын ач холбогдолтой олон төрлийн саналуудыг бүгдийг нь
 жагсааж байгаад санал хураалгаа гэхэд шал өөр, ганцхан
 ерөнхий санал дээр та санал хураалгачихлаа шүү дээ. Тэгэхээр
 миний санал бол ийм байсан шүү дээ. Анхны хэлэлцүүлэг дуус-
 гаад дараа нь Засгийн газар, Бага Хурлын тайланг бүрэн дуустал
 хэлэлцье, тэгээд Их цаазынхаа эцсийн хэлэлцүүлэгт орё гэсэн
 ийм тусдаа өөр санал байгаа.

Ж. Уртнасан: - Д. Мандах депутат аа тэгэхээр
 бид үүнийг бас болгоосон. Аливаа ямар ч улсын парламентын
 ёсонд, хэрвээ парламентын ёс гэж байгаа бол нэг асуудлыг
 хэлэлцэж дууссаны дараагаар нөгөө асуудалд шилждэг ийм түгээ-
 мэл зүй тогтол байдаг. Үүнийг Дүйсэнсанги гуай тодорхой
 хэлчихлээ. Депутат. Тийм учраас би одоо энэнийг заавал дундуур
 нь нэг асуудал хэлэлцэж байгаад дутуу алсан могой шиг хаячихаад

нэг асуудал барьж авна гэдэг бол аль ч парламентын ёсонд байдаггүй учраас үүнийг би болгоогоогүй юм аа.

-Хурлын дарга аа нэг юм хусье.Саяны цөөнхийн саналыг нэрээр хураалгана уу?

Ж.Уртнасан:-Нэр бичээтэй байгаа.Нэрийг бид энэ комьшотерээс авчихъя.Тэгээд сонгож болно.Ажлын техникийн хэсэг саяын хүмүүсийн нэрийг гаргая.Тэгээд уншиж сонгоё.

Арлын Их Хурлын 191 дүгээр тойргийн депутат Б.Лханаасүрэн:
-Баярлалаа.Их Хурал маань их сэтгэлийн хөөрөлд автаж асуудлыг маш зарчимч бус байдлаар шийдэж байна гэж үзэж байна. Тэгэхлээр яагаад ингэж байна гэхлээр өнөөдөр улс орны эрх ашиг, ард түмний маань сэтгэл санаа эхлээд биднийг Үндсэн хууль хэлэлцэхийг шаардаад байна уу, аль эсвэл Улсын Бага Хурал, Засгийн газрынхаа тайланг сонсоод үнэлэлт, дүгнэлт өгчихөөд тэгээд дараа нь Үндсэн хуулиа хэлэлцье гэж шаардаад байна уу гэдгээ бид бодолцох ёстой.Бид энэнийг эрхбиш харгалзаж үзэх ёстой.Өнөөдөр улс орон гүн хямралд байна.Цаашдаа үргэлжлэх хугацаа байхгүй.

Өнөөдөр бидэнд цаг минут хүртэл үнэтэй.Энэнийг эрхбиш бид бодолцох ёстой.Тийм учраас энэ бол Үндсэн хуулиа эхэлж хэлэлцэх асуудал бол зүгээр нэг ёс төрийн асуудал аа гэж ингэж яриад байх асуудал бол ямар ч утга учиргүй асуудал.Улс орны эрх ашиг, ард түмэн юу шаардаж байна.Тэрүүгээр л бид эхлэх ёстой.Тийм учраас би яах вэ бүрэн эрхийнхээ дагуу дахин санал хурааж эхний асуудалд Улсын Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайланг хэлэлцээд, дараа нь Үндсэн хуулиа хэлэлцээд баталчихъя.Тэгээд энэ асуудал бол өнөөдөр эрхбиш ард түмэн энэнийг хүлээж байгаа байх аа гэж ингэж үзэж байна.Тийм учраас энэ бол ёс төрийн асуудал биш ээ.Эхэлж Үндсэн хуулиа батлаад, дараа нь нэг соёрхон батлаад ингэх асуудал бол ёс төрийн асуудал биш,энэ

7.

бол бид ажлын шаардлагаас юуг нь эхэлж хэлэлцэх вэ гэдгийгээ л бид өнөөдөр тогтох ёстой. Тийм учраас дахин санал хурааж, миний саналыг харгалзаж үзнэ үү.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ

НИЙЛСЭН *Б.Баяндүүрэн*

Д.БАЯНДҮҮРЭН

БИЧЭЭЧ Л.ХОРЛОО

183 дугаар тойргийн депутат Ч.Намсрай: Би ганцхан санал хэлье гэж бодож байна.

250 дугаар тойргийн депутат Г.Дамдиндорж: Өнөөдөр бол Монгол улсын өнөөгөө болоод ирээдүйг шийдэх томоохон асуудлыг шийдэх улсын хэмжээний тэргүүн хүмүүс цугласан гэж би ингэж бодож байгаа. Ажлаараа ч байдаг юмуу, ухаан санаагаараа ч байдаг юмуу, цаашдын юмыг шийдэж чадах бүх депутат энд цуглажээ. Тэгэхдээр энэ дотор гаднаас хүн харах юм бол цөөнх, олонхи, хажуу гийн гээд ийм гурван бүлэг юм болж байгаа юм шиг ер нь миний сэтгэлд бодогдоод байна. Цөөнх гэхдээр зэрэг хэнийг хэлж байна аа. Олонхи гэдэг хэнийг хэлээд байна гэдэг энэ асуудал. Тэгвэл цөөнх, ашигтай цөөн саналыг авч хэлэлцье гэдэг ийм задруулга байдаг юмуу яадаг юм бэ. Энэ тал дээр ямаар байна. Нөгөө талаар бид Монголын ард түмэн бухимдаад байна гэж байгаа. Бухимдаж байгаа үнэн. Засгийн газрын асуудал, Бага Хурлын асуудал, Үндсэн хуулийн асуудал энэ гурван асуудлын алийг нь ч эхэлж ярилаа гэсэн, асуудлыг дээр дор нь орууллаа ч гэсэн Монголын ард түмний бухимдал арилахгүй. Энийг би баталгаатай хэлнэ. Харин энэ гурван асуудлыг хэлэлцээд эцэс дээр нь тодорхой зөв шийдвэр гаргаж чадвал бухимдал дарагдана. Тийм учраас бид цаг хугацаагаа хожоод өнөөдөр бухимдлаа даръя гэж бодож байгаа бол нэг минут, нэг секундын өмнө байлаа гэсэн Үндсэн хуулийнхаа асуудалд эхлээд оролцье гэдэг санал байна. Бусад саналаа тасалчихвал яадаг юм бол. Голд нь гуйж байж нэг микрофон олдсон дээр ингээд ярьчихлаа. Өөрөө босчихоод бусдыг хааж байна, боож байна гэж хэлдэг юм болов уу. Хааж боосон юмгүй ер нь саналын гол гарчихвуу гэж бодож байна.

183 дугаар тойргийн депутат Ч.Намсрай: Би олонхийн саналыг хүндэтгэж байна. Би уул нь цөөнхөд санал өгсөн юм. Би энэ дээр шинэ хувилбар оруулъя. Санал хурааж өгөөч гэсэн ийм хүсэлт байна. Үндсэн хуулийг эхэлж хэлэлцээ гэдгийг чинь хүлээж авъя. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт Үндсэн хуулийн илтгэлийн дараагаар Бага Хурлын илтгэлийг оруулж өгөөчээ. Бага Хурлын тайланг, Засгийн газрын тайланг бүр сүүлд нь хэлэлцээ. Ингэж хууль тогтоох дээд байгууллага

парламент хоёр танхимтай парламент юм бол энэ хоёр танхимтай парламент Бага Хурлын илтгэлийг сонссон байхад буруутахгүй гэж үзэж байна. Энүүгээр санал хурааж өгөөч гэсэн ийм санал байна.

Хурлын даргаа Э дугаар микрофонд зөвшөөрөл өгөөч.

Э.Бат-Үүл /52 дугаар тойргийн депутат/

Би зүгээр хэлэлцэж байгаа асуудлаар биш хурлын тэргүү-лэгчдэд хандаад депутатуудад хандаад нэг юм хэлэх гэсэн юм. Дэгээ бариачээ. Цөөнхийн саналыг хүндэтгэж үзнэ гэсэн байгаа шүү. Цөөнхийн саналыг хүндэтгэнэ гэдэг бол энийг зөвхөн хурлын дарга ч хүлээх ёсгүй. Депутатууд хүлээх ёстой. Тийм учраас нэгэнт цөөнх хэлж байгаа үед депутатууд маань олонхи нь цөөнх рүү орж хутгалдмааргүй байх юм. Яагаад гэвэл цөөнх чинь үгээ хэлэх хэрэгтэй байна шүү дээ. Хоёрдугаарт горимын санал хэлэхэд хурлын дарга бол нэгэнт микрофоны ард боссоны дараа нэрээр нь бүртгээд авчихмаар байна. Тэгээд саналыг нь таслуулаад энэ хүмүүсээр санал таслах уу гээд саналыг нь таслуулаад тэгээд яг микрофон дээр байгаа хүмүүс гүйцлээ. Тэгээд санал хураалтандаа орчихвол зүгээр юм байна л даа. Тэгэхгүй болохоор нөгөө яг явц дунд үсэрч босчихоод хэрүүл болоод байна.

Тэгэхээр би депутатуудад хандаад цөөнхийн саналыг хүндэтгэж үзэх гэдгийг бид их анхааралтай хандах ёстой юм шүү. Яагаад вэ гэвэл Дашбалбар депутат ярьж байна шүү дээ. Энд нэг хувилдаан байгаа юм шиг. Суүлдээ энэ чинь гадагшаа ингэж ойлгуулах аюултай шүү дээ. Тийм болохоор тийм биш байсан. Цөөнх чинь бүрэн бололцоотой үгээ хэлсэн. Депутатууд тэрийг нь сонссон. Тэгээд депутатууд өөрийнхөө хүсэл зоригоор шийдсэн гэдгээ бид бас ойлгуулах хэрэгтэй байна. Тийм учраас цөөнхийн хэрэгт оролцооморгүй байна. Цөөнхийг хүндэтгэж үзмээр байна.

Үгүйээ 60 цөөнх бүгд хэлэх ёсгүй л дээ. Цөөнхөө л сонс.

Буяндэлгэр /188 дугаар тойргийн депутат/

Би Ерөнхийлөгчийн тайланг хэлэлцэхийг нэрлэж оруулъя

гэсэн тодорхой санал хэлсэн. Та уг нь очсон хувилбаруудыг жагсаагаад ийм ийм саналууд ирсэн. Одоо энүүгээр санал хураая гээд авах

нь зүйтэй байсан болов уу гэж бодогдоод байх юм. Бусад гэдэг дээр оруулмааргүй байна. Энэ гурван толгой бол зайлшгүй холбоотой. Ерөнхийлөгч, Засгийн газар, Ерөнхий сайд. Энийг нэрлэж оруулья гэсэн. Тайлан бол тараасан. Энийг хэлэлцэе гэсэн шүү дээ. Тиймээ. Зүгээр сонсоё, үзье, харья, уншиё, мэдье гэжгүй. Энэ дээр санал хураач өгөөч гэж. Хэрвээ энийг хэлэлцэх шаардлагагүй гэвэл депутатууд бид шийдэх байх л даа.

Хурлын даргаа зөвшөөрөл авъя.

Хурлын даргаа нэг хүсэлт байна болох уу.

184 дүгээр тойргийн депутат С.Билэгсайхан:

Нэлээд цөөнх маань үгээ хэллээ. Тэгэхлээр цөөнхийнхээ

саналыг хүндэтгээд тэр Засгийн газрын Тайлан, Бага Хурлын тайланг урьдчилсан маягаар олшруулаад бүгдэд нь тараах ийм хүсэлт тавьж байна.

Боссон дээр хэлэхэд микрофон өгөх хэрэгтэй байна.

Хурлын даргаа зөвшөөрөл өгөх үү. Хурлын дэгэд орсон гуравдахь удаагаа санал хураалгахаар тавьж болно шүү дээ. Би нэг үг хэлмээр байна.

406 дугаар тойргийн депутат Ч.Тэрбиш: Бид хурлын дэгэд

орсон учраас гуравдахь удаагаа санал хураалгахаар хүсэлтээ тавих эрхтэй юм. Тийм учраас би нэг юм хэлбэ.

Депутатууд та нөхөд минь та нөхдүүд нэг юм бодож үзээчээ. Бид чинь нэг энгийн хар юман дээр зүйрлээд бодох юм бол ноднин Их Хурлаас нэг их мөрний урсгал дагаж урсах тийм л завь, завьчин хоёрыг томилоод Бага Хурлаа гаргачихсан юм. Бага Хурал маань завь завьчин гээд Засгийн газрыг томилсон. Зарим депутат сайн мэдээд байгаа юм шиг байна. Засгийн газар, Бага Хурлын хийсэн ажилд үнэлэлт, дүгнэлтийг нь өгөөд байгаа юм. Миний хувьд үнэхээр мэдэхгүй юм байна. Тэр одоо завьчин, завь хоёроо тавихдаа Бага Хурал маань нэг баахан моторт завины мэргэжилтэй хүнийг сэлүүрт завин дээр тавичихаад энэ маань явахгүй байгаа юм болов уу. Эсвэл одоо мотор завин дээр баахан сэлүүрчид тавичихаад явахгүй байгаа юм болов уу, ерөөсөө энэ тогтолцооноосоо ийм байна уу, үгүй юу. Бямбасүрэнгээсээ болоод байгаа юмуу, хэнээсээ болоод байгаа юм

гэдгийг л ялгаж урьдаар сонсож байгаад тэр танхимын зохион байгуулалтаа хиймээр байна. Тэрнээс тэрийг мэдээгүй байж байгаад хувь хүнээс ажил буруутаад байгаа юм гэж сайхан зохион байгуулалтыг нь эвдээд хаячих гээд шинэ хууль баталчих ч юм билүү. Зүгээр ер нь буруу тогтолцооноос болоод хувь хүн хичнээн сайн ажиллаад хийж чадахгүй байхад нь буруу тогтолцоогоо дахиад хуульчлаад баталчихгаад ч байгаа юм билүү. Энийг ойлгохгүй байна шүү дээ. Ийм учраас эхлээд бид ноднингийнхоо тогтолцооны үр дүнгийг нь сонсчихоод, тэрэндээ үнэлэлт, дүгнэлтээ өгчихөөд тэгээд шинэ тогтолцоогоо зоригтой шийдмээр санагдаад байгаа юм. Энийг анхааралдаа аваачээ.

425 дугаар тойргийн депутат Н. Ганзориг: Тэрбиш гуайн саналтай ижил байна. Цөөнх маань дотроо хоёр, гурван янз байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй байна. Тэгээд эднүүсийнхээ ялгааг гаргаад нэрээр нь санал аваад сонин хэвлэлд тавих хэрэгтэй юм.

Ж. Уртнасан
Нэрээр санал хураасан. Нэрээр авсан.

60 дугаар тойргийн депутат Д. Дамбийжанцан: Анх удаагаа микрофон барилаа. Тэгэхээр ийм санал байна. Цөөнхөө хүндэтгэлээ ингэж үзээд байгаа юм бол бид нар хэлэлцэх асуудлынхаа төлөвлөгөөг бөөнөөр нь баталсан. Энэн дээр бас эмзэглээд байх шиг байна. Тийм учраас хэлэлцэх асуудлынхаа дарааллаар санал авчих. Тэгэхэд болно. Асуудлынхаа дарааллаар. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт юу гэвэл сая Бат-үүл хэллээ. Цөөнхийн улсуудыг компьютерт оруулаад принтерээс нэрийг нь аваад хурлын дарга аваач. Тэдэн хүн иржээ гээд. Тэр хүн дотроос цөөнхийн цөмөөрөө ч үг хэлж болно. Хагас нь ч үг хэлж болно. Хэрвээ цөөнх нь их хүн байвал тэр цөөнх дотроосоо депутатуудаас санал авч байгаад хэдэн хувийг нь үг хэлүүлнэ гэж болно шүү дээ. Ийм байдлаар зохион байгуулвал яасан юм бэ.

Санал байна.

285 дугаар тойргийн депутат С.Батсүх: Энд хэлэлцэж байгаа асуудлын талаар олон янзын санал гарч байна. Хэрвээ Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайланг эхний ээлжинд хэлэлцэх боломжгүй болбол ямар нэг хэмжээгээр аймгуудад ч гэсэн цөөн хувиар урьдчилж олшруулж өгнө үү. Өнгөрсөн практикаа үнэлж дүгнэхгүйгээр ирээдүйг томъёолоход тун бэрхшээлтэй гэж бодож байна. Яагаад гэвэл Бага Хурлын тайлан, Засгийн газрын тайланг эхэлж сонсох гээд байгаа юм оэ гэвэл, миний л хувьд энэ өнгөрсөн шинэ тогтолцоонд сайн юм ч их бий, шүүмжлэлтэй ^{хандах ч} юм их бий. Энийг жаахан ойлгож мэдэж байгаад дараагийн шинэ Үндсэн хуулинд аа санал онолоо өгөөсэй гэж бодож байгаа юм. Тэгэхээр хэлэлцэж болохгүй бол олшруулж болно. Олноор болохгүй бол цөөнхөөр болно гэсэн ийм хүсэлт байна.

Уртнасан: За анхааралдаа авлаа. Энийг бид ярилцаж эхэлье.

За депутат нөхөд хоёрдахь санал хураалтын дараа зарим санал гарч байна. Гуравдахь удаа санал хураалгаж өгөөчээ гэж. Тэгэхээр гуравдахь удаа санал хураалгахын өмнө санал хураалт явуулах уу, үгүй юу гэдэг дээр санал авъя.

Уртнасан:

Дахин гуравдахь удаагийн санал хураалт явуулах уу, үгүй юу гэдгээр.

Шууд санал хураах нь зөвөө даргаа.

Танхимаас:

Гурав нь санал хураагаагүй байгаа учраас санал авахгүйгээр шууд гуравдахь саналыг нь авчихвал яасан юм бэ.

Уртнасан: Тэгвэл шууд гуравдахь санал хураалт явуулъя.

Тэгэхдээ томъёолол та бүхэн ойлгож байгаа. Эхнийх болбол ойлгомжтой. Энэ бид бөөнөөр нь баталчихсан энийгээ яг энэ дэс дарааллын дагуу батлаа ингэж санал хураалгасан. Олонхи болсон. Дахиад цөөнхийн саналыг сонсоод тэр саналыг хүндэтгэж бид нар энийн байрыг сольж эхлээд Засгийн газрын Бага Хурлын тайлан сонсоод, дараа нь Их цаазаа ярилцаж эхлээ гэдэг энүүгээр санал хураалт явуулсан. Гомдол гарч байна. Ийм учраас бид гуравдахь хувилбарыг депутат Хурцынхаар томъёолж байна. Депутат Хурцын томъёоллоор.

За баярлалаа.Тэгвэл бид олонхи депутатуудын саналаар хоёрдахь хувилбарыг дахин санал хураалтанд явуулж байна.Цөөнхийн санал гомдол гарсан.Ийм учраас бид хоёрдахь хувилбар дээр дахин санал хураалт явуулж байна.Энийг зарлаа Хурц депутат дахин эмзэглэж магадгүй юм.

Засгийн газрын болон Бага Хурлын тайлан хэлэлцсэний дараа Монгол улсын Их цаазын шинэ төслийг хэлэлцэнэ гэдэг дээр санал хураалт дахин явуулж байна.

За санал хураалтанд бэлтгэнэ үү.

Дахин хэлье.Бид хоёрдахь санал хураалтыг дахиж гэж байна. Засгийн газар болон Бага Хурлын тайлан хэлэлцсэний дараа Монгол улсын Их цаазын шинэ төслийг хэлэлцэнэ.Тэгэхээр санал хураалт явуулах гэж байна.

287-р тойргийн депутат Ч:Хурц:

За санал хураалтанд бэлтгэнэ үү.

Хурлын даргаа би нэг санал хэлээдхэе.Тэгэхээр одоо ингэмээр байна.Бид энэ парламент дээр та түрүү нэг асуудлаа дуусаагүй байхад нөгөөгөө хэлэлцдэггүй гэж.Манай бага хурлыг парламент гэж үздэг болбол анхны хэлэлцүүлэг дууссаны дараагаар дараагийнхаа асуудалдаа ороод жилийн дараа ч хоёрдахь удаагийн хэлэлцүүлэгээ хийх бололцоотой байдаг.Тийм учраас та бага хуралд сууж байсан хүн тэрэн дээр алдаа алдаад байх шиг болно лээ.За тэр нь яахав.Хамгийн гол нь та ингэж энэ асуудлыг хэлэлцүүлэхгүй юу.Их цаазаа энэ хурлын хэлэлцэх хэрэгт бичсэний дагуу хэлэлцүүлье.Анхны хэлэлцүүлэг Их цаазаар хийе.Анхны хэлэлцүүлэг дууссаны дараагаар Засгийн газар, Сайд нарын Зөвлөлийн тайланг сонсоё гэж.Тэгээд эцсийн хэлэлцүүлэгт хэлэлцүүлгээ хийхдээ энэнийхээ дараа хэлэлцэе гэж.

Ж.Уртнасан

Сонслоо.Дахин хэлье.Санал хураалтын юманд дахин анхааруулья.Манай зарим депутатууд томъёоллоо сайн өгч байгаа ч гэсэн энэ гуравдахь санал хураалтыг Засгийн газрын болон Бага Хурлын тайланг хэлэлцсэний дараа Монгол улсын Их цааз шинэ төслийг хэ-

лэлцэнэ. Тэгэхээр санал хураалт явуулъя.

Санал хураалтанд бэлтгэнэ үү.

Дахиад хэлбэ Засгийн газрын болон Бага Хурлын тайланг хэлэлцсэний дараа Монгол улсын Их цааз энэ шинэ төслийг хэлэлцэнэ.

За санал хураалтын дүнг та бид нар бүгдээрээ харлаа. Гуравдахь санал хураалт явууллаа. Зөвшөөрсөн 75 байна, татгалзсан 318 буюу 77 хувь нь энэ дэгийг энэ хэвээр үлдээж энийг мөрдөж ажиллаж гэсэн ийм санал ирүүлж байна. Энэ далиманд манай депутатууд энэ татгалзсан хүмүүсийн нэрийг нэрсийн жагсаалтаар ав гэсэн энэ цахим техник бидэнд татгалзсан. Нэрээр саналаа хураалгая гэсэн депутатуудын нэрийг гаргаж ирлээ. Үүнийг бид шаардлагатай гэж үзсэн хүмүүст өгч болно.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Бичээч

Муга

ЭНХТУЯА

В. ОЮН

Ж.Уртнасан -За одоо та бүгдийг санал хураалтанд бэлтгэхийг хүсч байна.Бидэнд үдийн хоолны цаг болоход 20 минут дутуу байна.Одоо Ерөнхийлөгчийн илтгэлийг сонсож хэлэлцэж эхлэх үү, үдийн хоолны дараа хэлэлцэх үү гэдэг ийм асуудал байна.

Ч.Хурц /287-р тойргийн депутат/ -Хурлын даргаа, дотоод журам гэдэг асуудал одоо хэлэлцээгүй явж байгаа шүү дээ.Тэрнийгээ хэлэлцэж дуусахад чинь тэгээд бараг болох юм биш үү? Минутын тухай асуудал яриагүй байгаа шүү дээ.Хэдэн минут, ямар юм хэлэлцэх вэ гэдэг.Төсөл л байгаа болохоос биш.Тэрнийгээ батлуулах юм биш үү?

Ж.Уртнасан -Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хэлэлцэж дуусаад дотоод журмаа хэлэлцье гэсэн санал уу? Энэ саналыг хүлээж авлаа.Дотоод журмыг та бүхэнд бас тараасан байгаа.Их Хурлын депутатуудын бүрэн эрхийн тухай 25 минутын илтгэл тавигдсан.Энүүгээр ярих юм байхгүй байх.Монгол улсын Их цаазын төслийг нийт ард түмнээр хэлэлцсэн дүн, шинэ төслийн тухай илтгэл 90 минут гэж байна.Энэн дээр өөр нэмэх, хасах саналтай депутат байна уу? За тэгвэл Монгол улсын Их цааз /Үндсэн хууль/-ын төслийг нийт ард түмнээр хэлэлцүүлсэн дүнгийн шинэ төслийн тухай илтгэл 90 минут.Энэн дээр санал хураалт явуулчихъя.Эсвэл бөөнөөр нь үү? За баярлалаа.

За гуравдугаарт Засгийн газрын үйл ажиллагаа, дотоод, гадаад бодлогын үндсэн асуудлын тухай илтгэл 60 минут. Өөрөөр хэлбэл гурав, дөрөвдүгээр асуудлын байрыг сольё гэсэн үг үү? Бага Хурлынхыг эхлээд, за юу ч гэсэн энэ хугацаан дээрээ тогтоё.

Р.Чойжинням / 186-р тойргийн депутат/ -Хурлын даргаа түрүүн байрлалаа баталчихсан шүү дээ.Одоо битгий буцаач дээ.

Ж.Уртнасан -Уучлаарай.Хугацаан дээрээ тогтоё.Засгийн газ-

рын үйл ажиллагаа, гадаад, дотоод бодлогын асуудлын тухай илтгэл 60 минут.

Дөрөвдүгээрт нь Бага Хурлын үйл ажиллагааны тайлан, хууль тогтоох ажлыг сайжруулах зорилт 45 минут.

Тавдугаарт нь Их цааз, Үндсэн хуулийн төсөл болон бусад баримт бичиг, илтгэлүүдийг хэлэлцэхэд цаг тогтоохгүй.

Зургадугаарт зохион байгуулалтын асуудал хэлэлцэхэд цаг тогтоохгүй. За одоо саналаа ярья. Зарим депутатууд дөрөв, тавдугаар илтгэлийн байрыг сольё гээд байгаа шүү дээ.

Д.Лхагвасүрэн /282 дугаар тойргийн депутат/ -Тэр тавд байна шүү дээ. Бусад баримт бичиг, илтгэлүүдийг хэлэлцэхэд цаг тогтоохгүй гээд. Тэр бусад илтгэлүүдэд нь цаг тогтоож өгмөөр байх юм. Жишээлбэл, хавсралт янз бүрийн илтгэлүүд орно шүү дээ. Тэрэнд нь цаг тогтоохгүй бол...

Ж.Уртнасан -Уучлаарай депутатууд аа. Энэ Ардын Их Хурлын II хуралдааны дотоод журмаа баталъя. Санал хураалтанд бэлтгэнэ үү. Дотоод журмыг батлах талаар санал хураалт явуулъя.

За санал өгсөн депутатуудын 95 хувь буюу 397 хүн энэ дотоод журмыг баталлаа. За баярлалаа. Дотоод журам батлагдлаа.

За депутат нөхөдөө, бидэнд ийм дараагийн асуудал байна. Илтгэлийг, одоо бид завсарлахад 15 минут дутуу байна. Хэрэв илтгэл эхлэх юм бол 90 минут үргэлжилнэ. Тийм учраас илтгэлийг үдийн хоолны дараа эхэлье гэсэн ийм санал байна. Энэн дээр санал хураалт явуулах уу? Үдийн хоолны дараа Ерөнхийлөгчийн илтгэлийг авч хэлэлцье. Одоо цаг бага болчихлоо. За санал хураалт явуулъя. Ерөнхийлөгчийн илтгэлийг үдийн хоолны дараа хэлэлцэж эхэлье гэдэг дээр санал хураалт явуулах гэж байна. 15 цагаас.

За баярлалаа. Санал өгсөн депутатуудын 97 хувь нь буюу

391 хүн Ерөнхийлөгчийн илтгэлийг 15 цагаас эхэлж гэсэн саналтай байна. За одоо үдийн завсарлага.

Г. Дамдиндорж /250-р тойргийн депутат/ -Их Хурлын даргаа би танд гурван өдрийн өмнө асуудал тавьсан шүү дээ. Ерөөсөө асуудал шийдэхгүй юм аа та. Голын микрофон тавиагч гэж хэлээд байсан шүү дээ.

Ж. Уртнасан -Голын микрофоныг бид сая ярилаа шүү дээ. Та нар сонсоогүй юм уу?

Г. Дамдиндорж -Ярилаа гээд тэр чинь одоо болтол байхгүй л байна шүү дээ.

Ж. Уртнасан -Шийдэх боломж байхгүй. Техникийн боломж байхгүй.

Г. Дамдиндорж -Тэгвэл тэр индэр дээр чинь хичнээн олон микрофон байна шүү дээ. Тэрнээснээ нэгийг нь тавихгүй юу. Салаалаад тавихгүй юу.

Г. Дамдиндорж -Даргаа голын хүнд микрофон олдох бололцоогүй бол бид нар энэ микрофонд ойрхон тэр хойд талын суудлаар сууж байна. Тэрийг зөвшөөрч өгөөч.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

А. Алтанцэцэг

Д. АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.13
Кассет № 04
15.00-15.15

Ж.Уртнасан: Эрхэм депутат та бүхний өдрийн амгаланг айлтгая. Хуралдааныхаа ажиллагааг үргэлжлүүлье.

Одоо уламжлал ёсоор депутатын ирцийг бүртгэе. Ирц бүртгэхэд бэлтгэнэ үү. Техник будилж байх шиг байна. Ирцийг дахин бүртгэе. Ирц бүртгэхэд бэлтгэнэ үү.

380 депутат хүрэлцэн ирсэн байна. Тийм учраас хуралдаанаа үргэлжлүүлье. Одоо дэгийн дагуу Монгол улсын Их цааз/Үндсэн хууль/-ын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, шинэ төслийн тухай. Илтгэгч нь: БНМАУ-ын Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат.

П.Очирбат: /БНМАУ-ын Ерөнхийлөгч

Эрхэм хүндэт Ардын Их Хурлын дарга, депутатууд аа.

Улсын Бага Хурал, Засгийн газрын эрхэм гишүүд ээ.

Хүндэт зочид оо.

Аливаа улс гүрний түүхэнд тохиолддог онц чухал үйл явдлын нэг нь төрийн дээд хуулиа баталж, даяар олондоо тунхаглан зарлах явдал байдаг. Монгол улсын Их цаазыг хэлэлцэж батлах түүхэн хариуцлага, нэг ёсны эрх, аз завшаан та бидэнд ногдлоо.

Бид Монгол улсын шилжилтийн энэхүү зүй цаг үе, ирээдүйн шалгалтыг давж чадах тэр ардчилсан, шударга хууль батлахаас Монгол улсын ирээдүй, еөрчлөн байгуулалт, шинэчлэлийн хувь заяа бүхэлдээ шалтгаална.

Энэ түүхэн үйл явдлыг Монгол орон төдийгүй, дэлхийн бусад улс орон, олон нийт анхааралтай ажиглан харж байгаа. Ингээд бодохоор улсынхаа маань Их цааз бол монгол түмний нийгмийн сэтгэлгээний хөгжлийн тодорхой үеийн түүхэн үнэлэмж, манай улс орны, хүн төрөлхтөний соёл иргэншлийн их санд, оруулж буй нэмэр, дэлхий дахины өмнө монгол орны нэр төрийн хэрэг, монголын үндэсний

эрх ашгийн хураангуй дээд илэрхийлэл болох ёстой. Ингээд би Монгол улсын их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн, төслийн үзэл баримтлалтай холбогдсон зарчмын гол гол асуудлын талаар Улсын Бага Хурал, үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссын дүгнэлтийг та бүхний анхааралд толилуулъя.

I. Их цаазын төсөл боловсруулах болсон учир холбогдлын тухай:

1980-90-ээд оны зааг дээр урьд социалист гэгдэж байсан орнуудад өрнөсөн өөрчлөн байгуулалт, тэдгээр орон төдийгүй, даян дэлхийн дүр төрх, хөгжлийн хандлагад гүнзгий өөрчлөлт гарлаа.

Социалист хэмээх тогтолцоо задарч, түүнд багтаж байсан нэлээд орон хүнд суртлын дэглэмээс иргэний ардчилсан ёс, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байна. Монголын ард түмэн бусад улс орны ард түмнүүдийн нэгэн адил ардчилал өөрчлөлт, шинэчлэлтийн замыг сонгож авсан билээ.

БНМАУ дахь өөрчлөн байгуулалт, өөрийн гэсэн өвөрмөц өнгө аястай өрнөж, нийгмийн амьдралыг ардчилах, үндэсний түүх соёл, ухамсар, сэтгэлгээг сэргээн зах зээлийн эдийн засгийн харилцаанд эргэлт, буцалтгүй шилжин орж, та бид нэг жил гаруй хугацаанд үнэндээ шинэ монгол орон, шинэ нөхцөлд амьдарч эхэлж байна.

Шинийг бүтээх нь хуучныг эвдэхээс хавьгүй хэцүү боловч өнгөрсөн хугацаанд бас ч хийж бүтээсэн зүйл багагүй байна. Ард түмэндээ бэлэн зэлэн өгсөн зүйл бага юмаа гэхэд та бид ирээдүйд төрөлх монгол орноо мандуулахын эхлэлийг тавьж чадаад одоо түүнийгээ төрийн гол хуулиар бэхжүүлэх гэж байна гэж хэлбэл хэтрүүлсэн болохгүй хэмээн бодож байна. Энэ бол хойч үеийнхний өмнө манай өнөө үеийнхний хүлээх үүрэг, нэр төрийн хэрэг юм.

3.

Хэдийгээр шилжилтийн чанартай төгс төгөлдөр биш ч гэсэн хууль дээдлэх, ардчилсан шударга хүнлэг ёсыг гол зарчмаа болгосон төрийн шинэ тогтолцоо бүрэлдэж байгааг юуны өмнө тэмдэглэх хэрэгтэй.

Олон намын оролцоо, түүний парламентат ёсны эхлэл тавигдсанаар төрийн байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагаанд зарчмын өөрчлөлт гарч байна. Энэ бүхэнд түшиглэн төрийн байгууллыг цаашид ардчилан боловсронгуй болгох, Засгийн эрх мэдлийг зөв хуваарилж, түүний уялдаа, хамаарал, харилцан үйлчлэх хэлбэргүүдийг хуульчлан тогтоох шаардлага хурцаар тавигдаж байна.

Одоогоор бүрхэг байгаа энэ талын олон асуудалд их цааз зохих хариулт өгөх учиртай. Их цаазын төсөл боловсруулах болсон өөр нэг шаардлага нь манай эдийн засгийн тогтолцоонд үндсэн өөрчлөлт гарч байгаатай холбоотой.

Бид төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас татгалзаж, үндэсний эдийн засгийн бодлогынхоо тэнхлэгийг олон хэвшил бүхий зах зээлийн харилцааны зүг эргүүлж байна. Бид аж ахуйг эрхлэх хэлбэр, өмчийн харилцаан дахь хязгаарлалт, явцуурлыг арилгаж, эдийн засгаа дэлхий нийтийн өмнө нээж, чөлөөт өрсөлдөөнд өргөн тавилуун зам тавьж байна.

Улсын болон хоршооллын хэмээгдэж хэт төржсөн өмч өөрийнхөө зүй жамын дагуу задарч, өмчийн олон хэлбэр үүсч байна. Эдгээр өөрчлөлтийн эрх зүйн үндсийг төрөөс тогтоох зорилгоор Улсын Бага Хурал эдийн засгийн шинэ харилцааг үүсгэн зохицуулах багц хуулийг батлан гаргасан билээ. Тэгэхдээ дан ганц салбар хуулиар зохицуулахын аргагүй, язгуур асуудал ч бас бий нь тодорхой билээ.

Жишээ нь, улсын болон түүний нийгмийн тогтолцооны шинж чанар, ирээдүйн зорилт, хувийн өмчийг оролцуулан өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөх газрыг хувьд өмчлүүлэх эсэх,

өмчлөх эрхийг хязгаарлах хийгээд төрийн биш өмчийн хөрөнгийг улс дайчлан авах хууль зүйн болзол зэрэг зарчмын зарим асуудлыг Үндсэн хуулиар тогтоох шаардлагатай юм.

Улс төрийн амьдрал, төрийн тогтолцоо, эдийн засгийн харилцаанд гарч буй үндсэн өөрчлөлтийг дагаж, нийгмийн оюун санааны амьдрал мэдэгдэм шинэчлэгдэж, түүх соёлыг үнэлэх шинэ хандлага бий боллоо.

Оюуны ертөнцийг дан ангийн учир утгаар нь цэгнэдэг өрөөсгөл байдал арилж байна. Үндэстэн, ард түмнийхээ түүх соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв санг, төрийн хамгаалалтанд байлгах тухай олон улсын эрх зүйн үндэслэлийг бид ч дагах ёстой болж байна.

Хүний авьяас, оюуны бүтээлийг үнэлэх, зохиогчийн эрхийг хамгаалах зэрэг асуудлыг шинээр авч үзэж, Их цаазад тусгах хэрэгтэй болсон юм. Ардчилал, ил тод байдлын үр дүнд, хүний эрхийн асуудал, чанарын шинэ, өндөр түвшинд тавигдах боллоо. Нийгмийн амьдралд гарсан эдгээр өөрчлөлт, үр хөврөл нь дөнгөж бүрэлдэж эхэлж байгаа нийгмийн шинэ харилцааг өмнөх үндсэн хуулиар зохицуулах боломжгүй болгожээ.

Эдүгээ үйлчилж буй үндсэн хуулийн хэм хэмжээ нь эрх зүйн тогтолцоонд дорвитой өөрчлөлт хийхэд саад болж байгаагаар барахгүй эдийн засаг, улс төр, нийгэмд гарсан өөрчлөлтөөр нэгэнт бий болсон харилцааг ч цаг тухайд нь хууль тогтоох замаар зохицуулахад бэрхшээл учруулж, зөрчил үүсгэж байна.

Өмнөх үндсэн хууль амьдралын алхаа, гишгээтэй тохирохгүй болсон нь түүний зүйл, заалт бүрээс тодорхой харагдаж байна. Энэ нь нэг талаас нийгмийн хөгжлийн цоо шинэ хандлага эрс өөр маягийн харилцаа, нөгөө талаас эдийн засаг, нийгэм, улс төрийн хуучин тогтолцоонд тохирч байсан үндсэн хуулийн хоорондын зөрчлөөр илэрч байна.

5.

Бид энэ бүх хямрал зөрчлийг богино хугацаанд тууштай, тэгэхдээ ухаалгаар бас тэгээд зоригтой шийдвэрлэж чадахгүй бол бодитой өөрчлөлт шинэчлэлт хийж, иргэний ардчилсан нийгэмд хүрэх тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахгүй болно гэдгийг ойлгох ёстой юм.

Ийнхүү улс оронд маань бий болсон бодит нөхцөл, нийгмийн шинэ хэрэгцээ, шаардлага хуучин Үндсэн хуулийг халж, шинийг баталж гаргахад хүргэж байна. Үүнийг ^{Үндэс болгон} иш үндэснийхээ төр, соёлын түүхэн уламжлал, хууль зүйн шинжлэх ухааны ололт, төрийн байгууллын тухай онол, практикийн нийтлэг үндэслэлийг харгалзсан зарчмын шинэ баримтлалаар Монгол улсын Их цаазын төслийг боловсруулсан юм.

БНМАУ-ын өмнөх Үндсэн хуулиуд, социалист хэв загварыг тунхагласан нэг үзэл номлолд нийгмийг бүхэлд нь захируулах зарчимд тулгуурлаж байсан бөгөөд энэ нь нийгмийн жам ёсны хөгжлийг гажуудуулсан, олон сөрөг үр дагаврыг төрүүлсэн байна.

Та бүхэнд өргөн толилуулж буй Их цаазын төсөл аль нэгэн номлол нийгмийн байгууллын загвар, аль нэгэн намын байр суурийг хуульчлан бататгахад чиглээгүй юмаа. Тухайлбал нийгэм, эдийн засгийн нэг байгуулал, нөгөөгөөр эрэмбэ дараатай солигдох тухай эсвэл техник технологи, шинжлэх ухаан үйлдвэрлэлийн хөгжилд эд материалын өсөлтийг нийгмийн дэвшлийн жам ёс, түүнийг шалгуур гэж үздэг аль нэгэн номлол үзэл баримтлалд хөтлөгдөлгүй, хүн төрөлхтөний хөгжлийн нийтлэг хандлага, улс орныхоо өвөрмөц онцлогийг эн тэргүүнд харгалзан үзсэн юм. Харин хүнийг бүх асуудлын гол төвд тавьж, нийгмийн хөгжлийг хүний үнэ цэнээр хэмжих утгаар их цаазын зорилгыг эх орондоо иргэний нийгмийг цогцлон хөгжүүлэх явдал гэж тодорхойлж байна.

Иргэний нийгэм гэдэг бол хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн тэдгээрийг төрөөс баталгаатай хангаж, хүний эрх

зөрчсөн аливаа илрэлийг таслан зогсоохын хамт гэм буруутай этгээдийг төр цээрлүүлж чаддаг, чингэхдээ төр,бие хүн, нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцдог бүх байгууллага,хүн төрийн хуулиа дээдлэн хуулийн хүрээнд ажиллах зарчим, журамд үндэслэсэн ардчилсан нийгэм мөн.


БНМАУ-ын нийгмийн хөгжилд гарсан нааштай өөрчлөлтүүд хийгээд ирээдүйн зорилтыг хууль зүйн бодит үндэслэлтэй болгож баталгаажуулахад Их цаазын агуулга бүхэлдээ чиглэгдэж байна.

Одоо би Их цаазын төслийг хэрхэн боловсруулсан талаар хэдэн зүйл хэлье:

БНМАУ-ын Үндсэн хуульд өөрчлөлт шинэчлэлт хийх тухай санаа, анх 1988 оны дунд үеэс эхлэн тавигдаж, 1989 оны эхээр БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийг шинэчлэн найруулах ажлыг эрхлэн гүйцэтгэх комиссыг байгуулсан билээ.

Гэтэл 1989, 1990 оны зааг дээр нийгмийн амьдралд бүхэлдээ болон манай төрийн тогтолцоонд гүнзгий өөрчлөлт гарлаа. Улсын Бага Хурал энэ байдлыг харгалзан үзэж, 1990 оны 10 дугаар сард Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комиссыг шинээр байгуулсан юм.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн



Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

1991.XI.13.
Кассет № 05
15.15-15.30

Ц.Очирбат -Та бүхний гар дээр байгаа энэ төслийг комисс удирдан боловсруулж, Улсын Бага Хурлаар хоёрудаа хэлэлцүүлээ. Төсөл боловсруулах ажилд төр, намуудын удирдагчид, хуульч, эдийн засаг, улс төр судлаач, түүхч, хэл шинжлэгчид зэрэг эрдэмтэд, мэргэжилтнүүд оролцлоо.

Комисс уул төслийг боловсруулахдаа тус улсын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийн эерэг, сөрөг тал хийгээд 1990 онд батлагдсан Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн үзэл санааны чиг хандлагыг мөн харгалзан үзлээ. Түүнчлэн зарим нам нь хувь хүний боловсруулж ирүүлсэн төслүүдийн гол, гол санаа, дүгнэлтийг анхааралтай судлан үзлээ.

Үндсэн хуулийн төслийг боловсруулах чиг баримтлалын талаар хуулийн дээд байгууллагууд, Шинжлэх ухааны академи, Монгол Улсын Их сургуулийн мэргэжлийн зарим хүрээлэн, танхимын санал дүгнэлтийг комисс хүлээн авч судлалаа.

Их цаазын төслийн талаар НҮБ-ын хүний эрхийн олон улсын хороо, Олон улсын Парламентын холбоо, Олон улсын өмгөөллийн байгууллага болон Азийн хөгжлийн сангийн зуулчилснаар гадаад орны нэрт хуульчид, еерсдийн санал, дүгнэлтийг ирүүлснийг талархан тэмдэглэж байна.

Өнгөрсөн 9-р сард Монгол улс ардчилал^д шилжих үйл явцад шинэ Үндсэн хуулийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний Бага Хурлыг дэлхийн 10 гаруй улс, олон улсын байгууллагын 30 орчим төлөөлөгчдийн оролцоотойгоор зохион байгуулсан. Эдгээр байгууллага, эрдэмтэн, мэргэжилтэн, тус бага хуралд оролцсон Парламентын гишүүд, төлөөлөгчдийн санал, дүгнэлтийг төслийг дахин боловсруулахдаа харгалзаж үзсэн. Ингэж үзэхлээр Монгол улсын Их цаазын төсөл

бол Үндсэн хуулийн тухай шинжлэх ухааны орчин үеийн ололтод тулгуурлан Монгол улсын оюуны чадавхийг бүхэлд нь дайчилсан Монголын хөдөлмөрчид, эрдэмтэд, мэргэжилтнүүд, депутат та бүхний хамтын бүтээл бөгөөд төслийн дутуу, дулимагийг нөхөх бололцоо Ардын Их Хуралд бүрэн байна.

Хоёр. Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүн

Монгол улсын Их цааз/Үндсэн хууль/-ын төслийг 1991 оны 6-р сарын 10-наас 1991 оны 9-р сарын 1-ний хооронд ард нийтээр хэлэлцүүлж дүгнэсэн бөгөөд төслийн талаар манай иргэд өөрсдийн санал бодлоо одоо ч хүртэл ирүүлсээр байна.

Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс, Улсын Бага Хурал, Их цаазын төслийг хэлэлцүүлэх ажлыг илүү үр дүнтэй болгохын тулд хэд, хэдэн томоохон арга хэмжээ зохион байгуулсан. Дархан, Улаанбаатар хот, Архангай, Дундговь, Ховд, Хэнтий аймагт Ардын Их Хурлын депутатуудын бүсчилсэн зөвлөлгөөнийг хийж, Их цааз/Үндсэн хууль/-ын төслийн талаар нухацтай ярилцлаа.

Их цаазын төслийн үзэл баримтлалын асуудлаар манай улсын эрдэмтэд, мэргэжилтэн, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагуудын оролцоотой онолын бага хурал зохион байгуулж, төрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр Их цаазын төслийг олон эшт үзлийн үүднээс өргөн тайлбарлаж хэлэлцүүллээ.

Ардын Их Хурлын зарим депутат, Улсын Бага Хурлын болон комиссын гишүүд төв, орон нутагт явж Их цаазын төслийн үзэл баримтлалын асуудлаар хөдөлмөрчидтэй ярилцаж, өргөн санал солилцлоо. Төрийн хэвлэл мэдээллийн байгууллагууд Их цаазын төсөл хэлэлцүүлэх ажилд ихээхэн чармайлт гаргаж, олны санаа, бодлыг илэрхийлэн солилцуулахад чухал үүрэг гүйцэтгэлээ.

Бүхэлд нь үзвэл төслийг нийт 7000 гаруй байгууллага, хамт олон хурлаараа хэлэлцэж, түүнд 900000 гаруй хүн оролцож, давхардсан тоогоор 200 мянга гаруй санал гарсан байна. Эдгээр саналыг яам, тусгай газар, нам олон нийтийн болон эрдэм шинжилгээний байгууллагууд, аймаг, хотын Гүйцэтгэх захиргаад шүүж үзээд, яам, газар байгууллага, орон нутгийн хэмжээнд шийдвэрлэх асуудлыг түүгээрээ ярилцаж, төсөлтэй шууд холбогдох 8000 гаруй саналыг түүвэрлэж комисст ирүүлсэн юм.

Түүнчлэн комисст 1200-гаад хүн саналаа бичиж ирүүлсэн. Комисс хөдөлмөрчдөөс ирүүлсэн саналыг судлан боловсруулж, төсөлд тусгах, төслийг найруулан засах үүрэг бүхий эрдэмтэн, мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын II хэсэг байгуулан ажиллуулаа.

Хэлэлцүүлгийн явцад гарсан саналыг төслийн бүлэг, тус бүрээр авч үзвэл I,5 хувь нь удиртгал хэсгийн талаар, 26,4 хувь нэгдүгээр бүлгийн талаар, 21,1 хувь нь хоёрдугаар бүлгийн талаар, 40,8 хувь нь 3-р бүлгийн талаар, 8,8 хувь нь 4-р бүлгийн талаар, 1,4 хувь нь тавдугаар бүлэгтэй холбогдсон санал байна. Эдгээр бүх саналыг цахим тоолуурт оруулж, бусад хуультай эрх зүй, улс төр судлалын үүднээс харьцуулан дүгнэлт хийж үзээд, 44,3 хувийг төсөлд ямар нэгэн хэлбэрээр тусгалаа. Мөн саналын 5,9 хувийг төр, захиргаа, иргэн, эрүү, гэр бүлийн болон байцаан шийтгэх зэрэг салбарын бусад хуульд тусгахаар ялгаж авлаа. Ингээд үлдсэн 49,8 хувь нь одоо мөрдөж байгаа бусад хуулиар зохицуулаг буюу эсвэл төслийн зохиу-

Их цаазын төслийн зарчмын гол, гол асуудлаар төв, орон нутагт социологийн судалгаа явуулсан дүнг төслийг дахин засварлахдаа бас харгалзаж үзлээ.

Төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн дүнгээс болон социологийн судалгаанаас үзэхэд дараахь хэд, хэдэн асуудалд олон нийтийн санаа гоц төвлөрч байлаа. Үүнд:

Нэгдүгээрт Монгол улсын мөн чанар, хөгжлийн чиг хандлагийн талаар ярьсан багц саналын дотор нийгмийн хөгжлийн формацийн онолоор Монгол орны туулсан замыг дүгнэж цаашид ямар байгуулалд хүрэх зорилго, баримтлах зарчим, үзэл номлолыг тусгах ёстой гэсэн санал нэлээд байна.

Дэлхийн олон орны Үндсэн хуулийн жишигийг судлан үзвэл туулсан замаа дүгнэж, ирээдүйн хэв загварыг тодорхойлодог арга зөвхөн социалист гэгдэж байсан орнуудын Үндсэн хуулийн номлолд байжээ. Одоо энэ загвар өөрчлөгдөж нийгмийн оюун сэтгэлгээ, зохиомол хэв загвараас чөлөөлөгдөж байна. Хэв загвар тогтоох ч аргагүй боллоо.

Монгол орон цаашид дэлхийн улс орнуудын нэгэнт туулж өнөөгийн энэ хөгжил дэвшилд хүрсэн тэр нийтлэг үндэслэл дээр сэргэн мандаж, өсөн хөгжих замаар л явах болно. Ийм санааг Их цаазын оршил тодорхойлсон.

Хоёрдугаарт Монгол улсад төрийн удирдлагын ямар хэлбэр зохистой байх тухайд олон түмний анхаарал нэлээд төвлөрч байлаа. Хөдөлмөрчдөөс ирүүлсэн нийт саналын 60 гаруй хувь мөн социологийн судалгаанд оролцогчдын 50 гаруй хувь, Монголд төрийн удирдлагын Парламентын хэлбэр зохистой гэж үзжээ. Энэ нь нэг хүний мэдэлд удирдлага төвлөрч, дарангуйлан захирах ёс тогтохоос болгоомжлох, төрийн нуруу төвшин, төрийн эрх мэдэл зохих шалгуур, харилцан тэмцэлтэй байхыг манай нийгмийн сэтгэлгээ хүсэн хүлээж байгаатай холбоотой болов уу гэж үзэж байна.

5.

Үүний зэрэгцээ Монгол улсад Ерөнхийлөгчийн удирдлагын хэлбэр илүү тохиромжтой юм гэсэн баримтлалыг дэмжсэн санал 40 орчим хувийг эзлэж байна. Бид төслийг боловсруулахдаа дээрх санал Монгол улсын хөгжлийн түүхэн сургамж, шилжилтийн үеийн онцлог зэргийг харгалзан зохих бүрэн эрхтэй, Ерөнхийлөгчтэй, төрийн удирдлагын Парламентын хэлбэрийг сонгож авч байна.

Гуравдугаарт, Монгол улсын эдийн засгийн тогтолцоог Их цаазын төсөлд дэлгэрэнгүй тодорхойлох нь зүйтэй гэсэн санал нэлээд иржээ. Энэ нь эдийн засаг, үйлдвэрлэлийн зорилго, өмчийн болон зах, зээлийн харилцаа, түүний зохицуулалт хийгээд санхүү, зээлийн зэрэг олон асуудлыг хамарч байна.

Их цаазын төсөл боловсруулах хэсэг дээрх саналыг асуудлыг зохих салбарын зарим эрдэмтэн, мэргэжилтнийг оролцуулан дахин нухацтай авч үзлээ. Улсын Бага Хурал, Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс, уул асуудлуудтай холбоотой саналуудыг нягтлан үзээд, төрөөс эдийн засаг, өмчийн талаар баримтлах бодлого, газрыг зөвхөн Монгол улсын иргэдэд өмчлүүлэх, эзэмшүүлэх мөн энэ явцад үүсэх харилцааг төрөөс зохицуулах үндэслэлийг нэлээд нарийвчлаж тусгалаа. Энэ тухай дэлгэрэнгүй илтгэх болно.

Дөрөвдүгээрт, төрийн бэлэг тэмдгийн талаар олон санал ирсэн байна. Тэдгээрийн нэлээд хэсэг нь одоогийн сүлд, далбааг хэвээр үлдээх, нөгөө нь сүлдийг соёмбо, далбааг хөх өнгөтэй болгож өөрчлөх, гуравдах нь 1960 оноос өмнөх уламжлалыг сэргээхийг санал болгожээ. Энэ асуудал зөвхөн хууль зүйн төдийгүй, түүх, улс төрийн, бас урлаг, утга зохиолын судлалын олон талтайг харгалзан төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс оролцсон ажлын тусгай хэсэг байгуулж, хөдөлмөрчдийн саналыг тусад нь нэгтгэн судалсны үндсэн дээр цагаан цэцгэн дээр суурилуулсан соёмбо бүхий өмнөх хувилбарыг өөрчлөн шинэ загвар төсөл боловсруулж, тухайлан хэлэлцүүлэх зэргээр ажилласан. Ингээд өмнөх бэлэн загварыг сэргээх амархан, харин арай шинэлэг санаа бүхий хувилбаруудыг

олон түмэн, мөн депутатууд та бүхэнд толилуулж сонголт хийлгэх нь зүйтэй гэж Улсын Бага Хурал үзээд, энэ хувилбарыг хэлэлцүүлэхээр оруулж байгаа юм. Төрийн дууллын талаар олон бүтээл ирлээ. Үүний нэлээдийг хэвлэлд нийтлүүлсэн. Ажлын комисс дээр ярилцаж шалгаруулсан бүтээлийг та бүхэнд мөн толилуулна.

Тавдугаарт, Төрийн байгууллагын талаар түүний дотроос төрийн эрх барих дээд байгууллагын эрх хэмжээ, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааных нь харилцан шүтэлцээ, зарчмын талаар ажил хэрэгч олон санал ирсэн. Жишээлбэл Улсын Их Хурал хэдэн танхимтай байх, бүрэн эрхийн хугацаа хийгээд Их Хурлын гишүүд, Ерөнхийлөгчийг сонгох журам, Засгийн газрыг бүрэлдүүлэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагууд, тэдгээрийн баримтлах зарчим, бүрэн эрх, байгуулагдах журам зэрэг олон асуудлыг хамарч байна. Манай комисс Улсын Бага Хурал эдгээр асуудал дээр нэлээд тогтож ярилцлаа.

Их цаазын төслийн энэ бүлэг дээр зарчмын болон найрууллагын олон чухал өөрчлөлт орсон. Энэ тухай холбогдох бүлгүүдийн агуулга, хуримтлалыг илтгэхдээ тодруулж ярина.

Зургадугаарт, Монгол улсын засаг, захиргааны хуваарь цаашид өөрчлөлт оруулах эсэх тухай асуудал хэлэлцүүлгийн явцад анхаарал татаж байна. Ирсэн саналын байдлаас үзэхэд үнэндээ өөрчлөлт оруулахгүй гэсэн хандлага давамгайлж байна. Энэ нь ч анхаарах ёстой асуудал юм. Гэхдээ улс оронд нийгмийн тогтолцооны чанартай гүнзгий өөрчлөлт гарч, өмч, аж ахуйг эрхлэх зарчим, арга хэлбэр, нийгмийн бодлогын чиглэл шинэчлэгдэж орон нутгийн өөрөө удирдах ардчилсан ёс тогтох хандлага буй болж байгаа нь засаг, захиргааны нэгж аяндаа хөдлөх зайлшгүйд хүргэнэ гэдгийг Улсын Бага Хурал, комисс иш үндэс болгож байгаа юм. Харин орон нутагт эрх барих буюу эсвэл өөрөө удирдах байгууллага хуралтай байх, тэрхүү хурал нь байнгын буюу түр төлөөллийн хэлбэртэй байх эсэхтэй холбогдож гарсан саналын

төслийг шинэчлэн боловсруулахдаа бас харгалзаж үзсэн.

Долдугаарт, хамгийн олон санал ирсэн асуудал бол улсын болон энэхүү хуулийн нэрийн тухай юм. Эдгээр саналд улсын нэр, хуулийн нэрийг одоогийнхоор хэвээр үлдээх санал харьцангуй олонхийг эзлэж байгааг хэлэх нь зүйтэй. Энэ бол сэтгэлийн хөдлөлөөр хөнгөн, гоомой хандаж болмооргүй, ярилцаж, харилцан ойлголцож байж шийдэх зарчмын чухал асуудал юм. Асуудлыг хэрхэн шийдэх эрх бололцоо Ардын Их Хурлын мэдэлд байна. Хэрхэхийг депутат, та нөхдийн мэргэн ухаан мэдэх биз ээ. Ингээд бүхэлд нь дүгнэж үзвэл хөдөлмөрчдөөр хэлэлцүүлсний үр дүнд Их цаазын өмнөх төсөлд 81 зүйлтэй байсныг зарим зүйлийг хасах, утга санааг нэгтгэх зэргээр 70 зүйлтэй болгож, II зүйдийг агшаан хасч, зарчмын чанартай хэд, хэдэн санаа шинээр нэмж, томъёо, жэллэг, зохиомжийн хувьд нэлээд өөрчлөлт хийж дахин боловсрууллаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Ц. Баярмаа

/Ц.БАЯРМАА/

Бичээч

С.ТУУЛ

1991-XI-13

Кассета № 06

15.30-15.45

Илтгэл

П.Очирбат: -2 төслийг харьцуулан нягтлан үзвээс ямар нэгэн өөрчлөлт ороогүй зүйл анги бараг байхгүй. Хүний эрх, эрх чөлөө гэсэн 2 дугаар бүлгийг нэлээн өөрчлөн шинэчилж улс орны тусгаар тогтнолын баталгаатай холбогдсон зарчмын хэд хэдэн асуудлыг шинээр нэмлээ. Төрийн эрх барих дээд байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шижмүүдийг төгөлдөржүүлэхдээ холбогдсон зарим асуудлуудыг тодруулж заалаа. Ингээд Их цаазын төслийн гол үзэл баримтлалтай холбогдсон асуудлыг төслийн бүлэг бүлгээр нь авч үзье. Гурав, Монгол улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг хуульчлан бататгасан нь. Монголын нийгмийн нийгэм эдийн засаг, улс төрийн гол шинж төрийн тусгаар тогтнол бүрэн эрхт байдлын хууль зүйн үндсийг бататгахад чиглэсэн төрийн гол хуулийн гол зангилаа асуудлыг төслийн монгол улсын бүрэн эрхт байдал нэртэй I дүгээр бүлэгт тусгасан байна. Ард нийтээр хэлэлцүүлсэн төсөлд монгол улс бол бүрэн эрхт тусгаар тогтносон хууль цаазат ардчилсан улс мөн гэж заасныг өөрчлөн тусгаар тогтносон бүрэн эрхт Бүгд найрамдах улс мөн хэмээн төрийн удирдлагын хэлбэрийг нэмж тодорхойлохын зэрэгцээ түүний мөн чанарыг илтгэсэн зарчмуудыг шинээр томъёоллоо. Тухайлбал хууль дээдлэх ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгосон нь төрийн мөн чанар, хөгжлийн чиг хандлагаа тодорхойлж байгаа чухал учир холбогдолтой юмаа. Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх тухай асуудал Их цаазад анх удаа орж байгаа бөгөөд энэ бол манайх шиг үндэсний хувьд нэг маягийн бүрэлдэхүүнтэй цөөн хүн амтай улсын хувьд тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын нэг гол илэрхийлэл мөн гэж үзсэн юм. Төрийн бэлгэ тэмдэг бол тухайн улсын тусгаар тогтносон бүрэн эрхт байдлын бас нэг чухал илэрхийлэл болдог ажээ. Тийм ч учраас Их цаазын төслийг хэлэлцэх явцад эл асуудал олон түмний анхаарлыг ихэд татаж байлаа. Төрийн сүүлд төрийн далбааны талаар нэлээн олон санал, бүтээл ирсний дотроос Улсын Бага Хурал зураач Чингэсболдын зурсан хувилбарыг сонгож Ардын Их Хуралд оруулж хэлэлцүүлэхээр тогтсон байна. Тэгэхдээ бусад төслүүдийг та бүхэнд танилцуулах болно. Монгол улсад Зас-

гийн эрхийг ард түмэн мэдэх бөгөөд тэд энэ эрхээ сонгуульд оролцох төрийн эрх бүхий байгууллагад сонгогдох ард нийтийн санал асуулга зохион байгуулах зэргээр шууд болон төлөөлөлтийн зарчмын бүх хэлбэрийг ашиглан хэрэгжүүлнэ. Их цаазын төсөлд хууль ёсны Засгийн эрхийг хуулиас гадуур авах буюу авахаар завдахыг хориглосон заалт шинээр орж байна. Энэ бол шууд утгаараа төрийн тусгаар тогтнол, ард түмнийхээ бүрэн эрхийг элдэв гэмт халдлагаас хамгаалж байгаа хэрэг юм. Төрийн сонгуулиар хууль ёсоор авсан Засгийн эрх мэдлийг ард түмнийхээ эрх ашгийн эсрэг хэрэглэхийг дээрхийн нэгэн адил хориглож байна. Монгол улсын тусгаар тогтнол бүрэн эрхийн гол шинж нь түүний нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил нь халдашгүй дархан байх явдал юм. Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ зарчимд нийцсэн гадаад бодлого явуулахдаа олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтээ үнэнч байх үндэслэлийг Их цаазад тусгаж байна. Төслийн 10 дугаар зүйлд Монгол улсын олон улсын гэрээнд соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ, гэсэн заалт орж байна. Энэ бол манай хууль зүйн шинэчлэлд нэг чухал алхам. Монгол улс олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд улс хоорондын харилцааны торим, хэм хэмжээг хүндэтгэн биелүүлэх шийдвэр төгс байгаагийн нотолгоо юм. Их цаазын удиртгал хэсэгт ирээдүйд бидний хүрэхээр зорьж байгаа иргэний ардчилсан нийгмийн үндэс болох төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн тухай үзэл баримтлалыг тодорхойлж байна. Энэ үзэл баримтлалын гол агуулга хэрэглэгч нь үйлдвэрлэгчээ чөлөөтэй сонгох, шууд харилцах, үйлдвэрлэгчид үйлдвэрлэлийн хүчин зүйлийг бүрэлдүүлэх бүтээгдэхүүнээ борлуулах талаар зах зээл дээр чөлөөтэй өрсөлдөх, таваарын ба үйлчилгээний үнэ эрэлт нийлүүлэлтийн харилцааны дагуу бүрэлдүүлэх, үйлдвэрлэгчид үйлдвэрлэлээ бие дааж явуулах боломжтой байх явдал мөн юм. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд Их цаазын гол үүрэг нь төрийн механизмаар дамжуулан нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн үндсэн тэнцвэрийг хангаж зах зээлийн харилцааны сөрөг үр дагаварыг хязгаарлаж хүн амын амьжиргааг нийгмийн зүгээс баталгаажуулахад оршино. Монгол улс эдийн засгийн хувьд бие даасан бодлого баримтлахдаа олон улсын эдийн

засгийн нийтлэг харилцаанд оролцох бүрэн боломжтой байх нөхцлийг төр хангах, чингэхдээ өөрийн орны уламжлал онцлогийг харгалзах зарчимд тулгуурлаж байна. Монгол орны эдийн засаг, жам ёсоороо хөгжих, үндсэн нөхцөл нь түүний бие даасан байдал юм. Тус орны эдийн засаг аль нэг орныхоо хараат бусаар хөгжих өөрийн хүч боломжит тулгуурласан эдийн засгийн салбаруудыг үүсгэн хөгжүүлэх бусад улс гүрэнтэй харилцан ашигтай, эрх тэгш хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн эдийн засгийн бие даасан бодлогын хууль зүйн үндсийг тогтооход энэ төслийн агуулга үүнд чиглэгдэж байгаа юм. Олон жилийн турш манай хүмүүс хувийн өмчийг ганц утгаар зөвхөн мөлжлөгийн хэрэгсэл гэж өрөөсгөл ойлгож даджээ. Чухам энэ дадал эдүгээ олон асуудлыг шинээр авч үзэх, шийдвэрлэхэд саад болсоор байгааг бидний өдөр тутмын ажил Их цаазын төслийг хэлэлцүүлэх явц харуулсан. Хэрэв бид өмчийн бусад хэлбэрийн нэгэн адил хувийн өмчийг хуулиар зөвшөөрч өгөхгүй юм бол зах зээлийн харилцаанд шилжих чөлөөт өрсөлдөөнийг хөгжүүлэх, эдийн засгаа олон улсын эдийн засгийн тогтолцоонд эрх тэгшээр оруулах, хүний эрхийг баталгаатай хангах тухай зорилтууд хэрэгжих үндэсгүй болоход хүрэх юм. Их цаазын төслийн үзэл баримтлалын хувьд олон нийтийн анхаарлыг нэлээд татаж байгаа бас ч багагүй санал зөрөөтэй байгаа нэг сэдэв бол газар өмчлөлийн тухай асуудал юм. Монголын ард түмний үеийн үед эрх чөлөө тусгаар тогтнолынхоо нэгэн үндэс гэж үзэж тэмцэж, хамгаалж ирсэн газар нутаг түүнд хамаатай бусад зүйл тухайлбал газрын хэвлий, ус, ой, амьтан ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад байх бөгөөд газрыг зөвхөн Монгол улсын иргэдэд өмчлүүлэхээр төсөлд заалаа. Газрыг иргэдэд хувьд өмчлүүлэх асуудлаар зарим нөхдүүдийг эмзэглүүлж буй учир баримтуудыг бид хүндэтгэн үзэж байна. Тэгэхдээ энэ бол ганцхан манайд тохиолдож байгаа асуудал биш, зах зээлийн эдийн засаг бүхий дэлхийн улс гүрнүүдэд нэгэн адил хэвшсэн арга юм. Газрын зохих хэсгийг тодорхой нөхцлөөр иргэдэд өмчлүүлэхгүйгээр зах зээлд жам ёсоор тогтож хөгжих, иргэд аж төрөх, хөдөлмөрлөх оршин суух, шилжин суурьших өв залгамжлах зэрэг хүний үндсэн эрхийг жинхэнэ утгаар нь эдлүүлэх аргагүй юмаа. Гэхдээ газар зүйн байршил газар эдэлбэрийн чиглэл зэрэг монгол орны өвөрмөц нөхцлийг харгалзан хөдөлмөрчдийн саналын дагуу шинчлэн найруулсан төсөлд улс орны тусгаар тогтнолын

баталгааных нь хувьд төрөөс газрыг хамгаалахад чиглэсэн зарчмын хэд хэдэн заалт шинээр нэмж орууллаа. Тухайлбал, газрын хэвлий болон бэлчээр, нийтийн эдэлбэрийн газар, тусгай хэрэгцээний зориулалтын газрыг иргэдэд өмчлүүлэхгүй байхаар төсөлд 6-р зүйлд тусгаж байна. Манай улсын газар нутгийн 78,9 хувийг хөдөө аж ахуйн, үүнээс 77,9 хувийг бэлчээрийн зориулалтаар ашигладаг. Монголын нийт нутаг дэвсгэрийн 03 орчим хувийг эзэлдэг хот суурин газарт оногдож буй төрүүхэн хэсгийг л Монголын иргэдэд өмчлүүлэх тухай асуудал тусгагдаж байгаа юм. Газрын эзэн, хуулиар олгосон эрхээ эдлэхдээ бусад хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх ёстой. Үүнтэй холбоотойгоор газрын эзэнд өмчилж, өмчилсөн газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улс орны зайлшгүй хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг эргүүлэн авах эсвэл байгаль хамгаалалт, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал уул газрыг хураан авч болохоор төсөлд шинээр тусгалаа. Гадаадын иргэд, харьяалалгүй хүн газар өмчлөх, эзэмших эрх эдлэх асуудалыг нягтлан үзээд төрийн өмчийн газрыг Монгол улсын болон гадаадын иргэн харьяалалгүй хүнд түрээсээр, түүнчлэн хуульд заасан бусад болзол хэлбэрээр эзэмшүүлэн эдлүүлж болно гэсэн заалтыг төслийн 6 дугаар зүйлд бас шинээр орууллаа. Газрыг иргэдэд өмчлүүлж болохгүй хэмээдэг учир баримт хэр үндэслэлтэй хэр ирээдүйтэй эсэхийг та бүхэн энэ бүхнээс тунхаан үзнэ бизээ. Би ингэж хэлэхдээ газрын тухай сэдэв бол 7 хэмжиж нэг огтолбоос зохих зарчмын асуудал гэдгийг огт үгүйсгэхгүй байна. Төслийн нийтлэг үндэслэлийг хамарсан энэхүү тэргүүн бүлэгт Монгол улс энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулах, эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг байх, өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байх, түүнчлэн төр, шашны харилцааны тухай зэрэг заалтыг шинэчлэн буюу шинээр оруулсныг та бүхний анхааралд толилуулж байна.

Дөрөв. Хүний эрх, эрх чөлөө, тэдгээрийн баталгааны талаар:

Хүний эрх, эрх чөлөөний тухай асуудал Их цаазын төсөлд биеэ даасан бүлэг болон томоохон суурь эзэлж байна. Хүний эрх, эрх чөлөөг дэлхийн улс орнуудын ардчилсан Үндсэн хуулийн төвшинд өргөн дэлгэр тусгахдаа Монголын ард түмэн эл асуудлыг эрх үүрэг хэмээн хос үгээр томъёолж салшгүй холбоотойгоор мөн чанарыг нь ойлгож ирсэн уламжлалыг Их цаазын төсөлд багтаасныг

шинэлэг тал гэж хэлж болох юм. БНМАУ-ын өмнөх Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид эл асуудал иргэний эрх, эрх чөлөө гэсэн нэлээд явцуу утгаар тусгагдаж ирсэн боловч тэдгээрийн зарим заалт хэрэг дээрээ гүйцэд хэрэгжээгүй гэж хэлэх үндэстэй. Үүний нотолгоог холоос эрээд хэрэггүй, манай олон жил ноёрхож ирсэн хүнд суртлын тогтолцооны үед төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрх, эрх чөлөөг янз бүрийн хэлбэрээр ноцтой зөрчдөг хэрнээ түүнийхээ төлөө хуулийн хариуцлага тэр болгон хүлээх нарийн чанд механизм илт дутагдаж байсныг та бид мэднэ. Иймээс Их цаазын төсөлд төрийг хувь хүний эрх, эрх чөлөөний баталгаа болгож заасан үзэл баримтлал энэ бүлгийн агуулгыг шууд хөндөж байна. Өөрөөр хэлбэл иргэн төрийнхөө өмнө төдийгүй тэр нь иргэнийхээ өмнө харилцан үүрэг хүлээх зарчмын Монгол улсын их цаазад ийнхүү анх удаа бататгаж байна. Хүний эрх, эрх чөлөө гэсэн энэ бүлгийг боловсруулахдаа, олон улсын эрх зүйн нийтлэг хэм хэмжээ, зарчим, манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг сайтар харгалзан үзэж тэдгээрт нийцүүлэхийг хичээнгүйлэн оролдсон. Нэгдсэн үндэсний байгууллагын хүний эрхийн судалгааны төвийн мэргэжилтэн хуульч, шинжээч нарт манай төслийг НҮБ-ын ерөнхий ассамблейн баталсан хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактаар харьцуулан жишиж үзээд олон улсын эрх зүйн хэм хэмжээнд дүйж байна гэсэн дүгнэлт хийж зарим саналыг дэвшүүлснийг харгалзан үзсэн.

Хүний эрхийг ямраар ч тунхаглаж болох юм. Галтхүү түүнийг төрийн зүгээс баталгаатай болгохгүйгээр тэр нь хоосон тунхаг болдгийг бидний өнгөрсөн түүх бэлхнээ гэрчилж байна. Ийм байдлыг цаашид хэзээд давтахгүй байхын тулд Их цаазын төсөлд төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдлын эсрэг тэмцэх хөндөгдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх үүргийг иргэдийн өмнө хариуцна гэсэн зарчмыг зориуд тусгалаа. Манай өмнөх Үндсэн хуулинд ийм баталгаа байгаагүй. Төслийг боловсруулахдаа хүний эрх, эрх чөлөө нь амьд явахаас эхлээд чөлөөтэй аж төрөх хүртэлх хүний амьдралын бүхий л хэм хэмжээгээр тодорхойлогддог нийтлэг зарчмыг иш үндэс болгосон юм. Иргэн бүр хувийн өмчтэй байх, хувийн сургууль байгуулах, оршин суух газраа

чөлөөтэй сонгох, дотоод , гадаадад зорчих, эх орондоо буцаж ирэх эрхтэй байх ёстой. Иргэний өмчийг хууль бусаар хурааж авах, тэр түүний байгууллага хариу төлбөргүйгээр дайчлан авахыг хуулиар хориглож хэрэв нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг нөхөх олговортойгоор дайчлан авбал үүнийг төлөх журмыг тогтоохоор төсөлд тусгаж байгаа нь иргэдийн өмчлөх эрхийг хамгаалсан хэрэг юм. Хэлэлцүүлж байгаа төсөлд хэнд боловч эрүү шүүг тулгах, хуульд зааснаас бусад тохиолдолд хэнийг ч албадан хөдөлмөрлүүлэхийг хориглохоор заалаа. Түүнчлэн гэм буруутай болох нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно гэсэн заалт орууллаа. Энэ бүхэн нь ганцаар дарангуйлах дэглэмийн үед хууль ёсыг ноцтой гажуудуулж, хүнийг олноор нь хэлмэгдүүлж байсан тэр гамшгийг дахин давтахгүй байх төрийн баталгаа болж байгаагаараа бүр ч ач холбогдолтой юмаа.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

1991.XI.IЗ.
Кассет № 07
15.45-16.00

Ерөнхийлөгч П.Очирбат: ... Төсөлд иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх, нийгэм, төрийг удирдах хэрэгт чөлөөтэй оролцох зэрэг иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад чиглэсэн тодорхой заалтуудыг тусгалаа.

Тодорхой нөхцөл байдлын улмаас улс оронд дайны болон онц байдал зарласан тохиолдолд ч хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахыг хориглосон заалтыг оруулснаар манай нийгэмд ямар ч нөхцөлд хүний эрхийг баталгаатай хамгаалах хууль зүйн үндсийг бүрдүүлэх болно.

Төсөлд иргэдийн эрх үүрэг, нэгдэлтэй байх нь иргэдийн ардчилсан нийгмийн гол шаардлага байх ёстой гэсэн үзэл баримтлалыг хуульчлан тогтоох нь зүйтэй гэж үзсэн юм.Энэ зорилгоор төрийн хуулиа эрхэмлэн дээдлэх, хүний нэр төр, алдар хүнд, хууль ёсны эрх ашиг, сонирхлыг эрхэмлэн хүндэтгэх, хуулиар тогтоосон албан татвар төлөх, цэргийн алба хаах үндсэн үүрэг хийгээд эх орон, байгаль орчноо хамгаалах журамт үүргийг ч нэгэн адил хуульчлан тогтоохоор төсөлд тусгалаа.

Энэ бүлгийг боловсруулахдаа хүн бүр эрхтэй, түүнийгээ хамгаалах баталгаатай байх ёстой гэсэн үзэл баримтлалыг иш үндэс болгох уу, ингэснээр Их цаазын төслийн энэ бүлэг бүхэлдээ хүний эрх, эрх чөлөө төрийн зүгээс баталгаатай болгохын хамт иргэн бүр хууль ёсны эрх, эрх чөлөөгөө хамгаалах хууль зүйн үндсийг бүрдүүлж байгаагаар хүний эрхийн салбарт бид урагш томоохон алхам хийж чадна гэж найдаж байна.

Төсөлд хүний эрхийн түгээмэл зарчмуудыг тусгахын хамт Монгол улсын харьяат иргэд, тус улсад байгаа гадаадын харьяат, харьяалалгүй хүмүүсүүдийн эрх, эрх чөлөөний хууль зүйн үндсийг олон улсын эрх зүйн хэмжээнд Монгол улсын бүрэн эрхт байдлын аль аль талыг уялдуулан харгалзаж үзсэн гэж бодож байна.

5. Төрийн байгуулалт, түүний тогтолцооны талаар

Тус улсын төрийн байгууллын хүрээнд цаашид хийх шинэчлэлийн утга учир бол хүн төрөлхтөний олон үеийн төлөөлөгчид томъёолж соёл иргэншлээр шалгалдсан засгийн эрх мэдэл хуваарилах онолыг иш үндэс болгон төрийн дээд эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүхийн байгууллагын хооронд оновчтой хуваарилах, энэ нь харилцан шүтэлцээтэй, эрх үүргийн тэнцэлтэй байх, бие биедээ хяналт тавих явдлыг хангахад оршиж байна. Энэ асуудлыг Их цаазын төслийн Монгол улсын төрийн байгуулалт гэсэн 3 дугаар бүлэгт тодорхойлж байна.

Хууль тогтоох эрх мэдлийн талаар. Засгийн эрх ард түмний мэдэлд байж үүнээс үүсэлтэй төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага Монгол улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийг ард түмний нэрийн өмнөөс хэрэгжүүлж байхаар тусгав.

Төсөлд Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим, бүрэн эрхийг тодорхойлохдоо манай улсад парламентын удирдлагын хэлбэр зонхилж байх үүднээс Улсын Бага Хурал Монгол улс бол парламентын бүгд найрамдах улс мөн гэсэн зарчмын шинэ томъёолол нэмж оруулсан.

Парламент буюу Улсын Их Хурал нь нэг танхимтай, байнга ажиллаж байх үзэл баримтлалыг иш үндэс болгож байна. Ингэхдээ нэгд, төрийн байгууламжийн хувьд холбоот биш улсын хэлбэртэй манайх шиг дэлхийн 50 гаруй улсад нэг танхимт парламенттай байдаг нийтлэг үндэслэл, хоёрт, хууль тогтоох дээд байгууллагын зохион байгуулалтад илүү шат дамжлаг, зардал, орон тоо гаргахгүй байх боломж, гуравт, манай орны шилжилтийн хүнд бэрх төвөгтэй үед төрийн удирдлагын нэгдмэл, цогц шинж чанарыг хадгалахын сацуу асуудлыг оновчтой, шуурхай шийдвэрлэх шаардлага зэргийг гол шалгуур болгож авсан юм.

Их цаазын төсөлд зааснаар Улсын Их Хурал 76 гишүүнээс бүрдэх юм. Энэ тооны хувьд олон янзын санал гарсан бөгөөд дунджаар энэ тоо нь бусад саналын агуулгад нийцэж байгаа юм. Улсын Их Хурлын нэг гишүүн нь 28000-30000 хүний буюу сонгуулийн насанд хүрсэн 14000-15000 орчим сонгогчийг төлөөлөхөөр

байгаа нь дэлхийн улсуудын жишигтэй бас дүйж байгаа юм.

Та бүхэнд тараасан төсөлд ийнхүү 76 гэсэн тэгш тоо сонгож авсны учир нь нэгдүгээрт, Улсын Их Хурлын нийт гишүүний хоёрны нэгийг 3 жил тутам сэлбэн шинэчилж байх, хоёрдугаарт, Улсын Их Хурлын дарга дэд даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил байхаар тогтоож байгаатай холбоотой юм.

Улсын Их Хурлын гишүүдийг сонгохын тулд манай нутаг дэвсгэрийг бүхэлд нь сонгуулийн нэг буюу эсвэл олон мандаттай тойрогт хуваах бөгөөд энэ үед сонгуулийн тэгш эрхийн зарчмын тухай асуудал гарна гэж бодож байна. Дэлхийн ямар ч оронд сонгуулийн тэгш эрхийн зарчим нэг тойрогт хамаарах хүний тоо яг адил байх утгаар биш, харин тэнд нэг сонгогч нэг тойрогт бүртгэгдэх, нэг л удаа саналаа өгөх зэргээр сонгогчид сонгуульд эрх тэгшээр оролцдогт энэний учир оршиж байх шиг байна.

Урьдчилсан баримжаагаар хэрэв нэг мандат гишүүнтэй нөхцөлд Улсын Их Хурлын нэг гишүүний сонгуулийн тойрог нь дунджаар 3-4 сумын нутаг дэвсгэрийг, хэрэв олон мандаттай нөхцөлд нэг тойрог нэг аймгийн нутаг дэвсгэрийг хамрах юм. Энэ асуудлыг сонгуулийн хуулиар шийдвэрлэхээр бодолцсон. Төслийн заалт нь одоогийн тогтсон практикттай харьцуулбал Улсын Их Хурлын гишүүнээс сонгогчидтойгоо харилцах бололцоог хязгаарлагдмал болгож болзошгүй мэт ойлголт төрүүлж болох юм. Төсөл боловсруулах комисс Улсын Бага Хуралд асуудлыг ийнхүү тавихдаа дараах учир шалтгааныг онцлон үзэж байгаа юм.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн бол бидний урьд ойлгож ирсэнчлэн ард түмний зарц-сонгогчийн захиа даалгавар биелүүлэгч биш харин нийт ард түмний өмнөөс ажилладаг, хууль тогтоох байгууллагын байнгын гишүүн, төрийн шадар зүтгэлтэн байх юм.

Хоёрдугаарт, төсөл ёсоор орон нутгийн засаг захиргаа нь зөвхөн төвөөс өгсөн үүрэг даалгавар гүйцэтгэгч бус хуулиар тусгайлан олгосон эрх үүрэг, өөрийн удирдлага бүхий нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн биеэ даасан цогцолбор байх болно.

Ийм нөхцөлд Улсын Их Хурлын гишүүн сонгогчид болон төвийн хооронд аж ахуй эрэлт хэрэгцээг хангадаг зуучийн үүрэг гүйцэтгэгдгээсээ чөлөөлөгдөх болно.

Гуравдугаарт, хэрэв шаардлагатай бол Улсын Их Хурлын гишүүн сонгогдсон тойргийнхоо хэмжээнд хэд хэдэн хэсэгт өөрийн туслагч төлөөлөгчдийг ажиллуулж сонгогчдын эрэлт хүсэлтийг хүлээн авч тэдэнтэйгээ байнга холбоотой байх тусгай боломжоор хангагдаж болох юм.

Улсын Их Хурлын гишүүдийн мэргэжсэн чадвар хийгээд хууль тогтоох ажлын залгамжлагдах, шинэчлэгдэх хос чанарыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүнийг 3 жил тутам өөрчлөн сэлбэж байх зарчмыг сонгон авч төсөлд оруулсан. Энэ бол манай парламентын хувьд үнэхээр шинэлэг зүйл бөгөөд уул зарчмыг сонгож авснаар цаашдаа Улсын Их Хурлынх бус харин түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 6 жил байж ингэснээр Улсын Их Хурал байнга тасралтгүй ажиллах нөхцөл боломжоор хангагдах юм.

Улсын Их Хурлын ажиллах чадавхи, үр дүн нь түүний гишүүдийн нас, боловсрол, мэдлэгийн түвшин, амьдралын туршлага, зохион байгуулах, бодлого боловсруулах чадвараас шууд шалтгаалах нь зүйн хэрэг. Үүнийг иш үндэс болгож Монгол улсын 25 нас хүрсэн иргэнийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгож байхаар төсөлд заасан.

Улсын Их Хурлын бүрэн эрхийг нэлээд дэлгэрэнгүй авч үзэхдээ улс орны дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэж байхын зэрэгцээгээр гагцхүү Улсын Их Хурлын шийдвэрлэх онцгой бүрэн эрхийн асуудлыг тодорхой тусгалаа. Ингэхдээ уг асуудлыг Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн бүрэн эрхийн хугацаа, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэртэй аль болохоор холбоотой байхаар бодолцсон юм.

Төсөлд заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлыг дараах хэд хэдэн чиглэлээр авч үзэж байна.

Тухайлбал, нэгдүгээрт, төрийн хууль тогтоох үйл ажиллагааг эрхлэн шийдвэрийнхээ биелэлтийг хянан шалгах, олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, хоёрдугаарт, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, энэ талаар төрөөс явуулах бодлого, гуравдугаарт, өөртөө ажлаа хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэн эрх, бүтэц бүрэлдэхүүнийг тогтоох, засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, түүн дээр үндэслэсэн өөрөө удирдах болон гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааных нь эрх зүйн үндсийг тодорхойлох, дөрөвдүгээрт, Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын гишүүний сонгуулийг товлон зарлах үндэслэл, тавдугаарт, Монгол улсын гадаад харилцаанд баримтлах бодлого, чиг хандлагыг тогтоох арга хэлбэр, зургадугаарт, иргэдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоож байгаа юм.

Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээ, хязгаар нь парламентын удирдлагын хэлбэртэй бусад улсын хууль тогтоох байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааных нь үндсэн чиглэлтэй үндсэндээ дүйж байгаа юм. Улсын Их Хурал бүрэн эрхээ өөрийн чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлж байхаар төсөлд тусгаж байна. Улсын Их Хурлаас бүрэн эрхээ байнга тасралтгүй хэрэгжүүлэх үүднээс үйл ажиллагааныхаа зохих салбар чиглэлээр байнгын хороодтой байх юм. Энэ нь дэлхийн олон орны парламентын зохион байгуулалт, үйл ажиллагааны нийтлэг хэлбэр мөн бөгөөд бидний судалж үзснээр эдүгээ 83 орны парламентад 2-23 төрлийн байнгын хороо ажиллаж байгаа хийгээд манай Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын өнгөрсөн хугацааны туршлага, одоогийн практикийг нэгэн адил харгалзан үзснээр тайлбарлаж болно.

Төслийн 33 дугаар зүйлийн I дэх хэсгийн II-д зааснаар Монгол улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ дагуу дайны болон онц байдал зарласан бол Улсын Их Хурлын онцгой чуулганыг түүнээс хойш 72 цагийн дотор тусгайлан зарлан товлдохгүйгээр хийхээр тусгалаа. Мөн онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгох бөгөөд хэрэв Улсын Их Хурал уг асуудлаар шийдвэр гаргаагүй бол уг зарлиг хүчингүй болох юм. Энэ бол Парламентын бүгд най-

рамдах улсын онцлогийг илэрхийлсэн төдийгүй хүний эрхийг хөсөрдүүлэхээс сэргийлэхэд чиглэсэн зарчмын шинэ заалт бөгөөд үүнд та бүхнийг анхаарлаа толилуулахыг хүсч байна.

Хоёр. Ерөнхийлөгч, түүний бүрэн эрхийн талаар

Энэ бүлгийн Монгол улсын Ерөнхийлөгч гэсэн 2 дугаар хэсэгт төрийн тэргүүнийг сонгох журам, бүрэн эрх, Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын дээд шүүхийн харилцах эрх зүйн үндэс, тэдгээрийг хэрэгжүүлэх баталгаа зэрэг асуудлыг тусгав.

Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл байх хууль зүйн үндэслэлийг тогтоох үзлийг баримтласан. Их цаазын төслийн ёсоор Ерөнхийлөгч нь зонхилох төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд ажиллах чиглэлтэй байгаа бөгөөд төрийн тэргүүний хувьд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүхийг удирдах ажиллагаанд зохицуулах зарим чиг үүрэгтэй байна.

Тухайлбал, Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд хууль санаачлах, Улсын Их Хурлаас баталсан хуульд хориг тавих, улс орны эдийн засаг, нийгэм, төрийн амьдралын ямар ч асуудлыг хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд санал оруулах эрхтэй байхын зэрэгцээ нэгэнт Улсын Их Хурлаас бүрэн эрхээ хүлээн зөвшөөрүүлсэн буюу сонгогдсонхоо хувьд түүнд ажлаа хариуцан тайлагнаж байхаар төсөлд тусгалаа. Үүний зэрэгцээ төрийн тэргүүнийхээ хувьд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад гадаад харилцаанд улсаа төлөөлөх, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх, зөвсөгт хүчний ерөнхий жанжин байх, Улсын Их Хуралд олон суудал авсан намтай буюу намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Монгол улсын Ерөнхий сайдаар томилох болон шаардлагатай гэж үзвэл Засгийн газрыг огцруулах тухай саналаа Улсын Их Хуралд оруулж байх зэрэг бүрэн эрхтэй.

Түүнчлэн Монгол улсын Ерөнхийлөгч нь бүх шатны шүүхийн шүүгчдийг томилж байх юм. Ерөнхийлөгч ямар нэг хэргийг хэрхэн хянан шийдвэрлэх талаар чиглэл зөвлөмж өгөх, хяналт тавих

зэрэг аливаа хэлбэрээр Улсын дээд шүүх, бусад шүүхийн шүүн таслах үйл ажиллагаанд оролцох эрхгүйг онцлон тэмдэглэж байна.

Соронзон хальстай тулгаж нийлсэн:



Ж.НАРАНТУЯА

Бичээч

Ө.ОЮУНЧИМЭГ

БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат:- Их цаазын төсөлд Ерөнхийлөгчийг сонгох сонгууль хоёр шаттай байхаар тогтоосон юм аа. Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлэх явцад энэ талаар гарсан саналуудыг харгалзан үзэж комисс Ерөнхийлөгчийн сонгуулийн хувилбарыг доорхи байдлаар шинэчиллээ.

Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахаар төсөлд тусгав. Энэ тохиолдолд хоёр дахь шатны сонгууль хийхгүй. Харин Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн хэн нь ч сонгогчдын олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг хоёр дахь шатны сонгууль букуу Улсын Их Хуралд оруулан хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар Ерөнхийлөгчийг сонгохоор тусгаж байна.

Их цаазын төслийг ард нийтээр хэлэлцүүлэх явцад Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгох, мөн Улсын Их Хурлаас сонгох, эсвэл энэ хоёр хэлбэрийг хослуулсан хувилбар байх тухай гурван янзын санал гарсан юм аа. Бид сүүлчийн хувилбарыг нь сонгож авсан. Ерөнхийлөгчийг шууд парламентаас сонгох зарчим нэлээд түгээмэл байгаа бөгөөд тухайн нөхцөлд парламентад ёс төлөвшин хөгжих үйл явц эхэлж байгаа орнуудад төрийн засаг нь ард түмнээс сонгогдсон парламентад төвлөрдөг байна. Үүний хамтаар Ерөнхийлөгчийг эрх мэдлээ хэрэгжүүлэхэд ард түмний төлөөлөгчдөөс төрийн дээд хяналт тавих, Ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд гарч болох дутагдал, доголцлыг сэргийлэх, тухайн үед нь залруулах, улмаар эрх мэдлээ хэтрүүлэх явдлыг хязгаарлаж байх боломжийг бүрдүүлдэг. Гэвч энэ тохиолдолд Ерөнхийлөгчийн сонгууль зөвхөн парламентын хүрээнд түүнд суудал авсан намуудын хэмжээнд болдог бөгөөд нийт ард түмний хүсэл эрмэлзэл үүнд төдийлөн нөлөөлж чаддаггүй байсан. Тиймээс ч бид эдгээр хэлбэрийг хослуулсан уян хатан, дундач гэж болох хувилбарыг сонгож авсан. Парламентын удирдлагын хэлбэр зонхилж байгаа зарим орны Ерөнхийлөг-

чийн эрх хэмжээтэй харьцуулахад манай Ерөнхийлөгчид нэлээд өргөн эрх эдлүүлэхээр төсөлд оруулсан боловч Ерөнхийлөгч төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх буюу Засгийн газрын үйл ажиллагааг чиглүүлэхтэй холбогдсон эрх хэмжээ одоогийн төсөлд арай дутмаг байгаа юм аа. Ерөнхийлөгчөөр сонгогдох хүний насны талаар ярилцах нь зүйтэй гэж бодож байна.

Гурав. Засгийн газар, түүний бүрэн эрхийн талаар

Төслийн гуравдугаар бүлгийн гуравдугаар хэсэгт манай төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хадгалж хэрэгжүүлдэг төрийн гүйцэтгэх дээд байгууллага нь Монгол Улсын Засгийн газар байж, Их цааз бусад хуулийг биелүүлэх үндсэн дээр аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдаж, Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа хариуцан тайлагнаж байхаар тусгалаа. Засгийн газрыг Монгол Улсын Ерөнхий сайд удирдаж бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Мөн Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилохоор заасан.

Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Харин Улсын Их Хурлын гишүүдийг шинэчлэн сонгож, сэлбэсний дараа Засгийн газарт итгэх эсэхийг тухай бүрд нь хэлэлцэж байж шийдвэрлэхээр бодолцсон байна. Энэ нь Улсын Их Хурлын шинээр сонгогдсон гишүүдийн бүрэлдэхүүнд зохих тооны суудал авсан намуудын бүлгийн бүтэцэд үндсэн өөрчлөлт орсон тохиолдолд гарч болох талтай юм. Үүнийг Улсын Их Хурлын болон Засгийн газрын хуульд тодруулан тусгах болно.

Засгийн газар нь үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд хариуцах бөгөөд Ерөнхий сайд нь төрийн хуулийг биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнана. Засгийн газрын гүйцэтгэх чиг үүргийг 9 дэд хэсгээр нэмж төсөлд тусгасныг анхааралдаа авахыг хүсье. Засгийн газрын тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг зөвхөн хуулиар тогтоож байхаар тусгасан болно.

3.

Нөгөөтэйгүүр Засгийн газраас эрх хэмжээнийхээ асуудлыг шийдвэрлэх үед Улсын Их Хурал, Ерөнхийлөгч болон Улсын дээд шүүх хөндлөнгөөс оролцох, шахалт үзүүлэх, дотоод хэрэгт нь хутгалдах зэргээр төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хязгаарлах явдал гаргуулахгүй байж, бие даасан бүрэн эрхийг нь аль болохоор хүчтэй байлгахаар төсөлд тусгаж байна. Төсөлд Ерөнхийлөгч Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдийн халдашгүй байдлыг хуулиар хамгаалахаар заасан нь тэдгээрийн бүрэн эрхийн нэг чухал баталгаа болж байгаа юм аа. Харин энэ асуудлыг өмнөх төсөлд нэгбүрчлэн нарийвчилсан заасныг хөдөлмөрчдийн саналын дагуу хассан юм.

Их цаазын төслийн нэг шинэ санаа бол улсын яам, төрийн бусад албан газар, төрийн жинхэнэ албан хаагчдын эрх зүйн байдлыг хуулиар тогтоох үндэслэлийг заасан явдал байгаа юм. Энэ нь төрийн ашгарт тогтвортой ажиллахад ямар нэг байдлаар уршиг тарих явдлыг хааж, төрийн алба, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хууль зүйн баталгаатай болгож байна. Мөн төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд тэд ард түмэн, эх орныхоо тусын тулд иргэний ёсоор хууль дээдлэх зарчмыг чанд баримтлан төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллах ёстой болж байна. Үүний зэрэгцээ манай зэвсэгт хүчин, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн байгууллагын ажилтан зэрэг төрийн зарим албан хаагч намын гишүүн байхыг хуулиар хязгаарлаж болохоор төсөлд тусгалаа. Энэ нь төрийн байгууллагад аль нэг үзэл суртал, номлол хэт ноёрхох буюу эсвэл олон үзэл суртал, номлолын мөргөлдөөн буй болгох, улмаар төрийн байгууллагын ажилд хор уршиг тарьж магадгүй гэсэн болгоомжлолтой шууд холбоотой юм аа.

Дөрөв. Шүүх эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэх асуудал

Их цаазын төслийг боловсруулахдаа төрийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох шүүх засгийг жинхэнэ утгаар нь тогтоох, түүнийг хөндлөнгийн аливаа нөлөөнд автахгүй, хараат бус, гагцхүү хуульд захирагдах биеэ даасан тогтолцоо байх үзэл

баримтлалыг иш үндэс болголоо. Хууль тогтоох болон гүйцэтгэх дээд байгууллага, түүнчлэн Ерөнхийлөгчийн гаргасан хууль, зарлиг, шийдвэр Их цаазад нийцэж буй эсэхийг хянах тийм механизм бий болгож эрх хэмжээ, чиг үүргийг хуульчлан тогтоох явдал үзэл баримтлалын шинжтэй байгаа. Ийм байгууллага бол төсөлд зааснаар Их цаазын Цэц юм аа. Төслийг ард нийтээр хэлэлцэхэд ч Улсын Бага Хурлын чуулганаар хэлэлцэхэд ч Их цаазын Цэц буюу Үндсэн хуулийн шүүх аль эрх мэдэлд багтах, чиг үүрэг нь хаана хамааралтай байх вэ гэдэг асуудал нэлээн маргаантай байсан. Зарим нөхөд энэ байгууллагын чиг үүргийг одоогийн Улсын дээд шүүхэд өгөх нь зүйтэй гэж үзээд, түүнийгээс орон тоо хэмнэнэ, шүүх эрх мэдэл буюу, засгийн нэг байгууллагаас хэрэгжүүлнэ гэсэн үндсэн дээр тайлбарлаж байсан. Харин Улсын Бага Хурал олонхийн саналаар Их цаазын Цэцийг Монгол Улсын шүүхийн тогтолцоонд гэхдээ биеэ даасан анги бүтэцтэй байлгах аар шийдвэрлэсэн нь зохистой шийдвэр гэж үзэж байна. Учир нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурор зэрэг төрийн дээд байгууллага, албан тушаалтан Их цаазыг зөрчиж байгаа эсэхэд хяналт тавих онцгой эрх мэдэл бүхий хөндлөнгийн байгууллагыг эрүү, иргэн, захиргааны болон бусад хууль зөрчсөн хэрэг маргаан шийдвэрлэдэг буюу хянадаг одоогийн Дээд шүүхийн бүрэлдэхүүнд оруулах нь асуудлын мөн чанарыг үл харгалзсан хэрэг болно гэж үзэж байна.

Ийнхүү Монгол Улсад Их цаазын биелэлтэд дээд хяналт тавих түүнийг заалтыг зөрчсөн тухай маргааныг магадлан шийдвэрлэх, үнэн хэрэгтээ биеэ даасан шүүхийг бий болгох нь эрх зүйт төр төлөвшин тогтох, Засгийн эрх мэдлийг зөв хуваарилах, харилцан тэнцлийг нь хангах, Их цаазад заасан хүний үндсэн эрх чөлөөг хамгаалахад нэн чухал ач холбогдолтой юм аа. Их цаазын Цэцийн эрх, үүргийг төсөлд тодорхой заасан байна. Харин Их цаазын Цэц хэмээх нэр оносон эсэх, Цэцийн шүүхийг зөвхөн Улсын Их Хурал томилохоор заасан нь хэр оновчтой эсэх талаар бодож ярилцах зүйл бий. Төсөл ёсоор шүүхийн үндсэн тогтолцоонд Их цаазын Цэц Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, хошуу, хорооны шүүхээс бүрдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвхөн хуульд нийцүүлэн

шүүхийг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болох юм. Тэгэхдээ ямар ч нөхцөлд хуулиас гадуур, тухайлбал онцгой шүүх байгуулах, шүүн таслах ажиллагааг шүүхээс өөр ямар ч байгууллага, албан тушаалтан эрхлэн хэрэгжүүлэхгүй байхаар төсөлд тусгалаа. Ингэснээр хүний эрхийг хууль бусаар хөндөж янз бүрийн байлдалар хэлмэгдэл бий болгож дураараа аашлах явдлыг хаах боломж бүрдэх юм аа. Шүүх, шүүгчийн хараат бус байдлын баталгаа болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр гагцхүү хуульчдын дундаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зорилгоор шүүхийн зохион байгуулалт, боловсон хүчин, санхүү, хөрөнгийн асуудлыг шийдэхэд нөлөөлөх эрх бүхий шүүхийн ерөнхий зөвлөл нэртэй орон тооны бус байгууллага байгуулж ажиллуулахаар төсөлд заалаа. Энэ төсөл ёсоор зөвхөн хуульд захирагдах, хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх, шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулах, хэргийг нь ил таслан шийдвэрлэх зарчмыг тогтоож, шүүхээс үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг хуульчлан заасны гадна цаашдаа бүх шатны шүүх, Их цаазад нийцээгүй буюу нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй болгож байна.

Шүүгчийн хараат бус байх зарчмын хууль зүйн баталгаа болгож Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцохыг шууд хориглосон заалт шинээр нэмж оруулсан.

Их цаазын төсөлд Прокурорын байгууллагын чиг үүргийг томъёолохдоо зах зээлийн эдийн засагтай орнуудын хууль хамгаалах байгууллагын, түүний дотор прокурорын байгууллагын жишгийг судалж үзлээ. Цаашдаа прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж шүүх хуралд төрийн нэрийн өмнөөс оролцох юм. Энэ нь прокурорын байгууллагын үүргийг сулруулахад биш харин жинхэнэ байр сууринд нь тавихад чиглэгдсэн гэж үзэж байна. Шүүхийг төрийн эрх мэдлийн бие даасан субъект болгож хэнээс ч хараат биш байлгах, шүүх эрх мэд-

лийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглох, шүүгчийг хугацаагүй буюу байнгын чанартай томилох нийгмийн баталгааг өргөжүүлэх зэрэг иж бүрэн асуудлыг шинээр тусгасан нь төр ёсыг бэхжүүлэх чиглэлээр хийсэн бас нэг алхам юм аа.

Зургаа. Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын бүтцийн талаархи зарим асуудал

Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, түүний нэгж нутгийн захиргааны тогтолцоог зөв тодорхойлох явдал Үндсэн хууль, төрийн байгууламжийн язгуур асуудлын нэг юм. Улсын Бага Хурал Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах комисс Монголын түүх, төр ёсны уламжлал, улсын эдийн засаг, газарзүй, хүн ам, үндэстний байршил, экологи зэрэг онцлогийг тал бүрээс нь харгалзан үзэж зохих байгууллагуудаас гаргасан судалгаа, санал дүгнэлтийг үндэслэн нутгийн захиргааны удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааных нь үндсэн чиглэлд зарчмын өөрчлөлт оруулахаар Их цаазад тусгалаа.

Тус улсад олон зуун жил төлөвшин тогтож, өөрчлөгдөн шинэчлэгдэж ирсэн манай улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэвшсэн хуваарийг 1930-аад оноос өөрчилжээ. Үндсэндээ 1940-өөд онд бүрэлдэж одоо хүртэл мөрдөж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь нь байгаль, эдийн засгийн дотоод нөөцийн хувьд хязгаарлагдмал, аж ахуйн уялдаа холбоо сул, аж ахуйн нэгжийг дагуулж байгуулсан засаг захиргааны олон жижиг нэгжтэй болсон учир бүх асуудлыг үндсэнд нь төвөөс шийдвэрлэдэг, орон нутгийн бие даасан байдлыг хангах эдийн засаг, нутаг дэвсгэрийн оновчтой, харилцан уялдаа холбоотой цогцолборуудыг бүрэлдүүлэн хөгжүүлэх боломжгүй байгаа юм аа.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

З.Баяндүүрэн

Д.БАЯНДҮҮРЭН

БИЧЭЭЧ Л.ХОРЛОО

Энэ байдал нь хүн ам зүйн бодлогод ч сөрөг нөлөө үзүүлэх болсон юм. Иймд тус улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламж, нэгжийн удирдлагыг боловсронгуй болгож шинэчлэх шаардлага зүй ёсоор гарч ирлээ. Энэ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрийг аль болох үр ашигтай, цогцолбор байхаар бодолцож тэдгээрийн нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин, чадавхийг дээшлүүлэх, байгаль орчныг зүй зохистой ашиглах, хамгаалах, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, үйлдвэрлэх хүчний байршлын оновчтой биш байгааг анхаарч орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлэн тогтоох нийгмийн болоод эдийн засгийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн олон талын хэлхээ холбоог өргөжүүлэх зэрэг асуудлыг улс орны өвөрмөц онцлогт зохицуулан шийдвэрлэхтэй холбоотой байна.

Сүүлийн 30-аад жил үйлдвэрлэх хүчний байршилд томоохон өөрчлөлт гарч, аж үйлдвэрийн олон төв шинээр бий болсны дээр нэлээд аймгийн төвүүд харьцангуй илүү хурдацтайгаар хөгжсөн байна.

Үйлдвэрлэл, эдийн засгийн хийгээд, нийгэм, соёлын талаар илүү үүрэгтэй тэдгээр төв сүлжээнд татагдсан бүс нутгийн хүрээ цаашид тэлж, хэд хэдэн аймаг сумын нутгийг хамарсан нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн томоохон цогцолборууд бүрэлдэн хөгжих хандлага нэгэнт эхэлжээ. Гэвч энэ үйл явц тухайн газар нутгийн болон хүн амын байдал, эдийн засгийн хүч нөөцөөс шууд хамаарч тодорхой хэмжээ зохистой хязгаарын дотор явагдах ёстой бөгөөд үүнийг зөвөөр зохицуулж чадваас эдийн засаг, нийгмийн үр ашиг нь илүү байхын дээр үйлдвэрлэх хүчний хэт бөөгнөрөл бий болгох экологи, байгаль орчны тэнцвэр алдагдах зэрэг гажуудал гарахгүй байх боломжтой юм. Ийм шаардлага алдагдсанаас болж эдүгээ манай улсын хүн амын 34 хувь нь аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 75 хувь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад хэт төвлөрсөн нь тэдгээрт оршин суугаа хүн амын орон сууц, хүнсний болон нийгэм ахуйн хэрэгцээг хангахад хүндрэл учруулж, амьжиргааны ертгийг зохимлоор өндөржүүлж байна. Нөгөөтэйгүүр засаг захиргааны нэгжийг ихэвчлэн төв суурин, аж ахуйн нэгжид түшиглүүлэн байгуулах хандлага ихэссэнээс нутаг дэвсгэрийн одоо-

2.

гийн хуваарь нь байгаль санхүүгийн нөөц багатай бөгөөд аж ахуйн бүтэц чиглэлээрээ үндсэндээ нэг төрлийн өөр хоорондоо үйлдвэрлэл, эдийн засгийн нарийн уялдаа холбоогүй нутаг дэвсгэрийн олон жижиг нэгжийг үүсгэж өмч хөрөнгийг цацан тарамдуулах, удирдлагын давхардмал чирэгдэл бий болгох зэрэг гажуудлыг үүсгэжээ.

Үүнээс шалтгаалан одоогийн хуваарь нь тус улсад орон нутгийн биеэ даасан оновчтой цогцолборыг бүрэлдүүлэн хөгжүүлэх явдлыг саатуулагч хүчин зүйл болж байна. Үүний дээр захиран тушаах аргын үед хүн амаас нутаг сэлгэх, чөлөөтэй нүүдэллэн суурьшихыг хязгаарласнаас зарим бүс нутагт нутагшлын болон уламжлалт хэв маяг, бэлчээрийн даац алдагдаж хүн, мал нутаг бэлчээрийн гурамдсан шүтэлцээ өөрчлөгдөхөд хүрснийг анхаарахгүй байж боломжгүй юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн олон жижиг нэгжид орон нутгийн тодорхой нөхцөлд аж ахуй хөгжүүлэх зорилт чиглэлээс хамаарал багатай үндсэндээ адил тооны ихээхэн зардал шаардсан удирдлагын байгууллагууд ажилладаг. Эдгээр нь манай орны удирдлагын нийт зардлын 65 хувь, удирдлагын хүрээнд ажиллагсдын 60 хувийг эзэлж байгаа боловч орон нутгийн аж ахуйн биеэ даасан цогцолбор хөгжлийг хангах зорилтыг хэрэгжүүлэхэд тун хангалтгүй үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Өнгөрсөн хугацаанд ийнхүү бүрэлдэн тогтсон одоогийн тогтолцооны доголдоос шалтгаалж нэгдүгээрт төрийн удирдлагын дээрээс удирдах арга барил зонхилсон, материал санхүүгийн бааз муу чадвар багатай боловсон хүчинтэй аппарат бий болгосноор төр захиргаа, аж ахуйн ажил ихээхэн хутгалдаж бүс нутгийн нийгэм эдийн засаг, экологийн талаар биеэ даасан цогцолбороор хөгжүүлэх төрийн нэг ч үүрэг хэрэгжээгүй орхигдсон байна. Хоёрдугаарт аймаг, ялангуяа сум бүр аж ахуйн олон асуудлыг нийслэл хотруу зэрэгцэн хөөцөлдөж удирдлагын дээд шатны янз бүрийн шийдвэрийг сумдад хүргэхэд удирдлагын зардал чирэгдлийг үлэмж ихэсгэхэд хүргэж байна. Гуравдугаарт аж ахуйн нэгжийг шинээр байгуулсан үед засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг бий болгож, ингэснээр нутаг дэвсгэрийн хуваарьт өөрчлөлт оруулж ирсэн явдал орон нутгийн төрийн байгууллагуудын бүтэц, хэлбэр нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарьт үндэслэн тогтоогддог зарчмыг ноцтой алдагдуулсан зэрэг сөрөг үр дага-

вар байна гэж үзэж байна.

Улс орон зах зээлийн харилцаанд шилжиж, өмчийн олон хэлбэр үүсэх эхлэл тавигдаж ардын аж ахуй, ардын хувийн аж ахуйтны уламжлалт хэлбэр сэргэн, аж ахуй тархан байрлах болж байгаа нь урьдын багийн хэлбэрийг зүй ёсоор шаардах боллоо. Гэхдээ төсөлд тусгаснаар одоогийн баг бол 1950-иад оны үеийнхээс ялгаатай, өөрийнхөө нутаг дэвсгэрт өөрөө удирдах болон төрийн удирдлагыг хослуулж хэрэгжүүлэх үүрэг бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж мөн. Энэ нь засаг захиргааны үндсэн нэгжийг хүн амд ойртуулах, завсрын нэгжийг томруулж чадавхжуулах чиг хандлагатай ч холбоотой болох болов уу гэж бодож байна.

Хөгжлийн нийгмийн чиглэлийг хүчтэй болгох, эдийн засгийг зах зээлийн харилцаанд тууштай шилжүүлэх, байгаль орчны тэнцлийг хангах эдгээр чиглэл нь төрийн зохицуулалтыг оновчтой болгох зэрэг нийгмийн шинэтгэлийн гол асуудлыг улс орон, засаг захиргааны нэгжийн хүрээнд хэрэгжүүлэх үүднээс улс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүтэц, харьцааг дараахь хоёр гол хандлагаар шинэчлэн хөгжүүлэх хэрэгтэй болж байна. Үүнд:

1. Улс орныхоо түвшинд манай газар зүйн байрлалын онцлог, өргөн уудам нутгийн байгаль, цаг уурын ялгаа, зах зээлийн харилцаанд татагдан орох чиг, хандлага, нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах арга зам, газар нутгийг зүй зохистой эзэмших чиглэл, нүүдлийн аж ахуй, соёл иргэншлийн түүхэн ололтыг суурин хөгжлийн дэвшилтэт хандлагатай оновчтой хослон сэргээх;

2. Нутаг дэвсгэрийн түвшинд янз бүрийн газар нутгийн байгаль цаг уурын өвөрмөц нөхцөл, нөөц баялгийг байгаль, хөдөлмөр, мал аж ахуй, түүхийн эдийн гэх мэт иж бүрэн ашиглах, орон нутгийн хэрэгцээг хангах, жижиг, дунд үйлдвэрийг түлхүү хурдацтай хөгжүүлэх боломж, чиглэл, үндэстэн, угсаатны соёл урлаг, түүх, аж ахуй эрхлэх онцлог, хүн амын нутагшин амьдрах тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ, зах зээлд татагдан орох гол гол төвүүдийн байршил зэрэг хүчин зүйлийг тооцсон бүс нутгийн аж ахуйн

биеэ даасан цогцолборуудын цоо шинэ тогтолцоог үүсгэх явдал мөн гэж үзэж байна.

Энэ үндсэн дээр одоогийн томоохон сумдыг дангаараа буюу хэд хэдэн сумдыг нэгтгэн хошуу байгуулах, аймгуудыг томсгох маягаар ойрын ирээдүйд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарьт шилжих зорилтыг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна. Бид энэ чиглэлийг хуульчлан бататгах ёстой юмаа. Үүний учир Их цаазын төсөлд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ гэж тусгасан. Энэ нь зарчмын хувьд шинэ зүйл төдийгүй төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай удирдлагын тогтолцооны үеийн арга барилаас тууштай татгалзаж байгааг харуулсан юм. Орон нутгийн өөрөө удирдах ёс гэдэг бол хүн ам, нутаг дэвсгэрийн хөгжил, дотоод амьдралын асуудлыг өөрсдөө шууд болон төлөөлөх байгууллагаараа уламжлан шийдвэрлэж хэрэгжүүлэх ардчилсан ёсыг хэлж байна. Үүний хамт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид төрийн удирдлагын харьцангуй бие даасан байдлыг хангахтай вохих тэмцэлтэйгээр хослуулахыг ч багтаасан ойлголт, нэг үгээр хэлбэл төр, олон түмний удирдлагыг хослуулах үйл ажиллагаа гэж үзэж байна.

Гэхдээ бус нутгийн үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин доогуур, төрийн удирдлагыг орон нутгийн хүн ам, үйлдвэрлэлд ойртуулж оновчтой болгох шаардлага улам ч нэмэгдэж байгаа нөхцөлд эл асуудлыг амьсгаагаар шийдвэрлэх гэж яаравчлах шаардлагагүй байж болох юм. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх ажлыг барагцаалбал 1995 оноос цаашхи хугацаанд хийж гүйцэтгэхээр төвлөж байна.

Аймаг, нийслэл, хушуу хорооны өөрөө удирдах байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний тэргүүлэгчид байхаар төсөлд тусгалаа. Эдгээр хурал буюу нутгийн өөрөө удирдах байгууллага одоогийн Ардын Депутатуудын Хурлын тогтолцооноос зарчмын үндсэн ялгаатай.

Энэ нь зөвхөн төрийн төлөөлөгчөөс бүрддэг депутатын хурал биш ер нь нэр сольж байгаа хэрэг биш, харин агуулга, зарчмын хувьд өөрчилж одоогийн хурлыг төрийн эрх барих байгууллагатай байгаагаас нь иргэний буюу нутаг дэвсгэрийн хүн амын өөрсдийнх нь байгууллага болгоход оршиж байна. Эдгээр хурал тухайн нутаг дэвсгэрийнхээ асуудлыг шууд өөрсдөө шийдэх, төр, улсын чанартай асуудал шийдэхэд оролцох үндсэн дээр ажиллана. Баг, хорин хувьд өөрөө удирдах хэлбэр нь иргэдийн нийтийн хурал байх, ингэхлээр баг, хоринхоо амьдралын асуудлыг эргэж өөрсдөө хэлэлцэн шийдвэрлэх боломжтой болох юм.

Сум, хороо, аймаг, нийслэлийн төлөөлөгчдийн хурал хуулинд заасан тодорхой хугацаагаар сонгосон төлөөлөгчдөөс бүрдэх тэрхүү бүрэлдэхүүн нь нэг удаагийн буюу эсвэл харьцангуй тогтвортой байх эсэхийг орон нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулиар шийдэхээр бодолцсоныг анхаарч хэлэлцэх бизээ.

Их цаазын төсөлд зааснаар төрийн удирдлагыг тухайн шатны нэгж бүрт дороос дэвшүүлж, дээрээс томилсон засаг дарга хэрэгжүүлэх юм. Тэдгээрийг зохих шатны төлөөлөгчдийн хурлаас нэрийг нь дэвшүүлж дээд шатны гүйцэтгэх байгууллагын эрх баригч гурван жилийн хугацаагаар томилох юм. Засаг дарга нь харьяа нэгжтэй тухайн нутаг дэвсгэрт төрийг төлөөлж, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг буюу, төрийн хууль, засгийн тогтоол шийдвэрийг бие даан хэрэгжүүлж байхаар төсөлд тусгасан юм. Энэ бүхнийг бид өөрөө удирдах ёс, төрийн удирдлагыг хослуулах гэсэн томъёоллоор зангидаж нэгэн бүхэл зүйл болгон тусгасныг та бүхний оюунд толилуулж байна.

Эрхэм депутатууд аа.

Монгол улсын Их цаазын төслийн сүүлийн бүлэгт Их цаазад оруулах нэмэлт өөрчлөлтийг Улсын Их Хурлаар хэлэлцэн Чуулганд оролцсон нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батлах буюу Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард түмний санал асуулга явуулах замаар шийдвэрлэж байхаар тусгаж байна.

Тийнхүү нэмэлт еерчлэлт оруулах санаачилгыг хууль санаачлагч эрх бүхий байгууллага, албан тушаалтан саналыг Улсын Их цаазын цэц гаргаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байх юм.

Улсын Их цааз уян хатан байх уу, тогтвортой хатуу чанд байх уу гэдгээс нь үндэслэж Монгол улсын Их цаазад оруулах нэмэлт еерчлэлтийг Улсын Их Хуралд хоёр удаа авч хэлэлцэхэд Чуулганд оролцсон нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналыг авч эс чадвал

Соронзон хальстай
тулгаж нийлсэн

Бичээч



ЭНХТУЯА

В.ОЖУН

П.Очирбат --Бид Их цаазаа баталснаар төр, улсын маань чиг зорилго тодорхой, хандах чиг зам тогтвортой байх, хүн ардад маргаашдаа итгэх итгэл бадрах үндсийг тавих боломжтой болно. Их цаазын баталж хэрэглэхэд завсрын тодорхой хугацааг хамарсан нийгмийн нэлээд ээдрээтэй олон харилцааг Их цаазын хүрээнд зохицуулах ийм шаардлага гарна. Их цаазын төслийг Ардын Их Хурлаар баталсны дараагаар төрийн дээд төв, орон нутгийн байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны залгамжлал хийгээд хүний эрхийн баталгааг бодитой хангах, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарьт өөрчлөлт орох, эсэх зэрэг шилжилтийн чанартай зарчмын гол гол асуудлаар Их цаазын хавсралт хууль гаргахаар төлөвлөсөн, энэхүү хуулийн төслийг Улсын Бага Хурлаас Ардын Их Хуралд өнөө, маргаашгүй өргөн барих болно.

Их цаазын төслийг боловсруулахад оролцсон нийт байгууллага, хүмүүст гүн талархлаа илэрхийлж байна. Ардын Их Хурлын түүхэн их хариуцлагатай, нэн онцлог бүхий хуралдааны ажиллагаанд амжилт хүсье.

Эх орныхоо хөгжил, дэвшлийн төлөө хичээнгүйлэн зүтгэцгээе. Та бүхэнд баярлалаа.

Ж.Уртнасан -За одоо БНМАУ-ын Ардын Их Хурлын хуралдааны II хурлын дэгийн 10 дугаар зүйлийн дагуу Монгол улсын Их цааз, Үндсэн хуулийн төслийг эцэслэн боловсруулах депутатын ажлын комиссыг байгуулах санал оруулж байна.Энэн дээр депутатын ажлын хэсгийг хэдэн хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгох вэ гэсэн ийм зүйл байгаа юм.Манай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгээс 15 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулъя гэсэн ийм саналыг оруулж байна.Энэ бүрэлдэхүүний 15 гэсэн тоон дээр санал хураалт явуулах уу? За санал хураалтанд бэлтгэнэ үү? Баримт бичгийн төслийг эцэслэн боловсруулах. За санал хураалтанд бэлтгэнэ үү.Депутатуудын ажлын хэсгийг 15 хүний бүрэлдэхүүнтэй сонгоё гэсэн санал оруулж байна.

Үндсэн хуулийн төслийг эцэслэн боловсруулах депутатуудын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгоё гэсэн санал оруулж байна. Депутатуудын ажлын хэсэг, дэгэн дээр ажлын хэсэг байгуулъя гэж байгаа шүү дээ.

С.Чулуунбаатар / 132-р тойргийн депутат / -Уучлаарай, Их Хурлын даргаа, нэг юм тодруулж асууж болох уу? Өглөө эцэслэн баталсан дэг бидний гар дээр байхгүй байгаа болох учраас нэрийг нь андуурч байж болзошгүй юм л даа бид нар. Би бодохдоо Их Хурлын нэгдүгээр хэлэлцүүлгийн дараа хоёрдугаар хэлэлцүүлгэнд бэлтгэх депутатуудын хороо гарах юм гэж ойлгож байсан. Таны одоо батлуулах гэж байгаа энэ ажлын хэсэг чинь тэр хороо мөн үү? Аль эсвэл энэ өөр ямар нэгэн ажлын хэсэг гарч байна уу? Хэрэв өөр болбол ямар үүрэгтэй ажлын хэсэг вэ гэдгийг бидэнд хэлж өгвөл тодорхой ойлголт авахад хэрэгтэй байна. Санал өгөхөд бэлэн байна.

Ж.Уртнасан -Депутат Баяр тайлбар өгнө үү?

С.Баяр /I дүгээр тойргийн депутат/ -Депутатууд аа, энэ дэгээ бол бид өнөөдөр баталчихсан, хараахан хэвлүүлж амжаагүй байгаа, та нөхдийн гар дээр ирнэ. Зүгээр гар дээр чинь байгаа засвартай хувилбарыг харах юм бол 10 дугаар зүйл, энэн дээр Ардын Их Хурлын депутатын ажлын хэсэг гэж нэг байгаа, ард талд нь депутатуудын хороо гэж бий, түүний ажлын хэсэг гэж бас бий. Депутатуудын хорооны ажлын хэсэг гэдэг маань аппаратын улсуудыг хэлж байгаа юм л даа. Ажлын хэсэг гэдэг маань дэг дээр биднийг томилсон. Тэр маань ажлын хэсэг байсан. Зөвхөн депутатууд орж байсан. Тэгэхээр хоёр зүйл байгаа юм л даа. Ардын Их Хурлын даргын саян санал болж байгаа нь бол депутатуудын ажлын хэсэг. Харин тэгэхээр ажлын хэсэг ч байгуулж болно, хороо ч байгуулж болно шүү дээ. Энэ бол депутатуудын ярьж байгаад л шийдэх асуудал.

Хороо байгуулж болно. Тэгэхдээ дэгэн дотроо бид бас депутатын ажлын хэсэг байгуулж болох гэдгийгээ бас санах хэрэг-

тэй юм л даа.

Ч.Цэрэндагва /257 дугаар тойргийн депутат/ -Тэгэхээр саяын саналыг ойлгохдоо би түрүүний Ардын Их Хурлын дэгийг эцэслэн боловсруулсан ажлын хэсэг^{ШИГ ТИЙМ ХЭСЭГ} байгуулах санал оруулж байна гэж ойлголоо.Саяын тодруулгаас ч ингэж харагдаж байна.Тэгэхээр Их цаазын төслийг хэлэлцэх явцад бол ийм ажлын хэсэг, депутатын ажлын хэсэг хэрэггүй гэж үзэж байна.Одоо энийг байгуулахад хороогоо байгуулж өгөх хэрэгтэй.Хороод бол ажлынхаа хэсгийг байгуулж эхлэх хэрэгтэй.Эхнээс нь эхэлж энэ хороод хороодын ажлын хэсэг бүлэг бүлгээрээ одоо еерийнхөө асуудлыг гартаа авч цэгцэлж оролцож ингэхгүй бол нэг ажлын хэсэг эхнээс нь ажиллачихаад сүүлд нь төгсгөлд нь дахин нэг хороо байгуулаад, тэрний ажлын хэсэг энэ Их цаазын төсөл дээр хоёрдугаар хэлэлцүүлэгт оруулахаар ажиллана гэвэл энэ бол бүтэхгүй асуудал гэж үзэж байна.Тийм учраас эхнээс нь явахын тулд тэр таван бүлэг дээрээ хороогоо байгуулаад, хороодууд ажлынхаа хэсгийг байгуулаад ингээд ажиллаж эхэлбэл зүйтэй болов уу гэсэн саналыг оруулж байна.

Ш.Цэндбаяр /280 дугаар тойргийн депутат/ -Саяын миний өмнө уг хэлсэн депутатын саналыг дэмжиж байна.Энд бол ажлын хэсэг, депутатын ажлын хэсэг гэж бол байхгүй болов уу гэж бодож байна.Депутатын хороо байх ёстой байх.Энэ депутатын хороо бол Үндсэн хуулийн гол гол бүлгүүдээр байгуулагдах байх.Миний ойлгож байгаагаар бол дөрвөн юм уу таван хороо байгуулагдах болов уу.Энэ депутатууд еерсдийн саналаар бүрэн оролцох бололцоотойгоор энэ хороонд орох байх гэж бодож байна.Энэ хороодын дэргэд бол ажлын хэсэг байх байх.Тэр ажлын хэсэгт нь бид түрүүн дэг ярилцах үеэр ойлгосноор тэр ажлын хэсэгт нь Улсын Бага Хурлын гишүүд, Үндсэн хуулийг эцэслэн боловсруулах комиссын гишүүдээс оролцуулж болно гэж ингэж ойлгож байна.

Д.Мүндээжанцан /15 дугаар тойргийн депутат/ -Би энэ ажлын хэсэг байгуулах нь зөв юм шиг санагдах юм.Тэр таван хороо гэдэг юм уу, дөрвөн хороо гэдэг юм уу, хороо байгуулагдаад тус

тусдаа явна. Эдгээрийг нэгтгэж зангидаж холбож байх нэг тийм ажлыг хэсэг, ерөнхий ажлын хэсэг байх юм болов уу гэж бодож байна. Өөрөөр хэлбэл таван бүлэг байгаа, за таван бүлгээр таван хороо байгуулж болох юм. Тэгтэл зургаан бүлэг гэж ойлгомоор юм шиг байх юм. Тэр шилжилтийн хууль буюу, хавсралт хууль бол өөрөөр хэлбэл манай энэ Их цаазын зургадугаар бүлэг. Үргэлжлэл бүлэг гэж ойлгож байгаа. Ийм учраас энэ сүүлийн хоёр бүлгийг тэр шилжилттэй нийлүүлээд нэг хороо, таван хороо, эдгээрийг дунд нь уялдуулж холбож өгч байдаг, ингэхгүй бол хороо хороогоороо тус тусдаа яваад өгөхөөр чинь таван тийшээгээ л салчихсан юм болчихож магадгүй шүү дээ. Энийг уялдуулж, зохицуулж өгдөг, тэрийг редакцийг нь хийж ингэж байх нэг ерөнхий ажлын хэсэг байхад буруу юмгүй юм болов уу гэж бодож байна.

Ж. Уртнасан - Депутатуудад өөр санал байна уу?

И. Гүлхүү /139 дүгээр тойргийн депутат/ - Энэ бүлэг гэдгийг чинь бол түрүүн дэгд ярихдаа бид Их цаазын төслийн таван бүлэг дээр таван хороо байгуулаад тэдгээр хороо маань өөрсдөө ажлын хэсгээ байгуулаад ингэж ажиллана гэж ингэж ойлгосон юм байгаа юм. Тэгэхээр сая энэ хоёр депутатын хэлж байгаагаар бол мөн зургаа дахь бүлэг байсан ч бас болохгүй юм үгүй юм шиг. Тэгэхээр энэ зургаан хороогоо байгуулах асуудлаа шийдээд, тэр зургаан ажлын хороо, тэдгээрийн ажлын хэсгийн саналыг нэгтгэх, харин бүр тийм нэгдмэл том хороо ч гэдэг юм уу, хэсэг ч гэдэг юм уу ийм юмыг байгуулахаар болоод байна уу даа. Ингэж ойлговол энэ асуудлыгаа сайн ойлголцож байж тоогоо тогтож, хүмүүсээ нэрсээ гаргаж, саналаа нийлүүлж байж байгуулмаар юм шиг байна.

Ерөнхийдөө саяын бид гурвын хэлж байгаа юмнууд утгын хувьд нэлээн ойролцоо болох шиг боллоо. Зүгээр дэгд ярьснаас арай жаахан өөрөөр сая манай хурлын дарга эхлүүлчих шиг болох юм.

Ч. Хурц /287 дугаар тойргийн депутат/ - Тэгэхээр энэ Их цаазын төслийг хэлэлцэхэд нэг л хороо, депутатуудын хороо байх

гэж бодож байна. Дотроо өөрөө ажлын таван хэсэгтэй байх юм уу, зургаан хэсэгтэй байх юм уу, энийгээ хороо өөрөө санаачилгаа гаргана биз. Тийм учраас одоо энэ хороо бол бүгдийг нь зангидсан, ажлынхаа хэсгийн улсуудыг томилсон, саналаа оруулаад дараагийн ээлжит хурал дээр ажлын хэсэгтэй, энэ бүлэгтэй ийм ийм улсыг авъя гэсэн ийм саналаа хороо оруулж ирнэ биз. Тийм учраас одоо энэ Их цаазын төслийг бүхэлд нь сүүлчийг нь найруулан, бид бол өөрсдөө ямар нэгэн шинэ санаагаар найруулан бичиж санаа оруулж ирэхгүй, зөвхөн Ардын Их Хурлын депутатуудын хэлсэн үгийг найруулан засаж, оруулж хэлэлцүүлэх хоороогоо байгуулъя. Хороо өөрөө дотроо ажлынхаа хэсгийн саналыг гаргаж ирье. Тэрийг нь дараагийн хурал дээр ярья гэсэн ийм саналтай байна.

Ж. Уртнасан - Ажлын хэсэг байгуулахыг уу? Эхлээд хороо байгуулъя гэдгээ шууд санал хураалтаар шийдье гэж бодож байна уу?

Л. Цог /13-р тойргийн депутат/ - Тэгэхээр энд ойлголтын зөрүү байх шиг байна. Би бодохдоо бид нар дэгийг хэлэлцэхдээ Баяр даргатай нэг комисс байгуулсан, хэсэг тиймээ. Яг иймэрхүү шинжтэй, 15 хүний бүрэлдэхүүнтэй нэг хороо гэж нэрлэе гэж. Дотроо бүлэг бүлгээ даасан хэсэгтэй байна уу үгүй юу өөрсдөө мэдэг гэж ингэж ойлгоод байна. Энэ зөв үү үгүй юу?

Д. Пүрэв /261 дүгээр тойргийн депутат/ - Тэгэхээр одоо бид дэгээрээ явах ёстой. Тэгэхээр дэгэнд зааснаар, 10-ын нэгд зааснаар бид депутатуудын хороо байгуулах ёстой. Хэрэв энэ хороо байвал. Тэгвэл энэ бүлэг дус бүр дээр хороо байгуулах бол одоо энүүгээр байгуулах ёстой гэж үзэж байна. Ажлын хэсэг байгуулах ёсгүй. II дүгээр зүйлийн дөрвийн "з"-д зааснаар бол Их цаазын төслийг эцэслэн хэлэлцсэний дараа редакци хийх хоороо, ажлын хэсгийг байгуулна гэж энэ дэгэнд заасан шүү дээ. Бид энэ дэгээрээ явах учиртай гэж ингэж бодож байна. Ийм учраас ажлын хэсэг биш, Их цаазын төслийн бүлэг тус бүр дээр ажиллах таван хороо байгуулах ёстой гэж, дэгээрээ бол ингэж байгуулах ёстой. Депутатын хороод байгуулна гэж байгаа. Энэ олон

тоон дээр хэрэглэсэн шүү дээ. Депутатын хороо биш, хороо байгуулна гэж хэлээгүй, депутатуудын хороод байгуулна гэж дэгэнд орсон. Тийм учраас бид одоо дэгээр явахаас биш дэг гажих эрх байхгүй гэж бодож байна.

Соронзон хальстай тулгаж
НИЙЛСЭН

Д. Алтанцэцэг

Д. АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

297 дугаар тойргийн депутат Тангад:

Даргаа бид одоо хурлаа дэгийнхээ дагуу явуулбал яасан юм бэ? Энэ чинь анхны хэлэлцүүлэг эхэлж байна шүү дээ. Энэ дэг дээр чинь бид баталсан шүү дээ. Эхлээд 4-ийн "а" дээр илтгэлээ сонсчихсон. Одоо дараад нь асуулт, хариултаа явуулаад, ерөнхий санал шүүмжлэлээ явуулаад, яг дэгийнхээ дагуу, дэгийн "в"-д нь заачихсан байж байгаа шүү дээ. Тэгээд дараа нь шаардлага гарахаар л хороогоо байгуулна биз. Одоо юу ч үгүй хороо байгуулна гэж яриад яах юм бэ? Бид анхны хэлэлцүүлэг дөнгөж эхэлж байна шүү дээ. Дэгийнхээ дагуу л явъя л даа. Одоо их цаазын төслийн тухай харин дүгнэлтээ хэн гаргах юм байгаа юм бэ? Дүгнэлтийг сонсмоор байна. Бид илтгэлийг нь сонсчихлоо. Дэгийнхээ дагуу л явъя. Асуулт, хариултаа явуулъя л даа, одоо.

Ж.Уртнасан: Уучлаарай, депутатууд аа? Асуулт, хариултыг эхлээд бичиж тэмдэглэж эхлэх, энд манай хуулийн зөвлөхүүд ийм асуудал оруулсан юм. Би дахин тайлбар хэлье. Энэ бол хуучин байсан дэгийн дагуу ажлын хороо гээд биччихсэн юм. Ажлын хэсэг гээд биччихсэн байна л даа. Тэгэхээр манай зөвлөхүүдийн санал болгож байгаа, та бидэнд санал болгож байгаа юм бол энэ хороо нэгдсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй ийм хороо байгуулъя. Энэ хороо дараа нь өөрсдөө ажлын хэсгээ байгуулаад, бүлэг тус бүрээ шүүгээ, энэ бол одоо бидний дэгд орсны дагуу депутатуудын ажлын хороо 15 хүний бүрэлдэхүүнтэй байж болох юм шиг байна. Энэ хорооны бүрэлдэхүүнд, манай нам, эвсэл холбоодын бүлгээс хуулийн байгууллагаас орсон 15 хүний нэрийг санал болгож бидэнд ирүүлсэн байна. Үүнийг та бүхэнд толилуулбал ямар вэ?

15 хүний бүрэлдэхүүнтэй депутатуудын хороо байгуулъя гэдэг дээр санал тогтвол ямар байна вэ? Дэгд байгаа шүү дээ.

52 дугаар тойргийн депутат Э.Бат-Уул: Би нэг зүйлийг хуулийн зөвлөхөөс лавлаж асуух гэсэн юм.

Энэ хороо, ажлын хэсэг байгуулж байгаа чинь энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулалтын хэлбэрт оруулж байгаа хэрэг шүү дээ, тиймээ? Тэгэхээр анх ерөнхий хэлэлцүүлэг явна гэсэн. Ерөнхий хэлэлцүүлэг дээр мэдээж ажлын хэсэг гараад ерөнхий хэлэлцүүлэг дээр хэлэлцсэн асуудал санал, бүх юмыг тэмдэглэж авна, тийм биз дээ? Тэгээд бид нар дараа нь депутатууд хороод болж хуваагдах уу? бүгдээрээ. Тэгэхгүй бол одоо нэг хэсэг нь ингээд хороод болоод ажилд орчихлоо, нөгөө хэсэг нь юу хийж суух вэ?

Ж.Уртнасан: Ажлын хэсгүүдэд бид өөрсдийнхөө саналыг өгөх байх л даа. Одоо өөрөөр хэлбэл хороо байгуулаад

Э.Бат-Үүл: Өөрөөр хэлбэл нэг депутат чинь нэг юм уу, 2,3 хороонд ажиллаж болох нь шиг байна шүү дээ.

Ж.Уртнасан: Болно, болно.

Э.Бат-Үүл: Тэгээд тэр хороодоор хэлэлцсэний эцэст дахиад ерөнхий санал шүүмжлэлийг авсан ажлын хэсэг чинь эргэж нөгөөдүүлийг чинь нэгтгэж, тэгээд нийт депутатад асуудлыг оруулах нь байна шүү дээ. Тийм зохион байгуулалтын хэлбэр гэж ойлгож болох уу?

Ж.Уртнасан: Энэ хороо нь өөрөөр хэлбэл ажлын хэсгүүд байгуулаад, бүлэг тус бүрээр ажлын хэсэг ажиллаад, түүний нэгдсэн дүнг, өөрөөр хэлбэл бидний Баярын байгуулсан, дэг дээр Баярын байгуулсан ажлын хэсэг шиг энэ ажлын хороо та бидэнд эцсийн, энэ редакцийн хэсэг л гэсэн үг л дээ.

Э.Бат-Үүл: За, за.

Г дүгээр тойргийн депутат С.Баяр: Би нэг тайлбар өгөх үү? Дэгийнхээ дагуу нэгэнт баталсан дэгийнхээ дагуу явах нь зүйтэй л дээ. Би нэрийг нь санахгүй байна. Нэг депутат сануулсан.

Анхны хэлэлцүүлэг явуулах журам гэж байгаа. Ингээд эхлээд илтгэлээ танилцуулна. Их цаазын төслийн тухай илтгэл, дүгнэлтийг сонссоны дараа асуулт хариулт явуулна. Асуулт хариулт шууд товч тодорхой байвал зохино. Хариултыг Улсын Бага Хурал, түүний комисс өгнө. Ингээд асуулт хариултыг тасалсны дараа Их цаазын төслийн талаар Ардын Их Хурлын депутатууд ерөнхий санал солилцож, бүлэг, зүйл хэсэг тус бүр дээр гээд... нэлээн юм явж байгаа юм. Тэгээд хамгийн сүүлд нь энэ 12 дугаар зүйлийн 3-ын "з" юм л даа. Ардын Их Хурал Их цаазын төслийг зарчмын асуудлаар бүхэлд нь зөвшөөрсөн нөхцөлд зохих саналын дагуу уг төслийг найруулан засч, түүнийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий депутатуудын хороог ажлын хэсэгтэй байгуулж ажиллуулна. Тийм учраас одоо асуулт, хариулт явах нь зүйтэй. Зарчмын асуудлуудаа тодорхойлоод, түүний дагуу төслийг найруулан засч буй, дэгийнхээ дагуу л явъя гэх юм бол асуулт, хариулт яваад, сүүлд нь зарчмын асуулт гараад ирэх юм бол тэр хороогоо ажлын хэсэгтэй байгуулна гэсэн дэгээрээ явах нь зүйтэй юм болов уу?

163 дугаар тойргийн депутат Б. Мижид: Дэгийнхээ дагуу явбал ажлын хэсэг, Ардын Их Хурлын депутатынх ажлын хэсэг байгуулах болмж бий. 10 дугаар зүйл дээр Ардын Их Хурлын депутатын ажлын хэсэг гэсэн асуудал бий. Ардын Их Хурлын хуралдааны үед шаардлагатай, гэж гэсэн баримт бичгийг нягтлан боловсруулж, маргаантай зарим асуудлыг шуурхай шалган тогтоож, хуралдаанд оруулах эрх, үүрэг бүхий депутатын ажлын хэсгүүдийг байгуулж болох талаар заасан байгаа.

Энэ байна уу? депутатын хороо байна уу гэдгийг дарга сайн зөвлөж, санал оруулмаар байна.

Ж. Уртнасан: Тэгье, бид хуулийн зөвлөхүүдтэй зөвлөө. За баярлалаа, депутатууд аа. Тэгэхээр бид дэгээ баримтлая. Баяр депутатын гаргасан саналын дагуу бид одоо асуулт, хариултаа явуулах саналтай байна.

105 дугаар тойргийн депутат Б.Чойжилсүрэн:

Тэгэхээр одоо энэ хороо, ажлын хэсгийг байгуулах дэгийг зөрчиж байгаа юм бишээ. Одоо санал шүүмжлэл явуулахаар чинь, тэр чинь тэмдэглэж авсан хүнгүй, эзэнгүй үлдчихнээ. Ийм болохоор зэрэг, одоо хороо, ажлын хэсгээ байгуулна гэдэг чинь, энэ санал шүүмжлэл дээр юу гарав? юу асуув? Хууль дотор зайлшгүй тусгах ёстой юмнууд чинь одоо гарч ирэх гээд байна? Тэгэхээр энэ чинь сүүлдээ эзэнгүй, үлдчихээр чинь энэ бидний санал шүүмжлэл, асуулт хариулт чинь ямар ч хүчингүй болно. Тэгэхээр энэ дэгийг эвдэж байгаа юм биш, одоо ерөөсөө яг хороо, ажлын хэсэг хоёрыг байгуулах явдал зайлшгүй чухал болчихоод байна.

Харин үүнийг байгуулахдаа хорооны хувьд бол ер нь эндээс Их цааз юм уу Үндсэн хуулийн төсөлд зайлшгүй тусгах ёстой, депутатуудын санал, асуулт, хариултын дүнгээс тунгаасан энэ зүйл, эцсийн боловсруулалт юм уу, нэгдүгээр хэлэлцүүлэгт бүрэн тусч уу? үгүй юу гэдгийг нийт депутатуудад таниулах үүрэгтэй хороо байх болов уу гэж бодож байна.

Ажлын хэсгийн хувьд бол ер нь бүлэг тус бүр дээр нэг, нэг ажлын хэсэг гаргаад 5 ажлын хэсэг гаргах юм бол энэ арай хөнгөвчлөл үзүүлэх байх. Ажлын хэсгийн хувьд депутатуудыг энэ хуралд оролцох бололцоогоор хангахын тулд энд туслах үүрэгтэй, тэр Үндсэн хуулийг эцэслэн боловсруулах комисс, Бага Хурлын гишүүд энэ бүхнээс бүрдсэн байж болно. Депутат биш Бага Хурлын гишүүд. Ийм маягаар эцэст нь ухаандаа нийтээрээ оруулж ирсэн саналуудыг шүүж хэлэлцэх болохоор нэг хороо, 5 ажлын хэсгийг одоо байгуулах явдал чухал байна гэж бодож байна.

Ж.Уртнасан: Хамгийн гол нь бид асуулт, хариулт явуулж болно, бидний түрүүчийн хэлдэг санал... тэр л дээ. Одоо бид ингээд зарчмын гол асуудлуудаа асуугаад эхэлнэ, түүнд хариулна. Энэ бүгдийг хэн тэмдэглэж, хэн базаж, та бидэнд

141

сүүлд нь дүгнэлт хэлэх юм бэ гэдэг асуудал байгаа юм. Тийм учраас бид урьдчилан 15 хүний бүрэлдэхүүнтэй, ийм хороо байгуулъя гэсэн юм.

198 дугаар тойргийн депутат С. Батмөнх:

Товчилж хэлэхэд саяын Чойжилсүрэн депутатын хэлсэн болон таны дэмжиж байгаатай санал нэгтэй байна. Ингэхгүй бол асуудлаа сүүлд нь, асуултанд хариулж байгаа хүмүүсүүд тодорхой үндэслэл хэлнэ, түүнийг эзэнгүй орхино гэдгийг анхааралдаа авмаар байна.

Өөр нэг санал юм уу асууж, тодотгох, санал нэгдэх нэг зүйл байна. Хуучин 9 буку 10 дугаар зүйлд байгаа депутатын ажлын хэсэг гэдэг бол ерөнхий журманд байгаа болохоороо Их цаазын төслийг ч хамаарч байгаа байх. Гэхдээ ер нь маргаантай шаардлагатай бусад асуудлаар ингэж ойлгоод, харин Үндсэн хуулийнхаа төслийн тухайд бол тэр "з"-д байгаа хороонуудаа эхлээд байгуулчих ийм зарчмын ялгаатай хоёр юмыг дунд нь хольсноос болоод саяны асуудал гарлаа гэж бүгдээрээ ойлговол зөв бишүү гэсэн ийм санал хэлэх гэсэн юм.

Ж. Уртнасан: За баярлалаа.

55 дугаар тойргийн депутат П. Адъяасүрэн: Энд анх нь Их Хурлын энэ хуралдааны дэг боловсруулахдаа бид нар юу бодож энэ хороо, хэсгийг байгуулсан юм бэ? гэдгийг тайлбарлаж өгье гэж бодож байна.

Тэгэхээр дарга түрүүн хэлчихлээ л дээ. 15 хүнтэй ажлын хэсэг гээд. Уг нь бол энэ 15 хүнтэй ч юм уу, хэдэн ч хүнтэй ийм, үүнийг нэгтгэж дүгнэх хороо байх юм байгаа. Тэгэхээр сая Чойжилсүрэн депутатын, тэр нэг депутат хоёрын хэлдэг үндсэн санаа нь бол зөв юм байгаа. Тэгэхээр юуны түрүүнд энэ хороог байгуулж авахгүй бол болохгүй. Хэн хэн энэ хороонд орох вэ? үүнийг нэгтгэж дүгнэж хэлэх депутатуудын хороо хэрэгтэй шүү дээ. Үүнд орох хүмүүс нь одоо депутатуудын ерөнхий

санал шүүмжлэлийг ултай сайн сонсч, бодож байх хэрэгтэй юм байгаа. Түүнээс гадна тэр бүлгүүдээр 5 дэд хороо юм уу? бид нарын дэг дээр орсноор бол ажлын хэсэг байгуулагдана. Тэнд депутатууд бид нар одоо ингээд бөөнөөр хуралдахгүй гэж бодсон юм шүү дээ. Тэр ажлынхаа бүлэг, бүлэг дээрээ хэн дуртай депутат нь дуртай бүлэг дээрээ, хэдэн ч бүлэг дээр байхыг үгүйсгэхгүй. Орж ажиллаад, саналаа нэгтгээд, ажлын хэсэг, бүлгийнхээ ажлын хэсгээс оруулж ирнэ. Түүнийг саяны 15 хүн ч юм уу хэдэн хүнтэй хороо ерөнхийд нь нэгтгэж зангидаад Их Хурлынхаа энэ хуралдаанд оруулж ирэхээр ингэж бодож, үүнийг уг нь хийсэн юм байгаа юм л даа. Тэгэхээр даргын байгуулах гэдэг бол зөв. Үүнийг та нар дэмжиж өгөөд, бүгдээрээ энэ дээрээ хүний хээ тоог тогтоод, саналаа хураачихмаар байна.

314-р тойргийн депутат М.Гантөмөр:

Тэр хороог заавал 15 хүнтэй гээд ч байх юу байх вэ? 30 хүнтэй байя гэсэн санал оруулж байна. Өөр юм алга. 5 ажлын хэсэг байна шүү дээ. 5 ажлын хэсгийн чинь боловсруулсан материал, Их Хурлын депутатуудын өгсөн саналд тусгагдаж байна уу? үгүй юу? тэр хороо хянах ёстой. Энэ энээс нь үндэслээд үзэхэд 30 хүнтэй байхад илүүдээд, олдоод байх юм байхгүй. Дэг дээр 21-ээс дээш хүн гэж байгаа шүү дээ. Одоо энд 15 гэсэн тоо ороод ирлээ.

107 дугаар тойргийн депутат Л.Баяндалай:

Энэ дээр ийм санал байна. Хэн, 15-ыгаа, нийт хурлынхаа юунаас тасдаад, бусдын юм тэмдэглэж аваад сууж байдаг хүн болгох юм бэ? Өөрөө тэр хүн чинь саналаа хэлмээр байна, ажилдаа оролцооор байна шүү дээ. Тэртэй, тэргүй бид нэр, дугаараа хэлээд бичиж аваад байгаа гэсэн, бид нарын ярьж байгаа юмыг. Ажлын хэсэг ажиллаж байгаа гэсэн. Тэд нараас бид, тэр байгуулагдсан хороод сүүлд нь ч хамаагүй, бүрэн эхээр нь ч авсан болно, бүр боловсруулаад ямар ямар зарчмын ялгаатай саналууд гарсан бэ түүгээд аваад ир гэсэн ч чадна шүү дээ.

Ийм байдлаар эхлээд одоо ажилдаа орёе. Тэр хооронд санал шүүмжлэлээ явуулъя, тэр хооронд ямар хороо байгуулах, учир нацираа олъё. Учрыг нь олоогүй байж ингээд будилаад байна шүү дээ. Учрыг нь олчихоод, дараа нь уурыг нь олсны дараа хороогоо байгуулъяг нь.

23 дугаар тойргийн депутат Ц. Энхбат:

Тэгэхээр энд ажлын хэсэг, депутатын хороо гэдэг дээр бид нар ойлголцохгүй байна л даа. Миний ойлгож байгаагаар бол депутатын хороод бол энэ 427 депутат 5 хуваагдаад 5 хороо болно гэж ойлгоод байгаа юм. Энэ хүмүүсүүдийн дэвшүүлж байгаа саналыг би юу гэж ойлгож байна вэ гэхээр одоо тэр хуваарилалтаа хийгээд, хэн ямар хороонд орох юм бэ? Одоо жишээ нь 3 дугаар бүлэг дээр тийм, тийм депутатууд саналаараа ажиллахаар болж байна гэдгээ гаргах юм бол одоо явуулах санал шүүмжлэл дээр тэр хүмүүс яг 3 дугаар бүлэгтээ хамаарсан, тэр асуудлыг илүү сонирхож, илүү сайн тэмдэглэж авах болов уу гэж би ойлгоод байна.

Хэрвээ энэ үүднээс ярьж байх юм бол одоо депутатын хороог байгуулах нь зүйтэй байна, үнэхээр. Би хувьдаа гэхэд одоо 5 дугаар бүлэг дээр ч гэдэг юм уу? 3 дугаар бүлэг дээр ажиллаж гэж өөрийнхөө ажлын хуваарийг мэдэж аваад одоо энд хүмүүсээс асуулт хариулт яваад ирэхээр тэр бүлэг дээрээ би ажлаа тэмдэглээд авчихмаар байна.

Тэгэх юм бол энэ үр бүтээлтэй. Хий хоосон баахан хүний ярьж байгааг тэмдэглэсэн ч юмгүй, яасан ч юмгүй явж явж байгаад, намайг ү бүлэг дээр ажилла ч гэдэг юм уу? би өөрөө саналаараа очих юм бол дахиад л эхэлнэ шүү дээ. Дахиад л одоо ярьж байгаа хүмүүсээс асуудгаа асуугаад явна.

Ж. Уртнасан: Ерөнхийлөгчид ярих зөвшөөрөл олгоё.

П. Очирбат: Эрхэм депутатууд аа. Үндсэн хуулиа эцэслэж, найруулж, баталж гаргах эрх үүрэг хоёр, одоо Их Хуралд шилжсэн.

Тийм учраас үүнийг энэ ажлыг хийх, зохион байгуулалтыг Их Хурал өөрөө эхлээд хийж байх ёстой. Тэгэхээр хороо гэж нэрлэнэ үү, салбар хороод гэж нэрлэнэ үү, ямар ч атугай энэ 5,6 бүлгээрээ дагнасан хороодууд байх ёстой байх, зөвхөн Ардын Их Хурлын депутатуудаас бүрэлдсэн. Бид та бүхэн түрүүн тэгж дэгэндээ оруулчих шиг болно билээ. Энэ болгоныг нийлүүлж зангидах нэгэн төв байх учиртай. Түүнийг ямар хороо, нэгдсэн хороо гэнэ үү, тэр хороогоо байгуулж авах ёстой. Тэгэхээр энэ болгоныг одоо байгуулж аваад, тэгээд хэлэлцүүлгийнхээ явцад гарсан үнэтэй, цэнэтэй санал бодлоо үнэхээр дор дороо сууж байхдаа, би чинь ийм үүрэгтэй гэж ингэж их анхаарч бичиж, тэмцэглэж аваад, хожим өнөө бүлгүүд дээрээ тодорхой суугаад ажиллахдаа тэр болгоныгоо тусгаж, өнөө депутатуудынхаа хэлсэн юманд эргүүлж, түүнийг чинь ингээд аваагүй, түүнийг чинь ингээд авсан гэдгээ хэлэх болно.


Тийм учраас энэ зохион байгуулалтаа өөртөө эхлээд хийж авах талаар тавьж байгаа саналзөв байхаа. Ардын Их Хурлын 427 депутатыг 6 хуваагаад, энэ хийчихнэ гэвэл энэ бүтдэггүй юм билээ. Би сая тэр 110 хэдэн ажлын мэргэжлийн хүмүүстэй ингээд ажиллаад үзсэн. Бэрх юм байна билээ. Тэр их томоор ажиллах. Тийм учраас та бүхэн бол тийм тодорхой хэсгүүд байгуулж авах асуудал зайлшгүй хэрэгтэй.

Үндсэн хуулийн төслийг болговсруулах ажлыг зохион байгуулсан комиссын хүмүүс, тэр ажлын хэсэгт хүчин зүтгэхэд бэлэн байгаа. Улсын Бага Хурлын гишүүд, алинд нь ч орох эрхтэй байгаа, депутатуудынхаа хувьд, хороодууд чинь тэр ажлын хэсэгт ор ч гэдэг юм уу, хаана яаж хуваарилна вэ? яаж сонгож томилно вэ? тэр ёсоор л ингээд бид ажлын хэсэг гэдэг бол тэр хар бор ажлынх нь түүнд нь бид зүтгэцгээе. Та бүхэн бол хамгийн сүүлд бөөгнүүлж, гаргаж ирж, Их Хуралдаа батлуулах үүрэг, Их Хуралд шилжсэн гэж би ойлгож байгаа. Тэгээд би бас нэг юм хэлье. Энэ удаагийн Ардын Их Хурлын II хуралдаан 3 сая 570 гаруй мянган төгрөгний төсөвтэй, 21 хоног хуралдахаар байгаа.

Нэг минутын үнэ 118 төгрөг. Энэ нэг минутын үнийг та бүхэн бас дотроо бодоод, тэгээд еерийнхөө хэдэн минут зарж байгаага дор, дор нь, би Их Хурлын депутатуудад тооцоо хөтөл гэж хэлээгүй байна. Дор бүрнээ би ер нь хэдэн минут ярив? Юу ярив? түүнийгээ 118-аар үржүүлээд байхаар депутат бүрийн үнэ, энэ хуралд оролцсон өртөг гарна шүү.

Ж.Уртнасан: Баярлалаа. Одоо хуралдааны дэгийн дагуу завсарлага 20 минут.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Д.ЧУЛУУНШЭЦЭГ

1991.11.13.
Кассет № 12
17.25-17.40.

Ж.Уртнасан -Хуралдаанаа үргэлжлүүлье. Завсарлагааны дараа бас оройн цагаар зарим суудал онгойгоод байдаг дутагдал хэвээр байх шиг байна. Түрүүнд ирц будилсан, мөн техник будлисан болов уу гэж бодож байна. Одоо ирцээ бүртгээд үзье. Ирц авахад бэлтгэнэ үү. Ирцийг бүртгэж байна, санал хураалтандаа бэлтгэнэ үү.

Ирвэл зохих 427 депутатаас 93 хувь нь буюу 398 депутат байна гэж мэдээлж байна. Одоо хуралдаанаа үргэлжлүүлье. Тэхээр эрхэм депутатууд аа! бид нэг зүйл дээр тохирмоор байна. Бид ажлын хэсэг үү, депутатуудын ажлын хороо байх юм уу гэдэг дээр бид сая нэлээд будлилаа. Бид сая хуулийн зөвлөхүүдтэй ярилаа. Тэхээр ийм тохиролцоонд хүрмээр байна. Депутатуудын ажлын хороог бид дэгдээ 15-21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна гэсэн хороогоо эхлээд байгуулвал ямар вэ гэсэн санал байна. Тэгээд энэ хороо нь дотроо дэд хороо гэж хэлнэ үү, ажлын групп гэж нэрлэнэ үү Бага Хурлынхнаас, хууль боловсруулсан мэргэжлийн хүмүүсээс Ерөнхийлөгчийн хэлдгээр хүчтатаад ажиллаг, тэгж таван бүлэг дээр ажиллана уу, зургаан бүлэг дээр ажиллана уу, хичнээн хүн байна, тэд зохион байгуулаад ажиллаг, ингэж дээд талд нь зангидаж, редакц хийх тийм цөөнх хүчтэй бүрэлдэхүүнтэй байхгүй бол гэнэт хорь, гуч, зуун хүнтэй депутатууд салаад, сүүлд нь түүнийг нэгтгэж, бидэнд оруулж ирнэ гэдэг нь их төвөгтэй болох нээ. Тийм учраас зарчмын тохиролцоонд хүрмээр байна. 15-20 гэдэг дээр бид тоогоо тогтоё. Дараа нь бид депутатуудын хороо байгуулчихъя. Энэ хороо маань намын бүлэг, ажлын бүлэг, мэргэжлийн группүүдтэй ярьж байгаад, дотроо дэд хороо буюу бүлэг, бүлэг тус бүрээр ажиллах ажлын группээ томилог оо. Хэрэв ингэвэл та бидний ажил шуурхай болмоор байна. Мөн бид асуулт, хариулт руугаа ороод явчихаж болмоор байна. Санал сонсьё.

Г.Очирбат/12-р тойргийн депутат/ -Дэгийн 10-т ажлын хэсэг гэж байгаа. Энэ нь өөр зорилготой юм. Үндсэн хуулийн

төсөлтэй ямар ч холбоо байхгүй. Энэ дотор томъёолсноор Ардын Их Хурал хуралдааны үед шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг нягтлан боловсруулахад, тэхээр энэ нь хурлын явцад гарч ирэх ямар нэгэн баримт бичгийг боловсруулах ажлын хэсэг байх юм байна. Тэр нь 21 хүний бүрэлдэхүүнтэй гэж бичсэн байгаа юм. Бидний одоогийн шийдэхгээд байгаа юм энэ нь хороо. Шинэ Үндсэн хуулийн төсөл дээр ажиллах хороо юм. Энэ нь дэгийн сүүлийн хоёрдугаар бүлэгт заасан байгаа юм. Энэ талаар түрүүнд нөхдүүд тайлбарлаж ярьсан. Тэхээр надад ийм санал байна. Хороо нь ганц хороо байх юм уу, эсвэл бүлэг, бүлгээр хороо байх уу. 5 бүлгийн бүгд нь ажиллах нэг хороо нь ажиллахад бэрхшээлтэй болох болов уу? Тийм учраас 5 бүлэг дээр цөөхөн хүнтэй, 16-15 орчим хүнтэй хороо байгуулаад, хороо бүр 3 хүнтэй ажлын групп байгуулаад, ингэж ажиллахад Үндсэн хуулийн бүлэг хоорондоо салаад явна гэж байхгүй байх гэж бодож байна. Тэр хороо нь Их Хуралд бүлэг, бүлэг дээрээ ажлын хэсэгтэй хамтраад, бүлэг, бүлэг дээрээ оруулчихсан засвараа илтгээд байвал яасан юм бэ.

Д.Манлах/32-р тойргийн депутат/ -Тайлбар тодотголгүй шууд саналаа хэлбэ. Гэхдээ үүн дээр тэд, эд гэж яриад, тоо хэлэлцүүлээд, дараа нь хүн хэлэлцүүлэмгүй байна. Дэгийн зарчмын тоо байгаа учраас түүнийгээ баримтлаад, Их цаазын төсөл боловсруулсан комисс, Бага Хурлын гишүүд, нөхдүүдээс зөвлөмж аваад, Их Хурлын орлогч дарга гараад, зөвлөөд бидэнтэйгээ, хэдэн хүн баймаар юм, хэн орох, ямар хүн байх гэж зарчмыг нь бодолцоод, санал оруулж хэлэлцүүлсэн нь тэрийг, энэнийг оруулъя гэж бидний будлиснаас дээр болов уу гэж бодож байна.

Нэгдүгээрт хорооны бүрэлдэхүүн бол санал боловсруулах бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийн, хороо, депутатуудаас Их цаазын комисс, Бага Хурлаас холбогдох хүмүүс оролцсон, мөн депутатуудаас оролцсон ийм нэг хороо байх нь зүйтэй юм. Дараа нь ажлын хэсгүүд 5 зүйл, бүлгээр нь аппаратын хүмүүс байх ийм санал боловсруулж оруулж ирээд, ингэж бодож байна.

гэсэн зүйл дээр хэлэлцвэл цаг бага орох болов уу гэсэн бодолтой байна. Дараа нь хэлэлцэх технологгоо бодсон ч гэсэн түүнд эхлээд дэг дээр ярьж байсан, асуулт, хариултаа явуулчихаад, зарчмын санал зөрүүтэй байгаа асуудал дээрээ тохирч авах талаасаа хэдэлцүүлгээ цааш нь явуулах саналтай байна.

Ж. Уртнасан - Депутатууд аа! зарчмын тожиролцоонд хүрлээ гэж үзэх үү, саналаа тасламаар байна. Депутат Очирбат гуай хэлэлцэх журмын дагуу ярьж байгаа юм. Бидний 21 гишүүнтэй депутатын бүрэлдэхүүнтэй сонгож болно гэдэг нь ажлын хэсэг байгуулах 10-р зүйлтэй уялдаж байгаа юм. Тэхээр дэгийн энэ хоёр зүйлийн аль нэгээр бол нэг нь таван хороо байгуулж болохоор болчихож байгаа юм. Эсвэл бид редакцийн комиссын шинжтэй нэг хороо байгуулаад, тэр нь ажлын группэд ажиллана гэдэг дээр хуулийн зөвлөхүүд бидэнд нэлээд зөвлөж байгаа юм. Энэ чиглэлээр ч бэлтгэсэн хүмүүсийн нэр байгаа юм. Санал хураалт явуулах уу?

Бид нарт хоёр хувилбар байгаа юм. Дэгийн 10-р зүйлийн дагуу 15-21 хүний бүрэлдэхүүнтэй депутатуудын ганц хороо байгуулж болохоор байгаа юм. Депутат Очирбат гуайн санал болгож байгаагаар бүлэг тус бүрээр депутатын хороо байгуулах мөн хоёрдахь хувилбар байгаа юм. Тийм учраас эхлээд дэгийн 10-р зүйлийн дагуу нэг хороо байгуулна гэсэн санал хураалт явуулаад үзье.

Депутатуудын нэг хороо байгуулъя гэдэг дээр санал хураалт явуулж байна.

Зөвшөөрсөн 357 депутат байна. 82 хувь гэж гарах ёстой юм. Тоогоор бол 334 депутат зөвшөөрч, 57 хүн татгалзаж, 13 хүн түүдгэлзсэн байна.

Бид тэгвэл цааш нь явж болж байна. Энэ хороо дэгийн дагуу 15-21 хүний бүрэлдэхүүнтэй байж болно. Тэхээр хүний тоон дээрээ тогтмоор байна. Үүн дээр ямар санал байна вэ депутатууд аа!

Депутатуудын хороо 21 хүний бүрэлдэхүүнтэй байна гэдэгдээр санал хураалт явуулъя. Санал хураалтандаа бэлтгэнэ үү!

21 хүний бүрэлдэхүүнтэй хороо байгуулъя гэдгийг 372 депутат зөвшөөрч, 28 хүн татгалзаж, 18 хүн түдгэлзсэн байна. 21 хүний бүрэлдэхүүнтэй хороо байгуулъя гэдэг дээр тогтлоо. Одоо хуулийн зөвлөх, ажлын группын нөхдөөс 21 депутатын нэр ирүүлсэн юм. Энэ депутатуудын нэрийг та бүхэнд уншиж сонсоё гэж байна. Үүнд голдуу хуулийн мэргэжлийн хуульчид, ажил мэргэжлийн хуваариар оролцох нь зүйтэй гэсэн хүмүүсийн нэр байгаа юм. Энэ хүмүүсийн нэрийг сонсоод, дараа нь санал хураалтаа явуулъя.

Ж.Авхиа - 141-р тойргийн депутат, хуульч, Ц.Адъяасүрэн - 55-р тойргийн депутат, С.Гончиг - 330-р тойргийн депутат, К.Зардыхан - 4-р тойргийн депутат, С.Зориг - 9-р тойргийн депутат, Б.Лигдэн - 405-р тойргийн депутат, Л.Түдэв - 136-р тойргийн депутат, Д.Лүндээжанцан - 15-р тойргийн депутат, О.Очиржав - 187-р тойргийн депутат, Н.Пүрэвдорж - 41-р тойргийн депутат, Р.Хатанбаатар 24-р тойргийн депутат, М.Энхсайхан - 45-р тойргийн депутат, Б.Энхтуяа 388-р тойргийн депутат, Л.Дашням - 22-р тойргийн депутат, Д.Лхамсүрэн - 173-р тойргийн депутат, Ж.Бямба - 11-р тойргийн депутат, Г.Нороврагчаа - 289-р тойргийн депутат, Ц.Энхбат - 23-р тойргийн депутат, К.Сайран - 85-р тойргийн депутат, Л.Пүрэвдорж - 27-р тойргийн депутат ийм 21 хүний нэрийг манай хуулийн зөвлөхүүд урьдчилан та бидний анхааралд сонордуулж байна. Үүн дээр ямар саналтай байна вэ? Уучлаарай, бид нэг хүний нэрийг мартсан байна. Б.Чимид - 396-р тойргийн депутат.

Ц.Хурц /287-р тойргийн депутат/ -Саналаа хэлбэ. Сая уншсан депутатуудын нэрсийн жагсаалтыг сонслоо. Үүнд манай хуульчдын нэлээд хэмжээ нь орсонд би баярлаж байна. Гэхдээ энд байгаа бүх хуульчид ороогүй байх гэж бодож байна. Бага Хурлын гишүүд орох нь зөв байх. Тэхдээ нэлээд их хэмжээгээр Бага Хурлын гишүүд орчихжээ. Бидний ойлгож байгаагаар Бага

Хурал өөрийн боловсруулсан хуулиа боловсруулаад өгчихсөн. Одоо бид энэ хууль дээр хөдөлмөрчдийн санал, хүсэлтийг авсан жинхэнэ ард түмний төлөөлөгчид үгээ хэлэх бололцоо олгох үүднээс, Бага Хурлын гишүүдээ цөөлөөд, орон нутгийн бүлгүүдтэй яриад, орон нутгийн бүлгүүдээс нэмэлт нэр авч, маргааш өглөө батлавал яасан юм бэ? Яагаад гэвэл бид нэг үгээр хэлбэл Бага Хурлын боловсруулсан, урдаад боловсруулчихсан төслийг энэ депутатууд чинь эмзэглээд байна шүү дээ. Тулгах гээд байна гэж байна шүү дээ. Тэр байдлаас гарая ч гэж бодсон, би орон нутгийн депутатуудыг хүндлэх үндсэн дээр энэ нөхдүүдээ үлдээж, оролцуулж өгөөч ээ. Мөн урьдынхтай адилхан нэг хэсэг нэр бичихээд, дараа нь та бүхэн батлах нь зүйтэй, гар өргөх үү, саналаа дарах уу гээд дарчих юм. Миний ойлгож байгаагаар орон нутгийн депутатууд дотор хуульч хүн бий, Мөн аймаг, орон нутаг, төрийн захиргааг авч явдаг хүмүүс ч бий. Төрийн захиргааны тогтолцоо ямар байх ёстой вэ гэдгээ мэддэг хүн ч бий. Тийм учраас энэ хүмүүсээ басамжлахгүй байвал ямар вэ? Тиймээс би Бага Хурлын гишүүдийг эрс цөөлж, орон нутгийн төлөөлөгчдөөс хүмүүсүүдийг гаргаж, нэмж оруулж өгөөч ээ, ажлын хэсэгтээ бид Бага Хурлын гишүүдээс оролцуулъя. Зөвлөлгөө авах зүйл дээрээ зөвлөлгөө авъя, Бага Хурлын гишүүдийг цөөлж өгөөч гэсэн хүсэлт байна.

Б.Мижид /163-р тойргийн депутат/ -Энэ бүрэлдэхүүнийг би заримыг нь танина, заримыг нь танихгүй юм. Нутаг, дэвсгэрийн бүлгийн бүрэлдэхүүн ямар байгааг мэдэхгүй байна. Ямар утга, агуулгатайгаар ийм бүрэлдэхүүн оруулж байгааг лавлаж асуумаар байна. Үүний цаана өөрөөр хэлбэл ямар ажил, мэргэжлийн бүрэлдэхүүнийг хэн оруулж ирж байгааг сайн ойлгох хэрэгтэй байна. Үүнийг тайлбарлаж өгөхийг хүсэж байна.

Ж.Уртнасан -Депутатуудын бүрэлдэхүүнийг үү!

Б.Мижид -Саяны 21 хүний бүрэлдэхүүнийг хаанаас, хэн гэдэг хүн боловсруулж оруулж ирсэн, хэн нь ямар мэргэж-

лийн, ямар нутаг дэвсгэрийн бүлэг, аль намын хүмүүс байгааг мэдмээр байна. Мөн мэргэжлийг нь ч мэдмээр байна. Магадгүй хийж байгаа ажлыг нь ч мэдмээр байна.

Ж.Уртнасан - Үүнд тайлбар хэлье.

Б.Нямдорж /281-р тойргийн депутат/ - Дэгийнхээ дагуу явмаар байна. Тэхээр хороо нь тодорхой асуудлыг хэлэлцэх дээр хороо байгаа шүү дээ. Тийм учраас үүнийг би ойлгохдоо ажлын хэсэг гэж нэрлэмээр байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хороо нь сүүлд өөрийн сайн дураар байдаг ч юмуу, жич том бүлэг дээрээ хороо байгуулагдах байх. Үүнийг бид ажлын хэсэг гэж үзэж байгаа болохоор энд ямар ч хүн ороход болохгүй юм байхгүй, дараа нь үүнийгээ батлахдаа үүнийг хэлэлцээд, бидний санал тусаж уу, үгүй юу гэдэг дээр батлах учраас, үүнийг би ажлын хэсэг гэж нэрлэмээр байна. Үндсэн зарчмын 10-р зүйлд байгаа ажлын хэсэг гэж байна. Энд ажлын хэсэг, хороо гээд хоёрхон зүйл заачихсан байгаа шүү дээ. Бид тодорхой асуудлаа хэлэлцэх үедээ эргэж жаахан буруу юм орчихож. Үүний "з"-д ингэж байгаа шүү дээ, түрүүнд Баяр депутат ярьж байсан.

Ардын Их Хурлын Их цаазын төслийг зарчмын асуудлаар бүхэлд нь зөвшөөрсөн нөхцөлд хороо байгуулна гээд орчихсон байгаа юм. Энэ нь болохгүй болчихсон юм шиг байна. Ямар ч байсан хороо байх нь зүйтэй. Энэ нь ажлын хэсэг, хороог жичлэн байгуулагдана гэсэн санал байна.

Соронзон хальстай
тулган нийлсэн

Ш.Баярмаа

/Ц.БАЯРМАА/

БИЧЭЭЧ

/С.ТУУЛ/

-Энэ 2I хүний нэрийг манай хуулийн зөвлөхүүд бэлтгэж ирүүлсэн байгаа юм. Хуулийн ажлын групп манай ХЗЯ-ны сайд Амарсанаа хуульч Төмөр зарим улсууд ажилладгийг мэднэ. Манай хуулийн зөвлөхүүд ямар ямар мэргэжлийн ямар оны улсууд байгаа вэ гэдэг талаар тайлбар өгөх гэж бодож байна. Төмөр тайлбар өгөх үү.

5-р микрофон , 2II-р тойргийн депутат Дагвадорж:
 -Бр нь одоо бид нар аппаратын бэлтгэсэн төслөөр ажилладаг энэ аргаасаа ер нь салмаар байна. Депутатууд өөрсдөө нэрээ дэвшүүлж байна, одоо сонгогчдынхоо нэрээ сонгох ийм л санал байна.

С.Төмөр:- Энэ хүмүүсийн нэрийг гаргахдаа хэд хэдэн зүйлийг харгалзаж үзсэн. Зохих зарим намын удирдлагатай АИХ-ын удирдах бүрэлдэхүүнтэй тохиролцож ярилцсан. Энэ дээр I-рт хуульчид байх болов уу, 2-рт орон нутгаас ганц нэг хүн байвал яасан юм, ж нь: Төв аймгийн гүйцэтгэх захиргааны дарга Гончиг гуайг оруулсан, 3-рт зохих мэргэжлийн асуудлыг бас харж үзсэн. Ж нь: Эдийн засагчид байх, хуульчид байх гэсэн үүнээс гадна ажлын хэсэгт зохих нэг баримтлах асуудал болов уу гэж бодсон. Энэ нь уг бүрэлдэхүүн жишээлбэл Бага Хурлын гишүүд нь нэлээн орсон байна гээд байгаа. Уг төслийг бүлэг, бүлгээр нь анхнаасаа авч явсан, энэ ажилд нэлээд хутгалдаж зохих зүг чигтэй болсон ч гэдэг юм уу, тийм байдлаар орсон гэж л хэлэх байна.

7 дугаар тойргийн депутат Ц.Балдорж: -Хурлын даргаас ингэж хүсмээр байна. Энэ санал хураалт явуулмаар байна. Тэгэхгүй бол одоо бид нар ингээд малын эмч байхгүй, зоотехник байхгүй, Архангайгаас хүн ороогүй, Сүхбаатараас хүн ороогүй гээд ингээд байгаад байвал энэ өнөөдөр оройжингоо юм болно. I-рт, 2-рт бие биеэ жаахан хардлагаа болимоор байна. Энэ улсууд чинь болбол шийдвэр гаргах улсууд биш шүү дээ. Бид нар энд санал хураалт явуулаад тэрний төлөө тэчнээн хүн санал өглөө гээд ингэсэн юмыг

л цэгцлэх ёстой улсууд болохоос биш одоо эд нар ингээд юм хий-
чих гээд байгаа юм шиг ингээд бие биеэ хардаад ингээд суугаад
байвал энэ чинь бид ер нь юу болох юм бэ? тийм учраас бушуу-
хан шиг санал хураалт явуулаачээ гэдэг ийм санал байна.

231-р тойргийн депутат Г. Амарбуян: -Депутатын хороог хааш-
даа одоо байгуулаад 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулья гээд
баталчихлаа. Тэгэхээр энэ дээр одоо яриад байх юм алга байна.
Харин орж байгаа хүний тухайд бол бид нар нутаг дэвсгэрээрээ
ярьж байж өнөө орой саналаа боловсруулаад маргааш өглөө хүнээ
батлая. Эд нар энд орж байгаа улсуудыг ихэнх төлөв бүгдээрэнгий
нь таних юм алга. Ер нь бараг нь Улаанбаатар хотын улсууд байна.
Хөдөөнөөс Архангай, Говь-Алтай эд нараас Адъяасүрэн, Түдэв гуай
нар тэр нэрээр орж байгаа байх. УБ-ын улсууд л байх юм. Тэгэхээр
нутаг дэвсгэрийн бүлгээрээ ярилцаад маргааш өглөө батлая.
Өнөөдөр шууд асуулт, хариултандаа орвол яасан юм бэ гэсэн сана-
лыг оруулж байна.

390-р тойргийн депутат У. Аварзэд: -Орж байгаа хүмүүсийн
бүрэлдүүнийг жаахан учиртай авч үзмээр санагдаж байна. Ж нь:
УБХ-ын орлогч дарга тэгээд ер нь дарга нар УБХ-ын хорооны
дарга нараас эхлээд орчихлээр Бага Хурал л эхэлж хуралдана
гэсэн санаа. Энэ хүмүүс ерөөсөө энэ байдлаасаа хэрхэвч гарч
чадахаа өнгөрсөн. Тэгэхээр харин Бага Хуралын доторхи жирийн
сул хуульчид байна л даа. Энэ Жанцангаас эхлээд л, эднийг оруу-
лаад аймгийн дарга, сумын дарга, улсууд их байна даа. Аймгийн
дарга нараас бол их оруулмаар санагдаж байна. Нэлээн гол чухал
зүйлүүд. Ер нь хуулийн мэргэжилтэй хүмүүс ч бий. Энэ комисс
хорооны хүмүүс шийдвэрлэдэггүй юмаа гэхэд ямар нэгэн байдлаар
даралт үзүүлнэ, ятгана, ухуулна, бодлогоо шингээнэ, ер нь
ийм л байдалтай байна. Нэлээн учиртай ярьж байгуулахгүй бол
хороо биш болно. Бага Хурлын жороо л тэр чигээрээ буцаж гарч
ирэх гэж байна, энийг хуулийн зөвлөхүүд санал өгч байгаа гэдэг
нь аргагүй, ийм л санал өгөх ёстой байсан байх.

165-р тойргийн депутат Ч. Гомбосүрэн: -Депутатуудын ярьж
байгаа санал бол Тэр бие биэндээ хардсан сэрдсэн ийм юм байхгүй.

Малын эмч, хүний эмч оруулах гэсэн асуудал байхгүй. Депутатууд бас цөмөөрөө ойлгож байгаа байх, депутат нөхөр Хурцын тавьсан асуудал бол яриа байхгүй харгалзаж үзэх санал. Энэ манай баримт бичиг боловсруулж байгаа ялангуяа хуулийн төсөл боловсруулж байгаа манай гол удирдлагууд маань болж өгвөл амьдралаас холхон байх юмсан гэдгийг хичээгээд байгаа ийм хандалга, эхнээсээ авахуулаад одоо хүртэл байгаа шүү. Тэгэхлээр амьдрал чинь нэлээн юмы нь шийднэ шүү. Тэрнээс бид ерөөсөө цэвэр онолоор явахгүй, цэвэр хийсвэр сэтгэлгээгээр явахгүй хэрвээ хийсвэр сэтгэлгээгээр явбал усанд живж унана, ийм тавилантай. Ийм учраас энэ хийсвэр сэтгэлгээ гэдгийг жаахан 2 тийш нь татаж чангааж шаардлагатай. Ийм учраас ийм бүрэлдэхүүнд аймгийн АХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нараас оруулах хэрэгтэй. Энд сууж байгаа сумын гүйцэтгэх захиргааны дарга нараас оруулах хэрэгтэй, депутат дарга нараас, ийм зүйлийг дэмжиж байгаа зүйлийг хэлбэ. 2 дахь нэг зүйл хурлын даргад нэг жаахан гомдол мэдүүлмээр байна. Хуулийн зөвлөхийг зөвлөх гэж АИХ-ын хуралдаанд ажиллаж байгаа гэж анхнаас нь эхэлж мэдэгдсэн. Энэ хуулийн зөвлөх хэн гэдэг ямар албан тушаалын улсууд яаж одоо их хурлын хуралдаанд зөвлөж байгаа юм ба тэр хүмүүсийг нүүр үзэж хийдэг ажлыг нь сонсож, танилцаж, сэтгэл санаагаа хуваалцаж, санал онолоо ярьж, ингэж нэг одоо ойр дотно ажиллая гэж хүссэн. Гэтэл хуулийн зөвлөх гэдэг өнөөдрийг хүртэл хэн байгаа нь мэдэгдэхгүй нууцлагдаад ч байгаа юм шиг, нүүгээд байгаа ч юм шиг ингээд ер нь мэдэгдэхгүй байна. Шаардлагатай бол депутатуудаас АИХ-ын хуралдаанд хуулийн зөвлөх оруулах хуульчин депутат манай депутатуудын дотор байж байгаа. Энийг нэг хариулж өгөөч ээ. Хуралдаан эхлэхэд хүссэн, одоо хүртэл хариу өгөхгүй байна. Ийм зүйлийг хэлэх гэсэн юм.

67-р тойргийн депутат Пүрэвдорж: - Бид энэ комисст орохоос татгалзаж байна. Тийм учраас миний оронд Сүхбаатар, өөр тэр Архангай мангайгаас хүн оруулахыг хүсч байна.

280-р тойргийн депутат Ш.Цэндбаяр: - Би хурлын даргад нэг хүсэлт байна. Энэ депутатуудын тавьж байгаа саналыг одоо эргэж тэр санал хураалгахдаа их зөвөөр томъёолж, тэгээд санал хураалгаж баймаар байна. Тэгэхгүйгээс болоод байн байн давтагдаж,

нэг санал дахин дахин гарах ийм зүйл гарч ирчихээд байна. Ингээд би энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж, тодорхой санал хэлье. Түргүүн Ерөнхийлөгч энэ талаар тодорхой санал хэлсэн. Депутатууд бүр тодорхой санал хэлсэн шүү дээ. Тэгэхлээр энэ саяын 21 хүн энэ бол ажлын хэсэг байх аа. Энэ одоо энэ төслийг эцэслэн боловсруулахад депутатуудын өмнө Их Хурлын өмнө одоо хариуцах ийм редакцийн хэсэг байх гэж би ингэж томъёолж байна. Энэ бол ажлын хэсэг байх аа. Дэгийнхээ дагуу юм бол энэ ажлын хэсэг байх. Энд Үнэхээр тийм зохих бүлгүүдээс үнэхээр тийм хариуцлагатай депутатуудыг оруулах ёстой. Энэ бол зүйтэй. Энийг бид нар их нухацтай сайн хэлэлцэж, тийм хүмүүсээ энд оруулах ёстой. Энэ бол зүйтэй. 2 дахь санал бол энэ депутатуудын хороод байх ёстой. Бидний баталсан дэгийн дагуу хороод байх ёстой. Энэ хороод бол 5 юмуу 6 байна. Лундаажанцан депутат хэлсэн. 6 дахь хороод байх гэж. Энэнд аль болохоор депутатууд өөрийнхөө хүсэлтээр, өөрийн мэргэжил, ажил, бусад чиглэлээрээ сонирхлынхоо чиглэлээр орох ийм бололцоотой, нэг хувилбар байж болох. Энэ бол мэдээж хэрэг бүгд хуваагдаад орчихвол бас учир дутагдалтай байх л даа. Ер нь зохих бүрэлдүүнтэй, 15 юм уу, 21 ийм ийм бүрэлдүүнтэй, тус бүр нь, ийм хороод байх. Энэ хороод ихээхэн дэг журамтай байх ёстой. Даргатай, нарийн бичгийн даргатай, Илтгэл дараа нь тавина, үнэлэлт, дүгнэлт өгөө, тэр өөрийн одоо эрхэлсэн бүлгээрээ, Үүний дэргэд энэ хороодын дэргэд ажлын хэсэг ажиллана. Бид дэгээ тэгж ойлгож ингэж баталсан. Энэ ажлын хэсэгт тэр одоо УБХ-ын гишүүд, тэр үндсэн хуулийг эцэслэн боловсруулсан комиссын гишүүд, мөн түүнчлэн, аппаратын ажилтнаас бүрдэнэ, энэ ажлын хэсэг бол. Тэр нь 3,4 хүнтэй байж болох байх. Ийм байдлаар бид энэ Үндсэн хуулиа нухацтай ярилцахгүй бол болохгүй. Тодорхой төвлөрч, мэргэжсэн чиглэлээр ингэж ярилцаад ингэхгүй бол болохгүй гэдэг ийм санал байна. Энийг нэг томъёолоод санал хураалт өгөөч гэсэн хүсэлтэй байна.

-Тэгэхлээр энэ хорооны тухай хэлэлцүүлгээ одоо зөгсооё гэдэг санал байна. Надад 1-рт, 2-рт, энэ нэрийг жаахан гоомой оруулчихсан юм болов уу даа. Би зүгээр 21 хүнийг энд орохгүй ёстой хүн орж гэдэг талааа яриагүй байна. Ер нь ингэвэл яасан

км бэ? I хороо байя гэдгээ бол бид тогтсон. Тэр 5 хороо юуу хэдэн хороо гэдэг дээрээ яриа байхгүй болсон км байх гэж ойлголоо. Нэг хороо цаанаа хэдэн ажлын хэсэгтэй байх км гэдэг бол тэр хороо зохион байгуулаад явах асуудал байх. Хорооныхоо бүрэлдэхүүнийг энэ намын бүлгийн ахлагч нар, нутаг дэвсгэрийн бүлгийн ахлагч нартай өнөө орой дахиж нэг яриад энэ 2I хүн байх км уу, эсвэл оронд нь еер улс орох км уу гэдэг энэ юмаа яриад тэгээд одоо тогтвол яасан км бэ? Өнөөдөр ингээд эцэс төгсгөлгүй яриад байвал тэгээд зарим нь татгалзаж байна. Зарим нь болино гэнэ, бид энийг шийдэж чадахгүй байх аа. Тэгэхлээр өнөө орой тийм зохион байгуулалт ярьчихаад өглөө батлачихвал болохгүй км уу.

24-р тойргийн депутат Р.Хатанбаатар: -Би бол АИХ-ын хуралдаанд бол депутатын хувьд оролцож байгаа. Бид бүгд ялгаа байхгүй адилхан депутатууд. Гэхдээ энэ депутатын хороог байгуулах үед хүмүүсийн дунд янз бүрийн үзэл бодол байх шиг байна. Энэ депутатын хороо гэдэг бол үнэн хэрэг дээрээ депутатуудын хэлэлцэж тохирсон юмыг үдэш оройн цагаар сууж, хийж, нухаж, ингэж өөрсдийн ямар нэгэн км шийдэх эрхгүй зүгээр л ийм ажлын боол болох хүмүүс л дээ. Гэхдээ энэн дээр бол депутатуудын дунд нэг ийм тодорхой бодлого байгаа учраас мөн үүнээс гадна энэ Их цаазыг аваад анхнаас нь батлахад бол анхнаасаа оролцож явсан, гэдэг маань ч гэсэн өнөөгийн байдлаар зарим талаар сөрөг маягийн үзэл болчихоод байх шиг байна. Энэ бүгдийг бол бид сая зөвлөж ярилцлаа. Ингээд Бага хурлаас энэ комисст нэр дэв игдсэн Зардыхан, Энхсайхан, мөн 2I-р тойргийн депутат Х.танбаатар бид 3 бол энэ ажлын хэсэг, Чимид гуай бид 4 бол ажлын хэсэгт оруулахгүй байхыг хүсч байна, депутатуудаас. Зүгээр ер нь нэрээ татаж авч байна аа. энд орохоос татгалзаж байна. Ер нь бол би уучлаарай боссон дээрээ ганц нэг үг хэлчихийг бодъё. Манай бага хурал дээр нэг сонин атмоспер байдаг км. Бага хурал дээр бага хурлын гишүүд заримдаа хууль хэлэлцэж байх үед нэлээн бухимдахаараа хамаг асуудлыг Бага Хурлын Гурван дарга шийдлээ гэж загнадаг км. Бүр их бухимдахаараа Бага Хурлын 3 дарга 5 байнгын хоросн дарга нартайгаа нийлээд дарга нар хамаг км шийдлээ гээд ингэж

загнадаг юм. Өөрөөр хэлбэл бид нарт нэлээн хардлагатайгаар хандаг юм. Өнөөдрийн байдлаар бол УИХ дээр бол УБХ-ыг бүхэлд нь хардсан ийм хардлагатайгаар хандаад байх шиг байна. Уучлаарай хүн болгон ийм биш байж болно, надад тэгж санагдсан юм. Энэ бол. Мөн өөр бас нэг атмосфер бас сая гарч ирж байна. Энэ бол юу гэхлээр УБ-ын депутатууд гэдэг бас нэг асуудал гараад ирж байна. Бид нар хэрвээ ингэж хэн хэндээ итгэлгүйгээр дандаа муу талаас нь бодож хардаж сэрдэх талаас нь бодож явах юм бол манай энэ хуралдаан маань өөрөө юу болох вэ гэдгийг бодолцох ёстой. Депутатууд гэдэг бол бид ард түмний төлөөлөгчид, бүгд адилхан эрхтэй байх ёстой. Энд адилхан эрхтэйгээр бүгд оролцож байгаа. Ингэхээр бол бид нар ард түмэн эх орны эрх ашгийн төлөө л ажиллах ёстой байх гэж би хэлэх гэсэн юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн



Ш. БУРМАА

413 дугаар тойргийн депутат Н.Насан-Очир: -Нэг хороо

21 хүн дээр тогтсон учраас дахиж энэ дээр цаг гарздаад хэрэггүй байх гэж бодож байна. Харин хүний тухайд бол хүнтэй холбогдуулаад Бага Хурлын дарга, орлогч нарт хэлэхэд та нөхдүүд минь бусад цагтаа ажлаа гартаа авч өөрсдөө удирдлагын зүгээс оруулж байгаа юм шиг санал оруулж байгаач ээ. Хүний тархиар, хаашаа ч юм бэ ийм маягаар оруулаад байхаар энэ доторх уур амьсгалыг улам эвгүйцүүлж байна. Тэгэхээр хариулт болгож ~~Төмөрийг~~ хэлэхээр энд дэд хорооны дарга нар цөмөөрөө байгаа юм, анхнаас нь гэхээр улсууд эвгүй болчихоод байна шүү дээ. Тийм учраас нутаг дэвсгэрийн комиссын дарга, намын бүлгийн ахлагч нартайгаа яриад энийг маргааш юмуу, нөгөөдөр ч байсан яадаг юм, энийг баталбал яасан юм бэ гэсэн санал байна.

Энэ дашрамд хэлэхэд түрүүний Баяр даргатай редакцийн бүлгийн ажилласнаас харахад энэний чинь зориулалтаар, Их Хуралд үйлчлэх ёстой, байнга цалин авдаг аппарат ер нь ажлаа хөнгөлөөд хамаг ачааллыг хорооны нөхдүүд рүү түлхэх юм биш биз ээ. Өдий төдий улсууд байдаг гэж байгаа. Энэ улсууд чинь юугаа хийж байдаг юм бэ? Хороо дараа нь байгуулагдаад бүх протоколыг зарчмын асуудал дээр бүлэг бүлэг дээр нь ангилаад Хуралдаа шилжүүлнэ биз ээ гэж бодож байна.

Хардаж сөрддэг гэдэг чинь ард түмний дотор байгаа уг шүү дээ. Бага Хуралдаа бага итгэж байгаа явдал. Яагаад гэхээр, улсын нэр, хуулийн нэр, сумыг битгий татан буулгаач гэсэн саналыг өдий төдийгөөр өгөөд байхад та нар тэгэж байна уу гэсэн шиг л улам хасаад байхаар энэ бухимдал гарч байна шүү дээ.

Тэгээд саяын Ерөнхийлөгчийн илтгэлд ч гарлаа шүү дээ. Бүр тодорхой, улам одоо бухимдлыг ихэсгэж, улсын нэр, хуулийн нэр, засаг захиргааны талаар хуучнаараа байлгах гэсэн санал давамгайлж байгаа хэдий боловч гээд уншихаар цаана чинь

ард түмэн, монгол орон даяар цуурайтуулсан, энэ чинь ингээд ийм байдлаас болоод байгаа болохоос биш бид нар хувьдаа, лав л би хардаж сэрдээд байх юм алга байна. Энийг бас манай Бага Хурлын удирдлага, Ерөнхийлөгч, Их Хурлын дарга нар ойлгооч ээ гэж хэлмээр санагдаж байна.

235 дугаар тойргийн депутат Ц.Өөлд: -Уул нь бид энэ 21 хүнийхээ бүрэлдэхүүнтэй хороогоо өнөөдөр байгуулчихвал нэг сайн тал байна. Нагаад тэр гэвэл, энд гарах шүүмжлэлүүдийг тэр хүмүүсүүд маань бичиж авах юм. Тэр утгаараа авч үзвэл бид энэ хороогоо байгуулчихмаар байна. Тэгэхээр хороогоо байгуулна гэхээр хоёр зам байна. Би горимын санал хэлэх гэсэн юм. Ерөөсөө оройдoo нэг хурал болж хийж байснаас энд нутаг дэвсгэрийн бүлгүүд, бүлгийн ахлагч нар энэ дотуураа яваад хүнийхээ нэрийг гаргаад ингээд Их Хурлынхаа даргад өгчихөөд тэр өгсөн нэрээрээ дахиад хэлүүлэхгүй юу гэж. Ухаан нь, энэ 21 хүнээ бүрдүүлэх нэг зарчим бол нутаг дэвсгэрийн шугамаар, үгүй бол 2 дахь хувилбар нь ерөөсөө энэ 21 хүн дээрээ холбогдох хүмүүсүүдээ нэмээд тэгэж байгаад олонхийн саналаар авч байгаад хэдэн хүн гарах нь вэ, тэгээд 21 хүнээ үлдээе гэсэн ийм хоёр горимын санал дээр та санал хураалгаад хэрвээ нутаг дэвсгэрийнх гэвэл энэ улсууд одоо энэ дотроо явж байгаад хүнээ оруулж, хүн хүний нэр гаргаж ирээгүй бол хүнийхээ нэрийг дэвшүүлж байгаад хамгийн олон санал авсан 21 хүнээ гаргах энэ хоёр хувилбараар одоо 21 хүнээ бүрдүүлчих арга зам хайвал яасан юм бэ гэсэн санал байна.

Хэрвээ хүнээр нэр дэвшүүлээд байна гэвэл надад нэг дөрвөн хүний нэр байж байгаа. Нэг боссон дээрээ одоо хэлчихье. 163 дугаар тойргийн депутат Б.Мижид, 303 дугаар тойргийн депутат Ж.Норовсамбуу, 245 дугаар тойргийн депутат Ч.Чинбат, 202 дугаар тойргийн депутат Ж.Адъяа.

405 дугаар тойргийн депутат Б.Лигдэн: -Тэгэхээр энэ комиссын бүрэлдэхүүнд Улсын Бага Хурлын гишүүдээс лав хорин хувиас наашгүй оруулах нь зүйтэй гэж бодож байна. Энэ хүмүүс бол хууль хэлэлцэх, батлах энэ бүгдэд практик суусан мэргэжсэн ийм хүмүүс. Хэзээ ч би бас заримдаа орж, харж сонирхдог юм байгаа юм. Энэ бол бидэнд ямар нэгэн

хэмжээгээр тулгалт болохгүй. Энэ практик, энэ туршлага, энэ боловсруулсан үйл явц, бүх юмыг хэлүүлж авдаг байгаадаа гэж бодож байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ комиссын бүрэлдэхүүнд би орно гэж бодоод байхаар нэг их сэтгэл хүрэхгүй байна. Тийм учраас энэ их хүнд ажил, чадал ч хүрэхгүй байж магадгүй. Тийм учраас өөрийгөө татгалзаад бусад нэр дэвшүүлж байгаа хүмүүст би байраа тавьж өгье гэж бодож байна.

Ж. Уртнасан: —Бид түрүүн тохирсон, микрофоны ард зогсож байгаа депутатуудаар санал тасалъя гэж. Санал тогтох шиг боллоо. Бид депутатын хороог 21 хүнтэй байгуулъя гэж байна. Энэ дээр санал зөрөөтэй юм юу байна вэ гэхээр голдуу Улаанбаатарынхан, тэр дотроо Бага Хурлын гишүүд их олон оржээ гэдэг энэ шүүмжлэлийг хүлээж авч, зарим депутатууд өөрсдийнхөө нэрийг энэ бүрэлдэхүүнээс татаж авч байх шиг байна. Ийм учраас ийм саналыг, томъёолол гарч ирж байна. Бид өнөөдөр энийг хэлэлцээд байвал янз бүрийн нэр гарч ирж, янз бүрийн хүн нааш цааш нь татаад байдал нэг л цаг идэх ийм шинжтэй байна. Тийм учраас ер нь депутатуудын орон нутаг, нутаг дэвсгэрийн бүлэг, намын бүлгүүдээс нэрээр дэвшүүлж бидэнд өгөхгүй юу. Бид энд нэгтгээд, саналыг нэгтгээд аль болохоор нягтруулаад та бүхэнд маргааш өглөө танилцуулъя. Үүнийг нээлттэй орхих ийм саналтай байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, депутат Гомбосүрэн асуусан. Энэ ямар нэртэй зөвлөгч, ямар нэртэй албанууд ажиллаад байна гэж. Чуулган эхлэхийн өмнө Ардын Их Хурлын дарга Гомбожав гуай та бүхэнд танилцуулсан. Тэр хэдэн группийг бид хайнгадуухан сонссон юм болов уу гэж бодож байна. Энд аппаратын ерөнхий нарийн бичгийн дарга, орлогч дарга нар гээд Д. Моломжамц, Л. Хангай, Р. Тунжин гээд гурван хүн байгаа юм. Баримт бичгийн төсөл боловсруулах, нутаг дэвсгэрийн болон намын бүлгийн ажилд туслах групп гэж байгаа. Энд Хууль зүйн яамны сайд Ж. Амарсанаа, Улсын Бага Хурлын Тамгын газрын хуулийн зөвлөгч С. Төмөр, Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Н. Лувсанжав байгаа юм. Энэ гурван хүн маань хуралдаан даргалагчийн зөвлөх гэсэн ийм нэртэй. Үүрэг

нь хууль тогтоож хэлэлцэх үед хуралдаан даргалагчид шаардлагатай асуудлаар хууль зүйн дагуу зөвлөлгөө өгч, аливаа асуудлыг хууль зүйн талаас нь зөв шийдвэрлэхэд тусална гэсэн ийм үүрэгтэй сууж байгаа улсууд аа.

Тэгээд энээс гадна техникийн үйлчилгээний хэсэг, шуурхай ажлыг зохион байгуулах хэсэг, бичээч олшруулагчийн хэсэг, танхим зохион байгуулагчийн хэсэг, захидал, мэдээлэл хүлээн авах хэсэг, депутатуудад үйлчлэх хэсэг, хэвлэл мэдээллийн хэсэг, хуралдаан даргалагчийн зөвлөх, холбоо, цахим тоолуурын алба гэсэн ийм II хэсэг байгаа шүү дээ. Үүнийг түрүүн Гомбожав дарга уншиж сонсож байсан. Үүнийг дахин нэг та бүхний сонорт хүргэе гэж бодож байна.

Ингээд 2I хунтэй депутатуудын хороо байгуулах асуудлаа түр нээлттэй орхиё гэсэн ийм санал хураалт явуулах гэж байна. Санал хураалтад бэлтгэнэ үү. Өнөөдөр намын бүлгүүд, орон нутгийн бүлгүүд өөрсдийнхөө энэ хороонд орох депутатуудын нэрийг гаргаж бидэнд маргааш өглөө өгмөөр байна. Бид боловсруулъя, тэгээд та бүхэнд сонордуулъя. Энэ дээр санал хураалт явуулъя. Үүнийг нээлттэй орхиё, депутатуудын намын бүлэг, орон нутгийн бүлгээс санал авсны дараа шийдвэрлэе. Нээлттэй орхиё гэсэн санал хураалт явуулах гэж байна. Маргааш шийдье. Эннийг нээлттэй орхиё, дарга, орлогчийг ч ярихаа больё, 2I гэсэн тоон дээрээ тогтё. Тэр бүрэлдэхүүнээ бид маргааш шилж сонгож та бүгдийн саналаа оруулъя. Санал хураалт явуулж байна.

Санал өгсөн депутатуудын 8I хувь нь энэ саналыг зөвшөөрч байна, 332 депутат саналаа өглөө. Энэ асуудлыг нээлттэй орхиё.

Одоо хурлын дэгийн дагуу 12 дугаар зүйлийн "в"-д заасан байгаа. Бид илтгэлээ сонссон. Манай нэг депутат түрүүн их зөв хэлсэн. Одоо асуулт, хариулт явуулах ажилдаа орох болж байна, бид нар. Тэгэхээр асуулт шууд товч тодорхой байвал зохино. Хариултыг Улсын Бага Хурал, түүний комисс өгнө гэсэн манай дэгэнд ингэж заасан байгаа. Ийм учраас Улсын Бага Хурлын дарга,

депутат Гончигдорж гуайг бид индэрт урьж байна. Энд асуултууд ирж байна.

Уучлаарай, илтгэл тавьсан комиссын дарга Ерөнхийлөгчид бид энэ асуултыг шилжүүлэе, асуултууд ирсэн байна.

Брөнхийлөгч П.Очирбат: -Бүх асуултыг би хариулж чадахгүй байх.Мэдэхгүй юм их олон бий.Санал зөрөөтэй ч юм бий.Тэгэхлээр та нөхдүүд дэгээ жаахан өөрөөр ойлгоод илтгэл тавьсан хүнээр гэсэн тодотгол хийж байгаа бол би хариулахад бэлэн байна, хариулж эхэлье.

Үндсэн хуулийн төслийг хэлэлцүүлэх явцад ард түмнээс улс ба хуулийн нэрийг өөрчлөхгүй байх, сүлд, далбааг хэвээр байлгах талаар гарсан олонхийн саналыг яагаад харгалзаагүй вэ?

Нэр, хаяг, хэв загваруудыг өөрчилснөөр улсын хэмжээгээр ямар зардал гарах вэ? Тодорхой хэлнэ үү?

Улсын нэр, хуулийн нэрийн талаар би илтгэлдээ асуудлыг нээлттэй орхисон.Та бүхнийг шийднэ биз ээ гэж хэлсэн.Энээс өөрөөр бид хэлж чадахгүй.Энэ нэр хаяг, загвар өөрчилснөөс ямар гээч зардал гарах вэ гэсэн асуудал бий.Энэ дээр байгууллагын хаяг, албан бичгийн хаяг, тамга тэмдэг зэргийг цөмийг өөрчлөхөд ойролцоогоор 8,2 сая төгрөгийн зардал гарна гэсэн ойролцоо тооцоо бий.Энэ бүх юм ойролцоо байгаа.

Гадаад паспорт, дотоодын паспорт юмыг солиход заавал Үндсэн хуулийг мөрдсөн өдрөөс нугийг сольсон байна гэж үзвэл 50,2 сая төгрөгийн зардал гарна.Гэхдээ одоо байж байгаа паспортуудыг дуустал нь хэрэглэвэл, дуустал нь хэрэглэж болдог практик байна.Хоёр Герман нийлээд хуучин хуучин паспорттайгаа байгаа юм байна.дэлхий нийтэд тэрнийг зарлаад мэдээлчихдэг юм байна.Дотоод паспортын загварын хувьд гэвэл тэрнийг мөн тодорхой хугацаанд, одоо байж байгаа нөөцүүдээ хэрэглээд дуустал гэдэг юмуу, тодорхой хугацаанд тэрнийг мөрдөж байхаар шийдвэл тэр бүх паспортуудыг цөмийг шинэчлэх шаардлага байхгүй байж болох юм.

Соронзон хальстай
тулгаж нийлсэн:



Бичээч

Ж.НАРАНТУЯА
Ө.ОЮУНЧИМЭГ

ингэж төсөөлж байгаа.

Б.Лигдэн -Нэг хүсэлт байна.Асууж байгаа хүнийхээ тойрог,нэр хоёрыг хэлэхгүй юу? Манай хэвлэлийнхэнд бас хэрэгтэй байна.

114 дүгээр тойргийн депутат Ёндонжамц гэдэг хүний асуулт саянх.

П.Очирбат -Төрийн далбаа,сүлд хэрэв солигдвол энэнтэй холбогдсон зардал урьдчилсан тооцоогоор 4 сая 250 мянган төгрөгт хүрч болохоор байна.Ингээд паспортуудыг хэвээр үлдээгвэл нэмэгдэл зардал гаргахгүйгээр хэвээр нь дуустал нь хэрэглээд,дуусгахлаар нь тэртэй тэргүй шинэ паспортууд гаргаж ирэх юмаа гэж бодоод тэрний зардлыг оруулахгүй болбол ойролцоогоор 12 сая 450 мянган төгрөгний зардал гарч магадгүй байна. Энэ дээр мөнгөн тэмдэгтийн тухай асуудал бий.Тэгэхээр мөнгөн тэмдэгтийн тухай асуудлыг улсын нэр,бусад зүйлтэй шууд холбож үзэх шалтгаан ч байж болох юм,шууд холбож үзэхгүй ч нөхцөл байдал буй болж болох юм.Тийм учраас энд **гарах** зардлыг заавал энэ нэр ус солигдож байгаатай холбож зардлыг нь ганцхан тэр лүү хийж өгөхгүй байх үндэс байх болов уу гэж тооцсон урьдчилсан тооцоо бий.

82 дугаар тойргийн депутат Сарай -Нэгтгээд ирэхэд хэдэн аймаг болов вэ? Үүнийг одоо тэдэн аймаг болно оо гээд урьдчилан тогтоосон юм байхгүйээ.Энэ асуудлыг зарчмыг нь шийдвэл боловсруулах,ярих хугацаа бий.Би хуулинд байхгүй нэг он хэлсэн. Үүнийг хууль гараад нэг амьсгаагаар заавал шийдэх гэж яарах хэрэггүй байх.Өөрөөр хэлбэл энэ жил,**хойтон** жил ч гэдэг юмуу. Ер нь энэ асуудлыг нарийн боловсруулаад 95 оноос мөрдөхөөр байвал яасан юм бэ гэсэн тийм өгүүлбэр хэлсэн.Ер нь Их хуралд өргөн барьчихаад байгаа юм байна.Тэр шилжилтийн хуулийн төсөлд энэ онууд тодорхой байгаа.Энэ дээр ярьж болно.Хэдэн хошуу байх юм бэ,мөн ялгаа байхгүй.Би баримжаа хэлсэн.Нэг сум ч нэг хошуу болж болох тийм хувилбар байгаа юм байна лээ.Хоёр гурван сум,

тав **хүртэл** сум нийлээд нэг хошуу болж болох тийм ч хувилбар байгаа юм байна лээ. Тэгэхээр үүнийг төвөөс тийм тийм сумууд нийлж ийм хошуу бол оо гэж хэлж өгөхгүй, хэлэхгүй, одоогоор тийм төсөл байхгүй. Энэ бол тодорхой орон нутгийн нөхцөл байдал, орон нутгийн иргэд, хөдөлмөрчдийн санал дээр үндсэндээ тулгуурлаж шийдэгдэх асуудал байгаа байх аа.

—Үндсэн хууль баталчихаад байхад орон нутгийн засаг захиргааг зохион байгуулах ажлыг 3 жил хойшлуулж ажил сунжруулах, орон нутгийг улам цалгардуулж байгаа шалтгаан юу вэ?

—Энэ ямар нэгэн өөр, хүнд ойлгогдохгүй санаа бодол агуулж байгаа юм бишээ. Олон түмний санаа бодол дээр тулгуурлаж шийдэхэд хугацаа хэрэгтэй байх болов уу, гэж байгаа юм. Энэ хооронд засаг захиргаа сонгуулийн ажлыг ямар зарчим дээр зохион байгуулах вэ гэдэг энэ зарчим тэр шилжилтийн хуулийн төсөлд мөн байж байгаа. Хуучин сум, аймгийн төвд юу үлдэх юм бэ, энэ асуудлыг арай дэлгэрэнгүй яривал ямар вэ. Хуучин аймаг, сумын төвд юу үлдэхээ орон нутаг мэднэ.

231 дүгээр тойргийн депутат Амарбаян: —Илтгэлд төрийн сүлд, далбааг өөрчлөхгүй байх талаар нийт ард түмний санал дийлэнх нь байжээ. Гэтэл хэлэлцэж байгаа төсөлд өөрчлөхөөр орсон. Зайлшгүй өөрчлөх шалтгаан юу байсан юм бэ?

П.Очирбат —Энүүгээр манай Бага хурлын нөхдүүд хариу хэлэг. Засаг захиргааны нэгжид аймгийг хошууд болгохоор орж байгаа, одоогийн төлөвлөж байгаагаар хэдэн хошуу хуваагдах юм бэ, одоогийн сумдын төвд ямар байгууллага, захиргаа яаж ажиллах вэ, хатуу төлөвлөгөөгүй сумдын хошуу төвлөрөөгүй сумын төвд гэж. За би хэлчихсэн дээ. Энэнээс би туг, далбааг хариулаагүй.

Тэгэхлээр депутатууд биднийг зөв ойлгож үзээрэй. Энэ Улсын бага хурлаас өргөн мэдүүлж байгаа Их хуралдаа ийм төсөл. Ийм учраас Улсын бага хурлын удирдлага бид ер нь цугаараа нийлж зарим юман дээр мэргэжлийн нарийн зүйлүүд бий. Тэрнийг энд тал талаасаа нийлж депутатууддаа аль болохоор зөв хариу өгөх ийм зорилго байгаа шүү. Тэрнээс хэн нэг хүн энэ асуудлыг

хир төсөөлж байна вэ гэдгийг шалгаж байгаа биш байгаа гэж ойлгож байна. Тийм учраас бид цугаараа нийлж хариулна шүү нэгдүгээрт, хоёрдугаарт биднийг зөв ойлгоорой. Бид ямар нэгэн ухуулга тийм юм хийхгүй. Тийм учраас их дуугайдуу байгаа шүү дээ. Тэгэхээр та нөхөд заавал хэл гэж байгаа зүйлүүд дээр энэ асуудлуудыг хариулж байгаа шүү. Энэ харилцан бас их сайхан илэн далангүй, зөв, цагаандуу сэтгэлтэй асуулт хариулт юманд аа хандацгаахыг бас уриалмаар байна. Тэгэхгүй бол ярианы өнгөн дотор жижиг сажиг юм байж магадгүй юм шиг байгаа шүү. Энэ дахиад нэр сүүлд байна.

Нанзаддорж - Хурлын даргаа нэг хүсэлт байна. Энэ асуулт хариултыг, ер нь Үндсэн хуулийг боловсруулсан субъект хуралдааны эхний үед анхны санаачлагч нь Бага хурал гэж Бага хурлын гишүүд их ярьсан. Ийм учраас ер нь Үндсэн хуулийг боловсруулах явцад ажиллаж байсан Бага хурлын гишүүд, мөн комиссын гишүүд ялгалгүй гол гол бичлэг энэ тэр нь байдаг байх, энэ үндсэн хуулийг боловсруулахад ямар ямар санал өгч, ухаандаа сүлдийг өөрчлөхөд хэн хэн санал өгч, ингэсэн гэдгийг тайлбарлахгүйгээр ганц ерөнхийлөгч ингэж болохгүй байна. Тийм учраас Бага хурлын эрхэм гишүүдийг тэр индэр дээрээс гараад эрхэм депутатууд зөвшөөрөх байх гэж бодож байна, хариулъя гэж бодож байна.

Уртнасан - Депутат нөхөд өө, бидэнд та бүгдээс хандсан бичгээр олон санал, хүсэлт ирж байна. Түүний дотор дэгээ баримталъя, энэ дэгэнд Бага хурал, комисс хариулах ёстой. Энэ асуудлыг Бага хуралд шилжүүлнэ үү гэсэн олон санал ирлээ. Ингээд ер нь ч ирж байгаа санал бол ойролцоо, тоймлоод нэгтгээд хариулж болмоор юм шиг байна. Хамгийн гол нь Их цааз, Үндсэн хуулийн нэр, улсын нэр, сүлд тэмдэг, бэлэг тэмдгийн асуудлаар их олон лавлаж ирж байгаа асуудлуудын 30, 40 хувь нь давхардаж байна. Ийм учраас Бага хурлын дарга депутат Гончигдорж даргадаа энэ асуудлуудыг шилжүүлъя. Бага хурлын нөхдүүд маань хэлэх ярих үгтэй байгаа байх гэж бодож байна.

- Хурлын даргаа болох уу. Ерөнхийлөгчид хандаж асуумаар юм байна?

П. Очирбат - Энд асуулт байж л байна. Энд асуусан юм биш байгаа даа. Ингэж байна. 137 дугаар тойргийн Бааран. - Та ерөнхий-

лөгчийн хувьд БНМАУ-ын одоогийн Үндсэн хуулийн төсөлд ерөнхий-
лөгчийн эрх хэмжээ, үйл ажиллагаагаа бүрэн явуулах боломжоор
аль хэр хангагдсан гэж үзэж байна вэ?

-Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийн дагуу гэвэл ерөнхий-
лөгч төрийн тогтолцооны энэ хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах
бүрэн эрх бололцоогоор хангагдсан гэж үзэж байгаа. Шинэ одоо
хэлэлцэж байгаа энэ төсөлд бид парламентын Бүгд Найрамдах
энэ улсынхаа засаглалыг гэж тогтвол төсөлд байгаа эрх хэмжээ
мөн тэрэнтэй шууд уялдаж, мөн үйл ажиллагаа явуулах эрх хэмжээ
тодорхойлогдсон гэж үзэж байгаа. Тэгэхдээ би хойно нэг өгүүл-
бэр хэлсэн. Гүйцэтгэх засаглал, Засгийн газрын үйл ажиллагааг
зохицуулах талаар тэнд дутсан эрх бий. Тэрэн дээр хуучин төсөлд
одоогийн мөрдөж байгаа Үндсэн хуулийн нэмэлтийн 17-д ч бий,
ерөнхийлөгчийн хуулийн улс орныг удирдах гэдэг зүйлийн 2-т ч
бий. Засгийн газарт чиглэл өгнө гэж. Тэр одоогийн төсөлд байхгүй
байгаа. Би хувьдаа тэрнийг байх ёстой гэж үздэг. Бусдаар бол ер нь
эрх үндсэндээ бүрэн хангагдсан гэж ойлгож байгаа.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ ТУЛГАЖ
НИЙЛСЭН

Баяндүүрэн

/БАЯНДҮҮРЭН/

БИЧЭЭЧ

/Д.ЭНЭБИШ/

1991-11-13

Кассет № 16
18.25-18.40

Банзрагч / 222 дугаар тойргийн депутат / -Тэгэхээр манай Ерөнхийлөгч Үндсэн хуулийг, Их цаазыг боловсруулах комиссын дарга байгаа, Бага Хуралд энэ төслийг оруулж хэлэлцүүлсэн, тэгэхээр хэрэв боломжтой бол ийм нэг асуултад хариулахгүй юу. Таны Бага Хуралд өргөн барьсан эхний хувилбараас Бага Хурлаар батлаад бидэнд өгч байгаа энэ төсөлд таны оруулснаас зарчмын хувьд зөвшөөрөгдөхгүй, эмзэглэж байгаа ч байдаг юм уу, одоо гол гол ямар асуудлууд байна вэ? Бололцоотой бол энийгээ хэлээд өгчихгүй юу.

П.Очирбат -За энэн дээр би ч хоёр удаа илтгэчихээд байгаа шүү дээ. Тэгэхээр ямар шийдвэр гарах нь Бага Хурлын эрхийн асуудал. Анхны оруулж байсан саналуудаас ер нь зөвшөөрөлцөөд, өөрөөр хэлбэл Бага Хурлын шийдвэр зөв юм гэж бодоод өөрчилсөн асуудлууд нэлээд бий. Хоёр дахь хэлэлцүүлэг дээр хуулийн нэрийг Үндсэн хууль гэж манай комисс оруулсан. Гарахдаа Их цааз гэдгээрээ гарсан. За төрийн сүлд, далбаа, дууны талаар бол бид тусгай групп ажиллуулсан. Тэгэхдээ энэ маргаантай байсан учраас энэ бол мэргэжлийн болоод олон түмний санал дээр илүү тулгуурлах ийм зүйл бас заримд нь байгаа гэдгийг үгүйсгэж болохгүй юм. Тийм учраас тэрэн дээр Бага Хурлын шийдвэрийг үндэс байхгүй гэж үзсэн юм байхгүй. Би сая илтгэлдээ хэлсэн. Олон түмнээс ирж байгаа санал бодол, Бага Хурлын шийдсэн шийдвэр хоёрт нэлээн зөрөө бий. Тэрийг та бүхэн болгооно биз ээ, анхаарч үзэж шийднэ биз ээ гэдгээр орхисон.

За тэр Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг ганцхан Улсын Бага Хурлаас томилох уу? Эсвэл Улсын Бага Хурал, Ерөнхийлөгч, Дээд шүүх гурав одоо гурав гурваар нь санал оруулж, томилох уу гэдэг дээр зөрөөтэй. Тэрийг анхаарна биз ээ гэж хэлсэн. Ерөнхийлөгчийн насны хувьд зөрөөтэй. Бид 40 гэдэг нас тавьж оруулсан, 50 гэдэг насаар гарч ирсэн. Нэг иймэрхүү л зүйл бий. Өөр зөрөөтэй юм байхгүй.

Гомбо /218 дугаар тойргийн депутат /

-Хурлын

даргаа болох уу? Нэг асуулт байна.Ерөнхийлөгчөөс асуулт байна.

Ж.Уртнасан -Ерөнхийлөгчид бас нэг асуулт байгаа.Энийг хариулахаар та дараа нь асуугаарай.

Ц.Очирбат -168 дугаар тойрог Вандандагва, нэгдүгээр бүлгийн зургадугаар зүйлийн тавдугаарт заагдсан байдал нь тус бүлгийн тавдугаар зүйлийн дөрөвт тэр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй гэсэн агуулгыг баталгаатай хангах ямар механизм энэ хуулинд тусгагдсан бэ? Нөгөө талаар 6 дугаар зүйлийн тавд хуульд заасан бусад болзол, хэлбэрээр эзэмшүүлэн, эдлүүлж болно, эзэмшүүлэн эдлүүлж болно гэсэн болзол, хэлбэрийг Их цаазад шууд томъёолж болохгүй юу?

Энэ зургаагийн тав газар эзэмшил байнаа даа янз нь. Тэгэхлээр Газрын тухай хууль гарна.Тэгэхээр энэ бүх эрхийн зохицуулалтыг, ялангуяа салбарын хуулиудаар зохицуулж болох эрхийн зохицуулалтыг нэг Үндсэн хуулиар зохицуулах боломжгүй юмаа.Тэгвэл хуулиудын эмхтгэл ч юм уу, тийм энэ юугүй болчихно.Тийм учраас гол зарчмаа Үндсэн хуулиндаа хэлж өгөөд тэгээд салбар хуулиудаар тэрнийг зохицуулна.Тэгэхдээ тэр салбар хуулиуд Үндсэн хуулийн гол зарчимтай зөрчилдөж болохгүй.Үндсэн хуулийн гол зарчимд багтаж түүний дагуу хийгдсэн байх ёстой.

Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах механизмын хувьд гэвэл улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого, төрийн бодлогыг боловсрогдсон байгаа, тэр нарийн механизм нь. Тэрнийг Улсын Бага Хурал хэлэлцэнэ.Ер нь нэг удаа хэлэлцсэн байгаа.Тэрнийгээ баталж гаргаагүй байна.Одоо энэ Үндсэн хуулиа батлагдсаны дараа бодвол тэр эдийн засгийн аюулгүй байдлын механизм, тэр бодлогын хүрээнд гарч батлагдахаар боловсрогдсон байж байгаа.

Ц.Гомбо /218 дугаар тойргийн депутат/ -Ерөнхийлөгчийн

илтгэлд энэ манай тусгаар тогтнолын гол баталгаа бол нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдал гол баталгаа нь гэж ингэж тусгагдаж байгаа. Тэгэхээр тэр газрыг худалдана, түрээслэнэ, хувьчилна, гадаадынханд түрээслэнэ гэж, тэгэхээр энэ үзэл бодлын талаар Ерөнхийлөгч, Бага Хурал хоёр ямар саналтай, санал нийлдэг үү? Аль эсвэл зөрүүтэй байна уу гэсэн ийм нэг асуулт байна.

Хоёрдугаарт, ер нь ямар ямар болзлыг хангасан улс тусгаар тогтносон улс гэж дэлхийн жишгээр үздэг юм бэ?

Гуравдугаарт, энэ Их цаазын төслийг хэлэлцэж баталснаар манайх одоо тусгаар тогтнолоо дэлхий нийтэд зарлан тунхаглана гэсэн. Тэгэхээр энэний урд талд манайх чинь одоо тусгаар тогтносон улс биш байсан юм уу? Мөн байсан юм уу? Одоо тусгаар тогтнолоо тунхаглах гэж байгаа юм уу гэсэн нэг ийм асуулт байна.

Дөрөвдүгээрт нь нэг асуулт байна. Тэр төрийн байгууллын хэсэгт Ардын Их Хурал маань 76 гишүүнтэй байх нь. Тэгэхээр 28 мянган хүн тутамд I гишүүн байх нь л дээ. Энэ хөдөө талд нөгөө улсууд чинь сонгогдохоор зэрэг, хойтон жил сонгууль болно, сонгогдохоороо зэрэг ямар янзын юм болдог бол? Тэнд тэр гишүүд чинь эндээс чадалтай гэгддэг юм уу ийм улсууд сонгогдож чадах болов уу? Эндээс нэг малчин сонгогдоод ирвэл нөгөө хууль элдэв өнгийн юмаа боловсруулаад, энд одоо сууж байх бололцоо гардаг болов уу үгүй болов уу? Ард түмэн энэ төр хоёрын чинь нөгөө нэгдмэл байдал одоо хаачих вэ? Энэ талаар тодорхой хариулт өгөхгүй юу гэж хүсч байна.

П.Очирбат -Газрын талаар, газар өмчлөлийн талаар Улсын Бага Хурал, Ерөнхийлөгч хоёрын хооронд зөрөө байхгүй. Хуулинд зааж байгаа хэмжээ, илтгэлд хэлсэн зүйлүүд Бага Хурал, Ерөнхийлөгчийн бодол нэгдмэл байгаа. Тусгаар тогтнолоо зарлан тунхаглана гээгүй. Зарласан тусгаар тогтнолоо баталгаажуулж, энийгээ дахин шинэ Үндсэн хуулиндаа шилжүүлж л хэлж байгаа юм. Түү-

нээс биш шинээр монголыг зарлан тунхаглана гэсэн тийм ойлголт хуулинд байхгүй. Ямар болзол хангасан улс байдаг юм бэ? гэж байх шив дээ. Манай улс бол тусгаар тогтносон бүрэн эрхт бүгд найрамдах улс байх болзлоо хангаад, НҮБ-ын гишүүн болчихсон. Ер нь НҮБ-ын гишүүн л байвал тусгаар тогтносон бүрэн эрхт болзлоо хангасан л гэсэн үг тэнд л, тэдний бүрэн эрхт гишүүн болж чадвал.

76 гишүүнтэй, би түрүүн илтгэлдээ хэлсэн дээ. Бид депутат гэдгийг одоо нөгөө ард түмний зарц, захиа даалгавар аваад тэрнийгээ нэг хэсэг бүлгийг төлөөлдөг энэ утгаараа цаашдаа байхгүй нь ээ. Одоо төрийнхөө жолоог барьж, хуулиа тогтоож хэрэгжүүлдэг ийм Улсын Их Хурлын гишүүн, төрийн шадар ийм төлөөлөгч байх нь ээ. Сонгогчидтойгоо, энэ бол сонгогчдоосоо бүр тасраад ямар ч эргээд харилцаагүй болно гэсэн үг бишээ. Харилцана. Төрийнхөө бодлогыг боловсруулахдаа санал бодол мэдээж хэрэг авна. Төрийнхөө хууль бодлогыг сурталчлах, таниулах ажлаа тэртээ тэргүй Улсын Их Хурлын гишүүн бүр ард түмэнтэйгээ холбоогоо барьдгаараа барьж байна. Зүгээр байнга харилцаа, тойргийнхоо сонгогчидтой харилцах харилцааг өөрийгөө төлөөлсөн, өөрөө завгүй, одоо энэ чинь 150-160 хоног байнга сууж ажиллах учраас тэр хугацаандаа тойрог дээрээ өөрийнхөө, өөрийгөө төлөөлсөн хүн явуулж, ажиллуулж, бас санал бодлыг нь сонсох ийм шуурхай үйл ажиллагаа явуулж болно. Тэгэхээр манай малчдыг, малчин хүн энэ Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдохоо болих нь ээ гэж ойлгож болохгүй ээ. Манай малчдын дунд, манай хөдөлмөрчдийн дунд тийм юмыг мэддэг, ийм юмыг мэддэггүй гэж, одоо ингэж, уучлаарай ямар нэгэн хэмжээгээр тийм басамжлах юу байж болохгүй. Өнөөдөр ажиллаж байгаа Улсын Бага Хуралд малчин ч бий, ажилчин ч бий, хуулиа тогтоогоод, хууль тогтоох, хянах, зохицуулах, төр удирдах үйл хэрэгтээ хамгийн идэвхтэй оролцоод явж л байгаа. Тийм учраас ийм ялгааг эмзэглүүлж гаргахгүй байвал их зүгээр байна.

Р.Гончигдорж /56 дугаар тойргийн депутат/ -За эрхэм депутатууд аа. Юуны өмнө та бүхэндээ бас нэг боломж байвал зөвшилцөх, ер нь ийм ойлголцох зүйл байгаа юм шиг санагдах юм.

Бид нар өнөөдөр Монгол улсынхаа Их цаазын төслийг хэлэлцэх эхний шат болох асуулт хариултанд орж байна. Асуултын нэг тал бол энэ хуулийг Улсын Бага Хуралд өргөн барьсан Улсын Бага Хурал, асуултын нөгөө тал нь бол манай бүх депутатууд энэ хуулийг хэлэлцэхээр өргөн барьсных нь хувьд асууж байна. Тийм учраас энийг ямар нэг уулзалтын хэлбэртэй ч юм уу, тодорхой гишүүн рүү хандаж асуусан асуултаар яах нь зохимжгүй байх нэгдүгээрт, гэж ингэж бодож байна. Бид асуудлаа ярилцаад ирэхээр депутатынхаа хувьд өөр өөрийн бодлуудаа, өөр өөрийн асуудлуудаа тодорхой ярина. Тэрэн дээр санал зөрсөн зүйл дээрээ бол бас ярина, маргана, ингэж таарна. Тийм учраас энэ бол ерөөсөө, энэ өргөн барьсан төсөлтэй холбогдсон зүйл Үндсэн хуульд яагаад энд тусах ёстой юм, ямар байдлаар тусав? Ингэж тусгасны учир холбогдол юу байна вэ гэдэг талаар нь хариултуудаа чиглүүлээд явуулья гэсэн бодолтой байна, нэг талаас.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

В. Мунца

ЭНХТҮЯА

Бичээч Уранчимэг

Р.Гончигдорж /56 дугаар тойргийн депутат/ -Нөгөө талаас би энд бүх асуултад хариулахгүй, нэг үгээр хэлбэл энд асуудлыг хуваарилах ерөнхий хуваарилагч, диспетчерийн шинжтэйгээр энд байх нь зүйтэй юм байгаа юм. Яагаад гэвэл манай Бага Хурал дээр Бага Хурлын гишүүд өөр өөрсдөө тодорхой асуудлууд дээр бас тодорхой хариултыг хэлэх ийм өөрийн мэргэжлийн болон парламент дээрээ мэргэшиж байгаа ийм чиглэлүүд байдаг юм. Тийм учраас энэ нь зөв болов уу гэж бодож байна. Түүнээс гадна маш олон асуудлууд давхардаж байгаа. Тийм учраас нэг гарсан асуултад хариулсны дараачаар тэрэн дээр дахин хариултуудыг газар газраас авахаа больё. За би асуудлуудыг хамгийн санамсаргүй сонголтоор нь аваад ингээд явъя.

Энд нэг хэсэг асуудлууд Үндсэн хуулийн та бүхэнд өргөн барьсан төслийн нэр, улсын нэртэй холбоотой асуудлууд байгаа. Яагаад монгол улс гэсэн нэрийг Бага Хурал өргөн барив, яагаад Их цааз гэж нэрлэв гэсэн асуудлууд байна. Эхлээд Монгол улс гэж нэрлэсэн талаар манай орлогч дарга Зардыхан хариулъя. Их цааз гэж нэрлэсний талаар Чимид гишүүн хариулна.

Дараагийн, уул нь бид нарт байсан нэг микрофоноо эргүүлээд тавьчихвал одоо арай өөр түвшинд байгаа учраас болмоор санагдана. Урд талын ширээн дээр. Дараа нь эрхэм гишүүдээс Ерөнхийлөгчөөс асуусан асуултууд байна. Тухайлбал хэдэн сумтай болох юм, хэдэн хошуу болох юм, эсвэл газрыг одоо ямар үнээр өгөх гэж байгаа юм. Энэ асуудлууд бол хэрэв бид үнэхээр Үндсэн хуулиа баталчих юм бол, энэ Үндсэн хууль гэдэг маань манай улс орны энэ Үндсэн хуульд зохицуулсан бүх харилцааг хэрэгжүүлэх энэ үйл ажиллагаанд ороход чухамхүү энэ асуудлуудыг бол зөвхөн эрхлэн гүйцэтгэх болон, үүнийг нарийвчлан зохицуулах хуулиуд дээр орж ирэх асуудлууд, тийм учраас чухамхүү энэнд л бид нар Үндсэн хуулиараа, үндсэн эрхийн хэмжээг бий болгож өгөх гэж байгаа юм. За эхнээсээ хариулж байя. Тэр хооронд нь би асуултуудынхаа хуваарилалтыг хийе. Монгол улс гэж нэрлэсний учир.

К.Зардыхан /4 дүгээр тойргийн депутат/ -Монгол улс гэдэг улсын нэрийн асуудлыг телевизээр олон удаа ярилцсан, хэвлэлд гарсан, үндсэн учир баримтуудыг үндсэнд нь хөдөлмөрчид мэдэж байгаа гэж бодож байна.Тэгээд яагаад өөрчлөхгүй байх шалтгаан, учир баримтыг сонссоны дараагаар бидэнд хариулах зарим юм гарч магадгүй гэж бодож байна.Яриад байх юм надад байхгүй.

Р.Гончигдорж -Их цааз гэдэг нэрийн талаар Чимид.Дараа нь хэрэв тэр гарах, өөрчлөлтүүдийг оруулсны дараачаар гарах зардлын тухай асуудлыг тодруулж сонсьё гэвэл Бага Хурлын гишүүн Товуусүрэн энд бэлтгэсэн асуудал байгаа.

Б.Чимид /396 дугаар тойргийн депутат/ -Их цааз гэж нэгдүгээрт, энэ бол эрдэм шинжилгээний байгууллагын улсуудаас гаргасан санал.Хоёрдугаарт, Үндсэн хуульд оноосон нэр өгөх гэсэн ийм оролдлого юм.Ингэхдээ Монгол улсын хууль цаазын түүхэн ийм уламжлалыг харгалзсан ийм л юм.Түүхийн уламжлалыг харгалзсан ийм зүйл.Өөрөөр хэлбэл одоо Монголд ардын хувьсгал хүртэл мөрдөж байсан жинхэнэ монголынх нь өөрийн хууль бол Цааз, Их цааз гэсэн хоёр нэртэй байсан юм.Монголынх нь өөрийн хууль. Монголд гаднаас, тухайлбал Манжаас дагуулсан хуулиуд нь хууль зүйлийн бичиг нэртэй байсан юм.Ийм учраас Монголын хууль цаазын түүхийн уугуул нэрийг сэргээн хэрэглэх гэсэн ийм утгатай. Үндсэн хууль гэдэг бол ерөнхий ангилалт.Өөрөөр хэлбэл хуулийг дотор нь үндсэн ба ердийн хууль гэж ангилна гэсэн.Тэгэхээр Үндсэн хуулиндаа Их цааз гэж нэр өгч байгаа хэрэг.Гадаад зарим оронд Үндсэн хуулиндаа өөрийн нэр өгсөн байдаг.Тэр нэрийг, за энэ товчдоо ийм.Энэ нотлох зүйлүүд их бий.Хэлэлцэх үед яригдах байх.

Р.Гончигдорж -За Бага Хурлын гишүүн Товуусүрэн.Дараа нь сүлд тэмдгийн талаар Бага Хурлын гишүүн Маам.

Ц.Товуусүрэн /Улсын Бага Хурлын гишүүн/ -Тэгэхээр энэ Үндсэн хуулийн нэр, Монгол улсын нэрийг өөрчилсөнтэй холбог-

3.

дуулж ямар зардал гарах вэ гэдэг асуудлууд нэлээд тавигдсан. Энэ асуудлыг Бага Хурлаас ажлын хэсэг гарч, холбогдох газруудын мэргэжлийн хүмүүс, удирдлагуудтай ярилцсан юм. Тухайлбал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газар, Монгол банкны удирдлагуудтай энэ асуудлыг урьдчилан ярилцсан. Ингээд бид бол ерөнхийдөө нэгэн тохиролцоонд хүрсэн. Мэргэжлийн хүмүүстэй ярилцаж. Энэ талаар Ерөнхийлөгч урьдчилж нэлээд хариулсан учраас би энд их давтахгүй байхыг хичээе. Тэгэхдээ зарим нэгэн юмнууд давтагдах байх.

Тамга, тэмдэг, байгууллагын хаяг зэргийг бол албан бичгийн хэвлэмэл хуудсыг бид Үндсэн хуулийг батлагдсаны дараа энийг солих нь зүйтэй гэж үзэж байгаа. Үүнд гарах зардлыг хэлсэн. Хэлэхдээ яасан бэ гэхээр, бид Цагдаагийн ерөнхий газар дээр бүртгэлтэй байгаа нийт байгууллагыг авсан. II мянга 200 байгууллага байгаа. Түүн дотроос төсвийн байгууллага хэд байдаг вэ гэдгийг авсан. 839 байгууллага байгаа. Тэрэн дотор нь төрийн байгууллага хэд вэ? Цагдаагийн байгууллага хэд вэ? Прокурор хэд вэ? Шүүх хэд вэ гэх мэтчилэнгээр ингэж бүр нарийвчлан авч үзсэн ийм тооцоо бидэнд байна. Ингээд тамга, тэмдэг хийх зардлыг бид нэг иймэрхүү дунджаар авсан даа. Нэг тамга хийхэд 200 төгрөг, нэг тэмдэг хийхэд 120 төгрөг, нэг байгууллагын хаяг хийхэд 2500 төгрөг, Ардын боловсролын яамыг Боловсролын яам болгоход албан бичгийн хэвлэмэл хуудсанд 3500 төгрөг нэг удаа хэвлүүлэхэд зарсан юм байна билээ. Тэрнийг нь бид нар 7000 төгрөг гэж авсан. Ерөнхийдөө бид энийг одоогийн мөрдөж байгаа Цагдаагийн ерөнхий газар тамга хийлгэж байгаа ханшаар авсан. Тийм учраас тэр их, энэ бага энэ тэр гэхгүй. Бид заавал чикаканкалсан мөнгөн, алтан, зэсэн тийм хаяг хийнэ гэж үзэхгүй байна. Ерөнхийдөө ийм дундаж юм авсан гэж үзэж байна. Ийм учраас энэ тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, байгууллагын хаяганд 8,2 сая төгрөг, 839 байгууллагад гарах нь ээ гэж үзсэн. Бусад байгууллагын хувьд бид Аж ахуйн нэгжийн хууль гарсан. Хуулийн дагуу шинээр бүртгүүлэх ёстой. Шинэ тамга, тэмдэг хийлгэх ёстой. Энэ бол Үндсэн хуулийн зохих заалт, юмтай огтхон ч холбогдох

гүй, өөрөө өөрийнхөө жамаар гарч байгаа зардал гэж ингэж тооцох ёстой гэж үзсэн.

Иргэний баримт бичиг байна.Иргэний баримт бичгийг бид Мөн Цагдаагийн ерөнхий газар, Гадаад явдлын яамны Консулын газартай ярьсан.Энэ 1990 онд Гадаад явдлын яамнаас эрхэлж гадаад паспорт хийлгэсэн.Гадаад паспортын одоогийн нөөц нь 200 мянган ширхэг бий.1995 он хүртэл нөөцтэй, иргэний паспорт 1 сая ширхэг бий.1996 он хүртэл нөөцтэй.За ингээд энэ олон юмыг яах вэ гэдэг асуудлыг бид нэлээд ярилцсан.Энэний эцэст ямар дүгнэлтэд хүрсэн бэ гэхээр ХБНГУ, хоёр германыг нийлэхэд Зүүн германы паспортыг хүчинтэй гэж дэлхийд нот зарлаад, манай улсын Гадаад явдлын яаманд тэр нь бий, нот зарлаад энэ паспортыг хүчинтэй хэрэглэж байгаа.Ийм практик нэгэнт дэлхийд байдаг олон улсын практик байдаг болохоор манайх 1995 он хүртэл байгаа нөөцөө хэрэглээд, дараа нь паспортаа шинэчлэх, энэ нь бол жинхэнэ гардаг зардал нь гараад, өөрийнхөө жамаар явах ёстой гэж ингэж үзсэн.Ийм учраас энийг бол бид энд Үндсэн хуулийн нэр өөрчлөгдмөгц гадаад паспортаа бүгдийг нь устгаж хаяад шинээр паспорт хийнэ гэсэн ийм ойлголт гарч ирэхгүй гэж үзсэн.Нэгэнт гадаад паспорт ийм болохоор дотоод паспортаа нэгэн адил.Би энд нэгэн логик уялдаатай нэгэн зүйлийг хэлье.Одоо манайд нас дээр настай хүмүүст хуучин монгол үсгээр бичсэн цэргийн батлах бий.Түүнийгээ барьж яваад хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн гэдэг юм уу, халх голын байлдаанд оролцож байсан хүмүүсийн үнэмлэх авахын тулд тэр батлахаа үзүүлээд явдаг, тэрийг хүчин төгөлдөр гэж үздэг.Тэрний нэгэн адилаар бидний одоогийн хэрэглэж байгаа иргэний бүх баримт бичиг, цэргийн батлах, гэрлэлтийн баталгаа, төрсний гэрчилгээ, гэх мэтчилэнгийн, дотоод паспорт гэх мэтчилэнгийн бүх баримт бичгийг бол байгаа нөөцөө дуустал нь ашиглаад, дууссаных нь дараа Үндсэн хуульдаа нийцүүлж шинээр хэвлүүлж болно.Ингэх юм бол тэр баримт бичгүүдийг хийхэд гарах ёстой зардал нь л гарна гэж үзсэн.Ийм учраас бид иргэний баримт бичгийг энд нэмэлт зардал болгож тооцох шаардлагагүй юм гэж үзсэн.Үүнтэй холбогдуулаад бас өшөө нэг зүйл бий.Энэ бол, харин энэн дээр нэг

зүйлийг анхаарахад бид магадгүй одоо хууль тогтоох байгууллагаас хууль гаргах ёстой. Энд бол иргэний баримт бичгүүдийг мөрдөх, гадаад паспортыг нот зарлах талаар нь зохих байгууллагуудад үүрэг өгсөн хууль гаргах ёстой гэж үзэж байгаа.

Төрийн бэлгэ тэмдгүүдийг байрлуулдаг газрууд бий. Өөрөөр хэлбэл сүлд байрлуулдаг газар. Төрийн далбаа байрлуулдаг газар гэх мэтчилэнгийн ийм юм бий. Энийг бид яах аргагүй Үндсэн хууль батлагдмагц хийх ёстой ийм ажил. Тэгэхээр бид энийг судалж үзсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран судалж үзсэн. Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 107 дугаар зарлиг гэж байдаг юм байна. Энэ зарлигаар хаана төрийн далбааг байрлуулах вэ? Хаана төрийн сүлдийг байрлуулах вэ гэдгийг зааж өгсөн. Бүр одоо ямар хүний машин дээр байрлуулах вэ гэдгийг хүртэл. Гадаадад суугаа дипломат төлөөлөгчдийн машин дээр хүртэл байрлуулсан. Улсын хилийн баганан дээр төрийн сүлд байрлах ийм учиртай байгаа. Ингээд бид энийг тоогий нь гаргаад, бид энэн дээр ойролцоо тоо авсан. Харин Батлан хамгаалах яамнаас цэргийн тугтай холбоотой зардлыг Точный тоо гаргаж өгсөн. Энэн дээр юу вэ гэхээр бид энэ бүх байрлуулдаг, чуулган хийх танхимаас эхлээд одоо бүх байрлуулдаг сүлд, далбаа энэ бүх юмыг хийхэд 4 сая 200 мянган төгрөг, 250 мянган төгрөг гэж Ерөнхийлөгч хэлсэн. Энэн дээр Батлан хамгаалах яамнаас гаргаж өгсөн нэгэн зүйлийг нэмэхэд бол цэргийн тугийг солих ёстой байгаа. Цэргийн тугийг солиход 323 мянган төгрөг байгаа. Ингээд 4 сая 573 мянган төгрөг нийтдээ ийм юм болох юм байна билээ гэж үзсэн.

Хамгийн сүүлд нь би мөнгөн тэмдэгтийн талаар товчхон юм хэлье гэж бодож байна. Мөнгөн тэмдэгт бол манайх өнөөдөр 1963 онд үйлдвэрлэсэн мөнгөн тэмдэгтийг ашиглаж байгаа. 1983 онд зарим мөнгөн тэмдэгтийг нэмж үйлдвэрлэсэн нь бий. Эдгээр мөнгөн тэмдэгтийн ашиглаж байгаа, 1991 оны I дүгээр сарын I-ний байдлаар мөнгөн тэмдэгт 10 жилийн нөөцтэй гэж байсан. Үүний дараагаар мөнгөн тэмдэгтийн хуваарь, мөнгөний хуваарь өөрчлөгдсөн, мөнгөний ханш буурсантай холбогдуулж энэ нөөц бол

их наашилж байгаа. Магадгүй нэг хоёр жилийн дараагаар одоо бид мөнгө үйлдвэрлэх тийм асуудал руу орох болж байгаа юм шиг байгаа юм. Тэгэхдээ ямар ч байсан нөөцөө дуустал үйлдвэрлээд, нөөцөө дуустал мөнгөө хэрэглээд, мөнгөн тэмдэгтээ тэр үйлдвэрлэдэг жамаар нь үйлдвэрлээ гэсэн түрүүчийн иргэний баримт бичиг, гадаад паспортын нэгэн адилаар ингэж л явъя гэсэн ийм бодолтой байгаа юм. Тэгэхээс биш одоо үйлдвэрлэхээд бэлэн байгаа мөнгөн тэмдэгтээ устгаад, шинэ мөнгөн тэмдэгт үйлдвэрлээ гэсэн ийм ойлголт руу орохгүй юмсан гэж ингэж бодож байна. Ийм учраас энэнд нэмэгдэл зардал гэхгүй, мөнгө үйлдвэрлэхэд ямар зардал гарах ёстой вэ, тэр нь гардаг зардал нь гараад, гарах ёстой хугацаандаа гарга гэсэн ийм үзэл баримтлалтай байгаа.

"Үнэн" сонин дээр нэг миллиард төгрөг энэ тэр гэсэн, үнэхээр ингээд Үндсэн хууль батлагдангуут хамаг юмаа устгаж хаячихаад шинээр бүгдийг нь үйлдвэрлэнэ гэвэл шинээр бүгдийг нь хийнэ гэвэл, энд нэлээн их зардал гарах ёстой. Зүгээр миллиард төгрөг хүрэхгүйг би сайн мэдэхгүй байна, арай хүрмээргүй юм шиг байна билээ. Бид бас үзсэн. Тэгэхдээ бид бол тэгж туйлшрахгүй, зөвхөн одоо жинхэнэ гарах ёстой нь юу юм бэ? Бусдыг нь хууль гаргаад, шийдвэр гаргаад цааш нь үргэлжлүүлж хэрэглээд, жинхэнэ нөөц нь дууссан үед нь үйлдвэрлэх энэ чигд өөрсдийнхөө үзэл баримтлалыг чиглүүлэх юмсан гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

Соронзон хальстай тулгаж
нийлсэн

А.Алтанцэцэг

Д.АЛТАНЦЭЦЭГ

Бичээч Уранчимэг

1991.11.13

Кассет - 18

18.55-19.00

56 дугаар тойргийн депутат Р.Гончигдорж:

Зохиогчийнхоо эрхийн хувьд одоо өөрийнхөө эрхэнд байгаа Тэнгисболд үүнийг тайлбарлана, сүүлд та бүхэнд дэлгэрэнгүй.

Тэр талаас ч гэсэн богино хэмжээний дүрс бичлэгийн кино хийж байгаа. Үүнийгээ та бүхэнд тайлбарлаад, ерөөсөө манай монголд бэлгэдлийн шинжтэй элементүүд ямар үед ямар, ямар байдлаар илэрхийлэгдэж гарч байсан болоод, тэгээд өнөөдрийнхөө оруулж ирж байгаа төслийг нарийн дэлгэрэнгүй тайлбарлана.

Энэ дээр хэрхэн ажиллаж, эдгээрийг сонгосон тухайгаа Бага Хурлын гишүүн Маам танилцуулна.

Улсын Бага Хурлын гишүүн Д.Маам:

Би товчхон 3,4 зүйл дээр ярьж. Нэгдүгээрт, Монгол улс манжийн эрхшээлээс гарч, цагагчин гахай жилийн хувьсгалыг 1911 онд хийгээд Богд хаант монгол улсыг тусгаар тогтносон байдлаар зарлахдаа одоогийн өвөрмонгол, барга, өмнөд дээд монголын нутгийг оролцуулан зарлах ^{дээ} соёмбыг сүлдэнд авсан байх юм, бадамлянхуа цэцгээр суурь хийж. 1924 онд Цэрэндорж гуай нарын боловсруулсан төрийн дээд байгууллагаас баталсан тэр сүлд бол 1911 оны сүлдийг залгамжлан авсан байна. 1940 онд уурга ^{га} барьсан морьтой хүн, нар ургах зүг давхиж байгаагаар сүлдний төв гол хэсгийг нь тэгж бодож хийсэн, сүлдийг 40 онд авсан. 1940 он маань бид мэдэж байгаа, ямар учир утгатай он билээ. 1960 онд бол тэр сүлдийг ерөнхийд нь хэвээр авсан боловч, тэр 4 хошуу малын толгойн дүрсийг арилгаад, бидний энэ харж байгаа сүлд, тэнд Үндсэн хууль дээр бол уургий нь бол аваад, малчин хүн гэдгийг хөдөлмөрчин хүн гэж бичээд, коммунизмын улаан наран зүг давхиж байгаа хөдөлмөрчин хүний дүрс бүхий сүлдийг төрийн сүлд гэж тунхагласан байгаа юм.

Энэ бол товчхон түүх.

Хоёрдугаарт, та бүхний асуусан асуултанд товчхон яс хариулахыг би бодъё. Тэгэхдээ ерөнхийгөөр авч үзэж, тодорхойгоор нэг авч үзэж, товч хариулъя.

Ерөнхийгөөр гэвэл би та бүхний асуусан асуултанд хариулж байгаа. Тийм учраас анхаарна гэдэгт найдаж байна. Ерөнхийгөөр гэвэл засаг өөрчлөгдсөнийг бид нар мэдэж байна. Засгийн газар гэдэг утгаараа ч бай, засаг гэдэг утгаар ч бай, тэр өөрчлөгдсөн тэр байтугай эрин өөрчлөгдсөн. Үүнийг бид бүхэн мэдэж байна. Эрин өөрчлөгдсөн болбоос, эринийг товчоодон зангидаж, бид бүхний магнай дээр, зулай дээр байх тэр сүлд бол өөрчлөгдөх ёстой гэдэг ерөнхий нэг ойлголт манай ажлын хэсгийн ажлын нэг үндэслэл болсон. Концепци маягийн. Тэгэхээр түрүүнд энэ сүлдний талаар хэллээ.

Нарийвчлаад ярих юм бол, тэгэхээр энэ маань та бүхэн харьцуулж үзэж болох юм. СССР улсын 16 дахь бүгд найрамдахын яах аргагүй тийм, харьцуулж харахад тийм зүйл байгаа юм. Тэгэхээр бид нар дээхэн үед Нацагдоржийн шүлгэнд хүртэл байсан, улаан монгол, Хөх монгол, улаан монгол боллоо гэж. Харин ч ерөөсөө Монгол бол хөх байсан бөгөөд, тэр завсрын улаан нь болилд бид нар Хөх монгол руу орж байгаа, гэж нэг бодож үзсэн. Гэх мэтчилэнгээр ийм хоёр тайлбар байж болох юм болов уу гэж санаж байгаа юм, сүлдний тухайд бол.

Тугны тухайд бол далбаа гэдгийг бид туг болгосон. Үгий нь өөрчилж. Сүлд өөрчлөгдвөл далбаа болно. Сүлднээсээ урган гардаг учраас, ямар нэгэн хэмжээгээр сүлдний өөрчлөлт далбаан дээр тусах ёстой болов уу? Иймэрхүү л зүйлийг хэлье гэж бодож байна.

Нарийвчлан хэлэлцэх үед 12 дугаар зүйл дээр бол манай ажлын хэсгийн нөхдүүд болон бид нар дахин ярих байхаа.


Ж. Уртнасан: За баярлалаа. Эрхэм депутатуудад нэг санал байна. Бид дэгийнхээ дагуу бол одоо 7 цаг боллоо.

Завсарлах цаг болсон байна. Бид ажил сайн явж байгаа ч гэсэн олон хоног хуралдахаа бодож, нэг өдөр ч гэсэн цагтаа завсарлах нь зүйтэй болов уу гэж бодож байна. Зарлалын чанартай хоёр зүйл байна.

Монголын Үндэсний дэвшлийн намын журмын нөхөр депутатууд болон дэмжигчдийг хурлын дараа 430 дугаар өрөөнд хүрэлцэн ирэхийг урьж байна гэж Монголын Үндэсний дэвшлийн нам зарлуулж байна.

19 цагийн завсарлагааны дараагаар МАХН-ын гишүүн депутатууд эндээ үлдэнэ үү. Хорооны бүрэлдэхүүнд оруулах депутатуудын нэрийн талаар ярилцъя гэж МАХН-ын бүлэг зарлуулж байна.

СОРОНЗОН ХАЛЬСТАЙ
ТУЛГАЖ НИЙЛСЭН



Д.ЧУЛУУНБИЛЭГ